




ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



ХУУЛЬ ЁС ДЭЭДЛЭХ ЁС

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА, ОНОЛ,
ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Хууль зүйн эрдэм-шинжилгээ, судалгаа, практикийн улирал тутмын сэтгүүл

2015 он, Цуврал 2 (52)

Улаанбаатар хот 2015

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ж.Амарсанаа	<i>Академич</i>
Б.Амарсанаа	<i>Хууль зүйн доктор</i>
Ж.Батзандан	<i>Хууль зүйн доктор</i>
Ж.Баярцэцэг	<i>Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга</i>
Б.Болдбаатар	<i>Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга</i>
Ж.Бямбадорж	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Ганбат	<i>Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга</i>
Б.Гүнбилэг	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Дорлигжав	<i>Хууль зүйн сайд</i>
Ц.Зориг	<i>Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч</i>
О.Мөнхсайхан	<i>Хууль зүйн доктор</i>
С.Нарангэрэл	<i>Академич</i>
Ч.Өнөрбаяр	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Солонго	<i>Хууль зүйн доктор</i>
Х.Тэмүүжин	<i>Улсын Их Хурлын гишүүн</i>
Ж.Эрдэнэбулган	<i>Хууль зүйн доктор</i>
П.Цагаан	<i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга</i>
Ш.Цогтоо	<i>Хууль зүйн доктор</i>
Ч.Энхбаатар	<i>Хууль зүйн шинэсэлэх ухааны доктор</i>

Ерөнхий эрхлэгч


Э.Батбаяр

Хариуцлагатай нарийн бичгийн дарга

Б.Гончигсумлаа

Хэвлэлийн эхийг

Д.Мөнхжаргал



Улсын бүртгэлийн дугаар: 279
ISSN:2226-9185
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс
эрхтэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар - 46,
Чингэлтэй дүүрэг, Чингис хааны талбай-7
Утас: +(976)-11-315735
Факс: 315735
Вэб хуудас: www.legalinstitute.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

EDITORIAL BOARD

J.Amarsanaa	<i>Academician</i>
B.Amarsanaa	<i>(LL.D)</i>
J.Batzandan	<i>(Ph.D)</i>
J.Bayartsetseg	<i>State Secretary, Ministry of Justice of Mongolia</i>
B.Boldbaatar	<i>Secretary General, the Secretariat of the State Great Hural of Mongolia</i>
J.Byambadorj	<i>(Ph.D)</i>
D.Ganbat	<i>Chairman, the Standing Committee of Law of the State Great Hural of Mongolia</i>
B.Gunbileg	<i>(Ph.D)</i>
D.Dorligjav	<i>Minister of Justice</i>
Ts.Zorig	<i>Chief Justice, Supreme Court of Mongolia</i>
O.Munkhsaikhan	<i>(LL.D)</i>
S.Narangerel	<i>Academician</i>
Ch.Unurbayar	<i>(Ph.D)</i>
D.Solongo	<i>(Ph.D)</i>
Kh.Temuujin	<i>Member of the State Great Hural of Mongolia</i>
J.Erdenebulgan	<i>(Ph.D)</i>
P.Tsagaan	<i>Head, the Office of the President of Mongolia</i>
Sh.Tsogtoo	<i>(Ph.D)</i>
Ch.Enkhbaatar	<i>(Sc.D)</i>

Editor-in-Chief

E.Batbayar

Acting Assistant Editor

B.Gonchigsumlaa

Designed by

D.Munkhjargal

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute
publishes this law review five times
per year.

Address: Ulaanbaatar-46, Chingeltei District,
Chinggis khaan Square -7
Phone:+(976)-11-315735
Fax: 315735
Website: www.legalinstitute.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад программ хангамж ашиглах боломж

9

Хууль зүйн доктор Б.Амарсанав;

Үндсэн Хуулийн Цэцийн мэдээлэл, технологийн инженер Б.Даваажав

Газар ба газартай холбоотой хязгаарлагдмал эрхүүд

14

Типбургийн Их сургуулийн Хууль зүйн сургуулийн докторант Н.Баярмаа

Насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ял здлүүлэх ажиллагааны зарим асуудал

26

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн доктор (Ph.D), дэд профессор, хурандаа Н.Гантулга;

ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн ахлах багш, хууль зүйн магистр, (LL.M), хошууч Н.Батдорж

ЭРХ ЗҮЙ, СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

34

Гэрээний тухай шинэлэг үзэл баримтлал

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн доктор (Ph.D) С.Должин

Хөршийн эрхийн зохицуулалт, анхаарах зарим асуудал

41

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимийн Ахлах багш Ц.Давхарбаяр

Кибер гэмт хэрэг: Хандлага ба төрөл, хэлбэр

49

МУИС-ийн ХШУИС-ийн Мэдээлэл, компьютерийн ухааны тэнхимийн багш Ц.Хүрэл-Очир

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ, АСУУДАЛ

Эрдэс баялгийн хууль тогтоомжийн систем дэх нутгийн захиргааны эрх хэмжээ

60

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш. (LLM), МРА Д.Батболд

**Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь төрийн нууцтай холбоотой
эрх зүйн зохицуулалтын асуудал**

70

Үндэсний тагнуулын академийн эрдэм шинжилгээний тэргүүлэх
ажилтан, (LL.M). Б.Батхишиг

**Авлига албан тушаалын гэмт хэргийн хор хенеөл, өнөөгийн тулгамдаж
буй асуудал**

77

АТГ-ын МШХ-ийн мөрдөн байцаагч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
магистрант Ч.Жаргалбаатар

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ, ҮР ДҮН

**Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулсан судалгаа:
ХБНГУ, БНСУ**

80

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн
судалгааны тооч тайллан

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

**Шүүхийн хамгаалалтын механизмын үр нөлөөг сайжруулах нь:
Асуудлыг улс хоорондын үүднээс авч үзэх нь**

91

Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн дарга. Хууль зүйн шинжлэх
ухааны доктор, профессор, Оросын Холбооны Улсын Гавьяат
хуулыч Валерий Дмитриевич Зорыкин

**Олон улсын байгууллагын эрх зүйн байдал, хариуцлагын асуудал
(Олон улсын эрх зүйн болон дотоодын эрх зүйн жишээн дээр)**

98

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Бодлогын судлаач Э.Туулайхүү

CONTENT

BEFORE CREATING A LAW (UNDERLINE ARTICLE AND INTERVIEW)

Opportunity for Using Software for Drafting Law	9
<i>B.Amarsanaa, (LL.D), Associate Professor of Law, School of Law, National University of Mongolia</i>	
<i>B.Davaajav, Engineer in charge of Information and Technology, the Constitution Tsets of Mongolia</i>	
Land and the Restricted Rights Related to Land	14
<i>N.Bayarmaa, Ph.D candidate, Tilburg University of the Netherlands</i>	
Some Issues on Juvenile Incarceration	26
<i>N.Gantulga, (Ph.D), Dean of Court Enforcement School, Law Enforcement University and the Colonel; N.Batdorj, (LL.M), Senior Lecturer of Law Enforcement University, and the Major</i>	
LEGAL THOUGHTS: REFLECTION	
New Concept of the Contract	34
<i>S.Dojin, (Ph.D), Professor of Civil Law Department, School of Law, National University of Mongolia</i>	
Regulations of Neighbours Rights and Some Considerable Issues	41
<i>Ts.Davkharbayar, Senior Lecturer of Civil Law Department, School of Law, National University of Mongolia</i>	
Cyber Crime: Tendencies and Types, and Forms	49
<i>Ts.Khurel-Ochir, Professor of Information and Computer Science Department, School of Engineering and Applied Science, National University of Mongolia</i>	
IMPLEMENTATION OF LAW, EFFICIENCY AND PROBLEMS	
Competence of Local Administration in System of Mineral Legislation	60
<i>D.Batbold, (LL.M. MPA), Professor of State and Administrative Law Department, School of Law, National University of Mongolia</i>	
With Respect to Legal Regulations on State Secrets in Criminal Proceeding	70
<i>B.Batkhisig, (LL.M), Senior Officer, National Intelligence Academy of Mongolia</i>	

Harmful Effects of Corruption and Other Official Crimes, and the Current Challenging Issues

77

*Ch.Jargalbaatar, Investigator of the Investigation Division, Anti-Corruption Agency of Mongolia***RESEARCH OVERVIEW****Comparison of Criminal Procedure Laws: The Federal Republic of Germany and The Republic of Korea**

80

*Summary of Research Paper of National Legal Institute***INTERNATIONAL PRACTICE****Improving Judicial Remedies: From Perspective of Various Countries**

91

*Valerii Dmitrievich Zorkin, (Sc.D), Honorable Lawyer of the Russian Federation, and Director of the Constitutional Court of the Russian Federation***Legal Status and Responsibility of International Organization**

98

(The Cases of International Law and Domestic Law)*E.Tuulaikhuu, Policy Researcher of the National Legal Institute*

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД ПРОГРАММ ХАНГАМЖ АШИГЛАХ БОЛОМЖ



Хууль зүйн ухааны доктор Б.Амарсанaa:

Үнсэн Хуулийн Цэцийн мэдээлэл,
технологийн инженер Б.Даваажав

Хууль тогтоомжийн төсөл батлагдсаны дараа зарим заалт алга болсон, дугаарлалт буруу, УИХ, байнгын хороо, ажлын хэсэг дээр ярж тогтсон агуулга ороогүй, эсхүл хамгийн сүүлийн хувилбар биш байх, буруу томъёолол, агуулгаар орсон байх зэрэг асуудал гардаг. Ийм тохиолдол нийтэд ил биш ч баагуй тоотойгоор гарсан байдаг. Энэ нь ялангуяа олон тоотой хууль болгино хугацаанд гарах, эсхүл олон заалт бүхий томоохон хууль батлагдах үед тухайн хуулийн төслийн эх баригчийн ажлын эчэллаас хамаарсан хүний хүчин зүйлээс хамаарлтай алдаа гарахыг угийсгэхгүй юм. Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдон цөөнгүй хүндрэл гардаг. Цаашлаад хаана, аль уе шатанд алдаа гарсныг тогтооход маш төвөгтэй, улмаар дараа, дараагийн удаа энэ алдаа гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхой бус болгох нэхцэлд хүргэдэг. Энд дурдсан асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх гарц, боломжийн талаар энэ өгүүлэлд авч узх болно.

Хууль, дүрэм, журам гэх мэт хууль тогтоомжийн төслийг боловсруулж ирсэн түүхийг үзвэл ихэнхдээ гараар бичих, түүнийгээ засварлах, бичгийн машинаар эхнээс нь дахин дахин хуулбарлаж, зохих засварыг хийж байсан ба харин компьютер гарч ирснээр энэ ажиллагаа хялбар болж өнөөг хүртэл төрийн байгууллагууд Microsoft Office Word программыг хэрэглэж ирлээ. Хэдийгээрэн нь бичиг баримт боловсруулах зорилготой учир ажиллагааг хялбарчилсан боловч хууль тогтоомжийг бичихэд тухайлсан зориулагдаагүй нь формат оруулах, фонт тохируулах, хэвжүүлэлт хийх, зэрэгцүүлэлт хийх зэрэгт төсөл боловсруулагчаас ихээхэн цаг хугацаа, хүч хөдөлмөр шаардлаг ажлыг хангалттай хөнгөвчилж чадахгүй байгаагаас гадна хамгийн гол нь хүний хүчин зүйлээс хамаарлтай алдаа гарах магадлалыг бууруулж чадаагүй юм.

Мөн төсөл боловсруулагч, төслийн эх баригчийн ажиллах чадвараас хамаараад сайтар боловсруулаагүй төсөл хууль болон батлагдан гарах ч эрдэл байна. Энэ нь хуулийн үзэл баримтлалаас үүдэлтэй бус зөрчил, хийдэлтэй хууль тогтоомж гарах, хуулийг нэг мөр ойлгохгүй байх үндэс болж байна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх, энэ үйл ажиллагааг хөнгөвчлөх, олон төрлийн төсөл боловсруулах үйл ажиллагааг цэгцтэй болгох зорилгоор хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд нэгдсэн стандарт мөрдүүлэхэд туслах програм хангамж боловсруулах шаардлагатай байна.

Програм хангамжийн шийдэл бий эсэх:

Програм хангамжийг хууль тогтоомжийн тесэл боловсруулахад ашиглах нь шинэ тутам хөгжих байгаа ч сүүлийн жилүүдэд хийгдэж буй судалгаанууд энэ чиглэлийн програм хангамжийн хөгжүүлэлтэд ихээхэн дэвшвилгийг авчирч энэ нь бие даасан судалгааны салбар болжээ.

Хууль тогтоомжийн тесэл боловсруулахдаа програм хангамж ашиглаж байгаа байдлаараа улс орон бүр харилцан адилгүй байна. Зарим орон уг асуудлыг тодорхой төслийн хүрээнд нарийвчлан судалж бие даасан системүүдийг бий болгон ашиглаж байгаа бол зарим нь үүнтэй адил төстэй системүүдийг хөгжүүлий хууль тогтоомжийн тесэл боловсруулах ўйл ажиллагаагаа тодорхой хэмжээнд хөнгөвчлөх оролдлогудыг хийж байна.

Аливаа хууль тогтоомжийн төслийг боловсруулахад түүнийг үүсгэх техник ажиллагаанаас гадна боловсруулж буй төсөлтэйгээ холбоотой бусад хууль тогтоомжийн зохицуулалт (зүйл, заалт, уг) зэргийг харах шаардлагыг зүйл ёсоор тавигддат. Түүгээр ч зогсогч тодорхой нэр томъёоны илэрхийлж буй утгыг тодорхой мэдэх шаардлагыг гарч болох юм. Сайтар зохион байгуулсан мэдээллийн сангаас энэ үйлдлийг тодорхой хэмжээнд хялбарчлах улмаар төсөл боловсруулагчийн техник ажиллагааг хөнгөвчлөх чиг үүрэг бүхий програм хангамжийг бий болгох боломжтой бөгөөд энэ чиглэлийн системүүд ихэвчлэх XML, Java, (Document object model), dot.NET, CGI, Php, Javascript, AJAX/ ашигласан байдаг.


LEDA, DALOS, NIR, AT4AM зэрэг нь дээрх байдлаар хөгжих эхэлж байгаа томоохон системүүд юм. Австралийн доктор Тимоти Арнольд Мор нь 1991 онос эхлэн хуулийн мэдээллийн системийн хөгжүүлэлтээр дагнан ажиллаж олон судалгааны ажил хийсан байна. Мөн FALM/Free Access to Law Movement/ хөдөлгөөн жил бүр

үулзалт зохион байгуулдаг ба 2012, 2013 оны хуралд Япон болон Италийн судлаачдаа энэ хүрээн дэх хуулийн систем хөгжүүлэлт, цаашдын чиг хандлагын талаар танилцуулсан.

Тэдгээр хөгжүүлэлт нь мэдээлэлд чиглэсэн (information oriented approach) болон хиймэл оюун хөгжүүлэлтийн (Artificial Intelligence approach) гасны хөр чиг хандлагаас бурдаж байгаа бөгөөд мэдээлэлд чиглэсэн хандлага гэдэг нь тодорхой зориулан хөгжүүлсэн мэдээллийн систем (веб сайт, мэдээллийн сан)-гийн тусламжтай хуулиин төсөл боловсруулах үед тулгарсан аливаа асуудлыг шийддэг бол хиймэл оюунд сууринсан хөгжүүлэлт нь тухайн салбарын цогц мэдлэгийг бүрдүүлсэн загвар үсгэн түүнийг дэмжих ажиллах хэрэгслийг бурдуулж илүү ухаалаг түвшинд мэдээлэл боловсруулах зорилготой байдаг.

Зураг 1-д үзүүлснээр "LegisPro" систем үүсгэж байгаа баримтад төслийн хэвжүүлэлтийг хийж хадгалах боломжийг олгосон нь хэрзгэлэгч хялбар, алдаагүй байдлаар төслийн бүтцийг үүсгэх боломжийг олгох байна.

Зураг 1



Товчхондоо техникийн шийдлийн хувьд дээрх техник ажиллагааг хөнгөвчлөх боломжтой бөгөөд үүнтэй холбоотой асуудлыг түр орхиод энзелирний програмын ач холбогдлыг авч узвэл.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад ашиглах програм, түүний ач холбогдол:

Програмын ач холбогдол нь түүний гүйцэтгэх чиг үүргээр дамжин илэрдэг. Хуулийн төсөл боловсруулах хүрээнд тулгардаг түгзэмэл бэрхшээл нь текст мэдээлэл үүсгэх үеийн болон засварлах шатанд оруулах нэмэлт өөрчлөлтийн гэсэн хоёр хэсэгт ангилж болох юм.

Текстээр төслийг үүсгэх үед төслийн хэвжүүлэлт, уг үсгийн алдаа, угийн оновчтгай сонголт, утга найруулга зэрэгт алдаа гарч болох бол засварлах шатанд тухайн төсөлд орсон засвар, нэмэлт өөрчлөлт, түүний агуулга, түүх зэргийн хялбар ойлгогдохоор хадгалж үзүүлэх нь хамгаас чухал юм.

Эн нь дараах ач холбогдолтой:

- Бидний одоо ашиглаж буй / Microsoft Office Word/ програм нь текст мэдээлэл боловсруулах өрөнхий програм тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах тухайлсан ажилд формат хэвжүүлэлтийн ажилд төсөл боловсруулагчаас ихээхэн цаг хугацаа, хүч хөдөлмөр шаарддаг. Тэгвэл дээрх төрлийн програм нь эдгээр үйлдлийг хялбар хийх боломж олгож болно.

• Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд Монгол хэлний зөв бичгийн дүрэм болон төслийн найруулга зүйд уг сонголтын алдааг няяглах боломжийг бий болгож болно.


- Төсөл боловсруулагч багийн хоорондын ажлын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо сайжирч төсөл боловсруулах үйл ажиллагааны хурд сайжирна.

- Төслийн шатанд боловсруулалтын нууцлал хамгаалалт бий болно.

- Програм нь хуулийн төсөл боловсруулах үйл ажиллагааг хөнгөвчлөхөөс гадна шинэ нэр томъёог давхар хадгалан, тэмдэглэх ач холбогдолтой байж болно.

Програмын загвар /төсөөлөл/
Зураг 2-т төсөл боловсруулагчийн ажиллах загварыг харуулав.

Зураг 2. Нэвтрэх хэсэг



Хууль тогтоомжийн төсөл өөрийн гэсэн тогтсон онцлог бүтэцтэй тэр нь байна давтагдан хийгдэг. Энэхүү төсөл болгонд дээр давтагдаг баримтын түгзэмэл өрөнхий бүтэц (гарчиг, зүйл, заалт) зэргийг хүний үйл ажиллагаагаар биш програмд урьдчилан хадгалсан хэвжүүлэлтийг ашиглах нь төсөл үүсгэх явцад гардаг техник алдаанаас сэргийлэх, хурдан хугацаанд баримтыг үүсгэх боломж олондоно.

Үүсгэж буй баримтыг хялбар урьдчилан бэлдсэн формат ашиглах нь хамгийн тохиромжтой юм. Зураг 3-т төсөл үүсгэх хэсгийг харуулав.

Зураг 3. Төсөл үүсгэх



Энэ нь зөвхөн хуулийн төсөл үүсгэхэд бус бусад төрлийн эрх зүйн акт үүсгэхэд ашиглах боломжтой юм.

Одоо байгаа хууль тогтоомжийн мэдээллийн сангийн хүрээнд төсөл боловсруулах шатанд уг үсгийн алдааг шалгах боломжтой байж болно. Энэ төрлийн програм хангамжаас Болорсофт ХХК-ны алдаа шалгач, ангууч зэрэг /морфологи/ байгаа боловсруулах шатанд хялбар ашиглаж чадвал хууль тогтоомж бүрэн алдаагүй гарах боломжтой ба алдаа шалгах хүний ўйл ажиллагааг хөнгөвчилж болно.

Зураг 4. Алдаа шалгах

Үүний алдаа засах програмтай холбогдон ашиглаз боломжтой байх нь чухал.

Мөн мэдээллийн баазыг сайтар бурдүүлснээр үгийн сонголттой холбоотой хувилбаруудыг шалгах боломжтой байж болно. Тухайлбал, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиуд дах үгтэй холбоотой мэдээлэл авах мөн адил утгатай уг, холбоо уг зэргийг ялгаж харуулж төсөл боловсруулагчид санал болгодог байж болно.

Зураг 5. Төстэй ўг

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1. Энэ хуулийн зорилт нь Жишээ жишээ бизнесийн худалдаа Арилгав

Мөн төслийн тодорхой уг, өгүүлбэр эсвэл агуулгад оруулсан өөрчлөлтийг тэмдэглэх түүнийг оруулсан цаг хугацаа, субъект, өөрчлөлтийн агуулга зэргийн түүхийг хадгалан харуулах нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах шатанд хийгдэх хамгийн чухал зүйл юм.

Зураг 6. Засварыг тэмдэглэх

Үүстэж буй төсөлд засвар, өөрчлөлтийг тэмдэглэх боломжтой байх.

Зураг 7. Засварын түүхийг тэмдэглэх

Нийтийн	Төсөл	Төслийн	Төслийн	Төслийн
Нийтийн	Төсөл	Төслийн	Төслийн	Төслийн
Нийтийн	Төсөл	Төслийн	Төслийн	Төслийн
Нийтийн	Төсөл	Төслийн	Төслийн	Төслийн
Нийтийн	Төсөл	Төслийн	Төслийн	Төслийн

Мөн өгөгдлийн сангаас хуулийн холбогдох зүйл, заалтыг харуулах нь төсөл боловсруулагчид илүү хялбар байж болно.

Зураг 8. Мэдээлэл харуулах

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Жишээ жишээ бизнес

1. Бизнес төвлөгөөгээ падан нь Хоршооны стратеги, зорилтыг тодорхойж, хоршооны уйл ажиллагааг архлахад түүчин бүтэц, зокон байгуулалт, уйлчилгэвшийн шүүрхий, найдвартай ажиллагаагаа, таргууллагчийн ур чадвар, сонгуу, төслийн тодорхойжилж, хоршооны уйл тусгай цагдаагүйн чөлөөнийгээ болгоорхуулсан баримтыг хийнэ. Хоршооны бизнес төвлөгөө.

Боловсруулж буй төсөлд хөргүүлэлт хийгдэх боломжтой. Word, PDF, Html зэрэг хэлбэрүүдэд хөргүүлэлт хийж төслийг тодорхой цахим хаягуудад явуулах боломжтой байх нь чухал юм.

Зураг 9. Хөргүүлэх



Зураг 10. Илгээх



Хууль тогтоомжийн нэр томъёоны нэгдсэн сан үүсгэн програмтай холбох боломж.

Энэ програмыг улам төгөлдөржүүлэх боломжтой нэг функция нь хуулийн төслийг одоо байгаа болон хууль тогтоомжид байсан нэр

томъёотой харьцуулах, улмаар шинэ хууль зүйн нэр томъёо хууль тогтоомж батлах замаар санамсаргүй Монголын хууль тогтоомжийн сан, шинжлэх ухаанд орж ирэх явдлыг хянах юм. Ингэхдээ www.legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд орсон текст мэдээллээс Монгол Улсын хууль тогтоомжийн нэр томъёоны санг үүсгэн, улмаар хууль тогтоомжийн теселтэй харьцуулан төсөлд шинэ нэр томъёо орж байгаа эсэх, нэг утга агуулгыг 2 болон түүнээс дээш нэр томъёогоор илэрхийлэх асуудлыг тодорхой хэмжээгээр шийдвэрлэх боломж юм. Мен хууль тогтоомжийн нэр томъёоны нэгдсэн сан улам баяжих бололцоо уугээр бий болно.

Нэгтгэн үзэхэд

Энд дахин дурдахад програм нь зөвхөн хуулийн төсөл боловсруулахад ашиглаж болохоо гадна хуулиас бусад хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам, тогтоол, тушаал зэргийг Монгол Улс даяар нэгдсэн байдлаар боловсруулах, адил төстэй агуулгатай эрх зүйн актыг аль нэг аймаг, сум өөр аймаг, сумд батлагдсан журмаас жишээ авч төсөл боловсруулах боломжийг бий болгох ба энэ нь цаг хугацаа, хүн хүч зэрэг хууль тогтоомжийн төсөл боловсруулах нийт нийгмийн зардлыг (social cost) бууруулах ач холбогдолтой юм. Дээрх байдлаар хуулийн төсөл боловсруулагч програм зохиосноор хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагааг бүрэн хөнгөвчилж, өгүүллийн хүнээс хамаарсан алдааг арилгах боломжийг бүрдүүлэх юм.

ГАЗАР БА ГАЗАРТАЙ ХОЛБООТОЙ ХЯЗГААРЛАГДМАЛ ЭРХҮҮД



*Тилбургийн Их сургуулийн Хууль зүйн
сургуулийн докторант Н.Баярмаа*

1. Өмчийн эрхийг гагцхүү хуулиар бүтээх зарчим буюу *Numerusclausus principle*

Өмч (property)-ийг авч үзэх үндсэн хоёр хандлага байдаг. Эхний нь өмчийг тодорхойлох үзэл баримтлалын хандлага гэж байх бөгөөд энэ нь өмчийг ойлгох академики хандлага юм. Энэ хандлагыг сүүлд "өмчийг авч үзэх багц эрхийн онол" гэж нэрлэх болсон бөгөөд ийнхүү Нэрлэхэд чухал нелөө үзүүлж "багц эрх" хэмээх нэр томьёог анх хэрэглэсэн эрдэмтэн бол А.М. Honore' юм. 1960-аад оны үед Нобелийн шагналт Роберт Коэс анх санааг нь дэвшигүүлсэн өмчийн эрхийг эдийн засгийн үүднээс тайлбарлах хандлагын эхлэл болсон "Нийгмийн зардлын асуудлууд" өгүүллийн суурь үзэл санаа өмчийг авч үзэх багц эрхийн онолоос үүдэлтэй гэж үздэг.¹ Энэ онолын үүднээс өмчлөх эрх нь эзэмших эрх, ашиглах эрх, удирдах эрх, тухайн эд зүйлээс ашиг хүртэх эрх, хөрөнгөтэй байх эрх, үүргийн гүйцэтгэлийг хангах эрх, бусад шилжүүлэх эрх, хохирол учруулах байдлаар ашиглахаас

хамгаалагдах эрх, эрхээ хэрэгжүүлсний дүнд хариуцлага хүлээх чадвэр зэрэг эрхийн багцаас бүрданэ гэж үздэг.²

Өмчийг авч үзэх хоёр дахь хандлагыг хэрэгслийн хандлага гэх бөгөөд энэ онолын дагуу өмч гэдэг нь sovereignty буюу дархан эрх гэсэн ойлголттой давхцах, хариуцлага хүлээлгэх эрхээр биш харин зөвшөөрөл олгох бүрэн эрхээр хамгаалагдан хэрэгжих ойлголт юм.³ Тодруулбал, өмч гэдэг нь эдийн засагчдын ойлгодоор аливаа баялгийг хянах талаар хүмүүсийн эдлэх бүрэн эрхийг хамгаалсан олон төрлийн дүрэм журмын тогтолцоо, институт юм. Тухайлбал нийтлэг эрх зүйн хүрээнд өмчийн талаарх бүрэн эрхийг өмчийн дүрэм журам (property rules), хариуцлагын дүрэм журам (liability rules), салшгүй эрхийн дүрэм журам (inability rules) гэсэн дүрэм журмын үндсэн төрлүүдээр хамгаалж байдаг. Өмчийн харилцааг зохицуулсан эдгээр бүлэг дүрэм журам нь өмчийн эрх нэгээс негөөд шилжих, эс шилжих, түүнчлэн зөвшөөрөвлөр шилжих эрх зүйн үндсийг тогтоож улмаар өмчийн ашиг сонирхлуудыг өөр хооронд нь ялангаа зааглах гол үндэслэл болдог. Товчондоо хэрэгслийн хандлага нь өмчлөлийн харилцаанд орохын тулд гагцхүү өмчлөгчийн зөвшөөрөлд сууринласан байх зарчимд сууринласан олон дүрэм журмыг бий болгох буй хэрэгсэл нь өөрөө өмч юм гэж тайлбарлаж байна.

Эзэмшил төвтэй онолоор өмчийн эрх зүйг тайлбарлахыг зорьдог хандлага нь мөн хэрэгслийн хандлагын нэгэн хэсэг байдаг бол өмчийг харилцааны

¹ Aileen McHarg, Barry Barton, Adrian Bradbrook and Lee Gordon, *Property and the Law in Energy and Natural Resources*, 2010, Oxford university press, P 24

² A.M. Honore', "Ownership in Oxford Essays in Jurisprudence (A. G. Guest, ed. 1961) 107 at 113

³ Aileen McHarg, Barry Barton, Adrian Bradbrook and Lee Gordon, Supra note 1. at 32

үнэ цэнэтэй хэрэгсэл гэх үзсл нь нийтэд түгсэн өмчийн эрхийн онол болох Өмчийн эрхийг гагчхүү хуулиар бүтээх зарчим буюу *numerus clausus principle*-ийн талаарх Мэрилл болон Смит нарын онолын суръя болсон юм.⁴

Аливаа ашиг сонирхлыг зөрчсөн гэх үндэслэлээр шаардлага гаргах өргөн хүрээний боломжтой нийтлэг ба иргэнлэг⁵ эрх зүйн тогтолцооны аль алинд шинэ төрлийн өмчийн эрх (property interest)-ийг бий болгох тал дээр төдийлөн таатай ханддаггүй. Бараг л бүх эрх зүйн системд тухайн орны хуулиар тогтоосноос илүү өөр төрлийн өмчийн эрхийн хэлбэр бий болгохгүй байх тал дээр харьцангуй хатуу байр суурьтай байдаг. Өмчийн эрхийн энэхүү онцлог шинжийг өмчийн эрхийг гагчхүү хуулиар бүтээх зарчим буюу "*numerus clausus principle*" гэнэ.

Энэхүү зарчим нь үндсэн хоёр аспектттай: Нэгдүгээрт, талуудын үүсгэж болох өмчийн эрхийн төрлийн тоо хязгаарлагдмал байна. Хоёрдугаарт, өмчийн эрхийн терөл тус бүрийн агууллыг талууд өөрчлен тогтоох боломжгүй байна. Энэ нь талууд өмчийн эрхийн агууллыг чөлөөтэй өөрчлен тогтоохыг зөвхөөрөхгүй харин энэ эрхийн агууллыг гагчхүү хуульд заасан тэр байдлаар л хэрэглэнэ гэсэн үг юм.

Numerous clauses зарчим нь нийтлэг ба иргэнлэг эрх зүйн системийн аль алинд байгаа талаар судлаачид дурддаг хэдий ч энэ нь өөр хоорондоо нийлээд ялгаатай. Иргэнлэг эрх зүйн тогтолцооны хувьд энэ зарчим ромын эрх зүйгээс үүдэн 19 дүгээр зууны үед германы өмчийн эрх зүйд онол болон хөлжсөн урт удаан хугацааны түүхтэй бол нийтлэг эрх зүйн системийн хувьд

харьцангуй сүүлд бий болсон гэж үздэг.⁶ Түүнчлэн энэ зарчим иргэнлэг эрх зүйд тухайн улс орны Иргэний хуульд тодорхой, ойлгомжтой туссан байдаг бол нийтлэг эрх зүйн орнуудын хувьд шуух засаглалын тогтоосон уян хатан хэм хэмжээгээр илрэн гарах бөгөөд тусгайлан хаа нэгтээ дурдагдаагүй байна.⁷ Монгол Улсын Иргэний хуулийн 103 дугаар зүйлд Өмчлөгчийн эрхийг гагчхүү хуулиар хязгаардана хэмээн заасан нь өмчлөх эрхийг хязгаарлах өмчийн эрхийн тогтсон хэлбэрүүдээс өөр хэлбэрэйг талууд тохиролцон бий болгох боломжгүй болохыг тодорхой илэрхийлсэн явдал юм.

Иргэнлэг эрх зүй ба нийтлэг эрх зүйн тогтолцооны дээрх зарчмын гурав дахь гол ялгааг энэхүү зарчмын дагуу тогтсон өмчийн эрхийн хэлбэрийн жагсаалтын хэмжээ буюу эрхийн хэлбэрийн тоо нь харилцан адилгүй байдаг явдал гэж үздэг. Иргэнлэг эрх зүйн системтэй орнуудын хувьд энэ жагсаалт маш богино Ромын эрх зүйгээс улбаатай 10 хүрэхгүй төрөл байдаг. Ийм эрхүүдэд өмчлөх эрх, дундын өмчийн эрх, цөөн тооны "*iura in re aliena*"⁸ эрх буюу эд хөрөнгийн хязгаарлагдмал эрхүүд (*lesser real right*)-ийг хамааруулна. Үл хөдлөх эд хөрөнгийн эрх гэдэгт "*emphytuses*"⁹ (урт хугацааны түрээсийн эрх), "*superficies*" (бусдын газар дээрх барилгыг өмчлөх эрх), "*usurfruct*" (бусдын эд юмсаас ашиг бий болгох зорилгоор өмчлөгчийн нэгэн адил ашиглах эрх), "*use*" (узурфрукттэй төсөөтэй боловч ялгаатай тал нь эрх эзэмшигч гагчхүү өөрийн хэрэгцээний

⁴ J. Micheal Milo, Property and Real Rights, in Elgar Encyclopedia of Comparative law 587-602 at 593. Bram Akkermans, The principle of Numerusclausus in European property law (2008) p19-80

⁵ Anna di Robilant, Property and Deliberation Numerusclausus principle, new property forms and new property values. 2010 at 98-104, Harvard Law Journal

⁶ Ромын эрх зүйгээс улбаатан өмчлөх эрхийн хязгаарлагдмал эрхүүд. Сервитут, узурфрукт гэж мат <http://www.oxfordreference.com/view/10.1093/oi/authority.2011.22312> дэлгэрүүлэн үзэх үү

⁷ Зохиогчийн тайлбар: энэ нь манай бусдын газар дээр барилга байгууламж барих эрхийн сонгодог хамбар байх боломжтой.

⁸ T.W. Merrill and H. E. Smith, optimal Standardization in the Law of Property: The NumerusClausus Principle' (2000-2001) 110. Yale LJ 1

⁹ Судлаач Ж. Оюунтунгагал тус нар томынг Харьцуулсан Иржиний эрх зүй номондоо хэрэглэсэн байна.

хэмжээгэр эд юмын үр шимийг хүртэх эрхтэй), "habitation" (орон байранд амьдрах эрх), "real servitudes" гэсэн эрхүүдийг ойлгодог байна.¹⁰ Ийнхүү аль хэдийн хүлээн зөвшөөрөгдсөн өмчийн эрхүүд нь харьцангуй тогтмол шинжтэй бөгөөд энэ төрлүүд дээр нэмж шинэ төрөл бий болгоход үнэхээр бэрхшээлтэй байдаг. Иргэнлэг эрх зүйн орнуудын хувьд шүүх шинэ төрлийн өмчийн эрхийг нэмэхгүй, харин маш цөөн тохиолдолд хууль тогтоомжоор шинэ төрөл бий болгох боломжтой.

Харин АНУ-ын хувьд өмчийн эрхийн цэс харьцангуй баялаг. Энхүү цэсэд үл хөдлөх эд хөрөнгийн эзэмшилийн үндсэн дөрвөн төрөл болох туйлын фий симпл эрх (fee simple absolute), дуусгавар болох нөхцөлтэй фий симпл эрх (defeasible fee simple), наасан түршид өмчлөх эрх (life estate), түрээсийн эрх, таван төрлийн давхцаамал буюу дундын ашиг сонирхол болох дундын өмчийн эрх (tenancy in common), хамтын өмчийн эрх (joint tenancy), гэрлэгсдийн өмчийн эрх (marital property), итгэмжлэн өмчлөх эрх (trusts), нийтийн орон сууцны өмчийн эрх (condominium), хоршооллын өмчийн эрх (cooperatives), улирлын чанартай өмчлөх эрх (time shares), эзэмшилийн бус ашиг сонирхлын дөрвөн үндсэн хэлбэр болох ийзмент (easements). Үр ашиг хүртэх эрх (profits), үл хөдлөх хөрөнгийн ковенант (real covenants), ижил тэнцүү сервитут (equitable servitudes) гэсэн төрлүүд багтаж байдаг.¹¹ Иргэнлэг эрх зүйн системтэй орнуудтай харьцуулбал өмчийн эрхийн энхүү баялаг төрлүүд харьцангуй хөдлөгөөнтэй байсан бөгөөд цаашид ч энэ хэвээрээ өөрчлөгдсөөр байх болно гэж судлаачид үздэг байна.

Харвардны Их Сургуулийн судлаач, эрдэмтэн Анна ди Робилант "Property and Deliberation. The Numerus Clausus"

¹⁰ Anna di Robilant, Property and Deliberation. Numerus clausus principle, new property forms and new property values. 2010, at 98-104. Harvard Law Journal

¹¹ Merrill & Smith, Optimal Standardization in the Law of Property: Numerusclausus principle, 110 Yale L.J. 1 (2000-2001) p12-17

Principle, New Property Forms and New Property Values" гэсэн бүтээлдээ иргэнлэг эрх зүйн тогтолцооны өмчийн эрхийг гагцхуу хуулиар бүтээх зарчим буюу "*Numerus clausus principle*" нь харгадж байгаа шигээ хувирч өөрчлөгдөшгүй хатуу зарчим биш бөгөөд түүхэн тодорхой тохиолдлуудад хэд хэдэн удаа хатуу, хаалттай байх шинжээ алдаж байнсыг нотопсон байна. Тэрээр "Ромын эрх зүйгээс улбаатай, тухайн үед л томъёологдсон байсан өмчийн эрхийн цөөн хэдэн хэлбэрүүд отг өөрчлөгдөхгүйгээр эх газрын системтэй орнууд хэрэглэсээр явваха нь хөдөлгүй үнэн зүйл биш юм. *Numerous clausus*-ийн зарчим 12-14 дүгээр зууны хооронд өмчийн эрхийн үзэл баримтлалыг шинэчлэн өмчлөх эрхийн элементүүдийг салгахыг оролдсон өөрчлөлт болох *Dominium divisum*¹² өмчийн эрхийн шинэ хэлбэрүүн үсслийн үед хоёр зууны түрш алдагдсан гэж үздэг. Гэвч энэ эрхийн төрлийг 15 дугаар зууны үед хассанаар *numerous calculus* зарчим дахин сэргэсэн" гэж тайлбарласан байна.

Түүний үргэлжлүүлэн тайлбарласнаар энэ зарчмыг зөрчиж шинаа хэлбэр байж болохыг хүлээн зөвшөөрсөн цөөнгүй шүүхийн шийдвэрүүдийг Францын болон бусад улс орны шүүхээс гаргаж байнсыг түүнчлэн Франц, Голланд зэрэг улсууд *emphytuses* хэмээх өмчийн хязгаарлагдмал эрхийг хууль тогтоомжоосоо хасах, буцаан суулгах арга хэмжээ авч байнсыг, мөн Франц, Герман зэрэг орнууд тухайн үеийн нийгмийн онцлог нөхцөл байдлаас шалтгаалан орон сууцны дундын өмчийн эрхийн шинэ хэлбэр болох *Anwartschaftsrechte* буюу "авах эрх" (acquisition right)-ийг шинээр бий болгон

¹² *Dominium divisum*дэгээ өмчлөх эрхийн элементүүдийг *dominium directum*буюу түрээсийн төлбөр эсхүл хувийн үйлчилгээ шаардлаг эрх бүхий нэг этгээд *dominium utilibus* буюу эд юмыг ашиглал эрх. Бусад шилжүүлэх эрх зэрэг олон эрхийн багыг түрээс төвлөх, үйлчилгээ үзүүлэх үргийн хамт эзэмшидэг негээ этгээдийн хооронд салган хуваврилахыг зөвшөөрсөн өмчийн эрхийн шинэ төрөл

хуульд суулгаж байсныг дурдсан нь сонирхол татаж байгаа юм.

2. *Solo Cedit* зарчмаас гажих өмчийн эрхийн төрөл

Эх газрын эрх зүйн системд бухэлд нь үйлчилдэг газрын бурдэл хэсэг нь түүний салшгүй хэсэг гэж тооцогдох *Superficies solo cedit* зарчмаас гажих дараах хоёр тохиолдол бий. Энэ төрлийн өмчийн хязгаарлагдмал эрх нь Азийн орнуудаас Япон, Солонгос, Тайланд зэрэг улсын Иргэний хуульд туссан байдгийн зэрэгцээ Европын эрх зүйн системд түгээмэл зохицуулагдсан эрх юм. Үүнд:

1. Европын ихэнх оронд "*in rem* барилгын түрээс" буюу *building lease* гэж нэрлэгддэг өмчийн хязгаарлагдмал эрх байдаг. Энэ нь газрын дээр буюу доор байгаа барилга, байгууламжийг газар өмчлөгчөөс тусдаа өмчлөх боломжийг эзэмшигчдээс олгож байдаг өмчийн хязгаарлагдмал эрх юм.

Европын холбооны орнуудад хийсэн судалгаанаас үзэвл хязгаарлагдмал эрхийн энэ төрлийн дор улс орон бүр агуулга нь тесеетэй боловч ялгаатай нэр бүхий эрхүүдийг ойлж байна. Тухайлбал Польшид урт хугацаат узурфрукт (*perpetual usufruct*)¹³, Шотланд болон Нидерландад урт хугацааны түрээс (*leasehold, long lease*)¹⁴, Германад *in rem* барилгын түрээс (*building lease*)¹⁵ гэх мэтээр нэрлэдэг байна. Ийм агуулга бүхий хязгаарлагдмал эрх нь Ромын эрх зүйд анх үүсэхдээс нэг этгээдийн газар дээр барьсан байшин нөгөө этгээдийн газар луу ялимгүй илүү гарсан тохиолдолд *solo cedit* зарчим үйлчлэхгүй байж тэрхүү илүү гарсан хэсэгт байшингийн үндсэн хэсгийг өмчлөг өмчлөх эрхтэй байхыг

зөвшөөрөх зорилготой байсан бөгөөд Ромын эрх зүйд энэ эрхийг *superficies* гэж нэрлэж байв. *Superficies* эрхээс гаралтайдээр дурдсан эрхүүд нь бусдын газрын дээр буюу доор баригдсан барилгыг аливаа хязгаарлалтгүйгээр бусад шилжүүлж, өв залгамжлуулж, барьцаалж, түүнчлэн газрын бүртгэлд бүртгүүлах боломжтой 20-99 жилийн хугацаагаар олгогддог эрх юм. Олон улс орны хувьд энэ эрхийг нийтийн эзэмшлийн газрыг болон ашгийн бус байгууллагаас нийгмийн сайн сийхны зорилгоор үнэ хямдтай барилга баруулах зориулалтаар бусад газар эзэмшүүлэхдээ хэрэглэдэг байна.¹⁶

Мөн Солонгосын Иргэний хуулийн 279 дүгээр зүйлд "Бусдын газар дээр баригдсан барилга болон байгууламжийг өмчлөх зорилгоор газрыг *in rem* байдлаар ашиглах эрхийг *superficies* эрх гэнэ гэж тодорхойлжээ.¹⁷ Энэхүү эрх нь удаан хугацаанд үргэлжлэх шинжтэй учир газар өмчлөгчид энэ эрхийн дагуу өмчлөх эрхээ хязгаарлуулах тал дээр таагүй хандаг. Солонгосын хувьд энэ эрхийг 15 жилээс багагүй, хэрэв эрх нь байшин барилгад үйлчилж байгаа бол 30 жилээс доошгүй хугацаатай байхаар хуульчилсан байна.¹⁸ Мөн тус улсын хуулийн дагуу өмнө нь нэг өмчлөгчтэй байсан байшин болон газар тус тусдаа өмчлөгчид шилжиж очсон бол хуулийн дагуу *superficies* эрх үүсэх талаар заажээ.

2. *Solo cedit* зарчмаас гажих дараагийн хууль зүйн боломж нь нийтийн зориулалттай орон сууцны барилгын өмчлөх эрх буюу *apartment ownership* эрх юм. Ихэнх тохиолдолд орон сууцны хорооллын дор байгаа газар болон орон сууцны нийтийн өмчлөлийн хэсэг нь дундын өмчид тооцогддог.

¹³ Supra note 13

¹⁴ Korea civil code, <http://www.moleg.go.kr/english/lawList> нээгүүдэд 2015 оны 04 сарын 01

¹⁵ Korean legislation research institute, Introduction to Korean law, 2012. Springer press, p. 131

¹⁶ European University Institute (EUI) Florence/European Private Law ForumDeutsches Notarinstitut (DNI) Würzburg. Real Property Law and Procedure in the European Union. 2005 05 31, al 21

¹⁷ Мен тэнд

¹⁸ Christian hertel, HartmutWicke, Real property law and procedure in the European union, National report, Germany, энэ эрхийн хурзэнд ертүүвээс – bail a construction/Erbbaurecht гэсэн эрхүүднэг ойлгодог байна.

Европын орнуудын үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн асуудлаар хийсэн судалгаанаас үзвэл энэ төрлийн өмчийн эрхийн дөрвөн үндсэн загвар¹⁹ байгааг анзаарч болно. Үнд:

- Нидерландын загвар – газар болон барилга бүхэлдээ хамтран өмчлөх дундын өмчид тооцогдох ба өмчлөг тус бүр өөрсдийн сууцыг ашиглах онцгой эрх эдэлдэг. Энэхүү ашиглах эрх нь өмчийн эрх буюу *in rem* эрх юм.

- Шотландын загвар – сууц өмчлөл газар өмчлөөс салангид байна. Өмчлөг тус бүр өөр өөрийн сууцаа өмчлөхийн зэрэгцээ барилгын нийтийн хэсэгт өөрийн өмчлөлийн тодорхой хувьтай байна. Газар бүх өмчлөгчийн хамтран өмчлөх дундын өмчид тооцогдоно. Хэрэв барилга галд шатах болон бусад байдлаар устаж угүй болж газрыг зарах бол үнийг бүх өмчлөгч тэнцүү хуваах авах архтэй.

- Скандинавианы орнуудад байх дараагийн загвар нь нийтийн зориулалттай орон сууцны барилгын өмчийн эрхэд компанийн эрх зүй үйлчлэх зарчмытай. Сууцны компани (*housing company*) нь энгийн хязгаарлагдам хариуцлагатай компани (Финлянд) эсхүл өмчлөгчдөөс бүрдсэн хамтын этгээд (Швед) байх бөгөөд газрыг барилгын хамт өмчилнэ. Сууц өмчлөгчид нь тогтоосон сууцыг ашиглах онцгой эрх олгосон хувь эзэмшигч этгээдүүд байна. Гэвч энэхүү хувь эзэмшигчийг нь *in rem* эрх тэж үздэггүй. Энэхүү эзэмшиж буй хувия хөдлөх хөрөнгийг захиран зарцуулгийн нэгэн адил шилжүүлэх боломжтой (Финлянд).

- Дараагийн загвар нь Белги, Франц, Герман, нийтлэг эрх зүйн тогтолцоотой улс болох Англи (2002)-д тархсан хамгийн түгээмэл загвар бөгөөд энэ загварын дагуу газар болон хана, дээвэр зэрэг барилгын үндсэн хэсгийг "ул хуваагдах" зарчмаар дундаа өмчлөх, сууцыг дангаар өмчлөх загвар юм.

¹⁹ Supra note 13, p 20

Сууц өмчлөгчийн хувьд өөрсдийн сууцыг бусад өмчлөгчдөөс хамааралгүйгээр өөрийн хүсэлзоригийн дагуу чөлөөтэй захиран зарцуулах боломжтойн зэрэгцээ бүх өмчлөгийд хүлээн зөвшөөрөх бол бусад этгээдэд газраа хязгаартай ашиглуулах, тэр ч байтугай барьцаалах боломжтой тэж үздэг.

Судалгааны ажлын үндсэн асуултад хариуцт өгөхийн тулд *notum erous clausus*-ийн зарчим болон Ромын эрх зүйгээс үүдэлтэй салшгүй эрх бурийн талаар нэг бурчлэн нүүршилгүйгээр манай улсын өмчийн эрх зүйн зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд дехөм болох үүднээс иргэнлэг эрх зүйн орнуудын Иргэний хуульд тусгагдсан онцлог төрлийн хязгаарлагдмал өмчийн эрх болох *superficies* буюу бусдын газар дээрх барилгыг өмчлөх эрх, нийтийн зориулалттай орон сууцын өмчлөх эрх буюу *apartment ownership* – ийн талаар дэлгэрүүлэн авч үзлээ.

Тус судалгааны ажлын хүрээнд *notum erous clausus* зарчмын талаар ийнхүү авч үзсэн шалтгаан нь Монгол Улсын Иргэний хуульд тухайлан зохицуулсан өмчийн эрхийн хэлбэрүүд өнөөдрийн практик шаардлагыг хангаж чадаж буй эсэх, хэрэв хангахгүй байна гэвэл түүний шалтгаан нь чухам юу болох, магадгүй хувийн өмчтэй байхыг хүлээн зөвшөөрөөд төдийлөн удаан хугацаа өнгөрөөгүй байгаа манай улсын хувьд эртний уламжлалтай өмчийн эрхийн төрлиүүдийг хуульчилсан ч тэдгээрийн мөн чанар, утга агуулгыг сайтар ойлгохгүй, хуулиа хэрэглэж чадахгүй байгаад асуудал байна уу гэдгийг ялгаж салгахыг зорьлоо.

3. Монгол Улсын Иргэний хууль дахь *solo credit* зарчим

Монгол Улсын Иргэний хуулийн 84.3 дахь хэсэгт заасны дагуу Газар түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж болох бүхий л эд юмс үл хөдлөх эд хөрөнгөнд хамаарна. Түүнчлэн зарим үл хөдлөх хөрөнгөнд үүссэн бусад эрхийг эрх зүйн хувьд үл

хедлөх хөрөнгөтэй эн тэнцүү хэмээн авч үзэх тохиолдол бий бөгөөд эдгээрийг үл хедлөх хөрөнгийн бүртгэлд тусгайлан тэмдэглэнэ.

Монгол Улсын Иргэний хуулийн 85.2 дахь хэсэгт “Түр зуурын хэрэгцээ хангах зорилгоор бус байнгын зориулалттай газартай салшгүй бэхлэгдсэн байшин, барилга, байгууламж болон бусад зүйл нь газрын үндсэн бурдэл хэсэг байна.” гэж заасан нь судлаачдын дунд баагүй маргаан дэгдээдэг. Өөрөөр хэлбэл газар болон түүн дээр баригдсан барилга байгууламжийн хувьд нэг л өмчлөг байх зарчмытай манай улсын хувьд газрын бүртгэл болон байшин, барилгын өмчлөх эрхийг тусад нь бүртгэдэг нь зөрчил үүсгэх болсон.

Өмнө хэсэгт дурдсанчлан үл хедлөх эд хөрөнгө нь газрын бурдэл хэсэг байх зарчмын “*solo cedit*” буюу хөрсөнд бэхлэгдсэн зүйл хөрсөнд харьялгадана гэсэн максим²⁰-аас үүдэлтэй. Монгол Улс энэхүү максимыг Иргэний хуулийн 85.2 дахь хэсэгт “байнгын зориулалттай, газартай салшгүй бэхлэгдсэн байшин, барилга бусад зүйлс нь газрын үндсэн бурдэл хэсэг байна” гэж томъёолнисноороо хуульчлан баталгаажуулсан.

Гэтэл энэ зохицуулалт нь газрын өмчлөх эрхийн үндсэн дүрмийг тогтоосон Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2 дахь хэсэгт заасан “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлэй, түнийн баялаг, ой усны нөөц, ан амьттан төрийн өмч байна” мөн Үндсэн хуулийн 6.3 дахь хэсгийн “Бэлчээр, нийтийн эзлэбэрийн ба тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэн өмчилне. Энэ нь газрын хэвлэлийг өмчлөхөд хамаарахгүй” гэсэн заалтуудтай зөрчилдэх байгаа мэт харагддаг. Гэвч нийтийн ашиг сонирхлын үүднээс нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр өмчлөх эрхийг хязгаарлах боломжтой

байх үзэл санааны үүднээс тайлбарлан зөрчил үүсгээгүй гэж үзэх боломжтой.

Түүнчлэн хуулийн зүйл, заалтын томъёоллыг бий болгоход зайлшгүй баримтлбал зохих нэгэн бичигдээгүй “дүрэм”-ийн дагуу төсөл боловсруулагч аливаа зохицуулалтын эхэн хэсэгт үндсэн дүрмийг тогтоон, түүнээс хойших хэсгүүдэд үндсэн дүрмээс гажих тусгай тохиолдуудыг дурддаг. Энэ үүднээс хөрсөнд бэхлэгдсэн зүйл хөрсөндөө үлдэх үндсэн зарчмыг Иргэний хуульд суулгахдаа тус дүрмээс гажсан онцгой зохицуулалтын дараа хоёрдугаарт тусгаж өгсөн нь төдийлэн зөв алхам байсангүй. Өөрөөр хэлбэл Иргэний хуулиар үл хедлөх эд хөрөнгө өмчлөгчийн өмчлөх эрхийн хүрээг тогтоохдоо 85.1 дэх хэсэг буюу “Устгах буюу зориулалтыг нь алдагдуулахгүй ээр салгаж үл болох бурдэл хэсэг нь хуульд заасан тохиолдолд иргэний эрх зүйн хариулцааны бие даасан объект болно.” Гэсэн нь *superficies solo cedit* зарчим бүхий 85.2 дахь хэсгээс гажсан онцгой тохиолдолд хэмээн тайлбарлах нь зүйд нийцнэ.

Салбарын хуулиудад газар хэмээх үндсэн ойлголтод багтаж явдаг салшгүй бурдэл хэсгүүдийн өмчлөх эрхийг хэрхэн томъёолсныг авч үзвэл: Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн Ойн тухай хуулийн 4.1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу ойн нөөц нь төрийн өмч мөн бөгөөд гагчхүү ард түмний мэдэлд байна” гэж Усны тухай хуулийн 4.1, 4.2 дахь хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны нөөц нь стратегийн үнэт баялаг мөн. Усны сан бүхий газрыг төрийн байгууллагын зохицуулалттайгаар нийтээр ашиглана.” Газрын хэвлэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлэлийн нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө мөн. Газрын хэвлэлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Газрын хэвлэлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг

²⁰ Ж.Оюунтунгалаг. Үл хедлөх эд хөрөнгөнд хамаарах газрын арх. 2012. Нийтийн болон хувийн өмчин эрийн түүн тулгамдсан асуудал сэгтүүл. 78 дахь тал.

хориглоно¹гэх мэтээр салбарын хуулиудад Үндсэн хуулийн еренхий дүрмийн дагуу зохицуулалтуудыг суулгаж өгсөн байна. Өөрөөр хэлбэл эдгээр бүрдэл хэсгүүд нь гагчүү терийн өмчлөлт байна гэдгийг аливаа хоёрдмог утгагүйгээр Үндсэн хуульд заасан тул энэ асуудлаар хуульд өөрөөр заах боломжгүй байжээ.

Харин газрын өөр нэгэн үндсэн бүрдэл хэсэг болох барилга байшингийн хувьд гол маргаан, онол практикийн зөрчил үүснэ. Энэ асуудлаар иргэний хэргийн давж заалдах шатны шүүгч, судлаач Ж.Оюунтунглагат:

"Барилга, байшин нь газраас тусдаа бүртгэлтэй байх тухай материаллаг хуулийн өөр заалт байхгүй байтал Эд хөрөнгө, өмчлөх эрх, түүнтэй холбоотой бусад эрхийн бүртгэлийн тухай хуулийн заалтуудаар газраас тусад нь барилга байшиг бүртгүүлэх боломжийг олгосон байна.²¹

Гэсэн нь Иргэний хуулийн 85.1, 85.2, эдгэрээс улбаалсан газрын эрхийн бүртгэлийн асуудлаар үсээд буй онол практикийн маргаанд өгсөн тун оновчтой хариулт болсон юм.

Дээрхээс дүгнэлт хийж үзвэл Монгол Улс ийнхүү хуульд тусгайлан заасан бол, тэр нь Үндсэн хуулийн 6 дугаар зүйлтэй нийцэж байгаа бол газрыг түүний үндсэн бүрдэл хэсээс тусад нь өмчлүүлж болох бурэн боломжтой эрх зүйн зохицуулалттай улс болох нь маргаангүй юм. Ийнхүү тайлбарлах нь ч үл хөдлөх эд хөрөнгө гэдэг нь газар, түүнээс салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс байна гэсэн Иргэний хуулийн 84.3 дахь хэсэгтэй бүрэн нийцэх юм

Нэгэнт үндсэн бүрдэл хэсгүүд тус тусдаа өмчлөгдж болох бол одоо энэ асуудлыг бүртгэлд хэрхэн тусгах вэ, барилга байшин өмчлөг болоод газар өмчлөгчийн хооронд үсэх харицааг

хэрхэн зохицуулах вэ гэсэн дараагийн асуудлууд ургаж гарал юм.

4. Монгол Улсын Иргэний хууль дахь өмчийн эрхийн төрөл, газрын хязгаарлагдмал эрхүүд

Тус тусдаа өмчлөгч бүхий газар ба үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг хэрхэн хөтлөх тухай асуудал нь онолын хувьд төдийлен ач холбогдолтой бус, материаллаг хуулиар асуудлыг нэг мөр зохицуулсны эцэст процессын зөв журмыг хэвшүүлэн тогтоо, бусад улс орны тэргүүн туршлагыг нэвтрүүлэх замаар шийдвэрлэх боломжтой гэж үзээд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн хоорондын харицааг зохицуулах тодруулбал, газар өмчлөгч болон түүний дээр болон доор орших барилга байгууламжийн өмчлөгч нь өөр өөр этгээд байгаа тохиолдолд *solo cedit* зарчим хэрхэн үйлчлэх, энэ дүрмээс гажих боломж бий эсэхийг тулхүү авч үзэхийг зорьж байгаа билээ.

Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн харицааг зохицуулах суурь эх сурвалж нь хууль тогтоомж, тухайн хууль тогтоомжийн хүрээнд талуудын хоорондын давтагдашгүй харицааг зохицуулах хэрэгсэл нь хэлцэл байх нь тодорхой.

Иргэний эрх зүйн үүднээс энгийнээр тайлбарлавал үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой Иргэний хуульд заасан төрөл бүрийн хэлцэл байгуулах боломжтой бөгөөд эдгээр хэлцлийг ерөнхийд нь үүргийн хэлцэл, өмчийн хэлцэл гэж ангилна. Илтгэлийн эхний хэсэгт авч үзсэн *Numerusclausus* зарчмын дагуу шинэ хэлбэрийг талууд зохио, бүтээх буюу хуульд заасан хязгаарлагдмал эрхээс бусад хэлбэрийг талууд тохиролцон бий болгох боломжгүй өмчийн эрхийн төрлийг хуулиар зөвшөөрсний дагуу үсгэж буй хэлцлийг өмчийн хэлцэл гэх бол гэрээний аливаа шинэ хэлбэрийг гарээтийн чөлөөтэй зохиох эд хөрөнгийг шилжүүлэх болон бусад эрх, үүрэг үсгэж буй хэлцлийг үүргийн

²¹ Ж.Оюунтунглагат, Үл хөдлөх эд хөрөнгөнд хамаарах газрын эрх. 2012. Нийтийн болон хувийн өмчийн эрх зүйн тулгамдсан асуудал сэргүүл. 81 дах тал.

хэлцэл гэж ойлгоно. Эд юмын эрх зүйн харилцаанд аливаа тохиролцоо нь зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн агуулгатай байх ёстай. Өөрөөр хэлбэл эд юмын эрх зүйн харилцаанд зөвхөн хуульд тусгасан хэлбэрүүд л зөвшөөрөгднө. Монгол Улсын Иргэний хуулийн 103 дугаар зүйлд “Өмчлөгчийн эрхийг гагчхуу хуульд заасан үндэслэлээр хязгаарлана” гэж заасан нь *Numerusclausus* зарчмын тод илрэл юм.

Тэгвэл Монгол Улсын Иргэний хуульд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчдийн нэг нь негеэгийн өмчийг зэмших, ашиглах боломж олгосон өмчийн хязгаарлагдмал эрхийн цэсийг дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

1. Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх – Өмчийн эрх/хэлцэл

2. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах эрх буюу сервитут – Өмчийн эрх/хэлцэл

3. Бусдын эд хөрөнгийг хязгаартай зэмших, ашиглах эрх буюу узурфрукт – Өмчин эрх/хэлцэл

Харин дээрхээс гадна өмчлөгчид үл хөдлөх эд хөрөнгөө зэмших, ашиглах эрхээ шилжүүлэхдээ ургийн эрх зүйн хэлцлүүдийг ашиглах боломжтой бөгөөд энэ нь Иргэний хуульд эд хөрөнгө хөлслөх гэрээ, түрээсийн гэрээ зэрэг хэлбэрээр зохицуулагдсан байdag. Ургийн эрх зүйн энххуу хэлцлүүдийг хязгаарлагдмал эрх гэж уззхгүй.

Эд юмын бүрэн эрх болох өмчлөх эрхээс гадна эд юмын хязгаарлагдмал эрхийн талаар Иргэний хуулийн 87.2 дахь хэсэгт “Илуу өргөн хүрээтэй эрхээс уламжлагдсан, тухайн эрхээр хязгаарлагдсан эрхийг хязгаарлагдмал эрх гэнэ” гэж тодорхойлсон байна. Өмчлөг нь эд хөрөнгийнхөө өмчлөх өөрийн бүрэн эрхийн тодорхой хэсгийг өөр этгээдэд шилжүүлж болно.

Эрхээс хэрэгжүүлэх зорилгоор бусдын өмчлөх эрхийг хязгаарлах эрх буюу хязгаарлагдмал эрхийн нэг төрөл нь барьцааны эрх мөн боловч

энэ илтгэлийн хүрээнд харилцаан нөлөөлөл бүхий үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчдийн харилцааг хөндөж, энэ төрлийн харилцааг зохицуулах хууль зүйн арга хэрэгслийн тухай авч үзүүхийг зорж буй толготек буюу үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрхийн асуудал нь хэдий сонирхолтой ч энэ удаагийн судалгааны ажлын судлах зүйлд хамаарахгүй.

- Монгол Улсын Иргэний хууль дахь Бусдын газар дээр барилга байгууламж барих эрх

Барилга байгууламж барих эрхийн хэлцэл болон үүргийн хэлцлийн хоорондын ялгаа заагийг үл хөдлөх эд хөрөнгийн хувьд ойлгомжтой тайлбарлахын тулд дараах жишээ²² авьяя.

А нь Улаанбаатар хотод Туул голын оройролцоо нэгэн сайхан газрын өмчлөгч. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд ч гэсэн өмчлөгчийн хувьд бүртгүүлсэн. Тэр газраа тэрээр харин ашигладаггүй. Түүний найз А-аасаа газар дээр нь байшин барьж болох эсэхийг асуухад А нь зөвшөөрчээ.

Энэхүү харилцааг талууд ямар гэрээ байгуулж хууль зүйн хувьд баталгаажуулах боломжтой вэ?

Нэгдүгээр шийдэл: Үүргийн эрх зүйн гэрээ байгуулах (турээсийн, эсхүл эд хөрөнгө хөлслөх гэрээ)

А нь Б-тэй газар дээр нь байшин барьж болнигэж Б-д зөвшөөрснүүтгатай гэрээ байгуулж болоюм. Ихэнхдээ энэ төрлийн гэрээ нь эд хөрөнгө хөлслөх гэрээ байdag. Учир нь А нь Б-д тодорхой хугацаагаар зэмшлээ шилжүүлж байгаа. Тийм учраас энэ төрлийн гэрээнд гол төлөв эд хөрөнгө хөлслөх гэрээний зохицуулалт үйлчилнэ. А ба Б-ийн хооронд байгуулагдсан ургийн эрхийн гэрээгээр Б тэр газрыг амьд байх хугацааны туршид ашиглахаар тохирчээ. 12 жилийн дараа А-гийн

²² GTZ, Монгол улсын шинэ иргэний эрх зүй, 2003 он, 67-85 дугаар тал

хүүхдүүд газар дээрээ өөрсдөө байшин барихаар шийджээ.

А Б-тэй байгуулсан гэрээгээ цуцалж чадах уу? – Иргэний хуулийн 293.2, 320.3

Гэрээ 10-аас дээш жилээр байгуулагдсан байх тул 10 дахь жил өнгөрмөгц А гэрээгээ цуцалж болно. Тэгсэн тохиолдолд Б тэр газрыг сулжах өгөх үүрэгтэй болно. Тэгэхээр үүргийн эрхийн гэрээ Б-ийн хүслийг бүрэн хангаж чадахгүй юм байна.

Хоёрдугаар шийдэл: Иргэний хуулийн 150 дугаар зүйлд заасан бусдын газар дээр барилга байгууламж барих эрх буюу өмчийн эрхийн гэрээ

Үүргийн эрхийн эд хөрөнгө хөлслөх гэрээний оронд А болон Б нар эд юмын эрхийн барилга, байгууламж барих эрхийг тохиролцож болох юм. Үүний тулд талууд ийм тохиролцоонос гадна 150.17-д заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд А-ийн газар дээр энэхүү эрхийг тохирсон болохыг тэмдэглүүлнэ. Ингэсний дараа л тохиролцоо хүчин төгөлдөр болно. Түүнчлэн энэ эрхийг эзэмшигч уг эрхээ гуравдагч өтгээдэд өвлүүлэх, барьцаалах, худалдах бүрэн эрхтэй бөгөөд 99 хуртал жилийн хугацаатай байгуулж, хугацаанаасаа өмнө гэрээ нэг талын санаачилгаар цүцлэгдэх явдлаас сайтар хамгаалагдсан байдаг.

Энэхүү жишээнээс Монгол Улсын Иргэний хууль дахь үүргийн эрхийн гэрээ, өмчийн гэрээний хууль зүйн үндсэн ялгаа харагдаж байна.

Манай улсын хувьд одоо нэгэнт үүсээд буй нэхцел байдал бол газар өмчлөгчийн зөвшөөрлийн үндсэн дээр түүний өмчлөх эрхийг хязгаарлан түүний газар дээр барилга байгууламж барихтай холбоотой харилцааг бус харин орон зайн хувьд хамааралтай хэдий ч цаг хугацааны хувьд өөр өөр үед, хэн нэгнийжээ өмчлөх эрхийг хязгаарласан хязгаарлагдмал эрхээс хамааралгүйгээр үүссэн хоёр төрлийн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн хоорондын харилцааг, тодруулбал манай иргэний эрх зүйн

шинэтгэл, бүртгэлийн тогтолцоо болоод хувьчалын бодлогын уялдаа холбоогүйгээс үүдэн байшин өмчлөх эрх нь 2010 (хийсвэр он) онд үүссэн байхад газар өмчлөх эрх нь төрд байгаа, эсхүл 2012 (хийсвэр он) онд өөр хэн нэгэнд аливаа хязгаарлалтгүй шилжин очсон хоёр өмчлөгчийн тухай харилцаа яригдаж байгаа билээ.

Тэгвэл энэ харилцаанд бусдын газар дээр барилга байгууламж барих эрх зохицуулалт болж чадах уу

Үгүй.

Учир нь 2010 онд аливаа хязгаарлалтгүйгээр байшин өмчлөх эрхтэй болсон А-ийн эрхийг Иргэний хуулийн 150 дугаар зүйлээр шууд хязгаарлагдмал эрхтэй хэмээн тайлбарлах нь өмчлөгчийн эрхийг ноцтой зөрчсөн хэлбэр болно. Иргэний хуулийн 150.9-д “Хууль буюу гарзэнд өөрөөр заагаагүй бол барилга байгууламж барих зориулалтаар олгосон газар эзэмшигээс эрх дуусгавар болоход газар өмчлөгч нь тухайн барилга байгууламжийн үнийг уг эрхийг эзэмшиж байгаа этгээдэд нөхөн төлөх үүрэгтэй.” гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл уг эрхийн хугацаа дуусгавар болмогж үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх, уг эрх дэх өмчлөх эрхээ дуусгавар болгох үр дагавартай.

Гаднын улс орнуудад орчин үеийн дундаж орлоготой иргэдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд төр өөрийн газарт орон сууцны барилга, хороолол барихад дэмжлэг үзүүлэх, газрын төлбэрийн үнийг тогтвортой доогуур байлагх замаар газар дамлан худалдах, үнийг хөөрөгдхөж асуудлыг зохицуулахад энэ эрхийг түлхүү хэрэглэдэг байна.²³

• Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч өөр нэгэн үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн эрхийг хязгаарлах буюу сервитут

Харин сервитут гэдэг нь хоёр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчийн хооронд үүсэх харилцаа байна. Бусдын

²³ 1180-р тал, Beck'sche Kurz Kommentare-Palatini Buergerliches, Verlag C.H. Beck, Muenchen, 1998.

эзэмшилд байгаа эд юмсыг өөрийн эд хөрөнгийнэрхийг хэрэгжүүлэх зорилгоор тэргүүн зэлжид хязгаартайгаар ашиглах эрхийг сервитут гээ бөгөөд энэ төрлийн сервитутыг идэвхтэй сервитут гэдэг. Сервитутын өөр нэгэн төрөл нь идэвхгүй сервитут юм. Өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийнх нь эрх хууль ёсны ашиг сонирхолд харшилсан үйл ажиллагаа явуулахгүй байхыг бусад өмчлөгчдөд даалгасныг идэвхгүй сервитут гэнэ.

Агууллын хувьд сервитут нь дараах байдлаар илрэч болно. Үүнд:

- ✓ Сервитут тогтоосон газар дээгүүр явах;
- ✓ Сервитут тогтоосон газраас элс, чулуу, ус, эрдэс баялгийг авах;
- ✓ Сервитут тогтоосон газар буюу "үйлчлэгч" газар (сервитутын харилцаанд "үйлчлэгч" ба "ноёлогч" гэсэн үл хөдлөх эд хөрөнгүүд оролцоно) нь эзэмшиг нь сервитутын эрхтэй этгээдийн газар буюу "ноёлогч" газраас гарч байгаа дуу чимээ, хий тоос, шороо зэргээр нөлөөлэхийг эсэргүүцэхгүй байж, тэвчихээр тохиролцож бүртгэлд бүртгүүлнэ. Эдгээр нь сервитут тохирч болох маш олон тохиолдлын цөөн хэдэн жишээ юм.²⁴
- Бусдын эд хөрөнгийг хязгаартай эзэмших, ашиглах эрх буюу түрэлфрукт

Бусдын эд хөрөнгийг үр шимиийг нь хүртэх, ашиг олох зорилгоор хязгаартай эзэмшиж, ашиглах эрхийг узурфрукт гэнэ. Энэ нь өнгөт анзаарагад мөн л үүргийн эрх зүйн түрэсийн болон эд хөрөнгийг хөлслөх гэрээтэй ихээхэн төсөөтэй харагдана. Энэ тохиолдолд мөн л бусдын газар дээр барилга байгууламж барих эрхийн жишээнд яригдаж байсан үүргийн гэрээний төдийлэн хамгаалалт сайтай бус сул тал байсаар байна. Харин узурфрукт нь хязгаарлагдмал өмчийн эрх учир тухайн узурфрукт тогтоосон эд хөрөнгийн хувьд узурфрукт тогтоосон хугацаагаар хадагдан үлддэг.

Узурфруктын сервитутаас

ялгагдах тал нь нэгдүгээрт эрхийн зүйл болох эд хөрөнгө, мөн хязгаарлагдмал эрх тогтоох шалтгаан, цар хүрээгээр ялгагддаг. Узурфруктын үед хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгөнд, үр шим ашигийг хүртэх зорилгоор бухээлд нь хязгаарлагдмал эрх тогтоодог бол сервитутын үед гагцхүү үл хөдлөх эд хөрөнгөнд өөр нэг үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч тодорхой ганц зорилгоор хязгаарлагдмал эрх тогтоодог. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх: Түрэсийн гэрээ

Нэг талаас түрэзслүүлэгч тодорхой хөрөнгийг хөдлөх аж ахуйн болон аж ахуйн зориулалтаар нөгөө талын ашиглалтад шилжүүлж, гэрээний хугацааны турш үр шимиийг хүртэх боломж олгохоор амласан, нөгөө талаас түрэзслэгч тохирсон хөлсийг төлөхөөн үүргэг хүлээх буй хоёр талын гэрээг түрэсийн гэрээ гэнэ.

Түрэсийн гэрээний хувьд хөрөнгийг ашиглахаас гадна түүний үр шимиийг хүртэх асуудал тэргүүн зэлжид тавигддаг.²⁵ Тиймээс энэ гэрээний зүйл нь Иргэний хуулийн 88 дугаар зүйлд заасан үр шим бий болгох бололцоо бүхий биет болон биет бус хөрөнгө байна. Гэсэн хэдий ч түрэсийн гэрээ нь өмчийн эрхийн төрөл бус үүргийн эрх зүйн хэлцэл буюу *in personam* эрх учир өмчийн эрхээр эд хөрөнгийг эзэмшихээс олон талын дутагдал бий. Тухайлбал түрэсийн гэрээ 10 жилээс дээш хугацаагаар байгуулагдсан бол ИХ-ийн 320.2 дахь хэсэгт заасны дагуу түрэсийн жил дуусгавар болсноос хойш 1 жилийн дараа цуцлах боломжтой.

5. Дүгнэлт буюу Монгол Улсын үл хөдлөх эд хөрөнгийн эрх зүйн тулгамдсан асуудалд хариулт зэрэхийлэх нь

Өмчлөх эрх болон өмчийн хязгаарлагдмал эрхийн төрлүүдийг ийнхүү нарийвчлан авч узсэн гол шалтгаан нь газар болон бусад үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой

²⁴ GTZ Монгол Улсын шинэ иргэний эрх зүй. УБ, 2003 он, 99 дэх тал

²⁵ Дам ишлээ Б.Бүйнхишиг, Иргэний эрх зүйн тусгай аяги, Улаанбаатар, 2011 он, 279 дэх тал.

дараах хэд хэдэн асуудлууд судлаач, мэргэжилтнүүдийн дунд байнга яригдах болсныг анаарц эдгэр асуудлудад хууль зүйн үүднээс тэр дундаа өмчийн эрх зүйн үүднээс хариулт эрэлхийлэх явдал байлаа. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон бусад хуульд заасан болзол, журмаар ашиглаулж болно" гэж заасан. Өнгөрсөн хугацаанд Газрын тухай хуулийн төслийн боловсруулалт болон салбарын мэргэжилтнүүдийн хэлэлцүүлгийн шатанд голлон өрнөж, маргааны сэдэв болиж байсан хэд хэдэн үндсэн асуудлын нэг нь Үндсэн хуулийн дээрх үзэл санааг органик хуульд хэрхэн оновчтой нарийвчлан зохицуулах тухай асуудал байлаа. Газрыг эзэмшүүлэхгүйгээр ашиглаулж болох эсэх, хэрэв тийм боломж байгаа бол иргэний эрх зүйн хэлцлийн ямар хэлбэрээр хэрэгжих, газрыг эзэмшүүлэхгүйгээр ашиглаудаа боломжгүй бол хуулийн төсөлд Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтыг хэрхэн оновчтой томъёолох

2. Орон сууцны барилгын сууц өмчлөгчдөд тухайн сууцны барилын орших газарт өмчийн ямар эрхтэй байх

3. Газрын өмчлөх эрхийн бүртгэл хийгдэхээс өмнө бусад этгээдэд өмчлөх эрх нь шилжсэн барилга байгууламжийн өмчийн эрхийн эрх зүйн үндсийг хэрхэн тодорхойлох

Монгол Улсын Иргэний хуулиар тогтоосон үл хөдлөх эд хөрөнгийг, тэр дундаа газрыг бусдын эзэмшил ашиглалтад шилжүүлэх хэлцлийн төрлүүдийг тодорхой дурдсаныг өмнөх хэсгүүдээр авч үзсэн. Өмчийн ба үүргийн эрх зүйн эдгээр хэлцлүүдэд дүн шинжилгээ хийж үзвэл хэн нэгний эзэмшилд шилжүүлэхгүйгээр дан ганц ашиглалтад шилжүүлэх нь өөрөө боломжгүй зүйл болох нь анаарагдана. Учир нь эзэмшил хэмээх ойлголт нь иргэний эрх зүйн шинжлэх ухаанд өмчлөх эрхийн илрэн

гарах хэлбэр гуравдагч этгээдэд өмчийн эрхийн талаар мэдээлэл өгөх зорилготой факт юм. Иймд эзэмшлийг эрхийн хандлагаар бус илүүтэй болит байдлын хандлагаар тодорхойлдог бөгөөд эзэмшилд шилжүүлэхгүй зөвхөн ашиглах эрхэд шилжүүлнэ гэсэн ойлголт байж нь боломжгүй зүйл юм.

Нийтлэг эрх зүйн оруулад өмчийн эрхийн төрлүүдийг эзэмшлийн ба эзэмшийн бус хэмээн ангилдаг бөгөөд тус ангиллын дагуу иймент²⁶, үр ашиг хүртэх эрх (profits), зөвшөөрлөөр нэвтрэх эрх²⁷, ковенант зэрэг эрхүүдийг хамааруулдаг. Гэвч нийтлэг эрх зүйн болон иргэнлэг эрх зүйн өмчийн эрхийн түүхэн хөгжил, эрх зүйн тогтолцооны ялгаанаас улбаалан эдгээр эрхүүдтэй төсөөтэй эрхүүд аль хэдийн манай улсын эрх зүйд бие дааж эсхүл тусгаар байдлаар өөр өөрийн хэлбэр, тэрхөөр сусун байдаг.

Түүнчлэн эзэмшлийг бодит факт гэж үзвэл Монгол Улсын Иргэний хуулийн 151 дүгээр зүйлд заасан өмчийн хязгаарлагдмал эрх болох сервитут эзэмшлийн бус эрхэд тооцогдох үндэслэлтэй. Гэсэн хэдий ч Үндсэн хуулийн 6.5 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор сервитутын эрхийг ашиглах боломжгүй юм. Иймд Үндсэн хуулийн энэхүү заалтыг "эзэмшүүлэхгүйгээр ашиглаулна" гэж тайлбарлах нь оновчгүй болно. Харин үүний оронд Иргэний хуулиар олгогдсон газрыг бусад шилжүүлэх өмчийн эрхийн төрлүүдээс гадаадын иргээдэд эзэмшүүлэхэд тохиорох хэлбэрийг сонгох, эсхүл гагчхүү үүргийн хэлцлээр шилжүүлдэг байхаар заах нь зүйтэй

²⁶ Зохиочний тайлбар: энэ нь иргэнлэг эрх зүйн оруулын сервитуттай төсөөтэй өмчийн эрх

²⁷ Н.Баярмаа. Нийтлэг эрх зүй дэх газар ба түүнтэй холбоотой ашиг сонирхлууд, судалганы ажил, 2015 он. Энэ төрлийн эрхээр газрын эрхийг бусад шилжүүлэх бус харин бусдын газар дээр тодорхон үйл ажиллагаа эрхийн эзэвшилжээ. Жишээ нь ан хийх, загасчах, эсхүл бусдын газар дээр түүр байж таарах эзгийг зөвшөөрлөөр бусдын газрыг ашиглах эрхийн дагуу хийж болно. Зөвшөөрлөөр ашиглах эрх нь газрын ашиг сонирхол гэж тооцогдохгүй тул түүнийн амард байгуулж болно. Хэрэв талууд ниймлэгээр энэ нь ниймлэгт бус зөвшөөрөл

Хоёр дахь асуудлын хувьд манайд үүсээд буй дээрх зөрчилтэй байдлын үндсэн шалтгаан нь эдгээр нөхцөл байдалд тохирсон өмчийн эрхийн төрлийг материаллаг хуульд суулгаж өгөөгүйтэй холбоотой. Тодруулбал манай улсын Иргэний хуульд нийтийн зориулалттай орон сууцны барилгын сууц өмчлөгчдийн өмчийн эрх (apartment ownership)-ийн төрлийг холбогдох хуульд бүрэн төсөг хүлээн зөвшөөрч сууц өмчлөгчдийн газрын эрхийг баталгаажуулах цогц зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Ийнхүү зохицуулах боломж Иргэний хуулийн 85.1 дэх хэсгээр бүрэн нээлттэй байний. Үүний тулд илтгэлийн өмнөх хэсэгт дурдсан Apartmentownership-ийн Европын орнуудын загваруудаас тохиорох загварыг ашиглах боломжтой. Энэ нь манай одоогийн зохицуулалт болоод Иргэний хуультай зөрчилдөхгүй.

Гуравдугаар асуудлын хувьд бусдын газар дээр барилга байгууламж барих эрх шийдэл болж чадахгүй байна. Иймд мөн л эх газрын эрх зүйн системтэй орнуудын хувьд өмчийн эрхийн нийтлэг төрөл болох Ромын эрх зүйгээс улбаатай бусдын газар дээр байгаа барилгыг газраас нь тусдаа өмчлөх эрхийг илэрхийлдэг *Surfaces* эрхийн зохицуулалтыг нэмж хэрэглэх нь зүйтэй байж болох юм.

Хэдийгээр "punctusclausus"-ийн зарчим өмчийн цэсэд өөрчлөлт оруулахгүй байхыг шаарддаг хэдий ч өмчийн эрхийн төрлийг зайлшгүй тохиолдолд хуулиар нэмж, өөрчилж түүнчлэн хасаж байсан түүхэн тохиолдлууд нийтлэг эрх зүйн орнуудад ч үеөнгүй тохиолдож байсан.

---ооо---

НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮНД ОНОГДУУЛСАН ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ АСУУДАЛ



**ХСИС-ийн Шүүхийн шийдвэр
гүйцэтгэлийн сургуулийн захираг, хувь
зүйн доктор (Ph.D), дэд профессор,
хурандаа Н.Гантулга**

**ХСИС-ийн Ахлагчийн сургуулийн ахлах
багш, хууль зүйн магистр, (LL.M), хошууч
Н.Батдорж**

Хурааныгүй

Эрдэм шинжилгээний энэ нийтлэлд Монгол Улсын Засгийн газраас санаачлан энэ цаг үед Улсын их хурлаар хэлэлцэж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуудийн шинжилсэн найрууллын төсөл дэх насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх журмыг¹ Үндэсний хууль тогтоомжийн түүхэн уламжлал, хүчин төгөлдөр үйлчилж буй хэм хэмжээ, ОХУ, Казахстан улсын Ял эдлүүлэх хууль, олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалттай харьцуулж судлаачийн байр сууринт илэрхийлсэн.

Түүхүүр 12

Насанд хүрээгүй хүн, ялтан, хоригдол, хорих ял, хүмүүжил-хөдөлмөрийн колони, хорих байгууллага /ангиг/, сургалт-

хүмүүжлийн тусгай байгууллага, түр. удаан хугацааны уулзалт, чөлөө зэрэг.

Бүтэц

Удиртгал, турван дэд хэсэг², судлаачийн дүгнүүлэлт-саналаас бүрдэн.

Удиртгал

Хүүхдийн эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах, баталгаатай эдлэх орчин нехцэдийг бүрдүүлэх, гэмт явдлаас урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчил гаргасан, түүний золиос болсон, халдлагад өртсөн тохиолдолд “тусгай журам”-аар хянан шийдвэрлэх, хариушлага хүлээлгэх явдал үндэсний төднүүгүй олон улсын эрх зүйн шинжлэх ухаан, эрх зүйн зохицуулалтын чухал объект³ болон төлөвшин хөгжжий байна.

Мөн монгол төрийн энэ асуудлаарх болдого жилээс жилд дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариушлагатай улдан тодорхойлогдож, зохицуулалт нь нарийвчлаждаг, салбарын үзэсгийн

¹-р дэд хэсэг “Үндэсний эрх зүйн зохицуулалтын түүхэн уламжлал, өнөөгийн байдал”. 2-р дэд хэсэг “Олон улсын гарзаний болон ОХУ, Казахстан Улсын Ял эдлүүлэх куулмын холбогдох зохицуулалтын онцлог”. 3-р дэд хэсэг “Хуулийн шинжилсэн найрууллын төсөл дахь зохицуулалт”

² Цаашид “насанд хүрээгүй хүн” гэх.

³ Манай ороодч өнөөдөр энэ карилцааг Монгол Улсын Үндэснэ хууль, Гар булийн тухай, Хуудасын эрхийг хамгаалах тухай, Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Мэргэжлийн боловсролын тухай, Эрүүгийн байцаан шийтгэх зэрэг хууль, ногдсан орсон, сөбрөг баталсан Монгол Улсын олон улсын гарз (койн нарийвчлан дурьдах болно) болон тадгээрт нийцүүлж гаргасан эрх бусад актаар зохицуулж байна. Мен энэ асуудал Үндэснэ хуулийн эрх зүй, эсрэг булийн эрх зүй нийгмийн хамгааллын эрх зүй, захиргааны процессын, эрүүгийн эрх зүй, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, криминологийн криминалистик, шүүх сэргээх зүй, эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй, эрх зүйн харьцуулсаар судалж, олон улсын нийтийн эрх зүй зорг шинжлэх ухааны салбар, салбар дундын судалганы объект болно.

¹ УИХ-ын Хууль зүйн байнгын хороо 2015 оны 05-р сарын 13-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинжилсэн найрууллын төслийг хэлэлцэн УИХ-ын чуулганы ногдсан хуралдаанд оруулахаар шийдвэрлэсэн. //www.gonews.mn/“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг хэлэлцэхийн дэмжжв”-2015 оны 5-р сарын 25-ны өдрийн хандалт.

мэргэшсэн судлаач эрдэмтэд⁵, мэргэжилтнүүд⁶ олширч байгааг тэмдэглэх ёстай.

Хүүхдийн эрх шинжлэх ухааны судалгаа, зохицуулалтын олон талтай, өргөн хүрээтэй объект учраас нийтлэлийн хүрээнд гагцхүү насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ял здлүүлэх

1. Үндэсний хууль тогтоомжийн түүхэн уламжлал, ёнөөгийн байдал,

2. Олон улсын эрх зүйн болон гадаад зарим орон /ОХУ, Казахстан Улс-/ны зохицуулалт,

3. УИХ-аар хэлэлцэж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинжилсэн найруулгын төсөл дэх журмын онцлогийг тодотгон судлаачийн байр суурийг илрхийллээ.

I

Манай орны хувьд насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ял здлүүлэх эрх зүйн зохицуулалт салбарын хуульд 1966-1993 онд нийтлэг хэм хэмжээ болон бие даасан “бүлэг”-ийн⁷, харин 1994 оноос нийтлэг, тусгай хэм хэмжээний нэрлэгдэж байна⁸.

1. Насанд хүрээгүй ялтан /хоригдол/-ы эрх, үүрэг, урамшуулал.

⁵ ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академийн Б.Болдбаатар (Насанд хүрээгүй хүмүүсийн ўйдэж буй углын гэмт хэрэг, М. 2004). ЦААмгаланбаатар (Насанд хүрээгүй хүмүүсийн ўйдэж буй гэмт харгийн талаарх азүүгийн бодлого), МУСД-т тушиглан Байгуулсан хууль зүйн салбарын докторын зэрэг хамгаалуулсан зөвлөлд Д.Бадам (Насанд хүрээгүй хид оногдуулсан онцлог, түүний эргүүгийн эрх зүйн идэсийн асуудал /хорих явлын жишээн дээр/ УБ, 2013). ОХУ-ын ДЯЯ-ны Москвагийн их сургууль Ю.Бадамчанд (Насанд хүрээгүй хүмүүсинг гэмт хандлагыга хамгаалалт химинологийн асуудал“ М. 2013 он) нар доктор (Ph.D)-ын зэрэг хамгаалсан.

⁶ Хүхэдийн байцааг, нийтийн ажилтан, мэргэшсэн өмгөөгөө, хэрэг бүртгэг, мөрдэн байцаагч, прокурор, шүүгч иргэнт бий болсон, зарим ний бий болох, төлөвшүү практик тогтжээ.

⁷ БНМАУ-ын Зассан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1966 оны хуулийн 9-р зүйл. 11-р зүйл, 14-р зүйл, 20-р зүйл, 21-р зүйл, 22-р зүйл, 5-р бүлэг/Хүмүүжил-хөдөлмөрийн колони/ийн 33-37-р зүйл, мөн хуулийн 53-р зүйл, 54-р зүйл, 55-р зүйл, БНМАУ-ын Зассан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1982 оны хуулийн 11-р зүйл, 17-р зүйл, 23-р зүйл, 27-р зүйл, 31-р зүйл, 33-р зүйл, 36-р зүйл, 37-р зүйл, 38-р зүйл, 49-р зүйл, 51-р зүйл, 53-р зүйл, 54-р зүйл, 13-р бүлэг/Хүмүүжил-хөдөлмөрийн колони/ийн 70-74-р зүйл, мөн хуулийн 106-р зүйл, 113-р зүйл, 115-р зүйл, 116-р зүйл.

⁸ Энэ нь нэр томъёоны төдийгүй мөн чанвар-чиг үүргийн хувьд ялгавтад байгууллага болно.

сахильтын шийтгэлтэй холбогдсон харилцаа салбарын хуульд бусад ялтантай нийтгэгдэн нийтлэг хэм хэмжээний түвшинд журамлагдаж байсны зэрэгцээ Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1966 оны хуульд “хоригддог байгаа нөхцөлийг өөрчлөх” тусгай зохицуулалтыг зөвхөн насанд хүрээгүй ялтанд урамшууллын журмаар нэмж“хэрэглэхээр тусгасан.

Мөн 1966 оны хуульд үлгэр жишиээчээр засарч хүмүүжиж, хөдөлмөрт үзүүч шударгаар хандаж байгаа насанд хүрээгүй хоригдолд урамшууллын журмаар сард нигудаа тур, удаан хугацааны уулзалтын аль нэгийг, мөн эргэлт ildгээлт авахыг⁹. Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1982 оны хуульд дээрх зан төлөв болон ялын тодорхой хувийг эдэлсэн тохиолдолд хүнсний бүтээгдхүүн, нэн тэргүүний хэргизээт зүйл худалдан авах мөнгө нэмж зарцуулах, тур хугацааны нэмэгдэл уулзалт хийхийг зөвшөөрсэн зохицуулалт¹⁰ байсан. Насанд хүрээгүй ялтан /хоригдол/-ыг салбарын 1966 оны хуулийн дагуу хүмүүжил-хөдөлмөрийн жирийн дэглэмтэй колонид, онц аюултай гэмт хэрэг үйлдэгсдийг дээрх дэглэмийн дотор чангалсан салбарт, 1982 оны хуулийн дагуу хүмүүжил-хөдөлмөрийн колонийн, 2002 оны хуулийн дагуу насанд хүрээгүйчүүдийн хорих ангийн жирийн, чанга дэглэмд тусгаарлан ял здлүүлж байна. Хүмүүжил-хөдөлмөрийн колонийн захиргаа 1982 оны 7-р сарын 01 хүртэл хугацаанд Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссийт зөвшилцөн уламжилж шүүх магадлал гарган, харин энэ үес 1994 оны 01-р сарын 01 хүртэл хугацаанд колонийн дарга Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх комиссийт тохиролцон прокурорын зөвшөөрөлтэйгээр тогтоод гарган, 1994 оноос онеөт хүртэл хорих ангийн даргын шийдвэрээр насанд хүрээгүй ялтыг

⁹ Хуулийн 20-р зүйл //А.Лхагваа “Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж, хууль, эрх зүйн баримт бичиг, харьцуулсан судалал” УБ/2013 он, 48 дах тал

¹⁰ Дурдсан эх сурвалжийн 54 дах тал, холбогдох хуулийн 33-р зүйл.

¹¹ Дурдсан эх сурвалжийн 91, 92 дах тал, холбогдох хуулийн 71, 72-р зүйл.

салбарын хуульд заасан үндэслэлтээр¹² жил буюу 20 нас хүртэл ньхорих ялыг тухайн байгууллагад ургажлуулсан эдлүүлэх зохицуулалт улчилж байна.

2. Харин 18 насанд хүрсэн ялтыг засан хүмүүжүүлэх-хөдөлмерийн колони /1994 оныг хүртэл/, насанд хүргэсдийн хорих ангил шилжүүлэх асуудлыг шүүх шийдвэрлж ирсэн.

3. 1994 оноос насанд хүрэгжүйчүүдийн жирийн дэглэмд ял зэвлж буй ялтан тоон хязгаарлалтгүйгээр түр уулзалт, илгээмж авах болон жилд 8 удаа удаан хугацааны уулзалт, чанга дэглэмд ял зэвлж буй бол 1 сард 1 удаа түр, 2 сард 1 удаа удаан хугацааны уулзалт хийж, 1 сард 1 илгээмж авах зохицуулалт бий болсон.

II

Эрдэм шинжилгээний нийтлэлийн зорилготой холбогдуулан насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх, тэдний эрхийг хамгаалахтай холбогдсон олон улсын гэрээний болон ОХУ, Казахстан улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн¹³ онцлох, анхаарал хандуулах нь зүйтэй хэмээн судлаачдаас үзжээ буй зарим зохицуулалтын талаар төвч үзье. Энэ нь;

Нэг. Олон улсын эрх зүйн зохицуулалт

а) Хүүхдийн эрхийн тухай конвенцийн¹⁴

-Оролцогч улсууд конвенциод хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоох, захиргааны

¹² Тухайлбал: 1966 оны хуулийн 34-р зүйлд зааснаар "... 18 насанд хүрсэн хоригдлыг засан хүмүүжүүлэх хөдөлмерийн колонид шилжүүлэх явдал хэрэв түүнийг ерөнхий боловсролын ба техникигэжлийн сургалтыг дусгахад саал болно гэж узвал шүүх магадлал гаргаж..." , 1982 оны хуулийн 74-р зүйлд зааснаар "... 18 насанд хүрсэн ялтан засарч хүмүүжин замд баттай орсон бол засарч хүмүүжин үр дүнг батлагах, ерөнхий болопсөр, мэргэжлийн олгох сургалтыг дусгах зорилгоор ..." , 1993 оны хуулийн 23-р зүйлийн 4 дахь хэсэг, 1996 оны хуулийн 82-р зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар "... Хоригдлын яланг хугацаа, хувин байдлын харгалзан..." , 2002 оны хуулийн 110-р зүйлийн 4 дахь хэсэгт зааснаар "... ялтын хувийн байдал, ял залсан хугацааг харгалзан ..." .

¹³ Орос хэлнээс "Уголовно-исполнительный кодекс" гэж бичсэндийн "Эрүүгийн ял эдлүүлэх /гүйцэтгэх/ хууль" хэмээн монгол хэлнээс хөрвүүлэв. //Ийнхийн бичиг "Манай улс энэ конвенцид 1990 оны 01-р сарын 26-ны өдөр гарын усаг зурж, 1990 оны 7-р сарын 05-ны өдөр сэргийн баталсан. //Төрийн мэдээлэл. Тусгай дугаар, 1 боть. УИХ-ын Тамгын Газар, Гадаад өргөгийн яам, УБ.2004 он.

бодон бусад бүх арга хэмжүүг авна. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлж арга хэмжээг нөөн бололцооноо тулгуурлаж дээл тэргүүр ашиглах, шаардлагатай бол олон улсын хамтын үйл ажиллагааны хүргэнд авна. /4-р түйл/

-хүүхэд эцэг, эхтэгтгүй харицаа холбоотой, тэдний талаар мэдээлэлтэй байх. /9-р түйл 3. 4 хэсэг, 10-р түйл/ -эцэг, эх, тодорхой тохиолдолд хууль ёсны асран хамгаалагчид хүүхдийн хүмүүжил, хөгжилд гол хариуцлагыг хүлээн. /18-р зүйл 1 хэсэг/

-Оролцогч улс таван жил тутам конвенциоор хүлээн зөвшөөрсөн эрхийг хангах талаар авсан арга хэмжээ, ахиц дзвшлийн талаарх тайланг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар уламжлан Хүүхдийн эрхийн асуудал эрхэлсэн хороонд ирүүлэх үүрэгтэй. /44-р зүйл "b"/

-Оролцогч улс тайланг өөрийн улсын олон нийтэд өргөнөөр хүртэхийн бололцоогоор хангана./44-р зүйл 6 хэсэг/

б) Хоригдлуутай харьцах наад захын жишиг дүрмүүдийн¹⁵

-Хоригдол эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хорих газраас гарч явах онцгой тохиолдолд түүнд өөрийнхөө хувцсыг эсвэл нүдэнд өртөхөөргүй бусад хувцсыг эмсэхийг зөвшөөрөх нь зүйтэй. /17.3 хэсэг/

-Насанд хүрээгүй хоригдлуудад ... тоглох, боломжийн дасгал хийж явдлыг хангавал зохино. Үүний тулд талбай, тоноглол, төхөөрөмжтэй байвал зохино. /21.2 хэсэг/

-Бүх хорих байгууллага өөрийн мэдэлдэл ядаадаа 1 сэтгэц судлалын зохиных мэдлэгтэй эмнэлгийн мэргэжлийн ажилтантай байх ёстай. /22.1 хэсэг/

-Хоригдол бүр мэргэжлийн шүдний эмчид үзүүлж эмчлүүлэх боломжтой байх ёстай. /22.3 хэсэг/

¹⁵ 1955 онд Женеве хуралдсан НҮБ-ын "Гэмт явдлаас урьдчилсан сэргийлэх ба эрх зүйн зорилтуудад хандах асуудлаарх" 1-р хурлаар баталж, Эдийн засаг нийтийн зөвлөлийн 1957 оны 7-р сарын 31-ны 663 С/ХХҮ/ 1977 оны 5-р сарын 13-ны 2076 /ЛХИ/ тогтолцоогийн сэргийн зорилсан "Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтолцоогийн шийдвэрийн эмхэгтэг" УБ.2014 он. Монгол Улсын ЗХҮК. Каритас Чех Байгууллага. х.78-88.

в/НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх

байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг

дүрмүүгийн¹⁶ /Бээжингийн дүрмүүгүй/

-Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллагын хүмүүжлийн яжлын гол зорилго нь халамж, хамгаалалтаар хангах, нийгэмд ашигтай, нийгэмд үр бүтээлтэй үүргээ биелүүлэхэд нь боловсрол, мэргэжлийн бэлтгэл олгоход чиглэгдэнэ. /26-р зүйлийн 26.1/

-Засан хүмүүжүүлэх байгууллагаас хугацааны өмнө тэнцэн суллах явдлыг зохих байгууллагаар аль болох боломжийн өргөн хүрээнд ял эдлэлтийг аль болох боломжийн эхний хугацаанд хэрэглэх ёстой. /28-р зүйлийн 28.1/

г/Хоригдолтуудтай харьцах үндсэн зарчмын¹⁷

-Хорих ял эдэлж буй хүмүүст ... нийгмийн амьдралд зргэн орох таатай нехцелийг бий болговол зохино. /10-р зүйл/

д/Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүний хамгаалахтай холбогдуулан гаргасан журмын¹⁸

-Засаг төрийн эрх хэмжээ бүхий байгууллага ... насанд хүрээгүй хүмүүс болон орон нутгийн оршин сүүгчийн хооронд чөлөөтэй холбоо хэлхээг урамшуулсан идэвхтэй алхмыг хэрэгжүүлж байх ёстой. /Хавсралт хэсгийн 8-р зүйл/

-... Засан хүмүүжүүлэх байгууллагад насанд хүрээгүй хүний ... эрүүл мэнд, өөрийгөө хүндэтгэх явдалд дэмжлэг үзүүлэх, өөрийг нийгмийн гишүүн болгох

¹⁶ Милан хотноо 1985 оны 8-р сарын 25-наас 9-р сарын 06-ны хооронд болсон НҮБ-ын Гэмт явдлаас урьдчилсан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үндэгчдэд хандах асуудлаар 7-р их курлаар батлуулхаар өргөн барьж Ерөнхий Ассемблейн 1985 оны 11-р сарын 29-ний 40/33 тогтолцоогоор баталсан. //Олон улсын гэрээ, хэлэлцээрини эмзэгтэй, эргүүгийн эрх зүй эргүүгийн байцаан шийтгэх эрх зүй Эрхлан эмхэтгэсэн Д.Баярсайхан, Т.Золбко УБ 2012 он. x 131-154.

¹⁷ НҮБ-ын Ерөнхий ассемблейн 1990 оны 12-р сарын 14-ны 45/111 тогтолцоогоор баталсан //25-р ишлэлд дурдсан эх сурвалж. x.88-89.

¹⁸ НҮБ-ын Ерөнхий ассемблейн 1990 оны 12-р сарын 14-ны 68-р куралдаанаар халзсан. //Дурдсан эх сурвалж. x. 118-136.

боломжийг хөгжүүлэхэд туслахуйц тийм үзэл бодол, дадал зуршлыг төлөвшүүлэх явдлыг урамшуулах, тэднийг харнуулагаа мэдэрдэг болгон хүмүүжүүлэхэд тус дэхем болсон үр нөлеөтэй арга хэмжээ, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ” /Хавсралт хэсгийн 12-р зүйл/

-Насанд хүрээгүй хүмүүсийн хувьд засан хүмүүжүүлэх байгууллагыг нээлттэй байгуулах ёстой. Нээлттэй засан хүмүүжүүлэх байгууллагад аюулгүй байдлын арга хэмжээ байхгүй буюу хяглаарлагдмал байна. Хаалттай засан хүмүүжүүлэх байгууллагад байгаа насанд хүрээгүй хүмүүсийн тоо хүмүүжлийн ганцаарчилсан арга хэрэглэх боломжтой байллах үүднээс цөөн байлагах ёстой. Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллага нь төвлөрсөн бүс, насанд хүрээгүй хүмүүс ба тэдний гэр бүлийн хоорондын хэлхээ холбоог тасалдуулахгүй байх хэмжээнд байна. /Хавсралт хэсгийн 30-р зүйл/

-Насанд хүрээгүй хүнийг галаад сртөнцтэй зохих ёсны холбоо хэлхээгээр хангах бүхий л хэрэгслийг ашиглах нь хүнтэй шударга, хүмүүнлэг харьцаа эрхийн салшгийг хэсэн болдог бөвөөд тэднийг нийгэмд буцаан оруулахад бэлтгэхэд нэн чухал ач холбогдолтой. Насанд хүрээгүй хүмүүс гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүс, нэр хүндтэй, найдвартай байгууллагын төлөвлөгчидтэй харилцаа, гэртээ очи, гэр бүлийнхэнтэйгээ уулзахаар засан хүмүүжүүлэх байгууллагаас гаргах, боловсрол, мэргэжил эзэмшиг, бусад нэн чухал зорилгоор засан хүмүүжүүлэх байгууллагаас гарч яввах боломжоор хангагдах ёстой. Ял эдлэж байгаа хүмүүс засан хүмүүжүүлэх байгууллагаас гадуур байсан хугацааг ялыг хугацаанд оруулан тооцно. /Хавсралт хэсгийн 59-р зүйл/ “... Ямарч тохиолдолд хоол ундыг хасах, гэр бүлийн гишүүнгүйсээ уулзахыг хялгажаар буюу хориглох явдал болохгүй ...”/ хавсралт хэсгийн 67-р зүйл/

-... Бүх ажилтнууд ... засан хүмүүжүүлэх байгууллагын дотоод ба түүний гаднах амьдралын ялгааг аль болохоор бууруулахыг эрмэлзэх ёстой” /Хавсралт хэсгийн 85-р зүйл “Г/

Хоёр ОХУ-ын Эрүүгийн ял залуулэх хуулийн дагуу¹²

а/Хорих ялаар шийтгэгдсэн насанд хүрэггүй хүн хүмүүжлийн колонид ял залэх ба гэднийг энд 19 нас хүргэл нь прокурорын зөвшөөрлөөр хүмүүжлийн колонийн даргын тогтоолоор үлдээж болно²⁰.

Харин хорих ял залэх хугацаандаа 18 насанд хүрсэн, зан байдлын хувьд серөг хандлагатай ялтыг хэрвээ хүмүүжлийн колони дотор засан хүмүүжүүлэх жирийн дэглэмтэй колонийн адил дэглэм бүхий тусгаарласан хэсэг байвал тэнд²¹, эсхүл жирийн дэглэмтэй засан хүмүүжүүлэх колонид ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу шүүхийн шийдвэрээр шилжүүлэх асуудлыг шийдвэрлэн²².

б/ Хэрэв гяндангаас бусад²³ насанд хүрэгсдийн засан хүмүүжүүлэх колонийн нэг дэглэмийн дотор хорих ял залэх ердийн, хөнгөвчилсен, хатуу /чанга/²⁴ нехцел байdag бол хүмүүжлийн колонид ердийн, хөнгөвчилсон, хөнгөн хатуу гэсэн 4 нехцел бий²⁵.

Хорих ял залэх нехцел нь ялтыг ялгамжтай эллүүлэх, ялтын зөрөг зан Үйлийг урамшуулан дэмжих, засан хүмүүжүүлэх байгууллагаас сурлахад бэлтгэх чиг үүрэгт захирагдах ба ялтын

¹² Энэ хуулийг Тарин дум 1996 оны 12-р сарын 18-нд батарж, Холбооны Зөвлөл 1996 оны 12-р сарын 25-нд эхлэлтийн дэмжисэн ба түүний 12-р зүйлд заасны дагуу 1997 оны 7-р сарын 01-ний өдөр хучин төгөлдөр болж үйлчилж байна. <http://ukidokos.ru>

²⁰ Хуулийн 74-р зүйлийн 9 хэсэг, 139-р зүйлийн 1, 3 хасаг //Дурдсан эх сурвалж.

²¹ Хуулийн 140-р зүйлийн 1 хэсэг, 139-р зүйл 2 хэсэг //Энэ тохиолдолд, тадний хорих ял залэх нехцел, хоол хүнс, материалын ахуйн хангт насанд хүрэзгүй ялтантай адил байна

²² Хуулийн 140-р зүйл 2 хэсэг

²³ Гяндан ял залэх нехцелөөр ердийн, чанга гэм хуваагдана. Хуулийн 87-р зүйл 2 хэсэг

²⁴ Орос халиээс "строгие условия отбывания наказания" гэх бичсэндийн "ял залэх хатуу нехцел" гэж цаашид хөвүүлэн хэрэглээн //нийтлэгч

²⁵ Хуулийн 132-р зүйл 1 хасаг: Мен зүйлийн 2-р хасагт "ердийн нехцел", 3-р хасагт "хатуу нехцел" хорих ял залэх насанд хүрэзгүй ялтын талаар, 4-р хасагт "ердийн нехцелөөс хөнгөвчилсен нехцел". 5-р хасагт "хөнгөвчилсен нехцелөөс хөнгөн нехцел". 6-р хасагт "ердийн нехцелөөс хатуу нехцел", 7-р хасагт "хөнгөвчилсен нехцелөөс ердийн, хатуу нехцел". 8-р хасагт "хөнгөвчилсен нехцелөөс ердийн нехцелд" шилжих тохиолдлыг хуулийлж.

эрхийн хязгаарлалттай холбогддог²⁶.

в/ Нийт ялтанд хэрэглэдэг урамшууллын арга хэмжүү²⁷-нээс гадна хорих ял залэж буй насанд хүрэггүй хүнд соёл, урлаг-уртан сайхны болон спортын арга хэмжээт хүмүүжлийн колонийн ажилтантай хамт үзэх, эзэг, эх тэднийг орлох болон ойрын төрөл садангийн хүнтэй хүмүүжлийн колониос гадагшаа гарах эрх олгох, хугацааны өмнө хорих ял залэх хатуу нехцелөөс ердийн нехцелд шилжүүлэх урамшууллыг үзүүлдэг²⁸.

г/ Зөрчил гаргасан насанд хүрэггүй ялтанд оногдуулах сахилтын арга хэмжээ мен өөрийн онцлогтой. Толруулбал: ял залэх тогтоосон журам зөрчсөн тохиолдолд тэдэнд донгдох, 200 хүртэл рүбийн сахилгын тортгуул ногдуулах²⁹ болон уран сайхны кино үзэх эрхийг сарын хугацаагаар хасах, хичээл сургалтад оролцуулан сахилгын тусгаарлах байранд 7 хүргэл хоног хорих гэсэн сахилгын шийтгэл ногдуулна³⁰.

д/ Хорих ял залэж буй ялтанд 4 цаг үргэлжлэх түр. З өдөр үргэлжлэх удаан хугацааны уулзалтыг засан хүмүүжүүлэх байгууллагын нутаг дэвсгэрт олгож болно. Энэ хуульд заасан тохиолдолд ялтанд засан хүмүүжүүлэх байгууллагаас

¹³ Хуулийн 132,

²⁶ 133-р зүйл. Хүмүүжлийн колонид хорих ял залэх нехцел ЖНБ: Едийн нехцел хорих ял залэх бий насанд хүрэггүй хүн сард хүнсний бутзэлдхүүн, энэ хэргээд зүйлийн худалдан авахад нарийн дансаасаа 4000 рублийг зарцуулах, жилд 8 удаагийн түр 4 удаан хугацааны уулзалт хийх эрхтэй бол хөнгөвчилсон нехцелд ял залэгээд ... сард 6000 рубль ... зарцуулах, жилд 12 удаагийн түр, 4 удаан уулзалт, хөнгөн нехцел ... хязгаарлалтуйгээр ... нарийн дансаасаа мөнгөө зарцуулах... түр уулзалт хийх, жилд 6 удаан хугацааны уулзалтыг хүмүүжлийн колонийн нутаг дэвсгэрийн гадна (хоноглож) хийх эрх адлан. Зөрчил хүмүүжлийн колонийн даргын тогтоолоор хөнгөн нехцелд ял залэж буй насанд хүрэггүй хүнс колонийн нутаг дэвсгэрийн гадна харуул хамгаалалтуйгээр, захиргааны ханалтын дор нийтийн байранд амьдралыг зөвшөөрч болно. Энэ нехцелд тэдэнд балэн мөнгө ашиглах, энгийн хувьцаа хэрэлзэхийг зөвшийрдэв. Хатуу нехцелд ял залэгээд сургарт: алхаас бусад цагт тусгаарласан хаалттай /цохижий/ байранд ял залэх беегээд тэдэнд сард ... 3000 рубль зарцуулах. Жилд 6 удаагийн түр уулзалт авахыг зөвшийрдэв.

²⁷ Хуулийн 113-р зүйл

²⁸ Хуулийн 134-р зүйл. Мен урамшуулалт олгох журам нь хуулийн 135-р зүйлд тодорхойлгэсэн.

²⁹ Хуулийн 115-р зүйлийн 1-р хэсгийн "а", "б" заасан/Энэ нь насанд хурсэн ялтантай адил болно.

³⁰ Хуулийн 136-р зүйл

гадуур 5 өдөр үргэлжлэх удаан хугацааны уулзалтыг олгож болно. Энэ тохиолдолд засан хүмүүжүүлэх байгууллагын дарга уулзалтын журам, уулзалт явагдах газрыг тодорхойлно.

е/ Хүмүүжлийн колонид ял эдлэгсэд өөриин хүснэгтээр удаан хугацааны уулзалтыг колонийн гадна хийх түр уулзалтаар болон нийт ялтны адил утсаар ярих явдлаар солихыг зөвшөөрнө³¹.

ё/ Хүмүүжлийн колонийн амьдралын бүсийн нэг ялтанд ногдох талбай 3,5 м²-ээс бага байж ёсгүй³².

ж/ Ажил хөдөлмөр эрхэлж буй насанд хүрээгүй ялтан жил тутам 18 ажлын өдрийн, хуульд заасан бусад тохиолдолд 24 хүртэл ажлын өдрийн цалинтай амралт эдэлнэ³³.

Мөн түүнээс үл хамаарах шалтгаанаар ажлаар хангагдаагүй ялтанд жил тутмын цалинтай амралт тэнцүү хоногоор засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагшав явахыг зөвшөөрж болно³⁴.

з/ Хууль зүйн туслаачаа авахад нь зориулан хорих ял эдлэгсэд өмгөөлгчтэй болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрх бүхий бусад хүмүүстэй уулзахад нь 4 хүртэл шагийн уулзалтыг тоон хязгаарлалтгүйгээр олгоно. Ялтны хүснэгтээр өмгөөлгчтэй хийх уулзалтыг түрвадагч хүнсийнсохоргүй болон техникин чагнах төхөөрөмжийг газарт ганцаарчлан явуулиа³⁵.

и/ Хорих ял эдлэгсийн хувийн онцгой нөхцөл байдал (ойрлын төрөл садангийн хүн нас барсан эсхүл амь насанд аюултгайгаар бичилсон, ялтан болон түүний гэр бүүл материалын үзэмж хохирол учруудсан байгалийн гамшиг тохиолдсон), тэрилэн суллагдсаны дараах ажил хөдөлмөр эрхлэх, амьдрах гэр ахуйн асуудлаа урьдчилан шийдвэрлэхтэй нь холбогдуулан тэдндээ явах, ирэх зам хоногийг оролцолгүйгээр засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагшав 7 хүртэл хоногийн хугацаагаар явахыг

зөвшөөрч болно³⁶.

Засан хүмүүжүүлэх байгууллагаас ийнхүү гадагшaa гарахыг насанд хүрээгүй ялтны хувьд гэр бүлийн хүмүүс эсхүл бусад дагалдан явах хүмүүсийн хамт зөвшөөрнө³⁷.

Гурав. Казахстан улсын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн³⁸

хорих ялшийтгэдээн насанд хүрээгүй этгээдийн харьцаанд тогтоосон журам нь ерөнхийдөө ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн холбогдох зохицуулалттай адил³⁹ боловч түүний дараах онологийг тодотгож болно. Энэ нь:

а/ Насанд хүрээгүй хүмүүсийн хорих ял эдлэх байгууллагыг “Насанд хүрээгүйчүүдийг хорих аюулгүй байдлын дунд түвшний байгууллага” гэж нэрлэдэг ба тэрээр бие даасан хорих байгууллагын төрөл мөр⁴⁰.

б/ Хэрэв ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн дагуу энэ улсад хорих ял эдлэж буй насанд хүрээгүй хүнд тоон хязгаарлалтгүйгээр илгээмж, гүйвуулга авахыг зөвшөөрдөг бол Казахстан улсын хувьд ердийн нөхцөлд ял эдлэж буй насанд хүрээгүй ялтан жилд 10, хөнгөвчлийн нөхцөлд-14, хатуу нөхцөлд- тус бүр 6 илгээмж, гүйвуулга авах, мөн хөнгөн нөхцөлд –тоон хязгаарлалтгүй удаан хугацааны уулзалт, хатуу нөхцөлд- жилд 2 удаагийн удаан хугацааны уулзалт, тус бүр 6 илгээмж, гүйвуулга авахыг зөвшөөрдөг⁴¹.

в/ Ял эдлэх тогтоосон журам зөрчсөн тохиолдолд хорих ял эдлэж буй насанд хүрээгүй хүнд сануулах, донгодх, хатуу донгодах,⁴² цаг хүртэл хугацаагаар түр тусгаарлах байранд хорих сахилгын шийтгэл хүлээлгэн⁴³.

³¹ Хуулийн 97-р зүйл 1 хэсэг “а”

³² Хуулийн 97-р зүйлийн 4 хэсэг

³³ Энэ хуулийн 7-р сарын 05-ны өдөр батлагдсан ба 2015 оны 01-р сарын 01-ны өдөрөөс үзүүлж эхэлсэн // http://online.zakon.kz/document/?doc_id=31577723 //2015 оны 5-р сарын 31-ны өдрийн нийтлэгчийн хандалт

³⁴ Тухайлбал: насанд хүрээгүй ялтны хорих ял эдлэх байгууллага нь наживцеөр хатуу, ердийн, хөнгөвчлийн, хөнгөн эзж хувьцасдана /150-р зүйл/, мөн тэдндээ хэрэглэх урамшууллын арга хэмжээ /152-р зүйл, 153-р зүйл/, түр, удаан хугацааны уулзалт, чөлөө эзрэг.

³⁵ Хуулийн 89-р зүйл 1 хэсэг //дурдсан эх сурвалж

³⁶ Хуулийн 151-р зүйл

³⁷ Хуулийн 154-р зүйл 3 хэсэг

Мөн хуулийн 154-р зүйлийн 2 хэсэгт ял эдлэх тогтоосон журмын ноцтой зөрчилд тооцох насанд хүрээгүй ялтны үйлэл, эс үлдэхүйг журамлаж өгсөн. Энэ нь:

1) Байгууллагыг тохижуулах, амьдрах нехцелүүг сайжруулах ажил хийхээс хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр татгалзах;

2) Согтууруулах ундаа, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл хэрэглэх;

3) Байгууллагын захиргааны төлөөлгөчдийг заналхийлэх, доромжлох, тэдэнд захиргаадагчийг байх болон ял эдлэх дэглэм зөрчих зорилгоор санаатайгаар биедээ ямар нэгэн гэмтэл учруулах;

4) Байгууллагын дотоод журамд тусгагаагүй эд зүйлс, баримт бичиг, хэрэгслэл, бодис, хүнсний зүйлийг олж авах, дамжуулах, бэлтгэх, хадгалах;

5) Материаллаг болон бусад ашиг олох зорилгоор хөзөр, мөрийтэй бусад тоглоом тоглох;

6) Шүүхээс тогтоосон зайлшгүй болон албадлагын эмчилгэнээс зайлсхий;

7) Бэлгийн харьцааны шинжлэх үйлдэл хийх;

8) Энэ хэсгийн 1-7 дэд хэсэгт заасан зөрчил гаргахад чиглэсэн ялтны бүлэглэлийг зохион байгуулах эсвэл түүнд орцоход.

г) Насанд хүрээгүйчүүдийг хорих аюулгүй байдлын дунд түвшний байгууллагад 18 нас хүрсэн ялтныг тэдний саналыг авч 21 нас хүргэл нь байглаж болох ба үүнийг байгууллагын даргын тодорхойлолтын үндсэн дээр шүүх шийдвэрлэн⁴³.

III

Энэ цаг үед Засгийн газраас санаачлан УИХ-аар хэлэлцэж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хуулийн шинэчилсэн найруулгын төслийн⁴⁴ дэх насанд хүрээгүй хүнд оногдуулсан хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын онцлог нь:

а) Уг харилцааг төслийн "Өсвөр насны

⁴³ Хуулийн 155-р зүйл

⁴⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн /Эзэмжтсэн: Хууль зүйн зам, хянасан: Ч.Бат-Эрдэнэ, Д.Амгалан, хэвлэсэн газар: ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр, хэвлэсэн он, сар: 2015 оны 5-р сар.

ялтныг ял эдлүүлэх" гэсэн 109-р зүйл болон бусад нийтлэгт зүйл-хэсгийн тувшинд⁴⁵ журамласан.

б) Төсөлд мөн зарчмын шинжлэх дараах шинэ зохицуулалт бий. Тухайлбал:

-өсвөр насны ялтны ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлэх/ Төслийн 109-р зүйлийн 109.1 хэсэг/.

-18 насанд хүрсэн ялтны сургалт хүмүүжлийн байгууллагад үргэлжлүүлж 3 жил хүргэл хугацаагаар үлдээж болох. Гэхдээ шийдвэр гаргах эрх өнөөгийн хуулийн зохицуулалтын ажил байгууллагын даргад хадгалагдсан. /Төслийн 109-р зүйл 109.4 хэсэг/

-Өсвөр насны ялтан илгээмж авах, түр уулзанд хийх тоог хязгаарлахгүй гэсэн нь өнөөгийн хуулийн зохицуулалттай ашиг, харин удаан хугацааны уулзанд 8-аас дээш удаа хийж болох. /Төслийн 109-р зүйл 109.5 хэсэг/

-Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын харуул хамгаалалт, орчин нехцэл, дотоод журамыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоох. /Төслийн 109-р зүйлийн 109.6 хэсэг/

в) Ялтан 18 насанд хүрмэгээ ялыг нь эдлүүлэхээр насанд хүрэгддийн хорих ангид шилжүүлэх асуудлаар сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын дарга прокурорт санал гаргах ба прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ гэж төслийн 109-р зүйлийн 109.3-д заасан нь үндсэндээ өнөөдөр үлчилж буй хуулийн зохицуулалт /110-р зүйлийн 110.3 хэсэг/, хууль зүйн практиктай ашиг болсон.

Дүгнэлт-санал

Монгол Улсын Засгийн газраас санаачлан УИХ-аар энэ цаг үед хэлэлцэж

⁴⁵ Тухайлбал: 112-р зүйл Оргосон яллагдагч, ялтны эрэн сурвалжлах, 114-р зүйл. Ялтны эрх, үүрэг, 11-р зүйл. Ялтны тусад нь ял эдлүүлэх, 118-р зүйл. Ялтан бусад уулах, харилцах, 124-р зүйл. Хорих анги дахь сургалт, 127-р зүйл. Ялтанд хулзалгах сахижлын шийтгэл, 128-р зүйл. Ялтны ахуйн нехцэл, 129-р зүйл. Ялтны суплах журам тус бол болно.

“Өөрөөр хэлбэл өнөөгийн хуулиар хорих ялаар шийтгэгдсэн насанд хүрээгүй хүний ялыг насанд хүрээгүйчүүдийн жирийн, чанга дэглэмэй хорих ангид здлүүлж байгаа бол төсөлд өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хорих анги бус сургалт-хүмүүжлийн "дэглэмийн ялваагүй" тусгай байгууллагад эдлүүлэхээр заажэж.

буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл агуулга, найруулга, хэлбэрийн хувьд “дүн нуруугаараа” олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээ, хөгжлийн чиг хандлагатай нийцсэн, гадаадын зарим орнуудын дэвшилттэй. манай нөхцөл байдал, амьдралын шаардлагатай уялдсан зарчмын шинээлгээ нэлээдгүй зохицуулалтыг өөртөө агуулсан боловч “мэргэшиж буй судлаач” билний үзэж байгаагаар түүний “хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй ялтын ялыг эдлүүлэх институци”-д өөрчлөх шаардлагатай цөөнгүй хэм хэмжээ байна. Энэ нь:

1. Төсөлд өнөөгийн хуулийн адил салбарын өмнөх хуулиудын/ялангуяа Засан хүмүүжүүлэх хөдөлмерийн 1966, 1982 оны/ уламжлалт. дэвшилтэд зарим зохицуулалт⁷ орхигдсон.

2. Мөн төслийн зарим зохицуулалт ялтын дахин нийгмийн⁸, зөрэгээр засарч өөрчлөгдөхдөй нь сергөөр нөлөөлөх боломжтой байна. Тухайлбал: Төслийн 127-р зүйлийн 127.1.1-д заасан “сар, улирал, жилд авах түр болон удаан хугацааны уулзалтын тоог бууруулах” зохицуулалт нь өсвөр насны хорих ялтанд ноотой байдлаар шууд нөлөөлэхгүй боловч хаалттай хорих ангийн “А”, “Б”, “В” харуул хамгаалалтын зэрэглэлд ял эдэлж буй насанд хурсэн ялтанд хундээр тусах магадлал өндөр байгаагийн зэрэгцэ Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүнийг хамгаалахтай холбогдуулан гаргасан НҮБ-ын журмын хавсралт хэсгийн 8-р зүйлтэй зөрчилдэж байна.

3. Нийтлэлд иш татсан болон гадаадын бусад орнуудын дэвшилтэд,

47 Энэ нь урамшууллын журмаар “удаан хугацааны уулзант авах”, мөн “хүнисний бүтээгдэхүүн, нэн хэрэгзээт зүйл худалдан авахад зөвшөөрөгдсөнөөс нэхмэ изирий данснаас мөнгө заршуулах /ялангуяа энэ хэм язмээз 1993 оны хойш хуулиас хасагдан, эрх зүйн дэд актын түвшинд оноштоой бус байдлаар зохицуулалтад болсон”

“Орос хэлний “реосоциализация” гэсэн угийг ийнхүү хөрвүүлэв. Манай орны эрх зүйн зарим дэд акт, хууль зүйн практикт хэрэглэж буй “ялтын нийгэмшиүүлэх” гэсэн уг хэллэйт бид шүүмжлэлтэй ханддаг. Учир нь ялан “хүн н юм болохоор” ямар нэг хэмжээгээр нийгэмшсэн, өөрний гэсэн наиз нехэд, амьдралын орчинтой тул “нийгэмшиүүлэх” ярийн нэхэмжлийг харин “дакинийг нийгэмшиүүлэх” буюу амьдралын хэв маяг, нийгэмд серег зан байдлыг нь өөрчлөх, ухааруулах, зассан төлөвшүүлэх боломжтой гэж үздэг.

мөн олон улсын эрх зүйн нийтлэг, тусгай зохицуулалтыг төсөлд нэмж тусгах шаардлага байна. Энэ нь юуны өмнө хорих ял шийтгэгдсэн өсвөр насны хүнд хэрэглэх урамшууллын, сахилгын шийтгэлийн, хорих ялаас тэнсэн суллах тусгай хэм хэмжээ, мөн удаан хугацааны уулзалтыг түр хугацааны уулзалтаар, утсаар ярийн явдалар солих, техникик-технологийг ашиглан уулзалт-ярилслагыг зохион байгуулах боломж олгох, ял эдэлж буй байгууллагын гадна гараха, чөлөөгөөр аваха, хөдөлмөрийн амралт эдлэх, иргэний нийгэмтэй харьцах, холбогдох эрхийг өргөжүүлэх явдал болно.

4. Төслийн боловсруулалтын түвшинг зарим талаар сайжруулах хэрэгтэй. Учир нь хууль зүйн техникийн дүрмийг тэр бур чадварлаг ашиглалаатгүй холбогдон төслийн бичвэрийн зарим зүйлхэсэг монгол хэлний үг зүй-найруулахаа зүйн “шүүд утга”, мөн эрх зүйн шинжлэх ухааны ерөнхий онолоор авч үзвэл “эрх зүйн хувьд хийэлдэгтэй” байна. Тухайлбал: Төслийн 106-р зүйлийн 106.5, 106.6, 106.7 хэсэгт “ялтанд чөлөө олгох” асуудлыг зөвхөн нээлттэй хорих ангийн ялтанд хамруулахаар тусгасан ба өсвөр насны ялтанд оногдуулсан хорих ялыг нээлттэй хорих байгууллагад бус “сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад” эдлэхээр маш тодорхой зассан тул энэ хэм хэмжээг хэрэглэхгүй боломжгүй.

Мөн төслийн 114-р зүйлийн 114.1.6 хэсэгт “утсаар ярийн эрх”-ийг нийт хорих ял эдлэгдэд хамруулан тусгасан боловч өсвөр насны ялтын хувьд түүний нарийвчилсан зохицуулалтыг мөн л орхигдуулсан байна. Гэтэл төслийн 106-р хэсгийн 106.8 хэсэгт уг харилцааны зарим зохицуулалтыг “нээлттэй хорих ангид ял эдлэгдэд (“ялтан өөрийн зардлаар таксофон ашиглах эрхтэй”) хамруулан журамлажээ.

Эдгээр дүгнэлт санал нь зөвхөн нийтлэг бичигчийн үзэл болд буулийн төслийн чанар, үр дүнг сайжруулах, хүний, тэр дотороо эрх, эрх чөлөө нь хязгаарлагдсан хүмүүсийн эрхэд анхааралтай хандан, зөрэгээр засарч өөрчлөгдөхдөй туслах, олон улсын эрх зүйн нийтлэг зарчим, хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид тусгах зорилго агуулж буй тул уншигч, судлаач та бүхэн мэргэн оюун ухаанаар олон талаас нь шүүн тунгаж, мэтгэлцүх бий тэ.

ГЭРЭЭНИЙ ТУХАЙ ШИНЭЛЭГ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэний эрх зүйн тэнхимиийн багш, хууль зүйн доктор (Ph.D) С.Долгжин

Түлхүүр уг: Орчин үе-гэрээний эрх зүй, Хувийн эрх зүйн чиг хандлага, Гэрээ

Товч агуулга: Өнөөдөр даяарших ўйл явц зэрчмийж, эдийн засгийн амьдралд худалдаа, арилжаа, тэзвэр, зээл тусламж, оюуны өмчийн харилцаа улам бүр өсвөн нэмэгдэж байгаатай холбогдох бусад улс орны хувийн эрх зүйн дахь гэрээний шинэлэг ойлголт, чиг хайдлагын талаар санал бодлоо угтуулэлд тусгасан болно.

Нэг. Оршил

Дэлхийн улс бүр өөрийн үндэсний эрх зүйн тогтолцоотой ба тэдгээрийн зан заншил, эрх зүйн уламжлал, сэтгэлгээ, оноплын хөгжлийн хувьд хоорондоо ихээхэн ялгаатай учраас улс орон бүрийн хувийн эрх зүйн ялгаа арилаад нэгдмэл хувийн эрх зүйн тогтолцоо бий болоход яагаач үүгий. Гэхдээ даяарчлалын эрин үед улс орны эдийн засгийн хөгжлийн маш хурдацтай ўйл явцыг дагаад улс хоорондын болон иргэд, аж ахуйн нэгжийн хооронд гэрээ олиноор байгуулах, мөн гэрээний маргаан ихээр гарах болсон энэ цаг үед гэрээний эдийн засгийн үргийн ач холбогдол, эрх зүйн зохицуулалтын шинэчлэлт нь анхаарал татааж байна.

I. Гэрээний ойлголтыг шинээр авч үзэх нь

Хувийн эрх зүйн харилцааг үүсгэх хамгийн түгээмэл хууль зүйн факт болох “Гэрээ” /*parte sunt servanda, agreement-contract*, /хэмээх ойлголтын хөгжлийг хараад утга агуулга, хэм хэмжээ, хэлбэр агуулга, агаа нь байнга өөрчлөгдэн иржээ. Өнөөдөр Эдийн засагт сууриссан гэрээний үзэл баримтлал нь/Contract, and the Economic Order/гэрээг эдийн засаг ба эрх зүйн хамаарал талаас нь тайлбарлах хандлага хүчтэй хөгжж байна. Эдийн засагт сууриссан гэрээний үзэл баримтлал нь өмнөх түүхэн цаг үеийн Солилцооны онол³, Солилцооны эрхийн онол⁴/Title/, Хүсэл зоригийн онол⁵/Will/, Гэрээний эрх чөлөөний онол⁶/ Freedom of Contract/ онолтой харьцуулахад гэрээний гүйцэтгэх үүргийн ач холбогдлыг эдийн засагтай холбон тайлбарлаж байна.

Бусад улс орны гэрээний хууль зүйн тодорхойлолтын агуулгыг хараад гэрээг талуудын сайн дурын, тэгш эрхийн, хүсэл зоригийн үр дунд үүсэж, иргэний эрх, үүргийг бий

¹ Robert F. "Contract Law and Theory", Lexis Nexis, 2013. PP. 1-25; Hein K, Axel F, "European Contract Law", Clarendon Oxford, 2002. PP. 1-16; Eric A, "Contract Law and Theory" Wolters Kluwer, 2011. PP. 5-7.

² Зайланыг шинжийг хадгалсан амлалтын үр дунд солилцох, эзэл, алгэв худалданы агуулгатай халцлийг түгээмэл хийж барсан (МЭӨ 1000 жилийн өмнө)

³ Гэрээн эзэл тодорхой нехцэлтэйгээр ургацаа эзэлэх түнхээ билэх болох эрдэлээс өмчье хамгаалахын түнд гэрээ хэрэгтай гадийг шүүх хулзэн зөвшөөрсөн иргэний эрх зүйн хөгжил (МЭӨ 1000 -1600 жилийн өмнө)

⁴ Хүсэл зоригийн үндсэнд дээр гэрээний талуудыг хоорондоо тохирон гэрээний агуулгыг хуулиар хулзэн зөвшөөрдөн гол нөхцөлийг тохирсон халцлийг гэрээ хэмжэн тайлбарласан иргэний эрх зүйн хөгжил (1601-1900-аад он);

⁵ XIX зууны либерализмтай холбоотоогоор талууд өөрсдөө гэрээний агуулгыг тодорхойлж, гэрээ байгуулах түншээ сонгох, гэрээний төрлөө өөрсдөө сонгох шиналаг иргэний эрх зүйн хөгжил (1901-1990-аад он); XIX-XX зуунас эхлан Гэрээний эрх чөлөөний онолын хувьд гэрээний эрх чөлөөний зарчмын нь түйтийн эрх чөлөө биш утваар тайлбарлагдан хэлбэлзэж эхлэсэн.

болгож, өөрчилж, дуусгавар болгоход чиглэгдсэн, хоёр буюу түүнээс дээш этгээдийн хооронд хийсэн амлалт тохиролцоо хэмээн хүсэл зоригийн үндсэн шинжийн онцолж тайлбарласан. Харин 1990-ээд оны сүүлчээс эхлэн гэрээний ойлголт нь хуулийн позитив, субъектив эрх зүйн сэтгэлгээний хүрээнд тайлбарлагдахаасаа илүү эдийн засгийг хөгжүүлэх эрх зүйн хэрэгсэл талаас нь тайлбарлаж байна. Ялангуяа Дорно дахины улс орны эрх зүйн сэтгэлгээний үнднээс гэрээг эдийн засгийн харилцаанд хэрэглэх, хэрэгжүүлэх агууллаа талаас нь, тухайлбал Солонгос улсын эдийн засгийн хөгжилд эдийн засгийн гэрээний ач холбогдол маш их үүрэгтэй байна.⁶ Гэрээний зорилт нь Хятад улсад нийгмийн бүтээн байгуулалтын ахиулахын тулд оршино.⁷ хэмээн гэрээний гүйцэтгэх үргийн ач холбогдлыг эдийн засагтай холбож байна.

Англи-Саксоны эрх зүйн системд багтах улс оронд гэрээ нь хуулиар хориглоогүй, шүүхийн практикт тогтсон амлалт, итгэлцээр давхин харилцаан эрх, үргийг бий болгох зөвшүүлсэн

Үйлдэл талаасны харин

Сүүлийн, үед зарим төрлийн гэрээ нь тохиролцооны хувьд гэрээ бүр талуудын харилцан хүлээсэн амлалт байдаг эсэх, хүсэл зоригт чөлөөтийн ийрэхийлж эсэх, гэрээ байгуулах субъектын сонгоход нь маргаантай боли ялан, тухайлбал, стандарт гарзж, болзоп тавьсан эзлэц, хэрэглэгчийн гэрээ зэрэгтэй холбоотой маргааны дээр дурдсан гэрээний эрх чөлөөний зарчмыг баримталагдсан түүнээс үүсж, ир дагавар нь гарзжин анхны зорилготой нийцах эсэх нь тодорхой бус байх, мөн гэрээ байгуулах субъектын сонгоход шударгаа бус ерөнхийдээ, ялагварлан гадууруулын хориглоосон кулийн хэс хэмжийнхээ хэрэгжихгүй аяч узвал гэрээний эрх чөлөөний зарчмыг үүлчлэхгүй боли байна. Түүнчлэн гэрээний стандарт нэхцэлийн хувьд гэрээнээс үүсж гол эрэлд нь худалдан авагч, хэрэглэгчид ногдаг тул стандарт нэхцэлийн гэрээнд тусгасан талын эсрэг тайлбарлах узлж баримтлал үүчиндэг боли байна. Энэ нь ног талын хариуцлагас бүрэн чөлөөлсөн, баарын догоондлын хариуцлагуулж байх тухайн заалт, баарын хургэх хугацаа тодорхой бус байх, болино хугацаанд үний нь ёсгийн эрхийн худалдагчид олгосон, хэрэглэгчийн эзлэх зэрэгт тусгасан стандарт нэхцэлийн гэрээнд тусгасан талын эсрэг тайлбарлах узлж баримтлал бин болиж байна

⁶ Park, N. "The Role of Law in Korean Economic Development". Korean Legislation Research Institute, 2008, PP.244-249

⁷ Оюунтунгулагал Ж. "Харьцуулсан иргэний эрх зүй", УБ, 2013, 13 дахь тал; Peter S. "Freedom of Contract and Paternalism -Prospects and Limits of Economic Approach", Bartins Press, 2013, PP.1-18

Ром-Германы эрх зүйн системд багтах улс оронд гэрээний үүсэх үндэслэл нь гол төлөв хуулиар зөвшөөрөгдсөн эрх, үүргийг харилцаан хүлээсэн, тодорхой үйлдэл тусгалаа олсон байдал, тухайлбал Герман улсад "Гэрээг субъектив сэтгэлгээний хүрээнд эрх зүйн харилцаа үүсгэхэд чиглэсэн талуудын хүсэл зоригто илэрхийлсэн тохиролцоо" гэж тодорхойлж байна.⁸ Үнднээс үүдээд Ром-Германы эрх зүйн системтэй улсын тооцд багтах Монгол улсын Иргэний хуулийн ихэнх заалт нь гэрээний хувьд хэрэглэгдэж маш товчлон гарээний тесэл боловсруулж заньсан байдал.

Мөн гэрээний эрх зүйн харилцаа нь араасаа үүргийн эрх зүйн харилцааг дагуулдагын хувьд гэрээг үүрэг бий болгож буй амлалт гэж тайлбарлаж байна, тухайлбал АНУ-д "Гэрээг зөрчвэл хуулиар нехэн төлбөр ногдуулж тодорхой үүргийг бий болгож буй амлалт." гэж тайлбарладаг.⁹

Гэрээний эдийн засгийн гол чиг үргүүдийн нэг бол талуудын эрсдэлийг бууруулах, дунд нь хуваарилах явдал байдаг. Гэрээнд орж буй талуудын хувьд өөрт болон гуравдагч этгээдэд ирээдүйд үүсгэх болох алдагдад, хохирлыг хэрхэн шийдвэрлэх нь гэрээний эрх зүйн гол асуудлуудын нэг болж байна. Тухайлбал, тээврийн компанийн болгоомжгүй үйлдлийн улмаас худалдагч, худалдан авагчийн хооронд худалдан авах гэрээний дагуу шилжүүлж егех ёстой бараа устсан байна гэж үзье. Энэхүү бараа устсанас бий болсон хохирол, эрсдэлийг хэн хариуцах асуудал үүснэ. Бараа алга болсонд худалдагч бууругүй буюу худалдагчийн санаатай болон болгоомжгүй үйлдэл нөлөөлөөгүй тул худалдан авагч нь худалдагчаас барааг нэхэх боломжгүй болно. Худалдан авагч, тээврийн компанийн хооронд гэрээ байгуулаагүй тул худалдагч барааг тээврийн компанийн нэхэх

⁸ Hein K, Axel F, "European Contract Law", Clarendon Oxford, 2002, PP.1-16

⁹ Lawrence M, "Contract Law In America- A Social and economic study", New Orlenas, 2011, PP.1-5

боловжгүй болж байна. Худалдагчийн хувьд тээврийн компаниас барааг нэхэн тохиолдолд худалдагчид бодит хохирол учраагүй тул мөн л амжилтгүй болно. Энэ тохиолдолд худалдагчийн хувьд гэрээний нөгөө тал болох тээврийн компаниас гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөхийг шаардах эрхтэй болохыг шүүхээс тогтоож, ийнхүү худалдагчийн тээврийн компаниас гаргуулсан хохирлын нөхөн төлбөрийг худалдан авагч нь худалдагчаас үндэслэлгүйгээр хөрөнгөсөнтэй холбоотойгоор нэхэмжлэн авах боломжтой гэж үздэг байна.¹⁰

II. Гэрээ байгуулах арга хэлбэр

Гэрээ байгуулсанд тооцох, түүнийг байгуулах үе шатны асуудал нь гэрээний эрх зүйд гол байр суурин эзэлдэг. Аль ч улсын шүүх, арбитрт шийдвэрлэгдэх байгаа иргэний хэрэг, маргааны ихэнх хувийг гэрээнээс үүссэн маргаан эзэлдэг бөгөөд эдгээр асуудлыг хянан шийдвэрлэхэд гэрээ байгуулагдсан уу? Байгуулагдсан бол хүчин төгөлдөр гэрээ мөн үү? зэрэг үндэслэл, нөхцөлийг зөв үнэлж тодорхойлсноор маргааны талаар шүүх, арбитраас гарч байгаа шийдвэрийн үндэслэлтэй байх зарчмыг хэрэгжүүлэх боломжтой болдог.

Эдийн засгийн хариулцааг зохицуулж өмчийг эргэлтэд оруулахад төрөл бүрийн шинэ гэрээний төрөл бий болж байгаагийн хирээр талуудын байгуулж байгаа гэрээ нь хууль зүйд нийцэх байгаа эсэх, чухам ямар төрлийн гэрээ байгуулахыг хүссэн, хүчин төгөлдөр болж чадсан уу гэдэгт анхаарах шаардлага бий болж байна.

Хувийн эрх зүйд гэрээ байгуулах нь талуудын хүсэл зоригийн илэрхийлэл нь нэгдэж байх үйл явц байдаг ч гэхдээ гэрээ байгуулахад хүсэл зориоос гадна оролцогч талууд хэн байх эсэх хуулийн этгээд, бусдын өмнө үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн этгээд, териин болон орон нутгийн өмчийн байгууллага/, ямар төрлийн гэрээ байгуулах/гуравдагч этгээдэд ашигтай гэрээ, нийтийн гэрээ,

¹⁰ Мөнхжаргал Т. "Бүгд Найрамдах Хятад улсын гэрээний хууль түүний онцлог", УБ. 2014, 15 дахь тал

холимог гэрээ, нэрлэгдээгүй гэрээ/тухайн төрлийн гэрээ байгуулахад ямар хууль баримтлах, гэрээний зүйл хаана оршин байгаа /гаадаа улсад / зэргийг харгалзан үзэх шаардлагатай.

Гэрээний тал өөрийн хүсэл зоригийг хүлээн зөвшөөрсэн этгээдтэй эрх үүргийн хувьд холбогдохоор нэг буюу хэд хэдэн тодорхой этгээдэд бодитойгоор, хангалттай, тодорхой илэрхийлэх замаар гэрээ байгуулдаг гэж үздэг. Гэхдээ зарим тохиолдолд тодорхой бус этгээдүүдэд хандсан хүсэл зоригийн илэрхийлэл шууд, бодитойгоор, хангалттай, тодорхой илэрхийлэхийг гэрээ байгуулах санал гэж ойлгохыг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Тухайлбал, сүүлийн жилүүдэд /электрон/ интернетээр гэрээ байгуулах мөн автомат машинуудааны гэрээ байгуулахаас энгийн түгээмэл үзэгдэл болсон. Интернетээр гэрээ байгуулахад гэрээ байгуулах журам, электрон гарын үсэг, гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээ цуцлах, электрон баримт бичгийг хадгалах, гаргаж өгөх арга, цаасан хувь гаргах арга, журмыг няяглан шалгах байж уг гэрээнээс үүсэх эрсдэлээс хамгаалагдана. Мөн нийтийн гэрээний хувьд ч гэрээний нэг тал нь тодорхой бус байдаг бөгөөд төрөл бүрийн худалдаа, тээврийн хэрэгсэл, эмнэлэг, зочид буудал, цахилгаан гэх мэт ажил, үйлчилгээгээр үйлчлэхээр нийтэд зарлаж үүрэг хүлээсэн иргэн, байгууллага гэрээний нэг тал болдог болдог ба тодорхой бус этгээдүүд уг гэрээг байгуулахаар хандсан тохиолдолд гэрээг байгуулсан гэж үзж эрх зүйн үр дагавар үүсдэг билээ.

Гэрээний саналыг гэрээ байгуулах санал гаргагчид хүлээн авсан нөхцөлд саналыг хүлээн зөвшөөрснөө нотолж буй нөхцөлд л гэрээ байгуулагдсанд тооцдог. Иймээс бичгээр байгуулсан гэрээ нь гарын үсэггүй, оноогоүй, тэмдэг, тамгагүй, гэрээний гол нөхцөлөө бүрэн тохироогүй, эсхүл гэрээг байгуулах эрх бүхий этгээд байгуулаагүй, гэрээг хожим нөхж байгуулсан, талууд тохиолцсон тохиолцооноосоо өөр төрлийн гэрээ байгуулсан, тухайлбал Хамтран

ажиллах гэрээ байгуулахаар хүсэл зоригоо нэгтгэсэн атлаа зээлийн гэрээ байгуулсан, зөвшөөрөл шаардагдах гэрээг холбогдох зөвшөөрөлгүйгээр байгуулах, тусгай бүртгэл шаардсан гэрээг зохих газар нь бүртгүүлээгүй байх явдал түгээмэл гардаг. Мен өнөөдөр аман хэлбэрээр гэрээг түгээмэл байгуулах болсон тул гэрээнд байгуулсан цаг хугацаа тодорхойлжүү, гол нөхцөлөө бүрэн ойлголцоогүй байх, хүсэл зоригоо нэгтгэж чадаагүй байх явдал нийтлэг байна. Тухайлбал, Орон сууцыг худалдах, худалдан авах гэрээ байгуулж, гэрээний үүргээ харилцан биелүүлэхээс уг орон сууцыг бэлзгэлэх гэрээ давхар байгуулан, бэлзгэлэлийн гэрээгээр өмчлөх эрхээ шилжүүлдэг.

Гэрээний саналыг заасан хугацаанд эсхүл түүний негеэ тал хүлээн авсны дараа буцаан татах тохиолдолд тодорхой үр дагаж авч үүсдэг. Герман, Итали, Япон зэрэг улсад гэрээний саналыг негеэ тал хүлээн авсны дараа санал гаргач нь буцаан татах эрхгүй.¹¹ Харин Францын Иргэний хуульд зааснаар саналыа буцаан татах болох боловч негеэ талд учирсан хохирлыг нөхөн төлөх ёстой байдаг.¹²

Түүнчлэн гэрээ байгуулсан хугацааг үндэслэлтэй тодорхойлох нь гэрээний талуудын хооронд гэрээний харилцаа, эрх, үүргэгүсэх цаг хугацааг тооцоход ач холбогдолтой юм. Гэрээ байгуулах хугацааг гэрээ байгуулах саналыг хүлээн авч, хариу илгээсэн хугацаагаар, эсхүл саналд өгсөн хариу нийцсэн үеэр, бичгээр байгуулсан гэрээнд огноогоор нь тодорхойлж байгаа боловч зарим гэрээнд гэрээг хэрэгжүүлэх хугацааг тусгайлан тохиролцоо явдал байдаг тул гэрээний эрх үүргэг гэрээг байгуулсан үесэс үүснэ гэсэн нийтлэг ойлголттой тохирдоггүй.

Зах зээлд орсон үеэс хэрэглэгдэж эхлээд байгаа гэрээг байгуулах өвөрмөц хэлбэрийн нэг

¹¹ Герман улсын Иргэний хууль. 145- дахь заалт. Итали улсын Иргэний хууль. 1326- дахь заалт. Япон улсын 521- дахь заалт.

¹² Франц улсын Иргэний хууль. 1714- дахь заалт.

нь үнэ хаялцуулах болон уралдаан хэлбэрээр гэрээ байгуулах явдал юм. Гэрээ байгуулах энэ хэлбэрийн онцлог нь сонирхогч /оролцогч/ тал нь нэг этгээд байхыг тогтоосон журмаар зөвшөөрдөггүй, хоёр буюу түүнээс дээш этгээдийн оролцуулахыг шаарддаг. Үнэ хаялцуулах ажиллагаа нь дуудлага худалдаа явуулах, уралдаан нь тендер шалгаруулах замаар хэрэгжих хэлбэршиж байгаа бөгөөд практикт үзгээр ажиллагааны талаар ялагчийг буруу тодорхойлсон, ялагч бус этгээдтэй гэрээ байгуулсан, эсхүл эдгээр хэлбэрийн талаар холбогдох хуулиар тогтоосон журам зөрчсөн тухай гомдол гарч байгаа нь мэн л гэрээний хүчин төгөлдөр байдалтай холбоотой. Ялсан этгээд нь тэмдэглэл гарын усгэг зурахаас зайлсхийвэл тавьсан дэчингээ алддаг бөгөөд талуудын аль нэг гэрээ байгуулаас зайлсхийвэл негеэ тал гэрээг байгуулсандаа тооцож, үүргийн гүйцэтгэлийн хангуулах, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх шаардах эрхийн хэм хэмжээний хэрэгзэг анхаарууштай.

Түүнчлэн хууль зүйн хувьд гэрээ хүчин төгөлдөр байх бас нэг шалгур нь хуульд заасан тохиолдолд заавал байгуулах гэрээг байгуулахад/шүүхийн шийдвэрээр, нийтийн гэрээ, шударга бус өрсөлдөөнтэй холбогдох гэрээ, дуудлага худалдаа, нийтийн гэрээ/талуудын хувьд гэрээний чөлөөт байдлын зарчим үйлчлэхгүй байх, гэрээ байгуулахаас зайлсхийвэл гэрээг шүүхийн шийдвэрээр албадан байгуулж болдог эдгээр онцлог шинж нь нийтлэг байдлаар байгуулах гэрээний ойлголттой тохирдоггүй.

III. Гэрээ дуусгавар болгох үндэслэл журам, түүний хууль зүйн үр дагавар

Гэрээ дуусгавар болох нь гэрээний дагуу үүссэн харилцаа ямар нэг үр дагаваргүйгээр дуусгавар болох агуулыг илрэхийлдэггүй бөгөөд тухайн харилцаатай холбоотой гэрээний талуудад учирсан хохирлыг нөхөн төлөх, хууль болон гэрээний

тохиролцооны улмаас шилжүүлсэн зүйлийг буцаах асуудлыг шийдвэрлэх эрх зүйн зүйн үр дагавартай байдаг.

Гэрээний дусгавар болох явдлыг зөв тодорхойлж чадсанаар, гэрээний үргээг гүйцэтгэсэн үү, үүргээ зөрчсөн эсэх, гэрээгээр тохиролцсон гэрээний хариуцлагыг тооцох үндэслэл байна уу, хохирол тооцох эсэх, гэрээнээс татгалзах цуцлах асуудал нь хууль зүйн үндэслэлтэй юу гэдгийг тогтоох боломжтой, зөв дүгнэлт гаргах үндэстэй болох юм.

Гэрээ нь үүрэг үүсгэх үндэслэл болох бөгөөд гэрээ дусгавар болох үндэслэл нь үүрэг дусгавар болгох үндэслэлийн адилдаар дуусгавар болдог. Гэрээ дусгавар болоход эрх зүйн ямар үр дагаврыг бий болгож байгаагаас хамааран гэрээнээс татгалзах /contract refusal- 계약거부/, болон гэрээг цуцлах /termination of contract- 계약의제/ гэсэн ойлголт нь гэрээг дусгавар болгох үндэслэлд багтдаг.

Бусад улсын хувийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулахад гарээнээс татгалзах, гэрээг цуцлах ойлголтын нийтлэг шинж нь гэрээнээс татгалзах, гэрээ цуцлахын аль аль нь эрх зүйн харилцааг өөрчлөх нэг талын хэлцэл байдаг, гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах тухай хүсэл зоригийн илэрхийлэл нь негеэ талын зөвшөөрлөөс үл хамааран хүчин төгөлдөр байдаг, гэрээнээс татгалзах, гэрээг цуцлахад хуульд заасан утвар нөхцөл бурдсан байхад хангалттай байдаг нь тодорхой харагддаг.

Харин гэрээг цуцлах асуудал нь гэрээний хэрэгжилтийг яг тухайн мөчид зогсоох, гэрээнээст татгалзах нь гэрээний хэрэгжилтийг гэрээг байгуулахаас өмнөх байдалд хүртэл буцааж зогсоох ойлголт гэсэн ялгаатай үр дагаварт хүргэдэг, тодруулбал үргийн харилцаа нь гэрээг цуцлах тохиолдолд бүрмсөн дусгавар болдог, тухайлбал банкны зээл, эд хөрөнгө хөлслөх гэрээ, түрээс, лизинг, франчайзинг, факторинг, хамтран ажиллас гэрээ, хөдөлмөрийн гэрээ зэрэг харьцаангуй удаан хугацааны гэрээ хамаардаг.

Харин гэрээнээс татгалзах тохиолдолд тодорхой эрх, үүрэг дусгавар болдог ч талууд гэрээний гүйцэтгэлийг биет байдлаар нь, түүнчлэн гэрээ биелснээс олсон ашгийг буцааж өгөх, мөнгөөр нөхөн төлөх, хариу гүйцэтгэсэн үүргийг оруулж төлөх хүртэл үүргийн харилцаа хадгалагдаж улддэг.

Гэхдээ нэг анхаарах асуудал бол гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах веер агууллыг илэрхийлдэг ч нэг нь негеөтэйгээ харилцан уялсан эрх зүйн үр дагаврыг хадгалж байдаг, тодруулбал гэрээний үүргээ зөрчигдсөнөөс гэрээнээс татгалзалаа энэ тохиолдолд гэрээг цуцалж болдог. Тухайлбал, үүрэг гүйцэтгэхэд нэмэлт хугацаа тогтоосноор ямар нэг үр дүнд хүрч чадахгүй нь тодорхой бол хүндэтгэн үзэх үндэслэлээр гэрээг цуцалж болно.

Манай улсын практикт гэрээний талууд гэрээнээс татгалзах, гэрээ цуцлах, буцаан шаардах ойлголтуудын ялгаа, мөн харилцан хамаарлыг ялгаж нэхэмжилэлийн шаардлагыг тодорхой гаргаж чаддаггүй. Тухайлбал, гэрээний хугацаа дусаагай үед зээлдэгч төлберийн чадваргүй болсон шалтгаанаар зээлдүүлэгч гэрээнээсээ татгалзаж, зээлийн хүүгээ нэхэмжилснийг зээлдүүлэгч гэрээнээсээ татгалзаж байна гэж үзэх үү, гэрээгээ цуцалж байна гэж үзэх үү? Одоогийн байдлаар зээлдүүлэгчийг гэрээнээсээ татгалзсан гэж үзэж нэхэмжилэлийг шийдвэрлэж байна.

Гэрээнээс үүссэн маргааныг шүүхээс шийдвэрлэхэд Иргэний хуулийн 42,43,56 дугаар зүйл, гэрээний тусгай төрлийн зохицуулалтаас гадна 196-р зүйл буюу "Гэрээ байгуулсандаа тооцох" үндэслэлийг анхаарч хэрэглэх нь зүйтэй гэж бодож байна.

III. Гэрээний эрх зүйн харилцаанд хэрэглэгдэх эрх зүйн эх сурвалжийг сонгох

Аль ч улс орон иргэний, худалдааны эрх зүйн харилцаанд нэг тал болж оролцсон нөхцөлд шүүх, арбитр нь шаардлагатай бол

иргэний хэрэг, маргаан шийдвэрлэх болон иргэний эрх зүйн харилцааг зохицуулахад гадаад улсын хууль, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсэн зан заншлын хэм хэмжээг сонгон хэрэглэж байна. Ялангуяа гадаад эдийн засгийн гэрээ, иргэн, гэр булийн хэрэг маргааныг үндэсний шүүх, арбитрт шийдвэрлэхдээ зарим тохиолдолд гадаад улсын хуулийг хэрэглэх зайлшгүй шаардлагыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй болсон.

Гадаад эдийн засгийн гэрээ, хэлцлийг байгуулах нехцөл, журам нь тухайн улс аль эрх зүйн системд хамаардгаас шалтгаалдаг. Хувийн эрх зүйн системтэй Монгол, хуучин ЗХУ, Европын ихэнх орнууд /Англи орохгүй/, Латин, Америк, Турк, Индонези, зэрэг орнуудад хэллэлцээрт оролцогч талууд өөрөөр шийдвэрлэгүй бол зөвхөн Иргэний хуулийн ихэнх заалт нь гэрээний хувьд хэрэглэгдэн. Үнээс үүдээд маш товчихон гэрээний тесел боловсруулж заниссан нь ажиглагддаг. Монгол орны гэрээний эрх зүйн ёнгөрсэн үед маш өвөрмөцөөр хөгжик ирсэн. Социалист орнуудад иргэний гэрээнд зарим эрх чөлөө оршиж байсан боловч ихэнх гадаад гэрээ, хэлцлийг төреес зохицуулж ирсэн. Сүүлийн жилүүдэд зах зээлийн эдийн засаг, барууны орны гэрээний гол санааг өөртөө агуулсан шинэлэг гэрээний төрлүүд бий болж, түүнчлэн харилцан ойлголцох зарчмыг сонгож Азийн элемент бүхий гэрээг байгуулах чиг хандлагатай болж байна.

Нийтийн эрх зүйн системтэй Англи, АНУ, Канад, Австрали, Энэтхэг. Шинэ Зеланд зэрэг орнуудад эрх зүйн хэм хэмжээг шүүгчид, хууль тогтоогчид үе уламжлан өмнөх хэргүүдийн шүүхийн шийдвэр нь эрх зүйн зарчмыг тогтоож ирсэн.¹³ Эдгээр гарасан шийдвэрийг бусад шүүгчид заавал дагаж мөрдөх ёстой. Иймээс хялбархан хэрэглэж болох эрх зүйн хэм хэмжээг боловсруулан батлаагүй учир нийтийн эрх зүйн системтэй орнууд маш дэлгэрэнгүй гэрээ байгуулахад хурдэг байна. Сүүлийн үед олон

тооны хууль тогтоомж батлан гаргаж байгаа боловч зарим эрх зүйн салбарт, ялангуяа гэрээний эрх, үүрэгтэй холбоотой асуудал дээр шүүгчийн мэдлэг чадварт үндэслэгдсэн шүүхийн шийдвэрт төвлөрсэн.¹⁴

Гэхдээ ихэнх улс орны зөрчилдөөний эрх зүй нь гадаад эдийн засгийн гэрээ, хэлцэлд оролцогчдод тухайн хэлцэлд хэрэглэгдэх хууль тогтоомжоо тохиролцоо замаар тодорхойлох боломжийг олгосон байдал. Энэ нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсэн талуудын хүсэл зоригийн чөлөөт байдал гэсэн зарчмитай холбоотой.

Гэвч хэрэглэгдэх эрх зүйгээ сонгох үед гадаад улсын худалдаа, эж ахуйн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийг мэдэхгүйгээс бэрхшээл гардаг. Хэрэв гэрээнд хэрэглэгдэх хуулиа сонгоогүй үед гэрээний нехцелийн талаар маргаан гарвал аль нэг холбогдох улсын зөрчилдөөний хэм хэмжээг үндэслэн хэрэглэгдэх хуулийг тодорхойлно. Ийм зөрчилдөөний хэм хэмжээ нь улс будд өөр өөр байж болно. Гэрээнд тодорхой улсын хуулийг хэрэглэхээр заасан бол тухайн орны хуулийн зүйл заалтыг мөрднө. Ихэнх улсын хуулиар гадаад эдийн засгийн хэлцлийн зарим тодорхой төрөлд хэрэглэгдэх туслах хэм хэмжээг зааж өгсөн байдал.

Талууд өөрөөр тохиролцоогүй бол үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа явуулах, мэргшүүлэх, хорших, их барилга барих, угсрал, бусад ажил гүйцэтгэх гэрээнд нутаг дэвсгэр дээр нь уг ажиллагааг явуулж байгаа буюу гэрээний үр дунд бий болж байгаа улсын хуулийг хэрэглэнэ. Гадаад улсын хуулийн этгээд буюу иргэн оролцсон хамтарсан үйлдвэр байгуулах тухай гэрээнд тухайн хамтарсан үйлдвэрийн оршин байгаа улсын хуулийг хэрэглэдэг.

Гэрээний талууд гэрээний дагуу эдлэх эрх, үүрэг, гэрээний агуулга, гэрээгээр хүлээсэн үүргээ

¹³ Robbins collection, <https://www.law.berkeley.edu/library/robbins/CommonLawCivilLawTraditions.html>

¹⁴ ОХУ, Австри, Унгар, Польш, Турк, ХБНГУ, Чех, Словак, Швейцари, БНХАУ зэрэг улсууд хууль тогтоомжийн зарчмыг хэрэглэсэн байдал.

Биелүүлэх, гэрээ дуусгавар болох буюу хүчин төгөлдөр бус болох гэрээний үүргээ гүйцэтгэхгүй буюу зохих ёсоор гүйцэтгэхгүй байж зэрэг асуудлаас үүсэх үр дагаврыг гэрээ байгуулагч талууд харилцан тохиролцож тодорхойлсон улсын хуулиар зохицуулдаг нийтлэг чиг хандлагатай байдаг. Харин талууд хэрэглэх хуулийг сонгоогүй бол дор дурдсан гэрээний хувьд нэр заасан талын оршин байгаа буюу үйл ажиллагааныхаа голыг явуулдаг улсын хуулиар хэрэглэх

хуулийг тодорхойлно.¹⁵ Хеен хэлэлцэх хугацааны асуудлыг тухайн харилцааг зохицуулахад хэрэглэж байгаа тухайн улсын хууль, тухайн улсын нэгдэж орсон олон улсын гэрээний дагуу шийдвэрлэнэ.

1980 оны Венин конвенц нь зерчилдээний хэм хэмжээ агуулаагүй байдаг учир олон улсын бараа худалдаан дах зерчилдээний асуудлыг шийдэх зорилгоор 1985 онд Олон улсын бараа худалдах худалдан авах гэрээнд хэрэглэгдэх эрхийн тухай Гаагийн Конвенцийн баталсан юм. Уг конвенц нь бүх төрлийн бараа худалдаа, түүний дотор үнэ хаялцуулах болон биржийн худалдааг хамардаг. Энэ конвенц одоо зааснаар худалдах, худалдан авах гэрээг нь талуудын сонгосон хуулиар зохицуулагдана. Хэрэв талууд хуулиа сонгоогүй бол худалдах, худалдан авах гэрээг гэрээ байгуулах үед худалдагчийн үлдэвэр, аж ахуйн газар байгаа улсын хуулиар зохицуулна.

Олон улсын болон дотоодын худалдааны гэрээний инкотермсн /гэрээний суурь нэхцэл/ барааг худалдан авах талаар худалдагч, худалдан авагчийн үүргийг тодорхойлж, барааны гэмтэл, гэнэтийн сүйрлийн хариуцлага, риск, худалдагчас худалдан авагчид шилжиж буй ёэ зэргийг тогтоож буй тодорхой

нэхцэлийг тодорхойлсон байдаг. Суурь нэхцэлүүдийг томъёогоор тайлбарлах нь улс орон бүрд вээр вээр байдаг. Иймээс үүний нэгтгэх зорилгоор Олон улсын худалдааны танхимаас ОУХП 1936 онд үйлдвэрлэл худалдааны практикт өргөн хэрэглэгдэж заншлын хэм хэмжээг нэгтгэн эмхэтжэж, худалдааны нэр томъёог тайлбарлах Дүрмийг "Олон улсын худалдааны нэр томъёо"¹⁶-г гаргасан байдаг.

Дүгнэлт

Даяарчлалын эрин үед гэрээний эдийн засгийн үүргийн ач холбогдол улам өсөхийн хирээр гэрээний эрх зүйн хөгжлийн нийтлэг жишиг, хөгжлийн чиг хандлагыг харьцуулан судлах, түүчинчлэн гэрээний эрх зүйн харилцаанд олон улсын гэрээ, гадаад улсын хэм хэмжээг хэрэглэх, гадаад улсын хуулийн агуулгыг тодорхойлох, гэрээний талууд хуулийг сонгох, шаардах эрх шилжих зэрэг асуудлыг үндэсний хувийн эрх зүйн салбарт нарийвчлан судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

¹⁵ W- works үйлдвэрээс шилжүүлэх FCA-Free carriage тээвэрлэгчид егнээр эрх чөлөөтэй, FAS-Free along ssde ship-xelleg онгоцны хажууд тальнаар эрх чөлөөтэй, FOB- Free on board- хөлөг онгоцны тавцанд дээр тавьснаар чөлөөтэй, CAF/CPI- Cost and freight-Өргөтгөг тээврийн зардал, CIF- Cost, insurance, freight-Өргөтгөг даатгал, тээврийн зардал, CPT-Carnage paid to ... нарласан өргөтгөг хүртэл тээврийн зардал төлгөдсөн. CIP- Carriage and insurance paid to ... нарласан өргөтгөг хүртэл зардал, даатгал төлгөдсөн. DAF-Delevered at frontier...- Хил хүртэл нийлүүлсэн, DES-Delevered ex ship-Хөлөг онгоцноос нийлүүлсэн, DWO- Delevered ex quay -Зогсоолоос нийлүүлсэн, DDU- Delevered duty unpaid -Хураамж төлгөдөгүй нийлүүлж, DDP- Delevered duty paid -Хураамж төлгөдсөн нийлүүлжт

¹⁶ Худалдах-худалдан авах гэрээнд худалдагчийн, Эд хөрөнгө хөлслөх гэрээнд хөлслүүлэгчийн, Хадгалалтын гэрээнд хадгалагчийн, Даалгаврын гэрээнд даалгавар гүйцэтгэгчийн, Тээвэрлэгчийн гэрээнд тээвэрлэгчийн, Зээлийн гэрээнд зээлдүүлэгчийн, Батлан даалтын гэрээнд батлан даагчийн, Барьцааны гэрээнд барьцаапуулагчийн

ХӨРШИЙН ЭРХИЙН ЗОХИЦУУЛАЛТ, АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Иргэний эрх зүйн тэнхимийн Ахлах багш
Ц.Даевхарбаяр

Хөршийн эрхийн талаарх хэм хэмжээний ойлголт нь хувь хүний эрхийг зэргэлдээс орших хөрш этгээдийн эрхтэй нийцүүлэх, зайлшгүй тохиолдолд хязгаарлах явдал байдаг. Хөрш залгаа эд хөрөнгөө өмчлөгч буюу эзэмшигч нь хуулиар тогтоосон эрх, үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд нөгөө талынхаа эрхийг харицсан хундэтгэх үүрэгтэй болохыг Иргэний хуулийн 134.2-т заажээ. Хувь этгээдийн тодорхой эрхийг хязгаарлах нь түүний дураар авирлах болон бусдын эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлж байгаа явдал ба ийнхүү хязгаарлагдсанар өмчлөх эрх болон эзэмшил нь х хязгаарлагдана. Эндээс үзвэл, хөршийн эрхийн хязгаарлалт нь тодорхой этгээдийн эрхийг хязгаарлах ойлголт болохоос нийтийн эрх, ашиг сонирхлыг хязгаарлах явдал биш болох нь харагдаг боловч суурьшмал амьдралын хувь шинжид хувийн эрх ашиг сонирхлоос гадна нийтийн эрх ашиг зайлшгүй хамгаалагдах нэгэн эх үүсвэр болж байна.

Үүнтэй холбоотой, хөршийн эрхийн зохицуулалтын шинж

чанарыг тодорхойлоход тухайн хэм хэмжээний мөн чанарын асуудал зайлшгүй хөндөгднө. Хөршийн эрх нь нийтийн болон хувийн эрх зүйн аль алинд хамааралтай байдгийг анхаардаггүйгээс зохицуулалт, үсэх маргааны харьяалал зөрчигдэх тохиолдол байдаг. Учир нь хөршийн эрхийн зарим нэгэн өмчлөх эрхийг хязгаарлаж байгаа эрх зүйн зохицуулалтын үндэс суурь нь нийтийн эрх ашигийн хүрээнд хамаардаг ба нийтийн эрх ашигийн үүднээс тогтоосон хэм хэмжээг хэрэгжүүлэх явцад тодорхой нэгэн өмчлөгч этгээдийн эрх ашиг хөндөгдөх, хязгаарлагдах нь бий. Иймээс хөршийн эрх зөвхөн хувийн эрх зүйн ойлголт гэж үзэх боломжгүй болох нь харагдана. Жишээлбэл: барилга хоорондын стандарт зай нь нэг талаас хувь хүний эрх ашигийг хөндсөн ойлголт болдог бол нөгөө талаар тухайн хот суурины газар төлөвлөлт, хотын төлөвлөлтийн анхааралд байх асуудал болж гарч ирнэ.

Хөршийн эрх, хөрш этгээдийн эрхийг хөндөхгүй байх асуудал өөрөө хувийн эрх зүйн зохицуулалтад хамаарагдах хэдий ч хэрэгжиж байгаа байдлын хувьд нийтийн захиргааны зүгээс гаргаж байгаа журам, дүрэм "нийтийн", "олонхийн" эрх ашигт нийцэж байгаа эсэх асуудал гарах, эдгэр олонхийн эрх ашигийг тусгайлан эрх ашигтай нийцүүлэх шаардлага хэрэгцээ гардаг онцлогтой.

Хөршийн эрхийн зохицуулалтыг уламжлалт хандлагаар үзэж тус эрх нь хувь хүний эрхийг хамгаалахад оршдог тул хувийн эрх зүйд хамааралтай¹ гэж үзэх хандлага байхад нь хөршийн эрх нь зөвхөн хувь хүний эрх, ашиг

¹ Е. В. Васильковский. Учебник гражданского права. М.: Статут, 2003. 286 с.

сонирхол бус нийтийн эрх ашгийг илэрхийлдэг учраас уг асуудлыг илүү өргөн утгаар буюу шинэлгээ байдааар авч үзэх нь зүйтэй /И.Б.Новицкий/ гэж үзэх чиг хандлага байгаа болно.

Хөршийн эрхийн асуудал орчин үед чухлаар тавигдах болсон учир нь

Нэгдүгээрт. Хөршийн эрх нийтийн ашиг сонирхлыг илэрхийлж байгаа тохиолдолд хөршүүдийн аль нэг тал нөгөө талынхаа эрх ашгийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх субъект нь тодорхой бус байгаа нөхцөлд зөвхөн өрийн зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр шуухэд хандах боломжгүй. Энэ тохиолдолд эрх бүхий байгууллага асуудалд оролцож зохицуулалт хийх шаардлагатай болно. Хоёрдугаарт. Хөршийн эрх нь диспозитив зарчмыг үндэслэх тул хөршүүд хоорондоо зөвшилцсөний үндсэн дээр мэргааны явцад харилсан тохиролцох боломж гарч ирдэг хэдий ч энэ байдал нийтийн эрх зүйн хүрээнд тогтоосон хэм хэмжээг харшилах тохиолдолд байна.

Хөршийн эрх гэж нэрлэгдэхгүй, харин тухайн захирагааны актын улмаас хуулиар хамгаалагдсан эрх ашиг хөнддөгдсөн гэж иргэд, хуулийн этгээд захирагааны шүүхэд нэхэмжлэл гаргадаг нь захирагааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаана онцлог боловч бодит байдалд, нийтийн захирагаанаа бусдад олгосон эрх, угээрхийг хэрэлжүүлэх нь эрх зүйн харилцааны оролцогчийн өмчлөх эрх, эд хөрөнгөө зээмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хөндсөн, зөрчсөн гэж маргадаг нь иргэний эрх зүйн хөршийн эрхийн зохицуулалтын үндсэн шинжийг агуулдаг ба иймд нийтийн эрх зүйн хүрээнд, нийтийн захирагаанаас гарч байгаа эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудад бусдын эрхэд нөлөөлж байгаа нөлөөлөл байгаа эсэх, уг нөлөөлөл хэвийн хэмжээнээс хэтэрсэн бол ямар зохицуулалт байх, хэвийн хэмжээнээс хэтэрсэн гэж юуг ойлгох зэрэг хөршийн эрхийг зохицуулсан хэм хэмжээг харгалзах шаардлагатай юм. Тухайлбал: НИТХ-ын 2014 оны 5-14 тоот тогтоолоор,

"Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх загвар зураг батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны "журмын" баталсан байх ба уг журмын 3.1-д "Нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллага иргэн, хуулийн этгээдийн өмчлөл, ашиглалт, эзэмшилийн газарт барилга барих асуудлыг хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцуулэн шийдвэрлэж, барилга барих зөвшөөрөл олгоно гэж засан ба зөвшөөрөл авахын тулд шаардлагатай тохиолдолд иргэд, хуулийн этгээдтэй гэрээ байгуулсан байхыг, ингэхдээ: орон сууцны хороолол дундах барилгажаагүй талбайд барилга барих тохиолдолд нэгж талбарын хил хязгаарын тогтоосон эргэлтийн цагүүдээс дор дурдсан зайд байрлах үл хөдлөх хөрөнгийн өмчлөгчөөс 2-4 давхар барилгад 15 метр, 5 давхар барилгад 21 метр, 9 давхар барилгад 30 метр, 12 давхар барилгад 40 метр, 16 давхар барилгад 45 метр, гэр хорооллын нэгж талбарт байгаа эзэлбэр газарт барилга барихад зөвшөөрөл авахаар заажээ. Уг журмаар, баригдах барилга орон сууцны барилгаас ямар зайд байгаагас хамааран, иргэд хуулийн этгээдийн зөвшөөрлийг авах талаар заасан нь баригдах барилга нарны гэрэл хаахгүй. үзэгдэх орчинг хязгаарлаагүй зэргээр ямар нэгэн нөлөөлөл байхгүй гэж үзсэн тохиолдолд зөвшөөрөл өгөх байдлаар зохицуулсан байна.

Хөршийн эрх иргэний хуульд уламжлагдан хуульчлагдаж ирсэн. Тогтолцоо болон практик талаасаас хоорондоо ихээхэн ялгаатай зүйлүүдийг нэгэн цогц ойлголт болгох гэж байгаа учраас ойлгомжгүй байдал бий болдог. Хөршийн харилцаанд зан заншил ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Зан заншил нь талуудын хоорондох маргааныг зохицуулах хамгийн дөт арга зам болох нь гарцаагүй юм. Гэхдээ зан заншлын хэм хэмжээ үйлчлэх нь

багасаж байгаа өнөө үеийн амьдралд, хөршийн эрх зүйн харилцаанд ч нэгэн адил байдал үүсэхийг угүйгсэх аргагүй. Хөршийн эрх зүйн харилцаанд хувь этгээдийн өмчлөх эрх, өмчлөлийн зүйл хөндөгдхөөвөс гадна болон нийтийн өмчлөлийн эд зүйлс дээр ч хөршийн эрхийн асуудал үүсэх боломжтой уураас эрх нь хөндөгдэх байгаа этгээд, өмчлөлийн объектыг тодорхойлох нь маргааныг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг шийднэ.

Хөршийн эрх зүйн харилцааны оролцогчид Хөршийн эрх зүйн харилцааны оролцогчид гэдэгт хэнийг ойлгох вэ. Эд хөрөнгө өмчлөгч зэвлэл эд хөрөнгийг зээмшилдээ бийглак байгаа зээмшигч байна. Амьдралд, хөршийн эрхийн зохицуулалт нь өмчлөх эрхийн бурдлийн нэг ашиглах эрхийг хэрэгжүүлж байгаа явцад илэрдэг ба харин ашиглах эрх нь өмчлөгчид, зэвлэл өмчлөгчөөс хөрөнгийг эрхийн хамтаар шилжүүлэн авсан этгээдэд байгаа нь хөршийн эрхийг иргэний эрх зүйн бусад субъектив эрхээс ялгах нэг онцлог гэж үзэх боломжтой. Харин уг эрхийг өмчлөгч этгээд дангаараа хэрэгжүүлж байна уу. Бусад хөрш нарын хамтаар шаардаж байгаа эсэхийг няяглалт нь хэний хүсэл зоригийн илэрхийлэл болохыг тогтооход ач холбогдолтой байдаг².

Хууль ёсны зээмшигч болох түрээслэгч, хөлслөгч, итгэмжлэгдсэн өмчлөгч түүнчлэн барьцаалагч этгээдэд барьцааны эд хөрөнгийг ашиглах эрх олгогдсон бол энэхүү эрх түүнд үүсч учраас хууль ёсны зээмшигчээс хасаж болохгүй, нэг талаар хөрөнгийн эзэн, өмчлөгч л хөршийн харилцаанд оролцох боломжтой гэж үздэг боловч зарим тохиолдолд /зөвхөн өмч хөрөнгө зээмшигчид/ дүрэмд үл хамаарах зүйл байж болох талтай. Иргэний хуулийн 136-р зүйлд зааснаар, ургсал усгыг ашиглах талаарх зохицуулалт тусгагдсан бөгөөд ургсал ус гэдэгт байгалийн голын ус төдийгүй нийтийн хэрэгцээнд зориулагдан бүтээсэн усан

сан зэрэг ч байхаас гадна газрын гүний ус, үйлдвэрлэлийн явцад гарах хаягдал усны асуудал ч хөндөгдхөх тул үүнтэй холбоотой зээмшигч, эсвэл заавал зээмшигч гэлгүй өөрийн усны хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа этгээд байх боломжтой.

Хөршийн эрхийн харилцаанд өртөгдхөх зүйл, объектүүд: Ашиглах эрхийг хэрэгжүүлэн хөршийн эрх зүйг хэрэглэдэг объектүүдийн хувьд, дээр тэмдэглэнсээр, зөвхөн үл хөдлөх хөрөнгө байх ба хөршийн эрх зүйн харилцаанд оролцогч талууд нь зөвхөн үл хөдлөх хөрөнгийн өмчлөгч, зээмшигч, мөн үл хөдлөх хөрөнгийг ашиглах явцад эрх нь хөндөгдэх байгаа этгээд байх ёстой. Хөршийн субъектив эрхийн хувьд маргаантай байдаа асуудал нь хөршийн эрхийн хэм хэмжээнд хөдлөх хөрөнгийг авч үздэггүйд байдаг юм.

Заримдаа хөршүүд хөдлөх хөрөнгөтэй холбоотой ч хоорондоо маргах тохиолдол байх бөгөөд, тухайлбал тэдний аль нэг нь хөршийнхэе газар дээр машинаа тавьсан бол маргаан үүсэх боловч үүнийг өмчийн эрх зүйн ерөнхий зохицуулалтыг үндэслэн шийдвэрлэнэ.

Хөршийн эрхийн хүрээнд газар болон барилга байгууламжтай холбоотой харилцааг дийлэнх байдлаар авч үздэг. Хөршийн эрхийн хүрээнд хамаарах маргаан нь газар / өмчлөгч, зээмшигчийн газар дээр барилга, байгууламж барих, хөршийн өмчийн газар дээгүүр дамжин өнгөрөх зэрэг хамаарч болно/, мөн хөршүүдийн хоорондын барилга, байгууламжийн маргаан /нийтийн зориулалттай орон сууцанд амьдрагсад болон зэргэлдээ орших барилгын өмчлөгч нарын маргаан / байх зэрэг багтана.

"Хөрш зэргэлдээ газар", "Хөрш зэргэлдээ сууц" гэдэг ойлголтыг нарийвчлан тодруулах хэрэгтэй. "Хөрш зэргэлдээ" гэдэг нь заавал "бие биетэйгээ запгаа, зэрэгцэн байх" гэсэн үг биш юм. Газрын хувьд гэвэл, хөрш зэргэлдээ газрууд нь ерөнхий нэг хилтэй байх албагүй

² + зээмшигч хөршийн эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан верин ашиг олониргүй хамгаалын болно.

(хэдийгээр хөршийн эрх зүйн хэм хэмжээнд юуны өмнө энэ тохиолдлыг авч үздэг ч гэсэн), хөршийн эрх зүйн хэм хэмжээг хоорондоо нэг буюу хэд хэдэн эзэмшлийн газраар зааглагдан хиллэдэг байгаа зэргэлдээ газарт хэрэглэж болно. Энд нэг эзэмшлийн газрыг ашиглах явцад нөгөөд ямар нэг / ус урссан, утас униар үүгэсэн гэх мэт/ байдлаар өрийн эрхийг хэрэгжүүлэх боломжийг хязгаарласан нөлөөлөл үзүүлсэн нэхцэлд хөршийн эрх зүйн хэм хэмжээг хэрэглэн. Сууцны хувьд, хөрш зэргэлдээ сууцнууд заавал нэг ханаар тусгарагдсан, эсвэл нэгнийх нь шал, нөгөөгийнхөө тааз нь байх албагүй. Энд мөн л нэг сууцыг ашиглах явцад нөгөөд ямар нэг үр нөлөө үзүүлсэн эсэхийг харгалzan үзэж шийдвэрлэнэ. Хэрэв энэ нөлөөлөл тус байрнаас хэтрэч, өөр нэг байрны сууцанд нөлөөлсөн тохиолдолд үүнээс үдэн гарсан маргааны шийдвэрлэхэд хөрш зэргэлдээ газрын хөршийн харилцааны эрх зүйн хэм хэмжээг баримтлах ёстой (учир нь хөрш зэргэлдээ газар эзэмшигчдийн эрхийг хөндөж байгаа хэрэг юм).

Хөршийн үл хөдлөх хөрөнгөнд үзүүлэх нөлөөллийн үндсэн хэлбэрүүд: Хөршийн эрхийн хүрээнд гарсан маргааны шийдвэрлэхэд хэм хэмжээг авч үзэхийн өмнө, хөршийн үл хөдлөх хөрөнгөнд үзүүлэх нөлөөллийн үндсэн хэлбэрүүд, хөршийн эрхтэй холбоотой маргааныг шийдвэрлэх үед баримтлах зарчмуудын талаар дурдах нь зүйтэй.

Хөршийн эзэмшлийн газар, эсвэл сууцад үзүүлэх нөлөөлөл нь хоёр үндсэн хэлбэртэй байж болно: Үүнд: нэвтрэх чадвартай, жингүй зүйл /үнэр, утас, тоос, широо г.м./, негөйтээгүүр дуу чимээ болон материаллаг зүйлс / ус, мод, барилгын суурь г.м/ байна. Эдгээр нь хөршийн үл хөдлөх хөрөнгө, эсвэл эзэмшлийн газрын хил хязгаарт нэвтрэхэд үзүүлэх нөлөөлөл, нөлөөлөл нь бусдын өмчлөх эрх, ашиглах эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байгаа бол түүнийг хэрхэн зохицуулах зохицуулалт хуульд тусгагдсан байдаг.

Мөн хөршийн эрхтэй зэрэгцэн гарч ирдэг зүйл бол хүлцэх, тзвчих асуудал байх бөгөөд ИХ-ийн 135.1-д зааснаар хөрш залгаа эд хөрөнгийн нэг талын өмчлөг буюу эзэмшиг нь веерин эд хөрөнгөе ашиглахад саад болохоогруй нөгөө талын зайлшгүй шаардлагатай нөлөөллийг хориглон хязгаарлаж болохгүй бөгөөдөрөөр хэлбэл эмчлэгч, эзэмшигчийн эд хөрөнгөе ашиглах боломжийг хязгаарлаагүй нөлөөллийг тзвчих, хүлцэхийг зохицуулсан болно. “Хөршийн учруулсан таагүй байдал, тухайн байгаль орчин болон эзэмшил газрын байршил, нутгийн ёс заншилаас хамааран тэвчээрийн зохих хязгаарыг даваагүй тохиолдолд хөршууд түүнийг тзвчих ёстой”³.

Германы Иргэний хуулийн / цаашид ГИХ гэх/ 906-р зүйлд дээрхтэй тестэй, илүү дэлгэрэнгүй заасан байна. “Аливаа газар эзэмшиг, өөрийнхөө газрыг ашиглахад нөлөөлөвгүй, эсвэл үл мэдэг нөлөө үзүүлж буй бусдын эзэмшилийн газраас гарах үнэр, хий, дулаан, уур, дуу чимээ, чичиргэ болон бусад нөлөөллийг хориглон хязгаарлаж болохгүй”⁴. Чухамдаа хөршийн эрхийн зохицуулалтад тзвчих, хүлцэх нөлөөлөл гэж зайлшгүй байх ба нийтлэг дүрэм журамд зааснаар, үл мэдэг нөлөөлөл гэдгийг хууль тогтоомжоор тогтоосон стандарт, хэм хэмжээнээс хэтрээгүй байгааг ойлгож болно.

ГИХ-ийн 906-р зүйл нь хөршийн эзэмшлийн газарт мэдэгдэхүйц нөлөөг хүртэл тооцохгүй байж болохыг заасан байна. Хэрэв мэдэгдэхүйц нөлөөлөл нь өөр нэг эзэмшилийн газар ашиглах үед тухайн нутаг дэвсгэрийн хувьд ердийн нэхцэлд үүсгэгдсэн бөгөөд энэ нэхцэлд эдийн засгийн тохиромжтой арга хэмжээ авснаар арилахгүй бол үл мэдэг нөлөөлөл байж болох /зөвшөөрөгдхөх талаарх дүрэм журам жилчилнэ.

Манай улсын Иргэний хуульд хөршийн эрхийн зохицуулалт тусгагдсан нь хотжилт болон төреөс хэрэгжүүлэх

³ Гражданский кодекс Квебека. М.: Статут, 1999.

⁴ Гражданское уложение Германии. Кн. 1. М.: Волтерс Клувер, 2004.

зарим бодлогыг хэрэгжүүлэх явцад өмчлөгчийн эрхийг хамгаалах үндэс суурь бүрдсэн. Гэвч хөршийн тэвчих нөлөөлөл юу байх вэ гэдгийг тогтоохын тулд аливаа зүйлийн стандарт, үзүүлэлтийг урьдчилан тогтоосон байх ёстой байталь эдгээр норм, стандартууд тогтоогдоогүй, тогтоогдсон үзүүлэлтээ баримтлахгүй байх зэрээс болж хөршийн эрх хөндөгдөх нь цөөнгүй байна. Эдгээр стандарт, норм нь тогтоогдсон нөхцөлд иргэний субъективийн эрх хөндөгдхөгүй хэрэгжих нэг ерөнхий баталгаа болох юм⁵.

ИХ-ийн 12-р бүлгийн 101-р зүйл нь ямар нэгэн байдлаар бусдад хор хохирол учруулахыг, түүнчлэн эрхээ хэтрүүлэхийг /эрхээ хэтрүүлснээр бусдыг эрх зөрчигдэх/ хориглодог болохыг энд дурдах нь зүйтэй. Дээр өгүүлсэн бусад улс орны иргэний хуульд, газар эзэмшигчийн зүгээс үүсгэсэн "Ердийн таагүй байдал", "Үл мэдэг нөлөөлөл" бол иргэний эрхийн зөвшөөрөгдэх түвшин болохыг бидэнд харуулж байна.

Үүний зэрэгцээ хэдийгээр өмчлөгч, эзэмшигч, иргэний эрхээ хэрэгжүүлэхэд үндэслэгдсэн ч, хөршийн эзэмшилийн газарт хэрээс хэтэрсэн нөлөөлөл үзүүлэхийг хориглох ба энэ тохиолдолд хөршийн эрхийг зөрчсөн ойлголт үснэ.

Ийнхүү, эзэмшигч бусдын үл хөдлөх хөрөнгөтэй зэрэлдээ орших үл хөдлөх хөрөнгөе ашиглах явцад үл мэдэг нөлөөлөл үүсгэх нь хуулиар нэг ёсоондоо хүлээн зөвшөөрөгддөг гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, үл мэдэг нөлөөлөл нь хөршийн үл хөдлөх хөрөнгө ашиглалтад нөлөөлөхгүй, эсвэл ялымгүй нөлөө үзүүлнэ. Зарим тохиолдолд хөрш үл хөдлөх хөрөнгөнд нь мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн ч тэвчих ёстой. Нэгдүгээрт, хэрэв мэдэгдэхүйц

нөлөөлөл нь богино хугацааны шинж чанартай байвал, ялангуяа, жишээ нь: хөршийн эзэмшилийн газарт явагдаж буй барилгын ажлаас үүдэн гарах чимээ шуугиан, тоос шороотой холбоотой бол зүй ёсны гэж үзэх ёстой. Хоёрдугаарт, тухайн орон нутгийн нөхцөлд, ул хөдлөх хөрөнгийн байршилаас хамааран үл хөдлөх хөрөнгийн ердийн ашиглалтын явцад ч мэдэгдэхүйц нөлөөлөл зайлшгүй үүсэх бол, жишээ нь, хөршийн эзэмшил газар нөгөө өмчлөгчийнхөөс нам дор оршидогоос болж байгалийн урсгал ус орж ирж байгаа бол⁶, мэдээж, ерөнхий зохицуулалтын үйлчилгийг тэр бүр угүйсгэхгүй. И.Б. Новицкий бичихдээ: "нарийн чанд дүрэм журамд амьдралын бүхий л тохиолдлыг хамруулж болохгүй: эзэмшил газрыг нэг хэлбэрээр ашиглахад зайлшгүй байгаа нөхцөл өөр нэг хэлбэрээр ашиглах уед тохиорох албагүй (жишээ нь, хэрэв зэмшил газар нэг талаараа сууцны байшинтай, харин нөгөө талаараа дархны газартай хиллэж байвал, орон сууцны оршин суугчийн зүгээс хамгийн замбараагүй, учир утгагүй ааш авир гаргалаа ч дархны газраас гарах дуу чимээ, утая униараас хавьгүй бага чимээ шуугиан, утая хөршид нь хүрнэ. Хөршийн нөлөөлөл нэг этгээдийн хувьд ноцтой, бүр тэвчишгүй дарамт болж байdag бол нөгөөд нь ялимгүй зүйл байж ч болдог.

Жишээ нь: тухайн эзэмшил газарт эмнэлэг, эсвэл мод, нүүрсний зах аль нь байхаас хамааран чимээ шуугиан, утая униар болон бусад нөлөөлөл ноцтой эсэх тухай асуудал хөршид өөр байж болох юм.

Нэг үгээр, зайлшгүй байдал болон ноцтой чанар зэрэг нь харьцангуй ойлголтууд юм.

Амьдралын янз бурийн нөхцөл байдал стандарт хэм хэмжээг уян хатан байхыг шаардах бөгөөд амьдралын эрзэн барааны учрыг олоход хялбар байлгах үүднээс хуульд зөвхөн хамгийн

5. Иргэний хуулиин 12-р бүлгийн 101-р зуилийн 101.1 дэх заалтын эх холбогдуулсаныг нь зүйтэй. Энэхүү заалт өмчилгээний эрхийг хэрэгжүүлэх хялгарыг тогтол эхийн сацуу адчин зорилж тал дээр ИХ-ийн 12-р бүлгийн 4-р дэд бүлгийн үндэс суурин болог "Өмчилгээ нь бусад эзэргээд хууль буку гарзгээгээр оптогодон эрхийн зөрнигүйнгэрээр, хуулиар тогтоосон хамжээ хэзэгварын дотор өмчилгээний зуулж өөрийн эзэмшигээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, залжирэн зарцуулсаа биеөнд аливаа хийдлэгээг хамгаалах эрхтэй".

6. Новицкий И.Б. Право соседства: Общие пределы пользования смежными участками / Право и житни. 1924. 16 - 17 х.

өрөнхий нийтлэг байх шинж тэмдгүүдийг заадаг: амьдралын харилцааг нэгэн жигд, нэг шугамаар тайран мэт байглахгүй тулд дээрх шинж тэмдгүүд нь зайлшгүй хөдөлгөөнтэй, уян хатан байх ёстой”⁷

Хохирол учрахаас урьдчилан анхааруулах: Хөрш залгаа газрыг эзэмшиг нь өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг ноцтой хохироож болох барилга байгууламжийг газар дээр буюу доор барих, ашиглахыг хориглон нөгөө талын өмчлөгч буюу эзэмшигчээс эрх зөрчсөн үйлдлээ зогсоохыг шаардах эрхтэй гэж ИХ-ийн 135-р зүйлийн 135.3-д заасан байна. Үүнээс үзвэл, хөрш эрхийн хүрээнд хэд хэдэн цогц эрх багтсан гэж үзэж болно. Үүнд:

- Хохирол учрахаас урьдчилан сэргийлж анхааруулах
- Хохирол учруулж болзошгүй үйлдлийг зогсоох /хохирол учрахаас өмнө/
- Ноцтой нелөөлөл учруулж байгаа бол нелөөллийг хязгаарлах
- Өөрийн эрхийн хүрээнд явуулж байгаа уг ажиллагаа боловч хэвийн байх хэмжээнээс хэтэрсэн гэж үзсэн тохиолдолд мөнгөн төлбөр шаардах зэрэг эрхүүд байж болно.

Орчин үед, хун амын төвлөрөл, хот суурин газар ихсэж байгаатай уялдан, хамгийн эхэнд хөндөгдхөн хөршийн эрх барилга байгууламж барих, өмчлөх явцад гарч байна. Хэрэв хөрш шинэ барилга барих нь нөгөө хөршид хохирол учруулахаар байвал хөршийн эрхээр, өмчлөгч нөгөө хөршийн барилга барихыг эрхийг хязгаарлах эрх бий болжээ.

Энэ эрх нь өөрийн барилга байшинг ашиглахад тааламжгүй байдал үүсгэх, эдгээр объектын үнэ цэнийг бууруулахаас хамгаалах ач холбогдолтой байдаг нь хохирол учрахаас урьдчилан сэргийлэх үүднээс анхааруулах, хөршийн серөг үйлдлийг зогсоо эрх байгаа болохыг харуулна.

Жишиээ: хөршийн шинэ барьсан барилга нь үзгэдэх орчинг хязгаарлах, нарны гэрлийг хаах зэрэг шалтгааны үед хөршийн эрх үйлчилни.

Тухайн тохиолдолд, уг үйлдлээс болж хөршийн эрх бодитой хохирч болох үндэс байгаа эсэхийг харгалзах ба энэ үед хохирол учирч болох, зөвлөл учирсан байх зэрэг нь ялгаагүйгээр хөршийн шаардах эрхийг үүсгэдэг.

Жишиээ нь: Шинэ байшигийн суурь \фундамент\‐ийн зориулалтаар газар ухсан нь хөршийн байшиг нурах, цууралт үүсэх нөхцөл бүрдүүлж байгаа, мөн хөрсний суулт өгөх, цууралт өгсөн гэх мэт.

Түүнчлэн, хөрш өөрийн байшин барилгыг засварлахгүйгээс болж нөгөө хөршийн байшин барилга нурах, зөвлөл нурах аюулаас болж хөршид хохирол учрахаар байвал барилга байшинг засварлахыг, хохирол учрахаас урьдчилан сэргийлэхийг шаардах эрхтэй. Барилга байгууламжийг засварлах ямар нэгэн арга хэмжээ авахгүй байгаа бол нурах гэж буй барилгыг зайлуулах ч арга хэмжээ авахыг шаардах эрхтэй. \гэхдээ энэ нь түүх соёлын дурсгалт зүйлд үл хамаарна\

Манай Иргэний хуульд хөршийн эрхийн зохицуулалт тусгагдсан нь ялангуяа хувийн өмчөө зээмших, ашиглах, захиран зарцуулахад бусдын ямар нэг нөлөө, саад учруулахаас сэргийлсэн, түүнийг хамгаалж байгаа нэгэн хамгаалалт болж өгснөөрөө давуу талтай. Иймд, ирээдүйд хохирол учруулахаар аюул заналхийлж байгаа, ноцтой нелөө үзүүлж байгаа нь хөршийн үйл ажиллагааг хязгаарлах нэхэмжлэл гаргах үндэслэл болохыг хууль зохицуулсан. Шүүхээр энэ үйл ажиллагаа нь хууль бус гэж үзсэн тохиолдолд \барилга, байгууламж барих нь\ нэхэмжлэлийг хангана \ барилга барих зөвшөөрөл олгоогүй, барилгын норм дурэм зөрчсөн гэх мэт. Нөгөө талаар, өөрийн эрхийг зөрчиж байна гэж үзэн, шүүхэд хандаж байгаа этгээд хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн

боловхыг нотлох үүрэг хүлээдэг нь хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавигддаг шаардлагаар үүсдэг болно. Хөршийн үйлдэлхууль бус байна гэж үзэх үндэслэл нь өмчлөгчийн эрх, үүнээс зарим тохиолдолд ашиглах эрхийг хэрэгжүүлэх боломж хязгаарлагдах тал байdag бол зарим тохиолдолд хөрөнгийн зориулалттай холбоотойгоор эрх хөндөгдөх ч нь байна.

Жишээ: нийтийн зориулалттай орон сууцанд хоол, үйлчилгээний газар байгуулснаа үүдэн, оршин суугчдад таагүй нөлөө үүсэх нь бий.

Өмчийн эзэн газар эзэмшигч хөршөөс түр хугацаагаар газар ашиглах: Барилга байшинд засвар хийхийн тулд хөрш газар өмчлөгчөөс зөвшөөрөл авахгүйгээр газрыг түр хугацаагаар ашиглан тэр засварыг хийх боломжтүй байdag. Барилга барих материал, дүнз, бансыг байрлуулах, булгах, хадгалахын тулд газрыг түр хугацаагаар ашиглана гэсэн уг. Ийм шаардлага гол төвлөв хот суурин газарт өөрийн газрыг ашиглах боломж хязгаарлагдахад хөршийн газрыг ашиглах шаардлага үүссэнтэй холбогдон гарч ирнэ (барилга хоорондын гудамжны хэмжээ бага, барилга хоорондоо зай багатай байх, хоёр өмчлөгчийн газрын хил залгаа хэсэгт зай бага зэрэг шалтгаанаар).

Хуулийн тусгай зохицуулалт болох хөршийн эрхийг шаардахгүйгээр барилгын өмчлөгч нь хил залгаа, хөршийн газар дээр сервитут тогтоохдор шаардаж болох боловч энэ зохицуулалт нь барилгын засвар хийх үйл ажиллагааны үед тохиромжтүй. Хэрэв хөрш нь сервитут тогтоохыг зөвшөөрсөн ч энэ эрхийг улсын бүртгэлд заавал бүртгэх зэргээр цаг хугацаа шаарддаг тул богино хугацаанд хийх засварын ажилд тохиромжтүй юм. Иймээс түр хугацаагаар дээрхи зорилгоор газар ашиглах өмчлөгчийн эрх хөршийн эрхийн зохицуулалтаас өөрөөр зохицуулагдах боломжтүй байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Дээрхи эрхийг эдлэх үндсэн шаардлага нь өмчлөгч өөрийн барилгад засвар хийхдээ хөрш өмчлөгчийн газрыг ашиглахаас өөрөөр засвар хийх боломжтүй байх нөхцөл юм. Газар өмчлөгч нөхөн төлбөр шаардаж болно. Энэ нь зөвхөн барилга байгууламжид засвар хийх тухайд л үүсч бөгөөд барилга байгууламж барих тохиолдолд сервитутын үндсэн дээр гүйцэтгэдэг.

Бусад улсын иргэний хуульд дээрх байдлаар хөршийн эрх хөндсөн асуудлыг зохих онцлогтойгоор тусган зохицуулсан байдал. Хөршийн газарт мод бут тарих, барилга байгууламжид засвар үйлчилгээ хийх шаардлага тарвал хөрш газар өмчлөгч нөгөө хөршийнхөө амаар болон бичгээр гаргасан хүсэлтийг хүлээн авч өөрийн газрыг ашиглуулахыг зөвшөөрөх үүрэгтэй /Квебекийн иргэний хуулийн 987-р зүйл/. Газар өмчлөгч өөрийн газрыг ашиглуулах үүрэгтэй боловч газар ашиглалнаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх эхний байдалд нь сэргээн засварлуулах эрхтэй. (988-р зүйл)

Хөршийн эрхийн хүрээнд, хөршийн газраар дамжин өнгөрөх, түүнчлэн бусад байдлаар хөршийн газрыг ашиглах асуудал үүсэн гардаг нь тухайн эрхийг хязгаарлахыг зарим тохиолдолд зүй ёсоор, хун амын төвлөрөл, хот төлөвлөлт зэргээс улбаалан үүснэ. Энэ байдал нийтийн зам гудамж руу гаралт гаргүй, газар нь өөр бусад газар өмчлөгчийн эзэмшлийн газраар хүрээлүүлж байгаа зэрэгт хөршийн газрыг ашиглан дамжин өнгөрөхийг, газраа ашиглуулахыг шаардах эрхийг олгож болно. Харин хөрш нь хариуд нь газар ашигласны нөхөн төлбөр шаардах эрхтэй.

Хөршийн эрхийн зохицуулалт нь:

- Хөршүүд эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын эрхийг хөндөхгүй байх үүднээс хэрэгжүүлэх эрх, түүний хязгаар

- Хөршийн эрх хөндөгдсэн бол түүнийг зохицуулах арга, хүлцэх, нөлөөлөл хэзвийн хэмжээнээс хэтэрсэн бол эрх зөрчсөн үйлдлийг зогсоох.

хохирлыг арилгуулах, мөнгөн төлбөр шаардах субъектив эрхийг хөршид бий болгосон юм.

Энэхүү субъектив эрхтэй зэрэгцэн гарч ирэх, ИХ-ийн нэг зохицуулалт бол 106-р зүйлийн 106.1-д заасан эрх сэргээх нэхэмжлэл болно. Өмчлөгч эрхээс сэргээлгэх нэхэмжлэлийг, өмчлөх эрх нь ямар нэгэн байдаараа зөрчигдсөн гэж үзвэл уг зөрчлийг арилгуулах, эсхүл өмчлөх эрхээс хэрэгжүүлэхэд саад болж байгаа үйлдлийг зогсоохыг эрх зөрчигчөөс шаардахын тулд гаргах ба ямар тохиолдолд хөршийн эрхийн зохицуулалт, ямар нөхцөлд эрх сэргээх нэхэмжлэлийг гаргахыг дээр дурдагдсан үндэслэлд тулгуурлан авч үзвэл дараах ялгаа байгаа тэмдэглэх нь зүйтэй байна.

Үүнд:

1. Хөршийн эрх үл хөдлөх хөрөнгийн хувьд яригддаг бол эрх сэргээх нэхэмжлэлийг бүхий л хөрөнгийн хувьд хөндөж авч үзэх

2. Хөршийн эрх илүүтэй ашиглах эрхийг хэрэгжүүлэхэд хөндөгдхөн бол эрх сэргээх нэхэмжлэл өмчлөлийн гурвал эрхийн аль алинд хэрэгжих боломжтой байх

3. Хэрэв хөршийн эрх хөндөгдсөн бол мөнгөн төлбөр шаардах эрх хөршид байгаа нь эрх сэргээх нэхэмжлэлийн үр дагавраас ялгагдах нэг онцлог болж байгаа юм.

---00---

КИБЕР ГЭМТ ХЭРЭГ: ХАНДЛАГА БА ТӨРӨЛ, ХЭЛБЭР



МУИС-ийн ХШУУИС-ийн Мэдээлэл,
компьютерийн ухааны тэнхмийн багш
Ц.Хүрэл-Очир

I. Оршил

ХХ зуунд хүн төрөлхтөний бүтээж бий болгосон шилдэг ололтын нэг болох "кибер ертэнц" цахим мэдээллийн цоо шинэ харилцаа, орчин, орон зайнг бурдүүлсэн бөгөөд танин мэдэх үйл явцад бидний зарцуулдаг цаг хугацаа, орон зайн тухай уламжлалт ойлголтыг халсан юм.

"Кибер ертэнц" мэдээллийг түгээх, дамжуулах, олж авах, ашиглах, солилцох орон зайн үүрэг гүйцэтгэхээс гадна бизнес, эдийн засаг, банк санхүү, шинжлэх ухаан, боловсрол зэрэг нийгмийн олон талт харилцааг агуулсан өргөн сонголтой, ашиглахад хялбар, цаг хугацаа хэмнэсэн, газар нутаг, орон зайн алслалтаас хамааралгүй, эрх зүйн зохицуулалтын өргөн агуулга бүхий үйл ажиллагааны талбар болж хувирлаа.

Дэлхий нийтийн даяаршлын өнөө үед эрх зүйн шинэ салбар тухайн улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн хамаарахгүйгээр мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн хурд, эдийн засгийн либералчлал, улс төрийн бодлогын хүрээнд үндэсний болон олон улсын эрх зүйн түгээмэл хэм хэмжээ үүсэн бүрэлдэж, үндэсний эрх зүйд нөлөөлөл замаар хөгжих боллоо.

Мэдээллийн технологи өндөр хөгжсөн улс орнуудад Интернэт (2014.06.30-ны байдлаар 3.03 тэрбум гаруйхэрэглэгчтэй¹) эдийнзасгийнчухал салбарын нэг болж, 2013 онд Интернэт-эдийн засгийн дэлхийн худалдааны нийт эргэлтийн хэмжээ 16 триллион ам. долларт² (IDC²- International Data Corporation-ийн судалгаагаар) хүрэх прогноз гарсан нь³ Интернэтийн олон зөрэг шинжийн нэг юм. Гэвч Интернэт нийгмийн олон талт харилцаанд дан ганц зөрэг үүрэг гүйцэтгэхгүй байгаад анхааралт хандуулах шаардлагатай.

Интернэтийн цэр хүрээ нь аль нэг улс ороос үл хамаарах бие даасан үйл ажиллагаа явуулах узэл санааг бий болгосноор XXI зууны технологийн хөгжилтэй уялдан Интернэтийн орчин дахь "эрх зүйн зөрчил" олноор гарах болов. Тухайлбал, кибер хандлага хийх, кибер довтолгоо зохион байгуулах, Интернэтийн орчинд залилан мэхлэх, луувар хийх, зохиогчийн эрхийг зөрчих, алтан хядлага, хүчирхийлэл, садар самуун, хуулиар хориглосон бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах г.м.

Харамсалтай нь Интернэтийн хэрэглэгчид "Кибер эрх зүй"-н талаар түүлийн хангалтгүй ойлголттой байна. Интернэтийн олон талт харилцааг техник, технологи дангаараа зохицуулж чадахгүй нь нэгэнт тодорхой тул "Кибер эрх зүй"-н асуудлыг нарийвчлан судалж, үндэсний эрх зүйн хэм хэмжээнд тусгахгүй нийгмийн харилцаа шаардаж байна.

Мэдээлэл, холбооны орчин үеийн технологийг ашиглан үндэсний мэдээллийн нөөц баялаг, түүний эрх ашигт заналхийлэх аливаа хандлагаас хамгаалах асуудал өдгөө нэг үндэстний хэмжээнд бус, дэлхийн олон улсын

¹ <http://www.internetworldstats.com/usage.htm>

² http://en.wikipedia.org/wiki/International_Data_Corporation

³ <http://www.myclouddoor.com/web/documents/The>New-Digital-Economy.Pdf>

өмнө хурцаар тавигдаж, уг асуудлыг эрх зүйгээр төрөлжүүлэн зохицуулах, технологийн оновчтой шийдлийг хослуулан хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

II. Компьютерийн гэмт хэрэг: Үндсэн асуудал

Гэмт этгээдүүд (гэмт хэргийн бүлэглэл) мэдээлэл, холбооны технологийг ашиглаж улс үндэстэн, хил хязгаар дамнасан гэмт хандлага, хууль бус үйл ажиллагаа эрчимтэй явуулах болсныг дэлхийн улс орнуудын шүүхийн практик, эх сурвалжууд баримтаар нотолж, хувь хүн, нийгэм, төрийн мэдээллийн аюулгүй байдлыг улс үндэстний тусгаар тогтолц, бүрэн эрхт байдлын тулгуур хүчин зүйлийн нэг гэж үзэх хандлага түгээмэл боллоо.

Улс үндэстэн дамнасан, нотлох баримт цуглуулахад бэрхшээлтэй, технологийн өндөр нууцлалтай, материалыг хохирлын хэмжээ үзэмж их⁴ зэрэг компьютерийн гэмт хэргийн шинж нь түүнийг бусад төрлийн гэмт хэргээс ялгах үндсэн онцлог болдог.

"Компьютерийн гэмт хэрэг"-ийг тодорхойлох асуудал судлаачдын дунд олон янзын үзэл бодол, хандлага бий болгож, мэттэлцэн өрнүүлж байсан.⁵ Уг гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголттой болох, тулгарч буй бэрхшээлийг зөв тодорхойлж, шийдвэрлэх арга зам боловсруулах, нэгдсэн системчлэл бүрдүүлэх боломжийг шинжээчдэд олгох нь хууль зүйн практикт чухал ач холбогдолтой.

ОХУ-ын судлаач Ю.М.Батурийн эрх зүйн утгаараа "компьютерийн гэмт хэрэг"-ийн ангилалд хамаарах онцгой төрлийн гэмт хэрэг байхгүй гэж үзэж, олон төрлийн "уламжлалт" гэмт хэрэг цахим төхөөрөмжжөөс шууд хамааралтайгаар хувирч,

* <http://www.ic3.gov/media/annualreports.aspx>

⁵ Судлаачид "компьютерийн гэмт хэрэг"-ийг олон янзааг тодорхойжж байсан. Энэ нь "компьютерийн гэмт хэрэг" нийгэмд аюулгүй зүйгийн ангилалд багах зэсэх, мөн "компьютерийн гэмт хэрэг" гэсэн нэр томъёог "компьютерийн мэдээллийн аюулгүй байдлыг зэрэг гэмт хэрэг", "компьютерийн мэдээллийн хэрээн дэх гэмт хэрэг", "компьютер ашиглалттай холбоотой гэмт хэрэг" зэрэг олон янзаар нэрлэж байсантай холбоотой юм.

өөрчлөгдж буйг харгалзан тусад нь гэмт хэргийн ангилалд оруулалтгүй, харин гэмт хэргийн компьютерийн аспектийн талаар ярих ёстой⁶ гэж санал дэвшүүлсэн нь энэ чиглэлийн судалгаанд анхаарч үзэх асуудал юм.

Зарим судлаач "компьютерийн гэмт хэрэг" гэсэн нэр томъёог хэрэглэжэд шүүмжлэлтэй хандаж байна. ОХУ-ын судлаач В.В.Крылов "мэдээллийн гэмт хэрэг" гэж илүү өргөн хүрээтэй томъёолболт тодорхойжж техникийн хэрэгслээс салгаж хийсвэрлэх боломж олгоно⁷ гэсэн санал дэвшүүлжээ. Жишээ болгон үзэж буй гэмт хэргийг мөрдөн шалгах аргачлал боловсруулахад техникийн тодорхойжж хэрэгслээс салгах хийсвэрлэх нь уг гэмт хэргийн криминалистик тодорхойлолтыг иж бүрэн байдлаар гаргах боломж олгохгүй. Өөрөөр хэлбэл криминалистик тодорхойлолт нүсэр болохын хиэрээр практик хэрэглээ, эрэн сурвалжлах, мөрдөн шалгах, бусад процессын (байцаан шийтгэх) ажиллагаа, мөрдлөлтийн тактикийн онцлогийг судлаад багагүй хүндэрэл учруулж болзошгүй.

Н.Ф.Ахраменка "компьютерийн гэмт хэрэг"-т "мэдээлэл, тооцоолох цахим системийг ашиглаж, эсвэл тэдгээрт нелвөлөх замаар үйлдсэн нийгэмд аюултай, хууль бус үйлдэл⁸-ийг хамааруулж үзжээ. Энэ нь "компьютерийн гэмт хэргийн" криминологийн ойлголттой тохирх боловч криминологи, криминалистикийн шинжлэх ухааны судлагдахуун ялгаатай тул "компьютерийн гэмт хэрэг" гэсэн нэр томъёоны криминалистик тодорхойлолтыг тодорхой болгох, цэгцэх шаардлага хууль зүйн практикт зайлшгүй тулгарч байна.

Судлаачдын судалгааны үр

⁶ Батурина Ю.М. Проблемы компьютерного права. –М.: Юрид. лит., 1991, стр. 129

⁷ Крылов В.В. Информационные компьютерные преступления. М.: ИНФРА-М Норма, 1997. стр. 11

⁸ Ахраменка Н.Ф. Проблемы криминализации общественно опасного поведения с использованием информационно-вычислительных систем. Автореф. дис. канд. юрид. наук 12.00.08/ белорусский государственный университет. – Минск, 1996

дүн, "компьютерийн гэмт хэрэг"-тэй тэмцэж буй бусад улсын туршлагыг харгалзаж хууль зүйн онол, практикт ач холбогдолтой криминалистикийн "тусгай" аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх үүднээс авч үзвэл "компьютерийн гэмт хэрэг"-т компьютерийн мэдээлэл, түүний орчинд компьютерийн технологийг ашиглан үйлдсэн гэмт хэргийг хамааруулж үзэх нь зүйтэй. Энэ нь НҮБ-ын шинжээчдээс санал болгож буйжишиг зааварчилгатай нийцэх бөгөөд компьютерийн систем, түүний тусламжтай үйлдэж болох; компьютерийн систем, сүлжээний орчинд гарч болох; компьютерийн систем, сүлжээний мэдээллийн аюулгүй байдлын эсрэг үйлдэж болох бүх төрлийн гэмт хэрэгт хамаарна.

2001 оны 11-р сард АНУ, Канад, Япон, ФАБНУ болон Европын зөвлөлийн гишүүн улсууд "Кибер гэмт хэргийн тухай конвенцii"⁹-д нэгдэн оржээ. Энэ конвенцийн дагуу компьютерийн програм хангамж "зэдэх", түүний хууль бусаар хуулбарлах, Интернэтийн орчинд заилиан мэхлэх, шашны эсрэг сурталчилгаа хийх, арье өнгөөр ялгаварлан гадуурсан мэдээлэл түгээх, хүүхдийг садар самууныг сурталчлахад ашиглах зэрэг гэмт хэрэгтэй хамтран тэмцэх үүрэг хүлээсэн байна. Уг конвенцийн¹⁰ II бүлэгт эрүүгийн хэрэг үсгэн шалгах гэмт хэргийн төрөл, хэлбэрийг дараах байдаа тодорхойлжээ. Үүнд:

1. Компьютерийн егегдэл, системийг хууль бусаар олж авах, түүний нэгдмэл, хүртээмжтэй байдал, нууцлалын эсрэг гэмт хэрэг, системийн ажиллагаанд санаатайгаар саад учруулах, компьютерийн техник, хэрэгслийг хууль бусаар ашиглахтай холбоотой гэмт хэрэг;

2. Компьютерийг хууль бусаар ашиглах, компьютерийн тусламжтай

хуурамч бичиг баримт бүрдүүлэх, компьютер ашиглаж заилиан мэхлэхтэй холбоотой гэмт хэрэг;

3. Өгөгдлийн агуулгатай холбоотой (хүүхдийн порнограф) материал бэлтгэх, байрлуулах (санал болгох), тараах, хүлээн авах, хадгалахтай холбоотой гэмт хэрэг;

4. Зохиогчийн эрх, түүнд хамаарах бусад эрхийг зерчсөн гэмт хэргийг багтаасан байна.

Компьютерийн гэмт хэргийн эзүүгийн эрх зүйн ойлголт. Үүний цахим мэдээлэл боловсруулах систем, түүний орчинд улс, нийгэм, иргэн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлын эсрэг компьютерийн технологийг ашиглан үйлдсэн эзүүгийн хуульд заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл (эс үйлдэхүй) гэж үзэж болох юм.

Компьютерийн гэмт хэргийн криминологийн шинжээр нь эдийн засгийн, хувийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг, нийгэм, улс орны ашиг сонирхлын эсрэг гэж ангилж болно.

Компьютерийн гэмт хэргийн илрүүлэлтийн төвшин харьцангуй бага байдгийн нэг шалтгаан нь тухайн байгууллага гарсан гэмт үйлдлийг өөрийн хүчээр шийдвэрлэх гэж оролдлог буруу зурсилтай холбоотой. Уг гэмт халдлагын улмаас учирсан хохирлын хэмжээ нь гэмт үйлдлийг мөрдөн шалгахын тулд сервер компьютерийн тодорхой хугацаагаар хураах тохиолдолд гарах алдагдаас бага байдаг асуудлын мэн чанар оршино. Мэн тухайн байгууллагын удирдлага ажил хэргийн нэр хундээ алдах, шүүхийн процессын явцад байгууллагын хамгаалалтын дотоод нууцлал задрах, зарим тохиолдолд өөрсдийнх нь хууль бус үйлдлүүд илэрч болзошгүй зэрэг олон хүчин зүйлээс болгоомжилдог.

Компьютерийн гэмт хэрэг нийгэмд аюултай, хор уршиг бүхий гэмт үйлдлэд гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна. НҮБ-ын баримт бичигт компьютерийн гэмт

⁹ 2001 онд батлан гаргасан "Кибер гэмт хэрэг"-тэй тэмцэх Будапештийн конвенцид эдгээ дэлхийн 51 улс нэгдэн орсон Дэлхийн олон улс өөрийн улсын хууль тогтолцоогийн энэхүү олон улсын эрх зүйн актын түгээмэл хам хэмжээ стандартыг тусгассан байна.

¹⁰ http://www.eos.ru/eos_delopr/eos_law/detail.php?ID=32063&SECTION_ID=671-ээс үзэх үү

хэргийн улмаас учирсан нийт хохирол хууль бусаар зэвсэг арилжаалах, хар тамихи худалдаалах наймаатай дүйцэхүйц хэмжээнд хүрсний цохон тэмдэглэхээ¹¹.

Олон улсын "Кассандра" судалгааны байгууллага дээрх асуудлаар хуульч, банк санхүүгийн ажилтнуудын хүрээнд социологийн судалгаа явуулахад энэ төрлийн гэмт хэргийн улмаас банк, санхүүгийн байгууллагуудын хүлээх хохирлын хэмжээ цаашид улам нэмэгдэнэ гэж судалгаанд оролцогсдын дийлэнх узсэн нь¹² уг гэмт үйлдэл нийгэмд аюултай. бодит үзэгдэл болсны харуулахын зэргээц цаашид энэ хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг нийгмийн шаардлага харуулж байна.

НҮБ, олон улсын хамтын нийгмэлэгийн бусад байгууллагууд компьютерийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоо чиглэлээр олон улсын төвшинд хэрэгжүүлэх арга замыг ямагт эрэлхийлж, холбогдох хурал, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж ирэв.

1995 оны 10-р сарын 4-10-нд хуралдсан Интерполын ерөнхий ассамблейн хуралдааны "Интерполын хүрээнд компьютерийн гэмт хэрэгтэй хийх тэмцийг зорилгоор үндэслний хууль сахиулах байгууллагуудын ажиллагааг чиглүүлэх ажлын зөвлөмж"¹³, 1997 оны 7-р сарын 1-2-нд Английн Брамшил хотод хуралдсан "Их найм"-ын уулзалтын "Өндөр технологийн орчин дах гэмт хэрэг"-ийн тухай салбар хуралдааны баримт бичиг¹⁴, 2005 оны 4-р сарын 18-25-нд Тайландын Бангкок хотод хуралдсан НҮБ-ын XI чуулганаас

гаргасан "Компьютер ашиглахтай холбоотой гэмт хэргийн эсрэг авах арга хэмжээ"¹⁵ эзрэг баримт бичигт энэхүү шинэ төрлийн гэмт хэргийн эсрэг авах арга хэмжээ, харилцаа холбооны дамжуулах хэрэгсэл, компьютерийн системийн найдвартай хэрэглэгээ баталгаажуулсан стандарт, универсаль хэм хэмжээг боловсруулан гаргажээ.

Компьютерийн гэмт хэргийг зүйлчлэхэд хэд хэдэн онцлог шинжийн харгалзан үзэх шаардлагатай. Тэдгээрийн нэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал болно. Гэмт хэргийн объектив тал буюу эрүүгийн хариуцлага хүлээлгэх үр дагаварт хүргэсэн үйлдлийг практикт илрүүлэн нотлоход нэлээд бэрхшээлтийг байдал. Энэ бэрхшээл нь компьютерийн систем, түүний процессын нарийн төвөгтэй үйл ажиллагаа, үйлдсэн гэмт хэргийн санаатай болон болгоомжгүй хэлбэртэй шууд холбоотой. Ялангуяа болгоомжгүй хэлбэрээр үйлдсэн компьютерийн гэмт хэргийн хувьд дээрх бэрхшээл илүү тулгарна.

Компьютерийн гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талыг зөв тогтоо явдал маш чухал. Хэрэв системийн администратор үйлдлийн дарааллыг өөрчилсний улмаас үйлдвэрийн дамжулага зогсож, ажил үйлчилгээ тасалдсан бол санаатай болон болгоомжгүй үйлдэл, эсхүл мэргэжлийн алдаа гаргасан зэрэг шалтгаан нөхцөлийг тогтооход төвөгтэй. Төгс програм хангамж байхгүй нь уг этгээдийг буруугүйд тооцож болох, түүний үйлдлийг цагаатгах хууль зүйн нэг гарц байж болох юм. Гэхдээ дээрх үйлдлийн улмаас учирсан нийгмийн хор аюул, хохирлын хэр хэмжээгээр нь эрүүгийн, эсвэл захирагааны болон эрх зүйн бусад зөрчилд хамааруулах эсэхийг нарийн зааглаж өгөх нь онол, практикийн ач холбогдолтой.

Заримдаа компьютерийн гэмт хэргийн халдлагын зүйлийг

¹¹ <http://www.un.org/events/11thcongress/>

¹² <http://www.cassandra.com.ua/index23-4.php>

¹³ <http://newasp.omskreg.ru/bekryash/app1.htm>
(Резолюция АГН/64/P, RES/19: Компьютерно-ориентированная преступность)

¹⁴ <http://newasp.omskreg.ru/bekryash/app10.htm>
(Подгруппа по преступности в сфере высоких технологий)

¹⁵ <http://www.unodc.org/unodc/en/crime-congress/crime-congresses-11-documents.html> (Workshop paper 6: Measures to combat computer-related crime)

тодорхойлоход нэлээд төвөгтэй байдаг. Тухайлбал, аль нэг хэрэглэгчийн компьютерийн эсрэг чиглэсэн гэмт халдлага эцсийн үр дундээ хоорондоо холбогдсон глобал сүлжээ, түүний бутцэд илүү их хор хөнөөл учруулж болзошгүй юм.

III. Эрүүгийн загвар хуулийн 16 дугаар бүлэг¹⁶ (Кибер гэмт хэрэгт хамаарах гэмт үйлдэл)

Эдүгээ дэлхийн олон улс орон кибер гэмт хэргийн тухай хууль тогтоомждоо шинээр тусгаж, үндэсний эрх зүйн хэм хэмжээг боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлж байна. Нөгөө талаас цөөнгүй улс оронд кибер гэмт хэргийн талаар тусгайлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага тооцох боломжгүй байсаар байна.

Кибер гэмт хэрэгт өргөн утгаараа компьютер, Интернэт ашиглан үйлдсэн гэмт хэрэг, мөн сүлжээнд холбогдоогүй боловч компьютер ашиглан үйлдсэн гэмт хэргийг хамааруулж болно. Кибер гэмт хэргийг компьютерийн гэмт хэрэг, Интернэтийн гэмт хэрэг¹⁷, өндөр технологийн орчинд үйлдсэн гэмт хэрэг¹⁸ гэж нэрлэх хандлага байна.

Интернэтийн ашиглаж зөвхөн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг төдийгүй бусад олон төрлийн гэмт хэрэг¹⁹ үйлдэх болов. Тухайлбал, хэн нэгний э-мэйл хаяг руу хууль бус мэдээлэл бүхий цахим шуудан явуулбал түүнийг эрх зүйн зөрчилд тооцох бодит нөхцөл бурдсэн гэж үзэж болно.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найрууллын төсөлд²⁰ орчин үед шинэ тутам гарч байгаа гэмт хэргийн бүрэлдэхүүнийг (тухайлбал, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг) шинэчлэн тодорхойлж, мэдээллийн аюулгүй байдад халдсан зарим гэмт хэргийн үйлдлийн аргыг ахин шинээр томьёолжээ.

Мөн цахим хэрэгсэл (13.10 дугаар зүйл. Хувь хүний нууцад халдах), цахим сүлжээ (16.9 дүгээр зүйл. Хүүхэд ашиглаж садар самоуныг сурталчлах), (17.3 дугаар зүйл. Залилах), (20.1 дүгээр зүйл. Террор үйлдэх), цахим карт (18.10 дугаар зүйл. Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах) ашиглаж үйлдсэн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага оногдуулахаар тусгажээ.

2001 онд Европын зөвлөл "Компьютерийн систем, сүлжээ, компьютерийн мэдээллийн сангийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлын эсрэг чиглэсэн үйлдэл, мөн дээрх систем, сүлжээ, мэдээллийг хууль бусаар ашиглах"-ыг таслан зогсоох зорилгоор кибер гэмт хэргийн тухай конвенцийг²¹ баталсан. Энэ төрийн гэмт халдлагатай тэмцэхийн тулд уг конвенцийн оролцогч талууд тодорхой гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцох, кибер гэмт хэргийг мөрдөн шалгах үйл ажиллагааны аргачлал, нэгдсэн зөвлөмж гаргах, энэ асуудалд олон улсын хамтын ажиллагаа нэн чухал болохыг онцлон тэмдэглэж, анхаарал хандуулсан байна.

Кибер гэмт хэргийг нийтлэг байдлаар тодорхойлох нь "нийтлэг шинжтэй наад захын жишиг бий болгох" зорилготой (Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэл, 33 дахь параграф).

Эрүүгийн загвар хуулийн (ЭЗХ) 16 дахь хэсгийн нэгдүгээр ангилалд багтах гэмт хэрэгт хууль бусаар нэвтрэх, хууль бусаар халдах, мэдээлэлд хөндлөнгөөс

¹⁶ Model Criminal Code, Volume I, Section 16. Cybercrime Offenses

¹⁷ Интернэтийн сүлжээгээр дамжин хийгдэж буй вэр вэр төрлийн гэмт хэргийн нийтлэг гэмт тодорхойлж болох юм. Энэ нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 226-229 дүгээр зуулд заасан гэмт хэргээс илүү ваген хүрээтийн онголтой. Интернэтийн гэмт хэргээ бол кибер гэмт хэргийн нэг төрөл.

¹⁸ Физик, хими, биологийн зэрэг шинжлэх ухааны технологийн шинж огылтыг ашиглаж үйлдсэн гэмт хэргээ.

¹⁹ <http://www.techopedia.com/definition/26587/internet-crime>

²⁰ <http://www.parliament.mn/laws/projects/532>

²¹ http://en.wikipedia.org/wiki/Cybercrime_Convention

нэвтрэх, системд орох, тоног төхөөрөмжийг зүй бусаар ашиглах зэрэг үйлдэл багтаж байна.

ЭЗХ-ийн тусгай ангийн 5 дугаар бүлгийн хүүхдийн эсрэг гэмт хэргийн 117 дугаар зүйл (хүүхдийн порнограф), 118 дугаар зүйл (хүүхдийн порнографийг зээмшилдээс байлгах) дээрх ангиллын гурав дах хэсэгт хамаарна.

Кибер гэмт хэргийн тухай конвенцийн тайлбар, илтгэлд дурдсан гол үзэл санаанд анхаарал хандуулахаадаа үндэсний зруүгийн хууль тогтоомжид кибер гэмт хэргэг, түүний талаар тусгайлан агуулыг анхаарах хэрэгтай. Энэхүү илтгэлээр ЭЗХ-ийн тусгай ангийн 16 дугаар бүлэг дэх гэмт хэргүүдийг тусгайлан авч үзэж, холбогдох хэсгүүдэд анхаарал хандуулсан болно. Аль нэг улсын хууль тогтоогчид кибер гэмт хэргийн тухай хуулийг боловсруулахаар төлөвлөж байгаа бол здгэр гэмт хэргийг мөрдэн шалгах мэргэжилтийг бэлтгэх, зайлшгүй түлгарч болох бэрхшээлийг урьдаас тооцож анхаарах ёстой. Учир нь энэхүү арга хэмжээ маш их хөренгө зардал шаардахаас гадна боловсон хүчин, сургалтын хетеплөр, хөренгө менгэ, техник, тоног төхөөрөмж зэрэг цогц асуудлыг шийдвэрлэх ёстай.

Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 14-21 дугаар зүйлд тухайн улс орон кибер гэмт хэргийг мөрдэн шалгахад туслахад чиглэсэн олон тооны арга хэмжээ авахыг шаардсан байдаг. Тухайлбал, MSCP²² (Mud Client Compression Protocol)-г дурдсан байна.

НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг шүүх тухай 11 дугаар конгрессийн²³ "Компьютертэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх арга зам" сэдэвт 6 дугаар семинаараас гаргасан баримт бичигт компьютертэй холбоотой гэмт хэргийн талаар хэлэлцэж, үндэсний болон олон улсын

санаачилга, зөвлөмжийг оруулсан байна²⁴.

184 дугаар зүйл. Компьютерийн системд хууль бусаар нэвтрэх

184.1. Гэмт хэргийн тодорхойлолт

1. Зөвшөөрөлгүйгээр компьютерийн системд бүхэлд нь, эсхүл аль нэг хэсэгт хууль бусаар нэвтрэсэн гэмт үйлдлийг ойлгоно.

2. Компьютерийн систем гэдэгт мэдээллийг автоматаар боловсруулдаг ямар нэгэн програмд холбогдсон нэг, түүнээс дээш хоорондоо холбоотой, эсхүл холбогдох үйлчилгээг авч байгаа нэг, эсхүл бүлэг тоног төхөөрөмжийг ойлгоно.

Тайлбар:

Параграф 1: Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 2 дугаар зүйлийг удирдлага болгон энэ параграфыг бичсэн. Компьютерийн системд хууль бусаар нэвтрэх гэдэгт ямар гэмт үйлдлийг тодорхойлсныг Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 44-50 дах параграфаас үзж болно. 38 дугаар параграфт "зөвшөөрөлгүйгээр" гэж ямар утга илэрхийлэхийг тайлбарласан байна.

Параграф 2: Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 1(а) дугаар зүйлийг үндэслэн "компьютерийн систем" гэдэгт юуг ойлгох талаар хэрхэн хэлэлцсэн тухай Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 23-24 дах параграфаас үзж болно.

184.2. Ял

Компьютерийн системд хууль бусаар нэвтрэсэн бол хоёроос авран жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

185 дугаар зүйл. Компьютерийн мэдээллийн санд хууль бусаар саад хийх

185.1. Гэмт хэргийн тодорхойлолт

1. Компьютерийн мэдээллийн санд хууль бусаар саад хийх:

²² <http://en.wikipedia.org/wiki/MCCP>

²³ <http://www.un.org/events/11thcongress/>

²⁴ <http://www.unodc.org/unodc/en/crime-congress-crime-congresses-11-documents.html> (Workshop paper 6: Measures to combat computer-related crime)

- a) Зөвшөөрөлгүйгээр
- b) Техникийн тусламжтайгаар
- c) Компьютерийн мэдээллийн санг агуулж буй компьютерийн системээс цахилгаан соронзон долгион илгээх зэргээр компьютерийн систем рүү, эсхүл компьютерийн мэдээллийг олон нийтэд нээлттэй бус байдлаар дамжуулахад саад учруулах үйлдлийг ойлгоно.

2. 185 дугаар зүйл заасан

- a) Компьютерийн систем гэдэгт 184.1(2) дах хэсэгт заасныг ойлгоно.

- b) Компьютерийн мэдээллийн сан гэдэгт үйл явдал, мэдээлэл, компьютерийн системд ямар нэгэн үйлдэл хийх боломжтой програм зэрэг компьютерийн системд мэдээлэл боловсруулах боломжтой хэлбэр бүхий ойлголтууд багтана.

Тайлбар:

Параграф 1: Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 3 дугаар зүйлийг удирдлага болгон энэхүү параграфыг бичсэн. Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 51-59 дэх параграфаас компьютерийн мэдээллийн санд хууль бусаар халдах гэмт үйлдлийг тодорхойлсныг үзэж болно.

Параграф 2(a): Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 1(а) дүгээр зүйлийг үндэслэн "компьютерийн систем" гэдэгт юуг ойлгох талаар хэрхэн хэлэлцэн тухай Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 23-24 дах параграфаас үзэж болно.

Параграф 2(b): Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 1(б) дүгээр зүйлийг үндэслэн "компьютерийн мэдээллийн сан" гэдэгт юуг ойлгох талаар хэрхэн хэлэлцэн тухай Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 25 дах параграфаас үзэж болно.

185.2. Ял

Компьютерийн мэдээллийн санд хууль бусаар саад хийсэн бол хоёроос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

186 дугаар зүйл. Компьютерийн мэдээллийн санд хөндлөнгөөс орох

186.1. Гэмт хэргийн тодорхойлолт

- 1. Зөвшөөрөлгүйгээр компьютерийн мэдээллийн санг гэмтээх, устгах, өөрчлөх, нуусан бол компьютерийн мэдээллийн санд хөндлөнгөөс орсонд тооцно.

2. 186 дугаар зүйлд заасан мэдээллийн сан гэдэгт 185.1(2)(b) хэсэгт заасныг ойлгоно.

Тайлбар:

Параграф 1: Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 4 дүгээр зүйлийг удирдлага болгон энэхүү параграфыг бичсэн. Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 60-64 дэх параграфаас компьютерийн мэдээллийн санд хөндлөнгөөс орох гэмт үйлдлийг тодорхойлсныг үзэж болно.

Параграф 2: Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 1(б) дүгээр зүйлийг үндэслэн "компьютерийн мэдээллийн сан" гэдэгт юуг ойлгох талаар хэлэлцэн тухай кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 25 дах параграфаас үзэж болно.

186.2. Ял

Компьютерийн мэдээллийн санд хөндлөнгөөс орсон хоёроос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

187 дугаар зүйл. Компьютерийн системд хөндлөнгөөс орох

187.1. Гэмт хэргийн тодорхойлолт

- 1. Компьютерийн системд хөндлөнгөөс оролцох:

- a) Зөвшөөрөлгүйгээр
- b) Компьютерийн системийг ноцтойгоор saatuulсан
- c) Компьютерийн мэдээллийг оруулах, дамжуулах, гэмтээх, устгах, эвдэх, өөрчлөх, нуух үйлдлийг ойлгоно.

2. 187 дугаар зүйлд заасан

- a) Компьютерийн систем гэдэгт 184.1(2) дах хэсэгт заасныг ойлгоно.
- b) Мэдээллийн сан гэдэгт 185.1(2) (b) хэсэгт заасныг ойлгоно.

Тайлбар

Параграф 1: Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 5 дугаар зүйлийг удирдлага болгон энэ параграфыг бичсан. Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 65-70 дах параграфаас компьютерийн системд хөндлэнгөөс оролцох гэмт үйлдлийг тодорхойлсныг үзэж болно.

Параграф 2(а): Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 1(а) дүгээр зүйлийг үндэслэн "компьютерийн систем" гэдэгт юуг ойлгох талаар хэрэн хэлэлцсэн тухай Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 23-24 дах параграфаас үзэж болно.

Параграф 2(б): Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 1(б) дүгээр зүйлийг үндэслэн "компьютерийн мэдээллийн сан" гэдэгт юуг ойлгох талаар хэрхэн хэлэлцсэн тухай Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 25 дах параграфаас үзэж болно.

187.2. Ял

Компьютерийн системд хөндлэнгөөс орсон хоёроос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

188 дугаар зүйл. Тоног төхөөрөмжийг зүй бусаар ашиглах

188.1. Гэмт хэргийн тодорхойлолт
1. Тоног төхөөрөмжийг зүй бусаар ашиглахад зөвшөөрөлгүйгээр, компьютерийн системд хууль бусаар нэвтрэх (184 дүгээр зүйл), компьютерийн мэдээллийн санд хууль бусаар саад хийх (185 дугаар зүйл), компьютерийн мэдээллийн санд хөндлэнгөөс ороч (186 дугаар зүйл), компьютерийн системд хөндлэнгөөс орох (187 дугаар зүйл) гэмт үйлдлийг хийх зорилгоор ямар нэгэн тоног төхөөрөмжийг ашиглах сэдэл агуулсан байна. Үүнд:

(а) Бэлтгэх, худалдах, хэрэглэхээр худалдан авах, импортох, боломж бурдүүлэх. Үүнд:

и. Компьютерийн системд хууль бусаар нэвтрэх (184 дүгээр зүйл),

компьютерийн мэдээллийн санд хууль бусаар саад хийх (185 дугаар зүйл), компьютерийн мэдээллийн санд хөндлэнгөөс орох (186 дугаар зүйл), компьютерийн системд хөндлэнгөөс орох (187 дугаар зүйл) гэмт хэрэг үйлдэх зорилгоор боловсруулсан, нийцүүлсэн компьютерийн програм зэрэг тоног төхөөрөмж эсхүл;

ii. Ашиглах нехцелөө бүрдүүлэхийн тулд компьютерийн системд нэвтрэхээр компьютерийн нууц уг, нэвтрэх код, эсхүл адил төстэй мэдээллийг бүхэлд нь буюу хэсэгчлэн олж авах;

(б) 1 (а) (i), 1 (а) (ii) дах хэсэгт заасны дагуу тоног төхөөрөмж, нууц уг, нэвтрэх код, адил төстэй мэдээлэл эзэмшиж байхыг ойлгоно.

2.188 дугаар зүйлд заасан компьютерийн систем гэдэгт 184.1(2) дах хэсэгт заасныг ойлгоно.

Тайлбар

Параграф 1: Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 71-78 дах параграфаас тоног төхөөрөмжийг зүй бусаар ашиглах гэмт үйлдлийг тодорхойлсныг үзэж болно.

Параграф 2: Кибер гэмт хэргийн тухай конвенцийн 1(а) дүгээр зүйлийг үндэслэн "компьютерийн систем" гэдэгт юуг ойлгох талаар хэрхэн хэлэлцсэн тухай Кибер гэмт хэргийн тухай конвенцийг тайлбарласан илтгэлийн 23-24 дах параграфаас үзэж болно.

188.2. Ял

Тоног төхөөрөмжийг зүй бусаар ашигласан бол хоёроос арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

IV. Кибер гэмт хэрэг: Үндсэн асуудал

Кибер гэмт хэрэг гэж юу вэ? Кибер гэмт хэрэг гэсэн ойлголт байна уу? Хэрэв байдаг бол "кибер гэмт хэрэг", "гэмт хэрэг" хоёр ямар ялгаатай вэ?

Кибер гэмт хэрэг үйлдсэн этгээдийг илрүүлэх, түүнд ялоногдуулах хууль зүйн асуудлыг жичлэн авч үзсэн зүйл сүүлийн үед нэлээд гарах болов.

Тухайлбал, компьютерийн гэмт хэрэг, компьютерийн арга хэрэгсэл ашиглан үйлдсэн гэмт хэрэг зэргийг нэрлэж болно. Гэвч энэ талаарх үзэл бодлын ихэнх нь манай нийгэмд гардаг дийлэнх шинэ үзэгдлийг ойлгож мэдэхийн нэгэн адил эхлэл төдий байна. Тухайлбал, кибер гэмт хэрэг гэж байдаг, тэдгээр нь эрх зүйн шинэ зохицуулалт, мэдрэн шалгах шинэ арга, техник бий болгож хөгжүүлэхийг шаарддаг, уламжлалт гэмт хэргээс ялгаатай гэж таамаглаж байна.

Кибер гэмт хэрэг бодитой байдаг эсэх нь энэ таамаглалд эргэлзэхэд хүргэж буй бөгөөд үүнд дун шинжилгээ хийх нь нэн чухал. Кибер гэмт хэрэг нь өөр үзэгдэл мөн бол "уламжлалт" гэмт хэргээс материаллаг агуулгаараа ялгарах ёстой. Кибер гэмт хэрэг "уламжлалт" гэмт хэргээс хэрхэн ялгагдахыг тогтоох нь түүнийг бодитой оршдог эсэхийг тодорхойлох эхний алхам мөн. Хэрэв кибер гэмт хэрэг болон бусад гэмт хэргийн хооронд материаллаг ялгаа байдгийг нотолж чадвал кибер гэмт хэрэг үйлдэгдэх үед тийм ялгаа байна уу, үгүй юу тэдгийг тогтоож, дун шинжилгээ хийх нь чухал юм. Хэрэв кибер гэмт хэрэг болон гэмт хэргийн хооронд ялгаа байдгийг нотолж чадахгүй бол энэхүү ойлголтууд хоёр өөр категори биш, харин кибер гэмт хэрэг нь өнөөг хүртэл оршиж ирсэн гэмт хэргүүдийн нэг хувилбар гэж үзэхэд хүрнэ.

Кибер гэмт хэрэг болон "ердийн" гэмт хэргийн хоорондын ялгааг тогтоох гэж оролдохоос өмнө эхлээд тэдний төсөөтэй талыг тогтоох нь чухал. Энэ нь тэдний хооронд байж болох ялгааг тодорхойлоход тусална. Тэдний төсөөтэй талыг гаргаж ирэх замаар чухамхуу ялгааг илэрхийлдэг асуудлаас "хөндийрч", шууд нотолж чадахгүй байгаа төсөөтэй зүйлүүдтэй холбогдсон асуудлыг судлахад анхаарал хандуулах нь зүйтэй.

Кибер болон "ердийн" гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх үр дагавар дагалдах учраас аль алинд нь (тухайлбал, "кибер гэмт хэрэг" гэсэн

еренхий категори болон "гэмт хэрэг" гэсэн еренхий категори) эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндсэн шинжийг баримтлах зарчмыг дагаж мэдрэн. Уламжлалт гэмт хэрэгт хүлээлгэдэг зарчмаас ялгаатай, кибер гэмт хэрэгт зориулсан эрүүгийн хариуцлагын тусгай категори бий болгоогүй байсан ч энэ зарчмыг мэдрхэд нь зайлшгүй.

Англи-Америкийн эрх зүй дээрвэн шинжийн давхцал дээр эрүүгийн хариуцлагыг үндэслэдэг. Энэ нь оюун санааны гэм буруутай байдал (*the mens rea*), үйлдэл эсвэл хийх үргэлжтэй байсан ч хийгээгүй эс үйлдэхүй (*the actus reus*), зайлшгүй тодорхой нэхцэл буюу "туслах нэхцэл байдал"-ын оршихуй, үр дагавар буюу хор хохирол юм.

Хэрэв кибер болон "ердийн" гэмт хэргийн аль аль нь эдгээр гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжээс бурддэг юм бол тэдэнд байж болох ялгаа нь тодорхой гэмт хэрэг болон кибер гэмт хэрэг үйлдэгдэхэд эдгээр шинж бүгд эсвэл зарим нь байна уу эдгээр тодорхойлогдох учиртай. Оюун санааны байдал гэсэн хоёр дах шинжид хамаарах материаллаг ялгааг таамаглах боломжгүй юм. Аль ч гэмт хэргийг нэг, түүнээс дээш тооны этгээд үйлдэх нь тодорхой. Энэ хоёр категориорид гэм буруугийн ялгаатай байдлыг тогтоох үндэслэл харагдахгүй байгаа учраас тэдний хоорондын чухал ялгаанаас энэ шинжийг хасч болно.

Гэмт хэргийн дээрх категори тус бүрт хамаарах зэрчилд хэргласэн зан үйл, үйлдэхтэй холбогдсон нэхцэл байдал, үйлдсэнээс гарах үр дагавар буюу хор хохирол нь энэ хоёр гэмт хэргийн ялгаатай шинж гэсэн эхний таамаглал дэвшиүүлж болох юм. Энэ таамаглалд үндэслэсэн ялгааг эрүүгийн хоёр категорийн хоорондын эмпирик зөвлөөнөөс гаргаж болох бөгөөд тэдгээрийг үйлдэх газрууд өөр өөр байдаг.

Уламжлалт гэмт хэрэг заншсан гэмт хэргийг бодит өртөнчдөй буюу "физик" бодит байдал"-д үйлдэдэг. Эдгээр гэмт хэргийн үйлдэл, үйлдэхтэй

холбогдсон нөхцөл байдал, үйлдсэнээс учрах хор хохирол нийтийн эзэмшил болох гудамж, хувийн орон байр зэрэг бодит газарт гардаг. Гэмт хэргийн тухай одоо үйлчилж байгаа хууль нь бусдын эд хөрөнгөнд хохирол учруулах, бусдын өмчийг зөвшөөрөлгүй авах зэрэг бодит хохирол бүхий зан үйлд хариуцлага, санкци (торгууль, хорих ял г.м) оногдуулахад чиглэдэг. Үндсэндээ орчин үеийн эрүүгийн эрх зүй гадаад физик ертөнцөд үйлдсэн зарим зан үйл (үйлдэл буюу үйлдэх үүргээ биелүүлээгүй эс үйлдэхүй)-д хариуцлага хүлээлгэнэ гэдгийг хүлээн зөвшөөрсөн, зохисгүй бодол санаа зэрэг бодит бус зан үйлд хариуцлага хүлээлгэх үзлээс татгалзсан билээ.

Кибер орон зай физик ертөнцийн хажууд байдаг боловч түүнээс тусдаа орших үйл ажиллагааны талбар юм. Энэ нь физик ертөнц биш, харин үзэл бодлын бодит байдал, "хийсвэр ертөнц" юм. Иймээс эрүүгийн эрх зүйн өнөөгийн зарчмууд кибер орон зайн өвөрмөц давуу талыг ашиглан үйлдэг гэмт хэрэгт хэрэглэхэд тохиороо уу гэсэн асуулт гарч ирнэ. Энэ хоёр категори тус бүрт хамаарах гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зан үйл, үйлдэхтэй холбогдсон нөхцөл байдал, үйлдсэнээс учрах хор хохиролтой холбоотой кибер гэмт хэрэг болон гэмт хэргийн хооронд материалыг ялгасаа байхгүйгээр ийм үл тохиороо байдал оршиж чадахгүй.

Хэрэв кибер орон зай нь уламжлалт гэмт хэргийг үйлдэхэд хэрэглэдэг ердийн орон зай буюу арга хэрэгсэл мөн бол кибер гэмт хэрэг гэсэн тусгайлсан нэр томьёо гаргах, түүний зохицуулахын тулд тусгай хууль тогтоомж гаргах биш, одоо мөрдөгдэж буй хууль тогтоомжоор түүнийг зохицуулахад хангантай. Тухайлбал, бусдын амь насыг санаатай хөнөөсөн үйлдлийг ноцтой гэмт хэрэгт тооцсоор ирсэн. Хүн амины гэмт хэргийг үхэлд хүргэхэд ашигласан аргаас шалтгаалж олон төрөлд яллахаас илүүтэйгээр "homicide" буюу "хүн амины гэмт хэрэг" гэж ерөнхийлөн

тодорхойлдог. Өөрөөр хэлбэл, аргад нь үндэслэн гэмт хэргийн тусгай төрлийг бий болгодоггүй. Тухайлбал, "талт зэвсгээр үйлдсэн аллага", "хордуулсан аллага", "зодож алсан аллага", "хутгалж үйлдсэн аллага" г.м. Бусдыг алахаар төпвлөсөн зан үйлээс учирсан хор хохиролд бид анхаарлаа хандуулдаг бөгөөд тэрхүү хор хохирлыг агуулсан гэмт хэргийг тодорхойлдог.

"Кибер гэмт хэрэг" гэж нэрлэж байгаа компьютер болон кибер орон зайгаар үйлдэг гэмт хэрэг нь удаан жил оршиж ирсэн тодорхой арга хэрэглэдэг гэмт хэргээс тийм ч өөр зүйлийг илрэхийлэхгүй байж болох юм.

V. Санал, дүгнэлт

Дээр дурдсан хандлага, саналыг харгалзан үзэж, хууль зүйн онол практикт хэрэглэх нь цахим мэдээллийн аюулгүй байдлыг эрх зүйн хүрээнд хангах, кибер гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс үрдчилан сэргийлэх олон талт хөтөлбөр боловсруулахын тулд тодорхой асуудлуудыг үр нөлөөтэй шийдвэрлэх зарим боломжийг олгоно. Үүнд:

1. Мэдээллийн технологи, түүний хэрэглээтэй холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндсэн (суурь) ойлголтыг хуульчлах;

2. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3. Кибер гэмт хэргийн нийгмийн хор аюулыг тодорхойлох шинж, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгсэдэд хариуцлага хүлээлгэх шалгуурыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах;

4. Компьютер гэмт халдлагын зүйл болсон, зэвслэл түүнийг хэрэгсэл болгож ашигласан гэмт хэргийг бусад төрлийн гэмт хэргээс ялгаж зааглах;

5. Компьютерийн гэмт хэрэгтэй холбогдолтой шүүхээр шийдвэрлэсэн хэргийг нэгтгэн судлах, дун шинжилгээ хийх;

6. Төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн унэлгээг хийх;

7. Кибер гэмт хэрэгтэй тэмцэх Европын конвенцод нэгдэн орох, олон улсын эрх зүйн түгээмэл стандарт, хэм хэмжээг үндэсний хууль тогтоомжид тусгах;

8. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхийн тулд хууль сахиулах байгууллагуудын олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх;

9. Өрнөдийн болон мэдээллийн технологийн өндер хөгжилтэй улс орнуудын туршлагыг нарийвчлан судалж, мэргэшсэн кибер-мердэгчдийг бэлтгэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх;

10. Цахим мэдээллийн эргэлтийн хүрээ гэмт халдлагын зүйл болсон нь энэ гэмт хэргийн онцлог үр дагавар. Үнээс үндэслэн тэрхүү хүрээнд гарсан гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хуульчлан тогтоох шаардлага гарч ирсэн. Үндэсний хэмжээнд "Кибер эрх зүй"-н тогтолцоо бурдээгүй, эрх зүйн зохицуулалтын механизм эхний шатандаа байна.

---оо---

ЭРДЭС БАЯЛГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМД НУТГИЙН ЗАХИРГААНЫ ЭРХ ХЭМЖЭЭ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Тэр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, (LLM), МРА Д.Батболд

ОРШИЛ

Нэгж (аймаг, нийслэл, сум, дүүрэг) тус бүр Үндсэн хуульд зааснаар харьцангуй бие даасан нийтийн эрх зүйн хуулийн этгээд байхын тулд юуны өмнө өмч, санхүүгийн нөөц, эрх мэдэлтэй байх нь нэн чухлаар тавигддаг. Өмчгүй, эд хөрөнгийн эрхгүй хуулийн этгээд гэж онолын хувьд байхгүй бөгөөд энэ нь түүний үндсэн шинж болдог. Үүнийг ном зохиолд “НӨҮЕ¹-ны баталгаа.үндэс” хэмээн бичдэг, Үндсан хуульд “... эдийн засгийн...цогцолбор” гэж туслаалаа олсон сонгогдог ойлголт юм. Эл үзэл санааг Иргэний хуульд “аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно” гэхчилэн хэд хэдэн

заалтаар тодотгон бэхжүүлсэн нь буй². Түүнчлэн түүний эдийн засгийн баазын нэгэн бүрэлдэхүүн нь харьялах нутаг дэвсгэрийн байгалийн баялаг мөн болох тухай хууль зүйн утга зохиол, хууль тогтоомж мөн л өгүүлнэ³.

Тэгвэл эл хуулийн этгээд, түүний удирдлага нь харьялах нутаг дэвсгэрийнхээз байгалийн баялагийн талаар ямар эрх хэмжээтэй байх бэ? гэдэг асуулт нутгийн эрх зүйн үүднээс урган гардаг. Үнд хариулт боловсруулах зорилгын үүднээс эрдэс баялагийн хэмжээнд судалснаа та бүхжил толижуулж.

Үүл асуудлыг эрдэс баялаг эзэмших, ашиглах, захирлан зарцуулах харилцаанд орон нутгийн хэмжээнд гарч байгаа үзэлдэл, үйл явц, нутгийн захиргааны эрх хэмжээг тодорхойлсон хууль тогтоомж, хуулийн дэд акт гэсэн үндсэн хоёр түвшинд авч үзэв.

Нэг. Ашигт малтмал ашиглахад хөдөө нутагт гарсан үзэгдлүүд юу өгүүлэв

1.1. Сум нутаг дэвсгэртэй ч эзэмшил газаргүй байсаар байх уу?
Төв аймгийн Заамар суманд 2003 оны 5 сарын байдлаар ашиглалтын 55, хайгуулын 36 лиценз олгосон нь сумын

¹ Энэхүү өгүүлэлд орсон төвчилсон үгсийг дараах байдлаар тайлна. АМГХЭГ-Ашигт мальтмал, гарын тосны хэрг эрхлэх газар, АНЗД-Аймаг нийслэлийн Засаг дарга, АМТХ-Ашигт мальтмалын тухай хууль, АТЭЭ-Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй эзэмшиг, БОХ-Байгаль орчны хамгаалах, БОЯ-Байгаль орчны яам, ИТХ-Иргэдийн Төвлөгөчийн хурал, ЗЭНДНТУХ-Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, ЗГХЭГ-Засгийн гарын Хэргээ эрхлэх газар, НӨҮЕ-Нутгийн өөрөө удирдах ёс, СДЗД-Сум, дурдгийн Засаг дарга, ХТЗЭ-Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй эзэмшиг.

² Хэдийгээр Үндсан хууль Иргэний хуульд нэгжийг харьцангуй бие даасан эрх зүйн этгээд буюу субъект байхыг хуулийсан ч орон нутгийн хууль тогтоомжин хэмжээнд гүнзгийрүүлэн хөгжүүлэгүү юм.-Д.Б.

³ Иргэнхуулийн 7.3. 99.2, 100.1-ийг тусгуст узэүү. Мен蒙古л Улсыд Хүний эрхийг хангах Үндсний хөтөлбөрт “Нутгийн өөрөө удирдах Бангууллагын үйл ашиглалгын санхүү, эдийн засгийн чадважийг бахжуулж, түүний дотор сүмдээг өөрчийг өмчтэй болгох газар, Байгалийн баялагийг хүн амын аж байдлыг дээшшуулж, хүний хөгжлийг хангах чиглэлээр зохицсан ашиглах эрхийг өргөтгэнэ” гэжээ. Төрийнмэдээлэл 2002 он №7.

нийт нутаг дэвсгэрийн 1/3-ийг⁴ хамарч байсан бол 2004 оны 05 сард буюу яг нэг жилийн дараа аймгийн газрын албанаас авсан мэдээгээр энэ тоо бараг 1/2 болтлоо ессэн байдал⁵.

1998 онд Ж.Алтангэрэл тэргүүтэй Заамар сумын 128 иргэн уурхайн эдэлбэр газар бэлчээрэйг шахан мал аж ахуй эрхлэх боломжгүй болж байгаа тухай, алтны компаниуд ашигласан газраа нөхөн сэргээдэггүй, усыг ихээр ашигласнаас болж булаг шандны тэн хагас нь ширгэж, ус багасч байгаа тухай, Засаг даргын нээсн тусгай дансанд барьцаалах барьцааны мөнгөө хийдэггүй зэрэг олон зөрчлийг цохон тэмдэглэх Ерөнхий сайдад бичиг өргөн мэдүүлжээ.

Тэд Заамараа замхуулчихгүйн төлөө уул бичгээр "одоо ажиллаж байгаа аж ахуй нэгжийн тоог нэмэгдүүлэхгүй байх, алтны хайгуулын ажлыг ойрын 10 жилд хийлгэхгүй байх, малын тоо толгой ёсч бэлчээр хүрэлцэхгүй байгаатай холбогдуулан 1981 онд Булган аймгийн Баяннуурт өгсөн Бор булагын буцаан олгож бидэнд эзэмшүүлж өгнө үү"⁶ гэсэн шаардлага тавьсан аж. Харамсалтай нь Ерөнхий сайд доривтой арга хэмжээ авалгүй, тэгэсгээд л өнгөрөөв!

Дээрх нөхцөл байдлыг үндэслэн 2001.01.05-нд тус сумын ИТХ-аас "нөхөн сэргээлтийн үр дүн гарч, талбай нэмэгдэх хүртлэх хугацаанд Заамар сумын нутаг дэвсгэрт алт опборлолт болон хайгуул хийхэд зориулан аж ахуй нэгтгэх байгууллагад эдэлбэр газар эзэмшүүлэхгүй байх" тухай тогтоол баталжээ.⁷ Гэтэл энэ тогтоолыг Төв аймгийн сум дундын шүүх "АШБ" компанийн "үйл ажиллагааг хууль бусаар зогсоосон" гэх үндэслэлээр 2003 онд

хүчингүй болгосон байх юм.

Архангай аймгийн Цэнхэр суманд бас Заамартай тестэй нөхцөл байдал үүссэн. Нийт газар нутгийн 85%-ийг хайгуулын болон ашиглалтын талбай эзэлсэн. Цэнхэрийнхэн оршин амьдрах нөхцөлгүй болсон тул эдэв төрлийн тэмцлийг үүсгэн, эцэстээ уурхай хурдэг нутгийнхаа зам дээр "ард түмний нэрийн өмнөөс орохыг хориглов" гэж чулуун дээр бичик тавьсан нь буй.

1.2. Сумын зөрчигдсэн эрхийг хэрхэн сэргээх бэ? (Заамарын Баржин уулсын кеис). Заамар сумын ИТХ-ын 1996.01.20-ны 03, 1997.02.03-ны 07, 1998.02.10-ны 04 тоот тогтоолуудаар өөрийн сумын зарим газрыг тусгай хэрэгцээнд авчээ. Үүнд хоёр багийн дийлэнх айл өвөлжих хаварждаг Баржин уул хамаарна.

1996 оны сүүлээр Баржин ууланд алтны хайгуул хийх зөвшөөрлийг анх "Монгол алт" компани авсан бөгөөд Заамарын Засаг дарга газрын зөвшөөрөл олгоогүй тул уг компани "Дельфин" ХХК-д ТЗ-өө шилжүүлсэн байна. Заамар сумын удирдлага "сум газар нутгатай байх" язгуур ашиг сонирхлын үүднээс "Дельфин" ХХК-д мөн л зөвшөөрөл олгоогүй тул "АШБ" ХХК-д 58000 доллар буюу 65 сая төгрөгөөр уул эрхээ худалдажээ.⁸ Харин аймгийн Засаг дарга 1999.02.08-ны өдөр 0/132 тоот албан бичгээр хайгуул хийхийг "АШБ" ХХК-д зөвшөөрсөн байна.

Компаниудын хүснэгт, аймгийн Засаг даргын шахалтыг сумынхан сөрөн зогсох бөгөөд үүнтэй нь холбогдуулан 2003.03.10-нд "АШБ" ХХК-ын захирал Н.Алтанцэцэг Төв аймгийн сум дундын шүүхэд хохирол болох 100.000.000 (100 сая) төгрөг шаардаж, үйл ажиллагаа явуулсаар эрхээ сэргээлгэхээр нэхэмжлэл гаргажээ.

Хэрэгт задлан шинжилгээ хийж үзэхэд "АШБ" ХХК, АМХЭГ, аймгийн Засаг дарга гурав нэхэмжлэгч талын

⁴ Засаг дарга М.Эрдэнэлдэл нарын 2003 оны 5 сард Төв аймгийн шүүхэд гаргасан давх: заалдах гомдолд

⁵ АМГТХЭГ-аас Заамарын сумын төвийг хүртэл хамруулсан ХТЗ илгэж байсан түүхэй. -Д.Б.

⁶ Му-ын ерөнхий сайд Ц.Элбэгдорж танваа Бат-Өлзийн. 1998.04.24. Заамарын иргэдийн өргөн барьсан бичигт. 6-7 дахь тал

⁷ Төв аймгийн Заамар сумын 2001.01.15-ны өдрийн №01 тоот тогтолц. 2-р зүйл.

⁸ Му-ын "Дельфин" ХХК-ын захирал Дэмбэрэл, Монголын хятадын хамтарсан "АШБ" ХХК-ын захирал Ша Ео Ди нарын хооронд байгуулсан гэрээ УБ., 1999.05.10.

байр суурь дээр, Төв аймгийн УМХГ-ын уул уурхай хариуцсан улсын байцаач, нутгийн иргэд, түүний засаг захиригаа, аймгийн ИТХ-ын дарга нар хариуцагч талын байр суурь дээр маргалджээ. Анхан шатны шүүх "ИТХ-ын тогтоолуудыг болон хариуцагч талын нотлох баримтыг хуулийн шаардлага хангагүй. Баржин ууланд компани үйл ажиллагаа явуулаагүйгээс ямар ч зөвшөөрөлгүй иргэд гар аргаар алт олборлож байна, хайгуулын лиценз хүчин төгөлдөр хэвээр байгаа" зэрэг үндэслэл зааж ИТХ-ын тогтоолуудыг хүчингүй болгож, сумын ИТХ-ын дарга. Засаг дарга нарыг хууль бус үйлдээ таслан зогсоохыг даалгажээ. Эл шийдвэр давж заалдах болон хяналтын шатны шүүхээр орсон боловч зарчмын хувьд огт өөрчлөгдөөгүй юм. Заамарынхан "нутаг дэвсгэр бүхий" гэсэн Үндсэн хуулиар тогтоогдоон статусдаа үндэслэн нэхэмжлэлийн шаардлагыг үүгүйгэж, өөрийн тогтоол, тайлбарaa хамгаалсан ч шүүх хүлээн аваагүй юм.

1.3. Экологийн буюу амьдралын мөхөл. Бидний лавтай тогтоосноор Өверхангайн Өлтийн алтны уурхай. Заамарын уурхайннууд байгаль орчин, тэр дундаа газрын хөрсийг улэмж зөвдж, цөлжилт бий болгож, голын усиг тохиордуулж, усанд лаг шавар ихээр үүсгэж, энэ бүхэн нь эцэстээ гол горхийг тасалдуулах зэрэг экологийн ноцтой сүйрэлд хүргэж байна.

2005 онд Өверхангайн Улаан цутгалан тасарсан. Заамарын Засаг даргын ярьж байгаагаар Заамар орчмоор Туул гол тасрас ирмэгт очсон.

Архангай Цэнхэр суманд алт олборлохын тулд Харгүйт, Нарийн хамар, Өлзий тээлийн (горхи), Өл, Шийрт зэрэг 5 голын гольдрол өөрчилсөн. Үүний улмаас эдгээр голууд ширгэж Цэцэрлэг, Цэнхэр, Урд тамир голыг цутгаж чадахаа болжээ. Иймд дээр дурдсан голуудын сав нутгийг даган нутагладаг гурван сумын олон зуун айлын амьдрал нь аюулд, экологи нь сүйрэлд өртсөн аж. Ийм нөхцөлд

ашигт малтмалын олборлолтыг хориглох эрх хууль тогтоо болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын аль альд нь байдаг. Гэвч төр хуулиар тогтоосон бурэн эрхийг хэрэгжүүлэхгүй үүрэглэсээр л, ард олны хохироосоор л байв. Харин Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бус, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг 2009 оны 07-р сарын 16-ны өдөр баталж, улмаар уг хуулийн дагуу 41 лицензийг хүчингүй болгосон нь байгаль орчин, экологийн сүйрлийг таслан зогсооход их дөхөм боллоо⁹.

1.4. Нутгийнхан үлдэж гадныхан ашиглласаар байх уу? (Жаргалантын жагсаал). Төв аймгийн Жаргалант сумас 5-6 кмт орших Наран толгойд нутгийн иргэдгараараалт олборлодог байжээ. Тэд нараас алт худалдан авдаг байсан гэх Хятадууд уул ордын АТЗ-ийг авснаар Жаргалантынхны амьдралын эх үүсвэр болоод байсан аж ахуй зогсооход хүрэв.

100 гаруй хүн 2005.03.12-нд өөрсдийн эрхийг хамгаалахыг шаардан ЗДТГ-ыг бүслэн жагсжээ. Тэд ИТХТ-ийн даргыг дагуулан алтны компанийн Хятадуудтай уулзах гэсэн боловч захирал нь байгаагүй байна. 800-аад өрхийн 3000 орчим хүн хамрагдсан сумын иргэдийн ажилгүйчүүдийн хөдөлгөөнүүхөн "Хятадууд манай алтыг аваад байхад бид яагаад гар аргаар олборлож болдоггүй юм бэ"¹⁰ гэсэн тооцон тавин жагсчээ. Тэмцэл бас л ур дунд хүрсэнгүй.

1.5. Орон нутгийн зовлонг яам мэдрэхгүй нь. Архангай аймгийн засаг захиргааны албан хаагчдын Цэнхэр суман дахь алт ашиглалтын талаар ийнхүү ярьж байна. "Архангай аймгийн Цэнхэр сумын нийт газар нутгийн 85%-ийг хайгуулын болон ашиглалтын талбай эзэлдэг.

⁹ АМГ-ын Геологи, уул уурхай, кадастрын халтсын дарлагын 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 295 дугаар шийдвэр.

¹⁰ Өдрийн сонин. №064 (1885). 2005.03.14. Жаргалантад бослого гарлаа.

Хайгуулын 18, ашиглалтын 3 лицензийтэй.

Түгээмэл зөрчил нь нөхөн сэргээлт хийдэггүй. Учир нь ашигласан газрын хэдэн хувийг нөхөн сэргээхийг БОЯ-наас төлөвлөгөөгөөр батлаад өгчидэг. Олон гол горхи ширгэсэн. Хөрсийг нь хуулчикаар ус чийг нь ууралчидаг бололтой. Байгаль орчны яамны ашигт малтмал ашиглах явцад БО-ыг нөхөн сэргээх талаар явуулж байгаа бодлого буруу”¹¹.

Дээрх судалгаанаас дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үндсэн:

1. Төв аймгийн Заамар, Архангайн Цэнхэрийг сумын бүрдүүлбэрээр хэмжэвлэх газар “газар нутагтгүй”, хамтлагийн гишүүд нь үндсэн аж ахуй болох малаад өөр сумын нутаг дэвсгэрт амьдардаг тул “хүн амгүй”, “зөвхөн” засаг нь л үлджээ. Чухамдаа сум сөнөх хандлагатай болж орших уз эс орших уз гэдэгт хүрсэн гэсэн уг. Дээр дурьдсан 2 сумаас үзэхэд хайгуулын талбай, уурхайн талбай, уурхайн эдэлбэр газрын¹² эрх зүйн дэглэмийг тодорхой болгоогүйгээс бэлчээргүй малчид, газар нутагтгүй сумд үүсч байна. Багийн хувьд ч мөн адил. Нөгөө талаас хайгуулын болон уурхайн талбай нь газрын нэгдмэл сангийн үндсэн антилгайлд тодорхой байр суургыг буюу¹³ газрын эрх зүйн харицааны үүднээс уул асуудлыг хуль тогтоомжид тодорхойлоогүй байна гэж үзж болно. Иймд эдээр асуудлыг шийдвэрлэх.

Мөн түүнчлэн сумдыг томосгох замаар газар нутгийг нь тэлэх, нутаг

¹¹ “Аймгийн удирдлагыг зохион байгуулалт-эрх зүйн үндсийг боловсронгуй болгох нь” Удирдлагын академын судалгааны багийн судлаач Да Батболдин Архангай аймгийн МХГ-ын уул уурхай хариуцсан улсын баяцааг Ч Оюунсайхан, аймгийн ЗДТГ-ын ҮДББОБЗХ-ийн дарга нараас авсан арилцлагаас: 2006.6 сар. Архангай, Эрдэнэбулаг сум

¹² Ашигт малтмалын тухай хууль. 4 дүгээр зүйл. 4.1.17: “Хайгуулынталбай” тажинэхуулиин 4.1.15-д заасантуусаа извээшвэрлөөр логдсонталбайг, 4 дүгээр зүйл. 4.1.18: “уурхайнталбай” тажинэхуулиин 4.1.16-д заасантуусай зөвхөнлөөр логдсонталбайг, 4 дүгээр зүйл. 4.1.19: “уурхайнзэлблэг” тажиижуулж тайвайдвахсаан, ашигт малтмалын борлогхөөр хөгжлийн тогтолцооны эснийг

гэжээ

¹³ Газрын тухай хууль 10-р зүйлийг үзнэ үү.

дэвсгэртэй байх язгуур үндсийг хангахын тулд газрыг эзэмшүүлэх, түүнийг хамгаалах механизмыг тогтоох хэрэгжээ, шаардлага байсаар байна.

2. Үндсэн хуулиар хамгаалгасан нэгжийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг Засгийн газар, түүний байгууллага, бусад нэгжүүд зөрчих, хөндөх, ул хүндэтгэх, уг асуудлал щүүхэдэвч эрх зүйн орчин муттайгаас зэрэг шалтгаанаар үл сэргэх тохиолдлуудаас сургамж авч орон нутгийн асуудал хариуцсан Засгийн газрын байгууллага буюу Засгийн газрын Хэрэг зэрхэг газрын чиг үүрэг, ажлын хариуцлагыг сайжруулах, жигдруулэх.

3. Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас байгаль орчин, түүний түвшин амьдарч буй нутгийн иргэдэд учруулж буй хохирол нь олох ашиглалтыг зогсоох арга, хэрэглүүрийг орон нутгийн иргэд, засаг захиргааны эрх хэмжээнд оруулан хуульчлах хэрэгжээ байна. Ашиг алдагдлыг үнэлэх үнэлгээний механизм, түүний үр дүнг орон нутгийн иргэдээр хэлэлцүүлэх эрх зүйн орчинг бий болгох шаардлагатай. Уурхайн үйлдвэрлэлийн бизнес эрхлэгч нь их хэмжээний бэлчээр газар ашиглаж орон нутгийн аж ахуйд сөргөөр нөлөөлгөгийн хувьд орон нутгийн хөгжлийн дэмжих үүрэг хариуцлага хүлээдэг байх нь, түүнчлэн иргэдэд уурхайн үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах зүй ёсны хэрэг.

4. Эрдэс баяялгийг ашиглах үед мөрдэх байгаль орчны хамгаалах төлөвлөгөөг дан ганц байгаль орчны яам баталж өгдөг журмыг өөрчилж, нутгийн засаг захиргааны оропцоог хуульчлах хэрэгтэй байна. Эндээс нэг ажиглагдаж байгаа зүйл бол байгаль орчныг удирдах төрийн удирдлага нь НӨҮБ-оос давчихсан, угийсгэхисэн байдал харагдаж байна. Уг нь орон нутгаас нийслэлд сугаа салбарын яам биш нутгийн өөрөө удирдах байгууллага нь удирдах шинэ Үндсэн хуулийн зарчимтай билээ.

Хоёр. Эрдэс баялгийн хууль тогтоомжийн системд нутгийн захиргааны эрх хэмжээг тодорхойлсон нь¹⁴

Д/д	Нутгийн захиргааны эрх хэмжээг тодорхойлсон хэм хэмжээний төвч агуулга	Хуулийн нэр, заалт	Хуулийн заалтын гол үр дүн, тайлбар	Төвч дүгнэлт, тайлбар
	<p>Ашигт малтмалын талаар нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага дараах 4 бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>1. ашигт малтмалын тухай хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ЗГ-аас гаргасан шийдвэрэйн биелзлтийг харьялаах нутаг дэвсгартээ зохион байгуулах;</p>	AMTX 12-р зүйл.	Ашигт малтмалын талаарх хууль тогтоомж, ЗГ-ын шийдвэр улс даяар биелнэ.	
	<p>2. харьяалах нутаг дэвсгарт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох;</p>	AMTX. 12-р зүйл.	Тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай зориулалтын бусаар ашиглагдахгүй	<p>Хэрхэн яаж таслан зогсоож болж гэдэг нь хуульдаа байхгүй.</p> <p>Харин Газрын тухай хуульд зөрчлийг арилгах шийдвэр гаргах, газрын төлөв байдлыг илэрхийл доройтуулсан нь мэргэжлийн эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн газрыг албадан чөлөөлүүлэх шийдвэр гаргаж, хэрэгжүүлах ажлыг зохион байгуулах зэрэг бүрэн эрхийг Засаг дарга нарт хуульчилсан байдал¹.</p>

¹⁴ Энд 2006 оны Ашигт малтмалын хуулийг голлосон бөгөөд ЗЗНДНТУ Газар, БОХ, БО-д налеөлөх үнэлгээний тухай хуулийг тус тус ашиглав.

	3.байгаль орчны хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн тесевт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн ўргэз тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;	AMTX. 12-р зүйл.	Нутаг дэвсгэрийнхээ байгаль орчин хүн амын эрүүл мэнд, тесвее хамгаалах эрх зүйн үндэс бүрдсэн. Гэвч ашигт малтмал ашигласны төлбөрөөс орон нутгат ордог хувь хэмжээг тогтоосон AMTX-ийн 58, 59 дүгээр зүйлийг хүчингүй болгосноор энэ заалтын агуулга ач холбогдол алдагдсан.	Биелэх зохих механизмуудаар хангагдсан. Гэвч БО-ыг нөхөн сэргээх Үүгрээ билэлүүлэгээг тохиолдолд СДЗД ТЭТБ-д санал гаргаж ТЗ-ыг цуцлахад нөлөөлне. БОЯ-наас нөхөн сэргээх газрын хэмжээг багаар баталдагаас нутгийн засаг захиргаа БОХ-ж чадахгүйд хүрдэг.
	Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар олгохоор сонгосон газрын талаар энэ хуулийн 11.1.23-д заасан дүгнэлт гаргуулах тухай хүснэгтийг төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.	AMTX. 12.1.5	Газрын давхардал, хамгаалалтад орсон газар зүй бусаар ашиглагдахгүй.	
	4.Газрын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах.	AMTX. 14-р зүйл.	Газар нутгаа тусгай хэрэгцээнд авч, неецтэй, хувсаартай ашиглах боломж бүрдсэн.	TЗЭ-ийн талбайг тусгай хэрэгцээнд авья гэвэл нөхөн олговорт егех менгэ суманд байхгүй тул газраа авч чаддаггүй. ТЗЭ-ээс урьдаад газраа тусгай хэрэгцээнд авья гэвэл 5-аас дээш жил авах эрхгүй. Иймд сум эл механизмаар нутгаа хамгаалах чадаахааргүй байгаа юм.
	Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 19.3-т заасан мэдэгдлийг хулээн авмагц тухайн талбай байршил сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч 30 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад хариу егех бөгөөд энэ хугацаанд хариу егөөгүй бол тухайн саналыг зөвшөөрсөн гэж үзнэ.	AMTX. 19.4.	Газар нутгаа хамгаалах арга, хэрэглүүр зарим талаар куулчлагдсан.	Орон нутгаас санал авч байгаа нь сайн хэдий ч эцсийн дундээ газрын эзэн болго. О сумнаас биш аймгаас авч байгаа нь буруу. АЗД-ын шийдвэрийг сумын хүн ам, ИТХ хүлээж авахгүй, суулдээ сум аймаг 2 шүүхдэг зохисгүй байдлыг үүсгэдэг.

	Хайгуулын ТЗ эзэмшигч нь БОХ алба болон СДЗД-тай зөшилцөн БОХ төвлөгөө боловсруулж СДЗД-аар батлуулна.	AMTX. 38.1.	Нутаг дэвсгэрийнхээ БО-ыг ТЗ эзэмшигчээр хэрхэн хамгаалуулах асуудлыг СДЗД веерөө мэдэж байгаа нь дэмжиүүштэй.	Төвлөгөөний гүйцэтгэлийн баталгаа болгож БХ ажлын нэг жилийн ажлын зардлын 50%-тэй тэнцэх хэмжээний мөнгийг СДЗД-ын дансандаа төвлөрүүлнэ. БОХ үргээ билэглүүлэгүү тохиолдолд СДЗД энэ мөнгөөр зөвдэрэн БО-ыг нөхөн сэргээх бөгөөд үлдсэн мөнгийг үл маргах журмаар гаргүүлна.
	Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд СДЗД болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй.	AMTX. 39.7	БОХ баталгаа болсон гэж үзэж болно.	Мен АТЗЭ-ийн БОХ төвлөгөөнд нутгийн засал зэкиргээны оролцоо байдалтуу нь ТЗЭ БОХ, нөхөн сэргээх үргээ хангалгүй билэглүүлэх нөхцөлжиг бурдаулж байгаа.
	ТЗЭ нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллаганы явцад худаг, өвөлжээ, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байгууллахтай холбогдсон зардлыг хариуцна.	AMTX. 41.	Гэм хор учирвал арилгуулах эрхтэй. Нүүн шилжих бол төлбөр авах эрхтэй. (шаардлагатай тохиолдолд)	Энэ нь иргэний хуулийн холбогдох хэм кэмжээтэй адил агуулгатай хэм хэмжээ юм. Шаардлагатай тохиолдолд шилжүүлэхтэй холбогдсон зардлыг хариуцаа заасан нь шударга бус болсон. Хохирлыг бүрэн хариуцна ёстой.
	ТЗЭ нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгууллахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай гэрээ байгуулж ажиллана.	AMTX. 42.1.	Нутаг дэвсгэрийнхээ БО-ыг сүйтгээс сэргийлэх, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд ахиц гарах боломжтой.	Хэнтэйэрээ байгуулах, гэрээ байгуулахгүй гэвэл хэрхэг тухай тодорхойгүй. Өөрөөр хэлбэл хуулийн холбогдох заалтуудаараа баталгаажаагүй.

Тусгай зөвшөөрөл зэмшигч нь энэ хуулийн 42.1-д заасан асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.	AMTX. 42.2.	Уурхайн үйл ажиллагааны талаар тодорхой мэдсний үндсэн дээр өөрсдийнхвээ зрх, хуул ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжтой.	Олон түмний оролцоо, хяналтыг тогтофсон.
1.Ашиглалтын тусгай зөвшөөрөл зэмшигч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах түрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажилласдын 10-ас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно. 2.Тусгай зөвшөөрөл зэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжэээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлслний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсөнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө.	AMTX 43.1 43.2	СД-ийн төсвийн орлого нэмэгдэнэ	Нутгийн зрх зүйн хувьд үндэслэлгүй хэм хэмжээ. Харин элс, хайрга матийн ердийн эрдэс баялаг ашигласны төлбөрийг дахин хувавирлдаггүй зөвхөн суманд нь улдээнэ, сумын өөрийн хүчээр ашиглах бол зөвшөөрлийг аймаг нь олгоно, бусад зөвшөөрлийг сум өөрөө өгнө гэхчилэн асуудлыг шийдвэрлэхэд журмыг тогтоомоор. Ердийн эрдэс баялагтүү сум гэж байхгүй тул сум бүр орлоготой болно. Завханы Тэс суманд хайрганы аж ахуй эрхлэх нэгэнд Улаанбаатараас зөвшөөрөл ав гээд байгаа нь тун ч зохицуй гэдэг ойлгомжтай. Ердийн эрдэс баялаг ашиглалт авсаар, байгаль орчинд хөнөөлт бага, нехэн сэргээлт хөнгөнний анхаарч ашиглалтын асуудлыг орон нутгаараа эрхлүүлбэл иргэддээ чирэгдэлгүй бус уу.

	Tухайн сум, дүүргийн иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой үйл ажиллагаа явуулна.	AMTX. 44.	Уурхайн үйл ажиллагаанаас болж хүн амын аюулгүй байдал алдагдахгүй болно.	Энэхүү тодорхой үйл ажиллагааг явуулаагүй бол хулээн хариуцлага тодорхойгүй. Өөрөөр хэлбэл биелэх баталгаа байхгүй.
	Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг нехэн сэргээх үүргээ биелүүлээгүй талаар нутгийн захираганы байгууллагын саналыг харгалзан байгаль орчны асуудал эрхэлсэн териин захираганы төв байгууллага дүгнэлт гаргасан бол тусгай зөвшөөрлийг цуцлана.	AMTX. 56.1.5	Орон нутаг орчны газар, хүрээлэн буй орчинoo хамгаалах, нэгэн механизмтэй болсон.	
	Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавих	ЗЗИДНТУТХ 30.1.5.	Орон нутгийн зүй ёсны эрх мэдлийг хуульчилсан	

Дээрх хүснэгтэнд дурдсанчлан эрдэс баялгийн хууль тогтоомжийн системд нутгийн засаг захирагааны байгууллагын эрх хэмжээг 15 зүйлээр тодорхойлжээ. Эдгээр нь:

1. Нутаг дэвсгэрийнхээ байгаль орчны хамгаалах (хүснэгтийн 3,6,8-р зүйл, АМТХ-ийн 12, 39.7, 38.1);

2. Дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах (хүснэгтийн 1,2,7-р зүйл.);

3. Эзэмшил газар нутгаа хамгаалах (хүснэгтийн 4,5-р зүйл.);

4. Нутаг дэвсгэрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах (хүснэгтийн 9,10,12,13-р зүйл) гэсэн 4 чиглэлээр тодорхойлогдсон байна.

Нутгийн засаг захирагааны эрх хэмжээг тогтоосон дээрх хэм хэмжээнд задлан шинжилгээ хийхэд бараг заалт бүр дээр нь "гар хүрч" болмоор буюу концепцийн хувьд бүхжд нь өөрчлүүштэй байна.¹⁵ Дурдсан хэм хэмжээнд бүхэлд нь анализ хийж үзвэл:

– Хуулийн бусад заалтуудтайгаа уялдаж, биелэх норматив бололцоотой болсон нь 50%-ийг;

– Биелэх бололцоогүй буюу хуулийн бусад хэм хэмжээтэй холбоогүй нь 6,25%-хувийг;

– Зөрчил үүсгэдэг буюу зүй зохисоо олж чадаагүй нь 43,75%-ийг тус тус эзэлж байна¹⁶.

Биелэх бололцоотой хэм хэмжээнд нутгийн засаг захирагаа байгаль орчноо

¹⁵ Энэ талзэр хүснэгтийн төвч дүгнэлт, санал хэсгээс дэлгэрүүлэн харна уу.

¹⁶ Хүснэгтийн дурдсан хэсэгт үзэх үү.

хамгаалах, эрдэс баялгaa ашиглах, дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтглийг хангах чиглэлийн заалтууд орж байхад биелэх бололцоогүй, зөрчил үүсгэж байгаа буюу зүй зохисоо олж чадаагүй хэм хэмжээнд нутаг дэвсгэрийнхээ эрхийг хамгаалах, газар нутгаа хамгаалах гэсэн чиглэлийн заалтууд орж байна.

Үйлчилж буй хэм хэмжээний тал хувь нь үр нөлөөгүй, зөрчил үүсгэдэг гэхээр "хуультай юмуу гэхээр хуульгүй, байхгүй юмуу гэхээр байгаа" ийм л байдалтай байна гэсэн сэтгэл гонсгойлгомоор дүгнэлтэнд арга буюу хүрнэ. Ийм алдаа гарах болсон үндсэн шалтгаан нь хууль тогтоогч ЗЗНДН-д зохион байгуулалтанд орсон хүн ам буюу хуулийн этгээд (субъект) гэдэг шинэ Үндсэн хуулийн үзэл санаагаар бус өөр бусад (жишээлблэл, засаг захирагааны нэгж) ерөөсгөл хандлагагаар хандсандаа оршино. Геолог, уул уурхайн олон талт харилцаанд тэр хэмжээнд нь хүрч, эрх зүйн олон салбарын үүднээс бүрэн хандаж чадаагүй нь алдаа гаргах бас нэгэн шалтгаан болсоннь судалгааны явцад ажиглагдаж байна.

Монгол нутагт өргөн дэлгэр, шинэ тутам өрнөсөн уул уурхайн үйлдвэрлэл, харилцаанд орон нутаг, түүний иргэдийн Үндсэн Хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдэж байхад түүнийг төв засгийн түвшинд буюу улсын хэмжээнд хамгаалан зохицуулах чиг үүрэгтэй Засгийн газрын хэрэг эрхлэх газар хэрхэн ажиллав аа гэдгийг бодууштай бас дүгнүүштэй юм.

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ АЖИЛЛАГААН ДАХЬ ТӨРИЙН НУУЦТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН АСУУДАЛ



Үндэсний тагнуульын академийн эрдэм
шинжилгээний тэргүүлэх ажилтан, (LL.M).
Б.Батхишиг

Гэмт хэргийг илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоож эрүүгийн хариуцлагад татах зорилго бүхий эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад төрийн нууцыг хамгаалах төрийн ашиг сонирхлыг хөндөгдсөн тохиолдолд түүнийг хэрхэн зохицуулах тухай асуудал нь эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн судалгааны чухал чиглэлийн нэг юм.

Аливаа нууц, түүний дотор төрийн нууц нь зөвхөн түүнийг итгэмжлэн хариуссан эсхүл ажил үүргийн дагуу мэдсэн цөөн хүний хувьд мэдэх, бусад хүний хувьд хаалттай мэдээлэл юм.¹ Тиймээс улс орон бүр үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс төрийн нууцад хамаарах мэдээллэтийн танилцах, ашиглах, хадгалах, шилжүүлэх зэрэг төрийн нууцтай холбоотой бүхий л ўйл ажиллагаанд нууцлалыг хангах арга хэмжээг хууль зүйн хүрээнд авч хэрэгжүүлдэг. Үүний дотор эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны онцлогтой холбоотойгоор төрийн нууцтай холбоотой асуудлыг эрүүгийн

¹ ХБНГУ-ын Эрүүгийн хууль төрийн нууцыг "ХБНГУ-ын гадаад аюулгүй байдалд түнд хор уршиг учруулах аюулаас сэргийлэхийн түрээ гадаад улсаас нууцлал шаардлагатай, зөвхөн хягдаж альгамал хүрээний хүн танилцах баримт, эд зүйл, мэдээ" гэж тайлбарласан байдал.

байцаан шийтгэх хуульд тусгайлан зааж зохицуулж байна,

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль²-аас үзэхэд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад төрийн нууцыг хамгаалах зорилгоор тус хуулийн тодорхой хэсэгт буюу 41.3.8, 48.4, 79.3, 132.2, 133.4, 235.1 зэрэг зүйл, заалтад төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон хэм хэмжээг тогтоожээ. Эдгээр нь үндсэндээ төрийн нууцыг хамгаалах төрийн ашиг сонирхлыг хангах шаардлагыг харгалзан тусгасан зохицуулалт гэж үзэх болно. Гэвч дээрх хуульд заасан хэм хэмжээнүүд нь гадаад орны нийтлэг жишиг, төрийн нууцыг хамгаалах хэрэгцээ, шаардлагыг хангаж байгаа эсэх нь эргэлзээтэй юм. Өнөөгийн байдлаар Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн шинжлэх ухаанд энэ сэдвээр гаргасан эрдэмтэн, судлаачдын бүтээл, судалгааны ажил төдийгүй энэ сэдвийг хөндсөн бүтээл байхгүй. Түүнчлэн практикт эрх бүхий байгууллага, албан тушаалтан төрийн нууцтай холбоотой нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд удирдлага болгох тусгайлан гаргасан эрх зүйн акт ч байхгүй байна.

Аливаа орны эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь төрийн нууцтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг үзэхэд эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааг явуулахад төрийн нууцыг хамгаалах болон энэ ажиллагааны үед төрийн нууцтай танилцах тусгай журмын агуулсан байdag ба эдгээр журмыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэрхэн бэхжүүлснээс төрийн нууцын

² Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль 2001.01.10 "Төрийн мэдрэлэл" сэргүүл, 2002 он №6

хамгаалалт ихээхэн шалтгаалдаг.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 172.3-т заасны дагуу гомдол, мэдээллийг шалгах явцад гэмт хэрэг үйлдэж байгаа болон үйлдсэн тухай үндэслэлтэй сэжиг байгаа тохиолдолд эрх бүхий албан тушаалтан эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэхийн тулд хойшлуулшгүй ажиллагааны хүрээнд, түүнчлэн эрүүгийн хэрэг үүсгэсний дараа эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд үзлэг, туршилт, хураан авах, нэлжих, эд хөрөнгөе битүүмжлэх, шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг хураан авах, байцаах, танъж олуулах, мэдүүлгийг шалгах, шинжилгээ хийх зэрэг ажиллагааг явуулдаг. Эдгээр ажиллагаанууд дотроос төрийн нууцыг хамгаалахтай холбоотой тусгай журмыг тус хуулийн 132.2, 133.4 дэх хэсэгт буюу хураан авах, нэлжлэг хийх ажиллагаанд тусгасан байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 132.2-т хураан авах ажиллагааны үед "Төрийн нууц агуулсан баримт бичгийг гагчхүү прокурорын зөвшөөрөлтэйгээр, зохих байгууллагын удирдлагад мэдэгдсэнд үндсэн дээр хураан авна." гэж заажээ. Энэ хэсэг нь хураан авах ажиллагааг явцад үүсэх төрийн нууцтай холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн боловч томъёоллын хувьд төрийн нууцыг хамгаалах шаардлагыг бүрэн хангаж чадаагүй байна. Учир нь Төрийн нууцын тухай Монгол Улсын хуулийн төрийн нууц тээгч нь мэдээ, баримт бичиг, эд зүйл зэрэг олон хэлбэртэй байж болох³ ба Эрүүгийн хуулийн тусгай ангийн 87 (Төрийн нууц задруулах),

88 (Төрийн нууц мэдээ, баримт бичиг, эд зүйлийг үрэгдүүлэх) дугаар зүйлд заасан гэмт хэргийн халдлагын зүйл нь "мэдээ", "баримт бичиг"-ээс гадна "эд зүйл" болдог. Гэтэл 132.2-т төрийн нууц агуулсан "эд зүйл"-ийг орхигдуулсан нь прокурорын зөвшөөрөлгүй төрийн нууцыг хураан авах боломжийг бурддүүлжээ. Үүнээс гадна "прокурорын зөвшөөрөл" нь ямар хэллэр (аман эсхүл бичгийн)-тэй байх, цаг хугацааны хувьд хэзээ үйлчлэх (урьдчилж, эсхүл тухайн үед нь зөвшөөрөл авах), зөвшөөрлийг ямар прокурор олгох, "зохих байгууллагын удирдлагад мэдэгдэх" гэдэгт ямар түвшний албан тушаалтыг авч үзэх зэрэг нь тодорхой бус байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн заалтыг хэрэглэхэд хүндрэлд учруулахаар байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 132.2-д заасантай ойролцоо зохицуулалтыг ОХУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хууль⁴-ийн 183 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тусгахдаа хураан авах зүйлд төрийн нууц агуулсан баримт бичгээс гадна эд зүйлийг хамааруулж, хураан авах ажиллагааг хуулиар тогтоосон журмын дагуу шүүхийн шийдвэрийн үндсэн дээр явуулахаар заасан нь илүү тодорхой зохицуулалт болсон байна.⁵ Эндээс үзвэл, Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 132.2 дахь хэсгийн томъёоллыг илүү боловсронгуй болгож вөрчлөх шаардлагатай юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 133.4-т "Хураан авах, нэлжлэг хийх үед хуулиар хамгаалагдан нууц баримт бичиг, бусад зүйл илэрвэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч түүнийг задруулахгүй байх арга хэмжээ авна." гэсэн нь бүх төрлийн

³ Төрийн нууцын тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд "Төрийн нууц тээгч Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлыог, эдийн засаг шинжлэх ухаан, техники-технологи, бетлан хамгаалалт тагнуул, серен тагнуул, гүйцэтгэх ажилтны колбиктом багаад задруулбал үндэсний агуултуулбад хор хөжирүүлчүүц мэдээллийн томъёолопол дүр: зураг, дэхиж тохиолд, техники-технологийн шийдвэр болон үйл ажиллагааны хэлбэрээр "өөрөөт агуули" байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг халин," гэж тодорхойлсон.

⁴ ОХУ-ын Эрүүгийн байцаан шинтэх хууль (Уголовно-процессуальный кодекс Российской Федерации) 2001.12.18 №174 www.consultant.ru

⁵ ОХУ энэ хуулиас эмне ўлшилийг байсан ЗХОУ-ын Эрүүгийн байцаан шинтэх хуулийн 167 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт төрийн нууцад хамаарах мэдээлэлтэй агуулсан баримт бичигийг хураан авах ажиллагааг прокурор, эсхүл түүний орлогийн зөвшөөрөлтийнөөр хоёр байгууллагын удирдлагатай тохиорцсон журавар явуулна" гэж заасан байсан багаад шинж куульдаа энэ алдаагаа засч боловсронгуй болгосон байна. Б.Б.

нууц, түүний дотор төрийн нууцыг хамгаалахад чиглэсэн заалт юм. Харин хуульд нууцыг задруулахгүй байх ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар заагаагий байна. Төрийн нууцын тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "б"-д Монгол Улсын Ерөнхийлөгч "төрийн нууцыг боловсруулах, хадгалах, хамгаалах, ашиглах, объект, тодорхой үйл ажиллагааг халхлах, төрийн нууцтай танилцах, төрийн нууцыг шилжүүлэх, татан авах, хаалттай хуралдаан хийх журмыг батлах", 19 дугаар зүйлийн 2-т Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, тэдгээртэй адилтгах бусад албан тушаалтан нь албан ургийн шаардлагаар танилцвал зохих төрийн нууцтай энэ журмын дагуу танилцахаар заасан. Төрийн нууцын тухай хуулийн заалтын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 213 дугаар зарлигаар "Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах журам"-ыг баталсан бөгөөд энэ нь төрийн нууцыг хамгаалахтай холбоотой бүхий л харилцаанд төрийн бүх байгууллага, албан тушаалтан нийтлэг дагаж мөрдөх журам юм. Эндээс үндэслэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 133 дугаар зүйлийн 133.4 дэх хэсгийн "задруулахгүй байх арга хэмжээ" гэдэг нь "Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах журам"-д заасны дагуу авч хэрэгжүүлэх хамгаалах арга хэмжээ гэж ойлгож болох ч энэ талаар Эрүүгийн байцаан шийтгэх хуульд ч, "Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах журам"-д ч тодорхой заалт байхгүйгээс шууд ингэж узэх боломжгүй юм.

Гадаадын зарим орны хуулиас үзэхэд, нууцын дэглэмийг хангах журмыг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд сахин биелүүлж байхаар хуулиар заасан байdag. Тухайлбал: Украян Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль⁶-ийн 517 дугаар зүйлийн

1-т "Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагаа болон шүүхээр хэлэлцэх ажиллагаанд нууцын дэглэмийн шаардлагааг сахин биелүүлж явуулна" гэж заасан бол Молдав Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль⁷-ийн 213 дугаар зүйлд "Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд төрийн нууц агуулсан мэдээллийг хамгаалахын тулд тус хууль, Төрийн нууцын тухай хууль болон бусад эрх зүйн хэм хэмжээний актад заасан арга хэмжээг авна" гэж заажээ. Эдгээр орны жишигийн дагуу Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 133.4 дэх хэсгийн хэм хэмжээг нөхөж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад төрийн нууцыг хамгаалах арга хэмжээг төрийн нууцын тухай хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэх талаарх заалтыг хуульд тусгах нь өновчтэй юм.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаач төрийн нууцад хамаарах хэргийг шалгах явцдаа холбогдох байгууллагаас төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг шаардан гаргуулах, эсхүл төрийн нууц хариуцсан болон ажил үүргийн дагуу танилсан албан тушаалтан, иргэнээс төрийн нууцад хамаарах асуудлаар тайлбар мэдүүлэг авах эрхтэй байдаг. Гэхдээ энэхүү шаардан материалыг тухайн байгууллага гаргаж өгөх, албан тушаалтан, иргэн тайлбар, мэдүүлэг өгөх асуудлыг тусгайлан зохицуулаагүй учир нийтлэг журмын дагуу явуулдаг билээ. Гэтэл энэ зохицуулалт нь төрийн нууцын тухай хууль тогтоомжийн зарим нөхцөл, шаардлагатай зөрчилдөхөд хүргэдэг. Төрийн нууцын тухай хууль тогтоомжийн дагуу төрийн нууцтай албан үүргийн дагуу танилцсан албан тушаалтан, иргэн төрийн нууцыг ил

⁶ Украян Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (Уголовно-процессуальный кодекс Украины). 2012.04.13 №4651-VI

⁷ Бүгд Найрамдах Молдав Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (Уголовно-процессуальный кодекс Республики Молдавия). 2003.03.14 №122

болов хүртэл хугацаанд задруулахыг хориглодог (12 дугаар зүйл) ба энэ тухайгаа илэрхийлж баталгаа⁹ гаргадаг. Мөн Төрийн нууцын тухай Монгол Улсын хуулийн 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт тагнуул, серх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд хамаарах төрийн нууц болох гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж болон гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлд холбогдох мэдээ, баримт бичигтэй зөвхөн шалгаж байгаа асуудлын хүрээнд Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны дарга, гишүүнээс бусад хүн танилцахыг хориглосон байдаг. Эдгэр шаардлагын дагуу төрийн нууц хариуцсан байгууллага, албан тушаалтан холбогдох мэдээллийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид гаргаж өгөхгүй байх, албан тушаалтан, иргэн мэдүүлэг өгөхгүй байх үүрэгтэй. Гэтэл энэ онцлогийг харгалзан үзсэн зохицуулалтыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгаягүй учир дээрх шалтгаанаар баримт сэлтийг гаргаж өгөөгүй буюу мэдүүлэг өгөхөөс татгалзсан тохиолдолд хэрэг шалгах ажиллагаанд саад учруулсан, мэдүүлэг өгөхөөс зайлсхийсан гэж эрүүгийн хариуцлагад татагдахад хүрдэг нь нууцад хамаарах асуудлаар ямар ч хязгаарлалтгүй албадан мэдээ, мэдээлэл авах механизм үйлчилж байна гэж үзэхэд хүргэж байна. Гэтэл гадаад орууудын эрүүгийн байцаан шийтгэх хуульд эсрэгээр нэлэн нарийн зохицуулалтыг тусгасан байх нь бий. Жишээлблэл: Эстони Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 73 дугаар зүйлд зааснаар, гэрч төрийн нууц болон гадаад улсын нууц мэдээлэлтэй холбоотой асуудлаар мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй бөгөөд мэдүүлэг өгөхөөс татгалзсан тохиолдолд мөрдөн байцаах байгууллага, прокурор, эсхүл шүүх тухайн төрийн нууц, гадаад улсын нууц мэдээллийг эзэмшиж

хариуцсан байгууллагад тухайн үйл баримтыг төрийн нууц, гадаад улсын нууц мэдээлэл болох эсэх талаар баталгаа гаргуулж авдаг. Хэрэв төрийн нууц, гадаад улсын нууц мэдээллийг эзэмшиж хариуцсан байгууллага тухайн үйл баримтыг төрийн нууц, гадаад улсын нууц мэдээлэл болохыг хүлээн зөвшөөрч батлаагүй, эсхүл хүсэлт гаргасан едрөөс 20 хоногийн хугацаанд хариу өгөөгүй бол тухайн гэрч мэдүүлэг өгөх үүрэгтэй болдог байна. Чехийн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 99 дүгээр зүйлд "Зохих байгууллага үүргээс нь чөлөөлснөөс бусад тохиолдолд гэрчийг төрийн нууцад хамаарах асуудлаар байцааж болохгүй. Зохих байгууллага нь гэрчийн мэдүүлэг улсад ноцтой хохирол учруулах нөхцөлд тухайн үүргээс чөлөөлхөөс татгалзаж болно" гэж заажээ. Латвийн Эрүүгийн байцаан шийтгэх хуульд⁹ зааснаар шаардсан мэдээлэл нь хуулиар хамгаалсан төрийн нууцад хамаарч байгаа бол тухайн этгээд нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны халдашгүй эрхтэй этгээдэд тооцогддог.(113 дугаар зүйл)

Дээр дурдсан бүх жишээ баримт нь Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд төрийн нууцад хамаарах мэдээллийг, ялангуяа мэдээллийн эх сурвалжтай холбоотой төрийн нууцад хамаарах мэдээллийг хариуцсан байгууллага гаргаж өгөхгүй байх, холбогдох албан тушаалтан энэ талаар мэдүүлэг өгөхгүй байх нөхцел, журам, түүнчлэн мэдүүлэг өгөх тохиолдолд тавигдах шаардлага зэрэггүй хуульчлах шаардлагатай харуулж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 48 дугаар зүйлийн 48.4-т "Хөндлөнгийн гэрч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүхийн дуудсанаар ирэх, байцаан шийтгэх ажиллагааны журмыг сахиж, нууцыг задруулахгүй байх үүрэгтэй." гэж заасан.

⁹ Латвий Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (Уголовно-процессуальный кодекс Республики Латвии). 2005 04 21

Харин хөндлөнгийн гэрчээс бусад бусад байцаан шийтгэх ажиллагааны оролцогчид болох иргэдийн төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч, хохирогчийн төлөөлөгч, орчуулагч, хэлмэргч, шинжээчид ийм үүрэг хүлээлгэсэн зүйл байхгүй байна. Гадаад орны хууль тогтоомжид тухайлбал, Эстони Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль¹⁰-аар хохирогчийн хамгаалагч, төлөөлөгч, шинжээч, эвлэрүүлэгч эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцох явцдаа мэдсэн мэдээллийн нууцыг хамгаалах уургатгын байдал.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 166.1.5-д "гэмт хэргийн талаар гүйцэтгэх ажлын шугамаар авагдаж баримтжуулагдсан мэдээ баримт байгаа бол" эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болох ба 28 дугаар зүйлд заасны дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаач "гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоохын тулд зайлшгүй хийвэл зохицгээх ажлыг эрх бүхий байгууллагад даалгавар бичих гүйцэтгүүлэх(28.2.14), гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, түүнчлэн гүйцэтгэх тодорхой ажиллагаа явуулах шаардлагатай бол энэ тухай даалгаврыг бичгээр гаргах (28.2.15) эрх, үүрэгтэй байdag. Иймээс тус хуулийн 79.3-т "Эрүүгийн хэргийн талаар хуульд заасан үндэслэл, нөхцөл, журмын дагуу прокурорын зөвшөөрлөөр явуулсан гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж авсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болох ба ингэхдээ нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх үйл ажиллагааны эх сурвалжийг нууцална." гэж заажээ. Энэ заалт нь Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль¹¹-ийн 1 дүгээр зүйлийн 39-д "тагнуул, серөх тагнуул, гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж" гэж заасан төрийн нууцтай шууд холбоотойгоор Эрүүгийн байцаан

шийтгэх хуулийн 79.3-т тусгалаа олсон гэж үзэх үндэстэй юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79.3-т заасан "Нууцлах" гэдэг нь нэр томъёоны талаас нууцад хамаарах мэдээллийг хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх агууллыг илрэхийлдэг¹² учир гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж олж авсан баримт сэлтэй танилцах, ашиглах асуудал тусгайлан зохицуулах ёстой ч тус хуулийн бусад зүйл, хэсэгт зохицуулагдаагүй. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-т гүйцэтгэх ажлын үр дүнг "гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, нотлох баримт цуглуулах, тэдгээрийн эх сурвалжийг олж тогтоох" зорилгоор ашиглахаар заасан боловч гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж олсон баримт сэлтийг танилцуулах эрх зүйн зохицуулалт байхгүй, өнөөг хүртэл журамлагдаагүй байна. Гадаад орнуудын хувьд энэ эрх зүйн зохицуулалтыг Гүйцэтгэх ажлын тухай хуульд эсхүл Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шууд тусгаж шийдвэрлэсэн байдал.

Төрийн нууцтай танилцах тусгай журам тогтоосон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн нэг хэм хэмжээ бол өмгөөлөгч "хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт дууссаны дараа хэргийн бүх материалтай танилцаж, тер, байгууллага, хувь хүний нууцад үл хамаарах нотлох баримтыг өөрийн зардаар хувилах, хуулбарлан авах" эрхтэй гэсэн заалт юм. (41.3.8) Харин өмгөөлөгчесөн бусад оролцогчид болох хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, шинжээч, орчуулагч зэрэг оролцогчид танилцах эсэх, цаашлаад танилцаад хягаарлалт байх эсэх асуудлыг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шийдвэрлээгүй. Украян Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 517 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт, "Хохироч, түүний төлөөлөгч, орчуулагч, шинжээч,

¹⁰ Эстон Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (Criminal Procedure Code of the Republic of Estonia). 2003.02.12

¹¹ Төрийн нууцын жагсаалт батлах тухай Монгол Улсын хууль. 2004.01.02

¹² Б.Батхишиг "Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах үндэс" гарын авлагы. УБ., 2015 23 дахь талаас үзэх.

мэргэжилтэн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн зохион байгуулагч төрийн нууцад хамаарах материалыаас хуулбарлах, тэмдэглэл хийхийг хориглоно. Сэжигтэн, яллагдагч хууль ёсны төлөөлөгч, хамгаалагч төрийн нууцад хамаарах материалыаас хуулбар хийхийг хориглоно." гэж заасан бол Белорусийн Эрүүгийн байцаан шийтгэх хууль¹³-д "... Эрүүгийн хэрэгт төрийн нууц болон хуулиар хамгаалсан бусад нууцад хамаарах мэдээлэл байгаа бол яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, хамгаалагчас тэдгээрийг задруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар урьдчилан сангуулснаас баталгаа авна." гэж заажээ. (257 дугаар зүйлийн 2) Мөн Чехийн Эрүүгийн байцаан шийтгэх хууль¹⁴-ийн 50 дугаар зүйлийн 3-т "Төрийн нууцад хамаарах нэхцэл байдлыг авч хэлэлцэх байгаа эрүүгийн хэргийн хохирогчийн болон иргэний нэхэмжлэгчийн төлөөлөгч нь зөвхөн төрийн нууцтай танилцах зөвшөөрөл авсан ёмгөөлөгч, эсхүл иргэн байна" гэж зааж, 65 дугаар зүйлийн 1-д яллагдагч, хохирогч, иргэний нэхэмжлэгч, тэдгээрийн хамгаалагч, төлөөлөгч, олон нийтийн төлөөлөгчид "Хэргийн материалтай танилцахыг зөвшөөрсөн уед төрийн, албаны, аж ахуйн нууцыг хамгаалах арга хэмжээг авсан байх шаардлагатай" гэжээ. Гадаад орнуудын зохицуулалтаас үзэхэд, төрийн нууцтай холбоотой эрүүгийн хэргийн материалтай ёмгөөлөгчөөс гадна бусад субъект танилцаж болох ч төрийн нууцтай танилцах зөвшөөрөл авсан байх, эсхүл задруулсан тохиолдолд хариуцлага хүлээх баталгаа гаргаж танилцах зэрэг хязгаарлалтыг тогтоодог нь Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуульд ч авч хэрэгжүүлбэл зохих жишиг юм.

¹³ Бүгд Найрамдах Белорусь Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль (Уголовно-процессуальный кодекс Республики Беларусь) 1999.07.16 № 295-З

¹⁴ Бүгд Найрамдах Чөл Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (Act on Criminal procedures), 1961.11.29 №141

Аливаа орны эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид нийтлэг заасан төрийн нууцыг хамгаалах нэг зохицуулалт бол төрийн нууцад хамаарах хэргийг авч хэлэлцэх шүүх хуралдааныг хаалттай явуулах явдал юм. Үүний нэгэн адил Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 235 дугаар зүйлийн 235.1-д "Төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалах болон насанд хүрээгүй этгээдэд холбогдох хэрэг хянан шийдвэрлэхээс бусад бүх шатны шүүхийн шүүх хуралдааныг нээлттэй явуулна." гэж заасан. Өнөөгийн байдлаар манай улсад шүүх хуралдааныг хаалттай явуулах эрх зүйн үндсийг үндсэн хуулийн цэц, эрүү, иргэний, захирагын процессын хуулиудаас гадна бусад хуульд тусгасан боловч хаалттай хуралдаан явуулах нийтлэг журам байхгүй, албан тушаалтнуудын хувьд хуралдааны танхимаас зөвхөн гаднын оролцогчид, хэвлэл мэдээллийг хэрэгслийнхийг гаргаснаар хаалттай явагдана гэж үздэг хандлага байдаг. Хаалттай хуралдаан явуулахад хуралдааны танхим, техник хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангах, мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, үзлэг хийх, хуралдаанд оролцож этгээдүүдийг тогтоох, нууц задруулахгүй байх баталгаа авах, хуралдааныг явуулах дэгийг тогтоох, хуралдааны уед нууцад хамаарах баримт бичиг, бусад зүйлийг танилцуулах зэрэг олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болдог. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 54-т "Төрийн нууцад хамаарах асуудлаар хэлэлцсэн төрийн байгууллагын хаалттай хуралдааны тэмдэглэл, түнд холбогдох мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа"-г төрийн нууцад хамааруулсан. Үүнтэй холбоотойгоор Төрийн нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-ын "б"-д Монгол Улсын Ерөнхийлөгч "... хаалттай хуралдаан хийх журмыг батлах"-аар тогтоосны дагуу Монгол Улсын

Ерөнхийлөгчийн 1999 оны 213 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах журам"-д "Хаалттай хуралдаан хийх" гэж тусгай зүйл оруулсан байна. Ийм учраас төрийн нууцад хамаарах асуудлыг хэлэлцэх хаалттай шүүх хуралдааныг энэ журмын дагуу явуулах ёстой. Гэхдээ "Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах журам"-д заасан хаалттай хуралдаан хийх журам нь дэлгэрэнгүй бус, шүүхийн үйл ажиллагааны онцлогийг тусгаагүй учир шүүхийн хэмжээнд мөрдөх нарийвчилсан журам байх шаардлага үүсж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд шүүх хуралдааны төгсгөлд шүүхийн тогтооны агуулгыг танилцуулж, тогтоох хэсгийг унших сонсгох (299.1), шийтгэх ба цагаатгах тогтоол хүчинтэй болсоноос хойш 7 хоногийн дотор тогтооны агуулгыг хуульд заасны дагуу бүрэн эхээр, бичгээр үйлдэж ял шийтгүүлсэн буюу цагаатгасан этгээд, хохирогч, өмгөөлгч, прокурорт гардуулан өгөх (302.1), "Шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаанд оролцогчийг тэмдэглэлтэй танилцах бололцоогоор хангах үүрэгтэй" (314.3) байхаар заажаа. Энд хаалттай хуралдаанаар хэлэлцсэн төрийн нууцад хамаарах мэдээллийг холбогдох этгээдэд танилцуулах эсэх, шүүхийн шийдвэрт тусгасан тохиолдолд шүүхийн шийдвэрийг хүлээн авсан этгээд хэрхэн хадгалж хамгаалах зэрэг олон асуудал тодорхой бус, хууль зүйн шийдэл шаардлагатай юм. Хэрэв төрийн нууцад хамаарах мэдээллийг шүүхийн шийдвэрт тусгасан тохиолдолд тухайн яллагдагч, иргэн төрийн нууц баримт бичгийг задруулахгүй байх баталгаа байхгүй бөгөөд төрийн нууцыг хамгаалахад тавигдах бүх шаардлага зөрчигдхөхдөө хүрнэ. Ийм учраас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны аливаа шийдвэрт төрийн нууцад хамаарах мэдээллийг тусгахгүй байх шаардлагыг гадаадын зарим орны эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид шууд заасан байдаг.

Тухайлбал: Украинаы Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 517.2-т, "Байцаан шийтгэх ажиллагааны шийдвэр төрийн нууцад хамаарах мэдээллийг агуулсан байж болохгүй" гэж заасан нь Монгол Улсад зайлшгүй хуульчлах ёстой жишиг юм.

Монгол Улсад 2013 онд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль батлагдсантай холбоотойгоор Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд "Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээг хэрэглэх журам, арга хэмжээнд явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл"-ийг төрийн нууцад хамааруулсан. Харин Эрүүгийн байцаан шийтгэх хуульд энэ төрлийн нууцтай холбоотой тусгай журам тогтоогоогүй учраас хамгаалалтад авсан этгээдийг шүүх хуралдаанд биечлэн оролцуулах эсэх, хэрэв оролцох тохиолдолд нууцлалыг хэрхэн хангах, биечлэн оролцохгүй тохиолдолд мэдүүлэг хэрхэн авах, асуулт хариулт хэрхэн явуулах зэрэг олон асуудал үүсж үед хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна.

Дээр дурдсан бүхэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн төрийн нууцтай холбоотой зохицуулалт олон талаар хангалтгүй хуульчлагдсан, хийдлэлтэй, төрийн нууцыг хамгаалах шаардлагыг хангагүй, төрийн нууцын тухай болон эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомж хоорондоо харилцан уялдаагүй болсны илрэл гэж үзж байна. Ийм учраас төрийн эрх бүхий байгууллагуудаас үндэсний аюулгүй байдлыг хангах хэрэгцээ, шаардлага, гадаад орнуудын жишиг, өнөөгийн бодит практикийг харгалзан хөндсөн чиглэлийн хүрээнд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох хэм хэмжээг боловсронгуй болгох буюу шаардлагатай эрх зүйн зохицуулалтыг шинээр бий болгох арга хэмжээг нэн даруй авах нь хойшлуулшгүй шийдвэрлэх асуудал юм.

АВЛИГА АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ХОР ХӨНӨӨЛ, ӨНӨӨГИЙН ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ



АТГ-ын МШХ-ийн мөрдөн байцаагч, МУИС-ийн
Хууль зүйн сургуулийн магистрант
Ч.Жаргалбаатар

Энэхүү нийтлэлдээ авлигын хор хөнөөл, авлига үүссэн түүхэн цаг хугацаа, одоо цагт манай улсын эрх зүйн тогтолцоонд авлигатай тэмцэх эрх зүйн зохицуулалт дутагдлтай байгаа болон авлигас эрьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ажил олон улсын хүрсэн түвшин, хэрэгжүүлсэн туршлагаас хол хоцрогдсон байгааг дурдаа цаашид авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэхэд эрх зүйн зохицуулалтгыг боловсрон болгох тэр дундаа эрүүтийн хуулийг боловсронгуй болгохын ач холбогдолыг хөндөн бичихийг зорьлоо.

Авлига бол их, бага ямар ч улс гүрний хөгжил дэвшлийн саатуулагч, улс төр, эдийн засаг, хууль эрх зүй болон ардчилалд хор хохирол учруулдаг, улс үндэстний мөхөөдөг олон талын сорог үр дагавартай нийтмийн бодит үзүүлэл. Гэмт үйлдэлээ бусдад илчлэгдэн баригдахгүйн тулд маш нууц лалз аргаар хийвалдан үйлддэг, талууд харилсан сэтгэл ханамж авлаг, нэг талд нь эрх мэдэг бүхий эгзээд байдаг тул тухайн үйлдэл илрэхгүйгүр үл барам нийтмийн үндэс суурийн шурлуулж байдаг.

Нийтмийн шударга ёсны зарчим алхам тутамд зирчигддөгөөс иргэдийн төрийн хуулийг дээдлэн хүндэтгэж сахин

биелүүлэх сахилга хариуцлага бүх төвшинд сularч, төрд итгэх итгэл алдарт эх орноо, улс үндэстнээ, хүн хүнээ хайрлах нийжин сэтгэлээ гээж авлига байх ёстой хэвийн үзэгдэл мэт ойлголт ардчилсан төрийг мөхөөдөг гашуун сургамжийг түүхээс харж болно.

1990 онос өмнө “авлига” гэсэн ойлголт БНМАУ болон хуучин пост коммунист улсуудад байгаагүй мэтээр тайлбарлаж энэ төрлийн гэмт үйлдлийн судалгааг тогтвортой хийж явваагүйгээ өнөөдрийн хүндэх нэхцэл байдалд ороод байгааг өөрчлөх цаг хугацаа ирсэн. Үүний зэрэгцээ 21 дүгээр зуунд либерал ардчилал хөгжлийн чиг хандлага бий болоод байгаа өнөө үед тухайн засаглалыг угийг хийдэг, мөхөлд хөтөлдөг авлига их байгаа нь тухайн улс үндэстний хөгжил, дэвшилтэд хортой талаар дэлхийн олон орны судлаачид бичиж нотолж байгаа бөгөөд Монгол улсын хувьд олонхийн ардчилал хөгжжэй байна гэсэн дүгнэлтийг зарим эрдэмтэд хийсэн байдал¹.

Нэгдсэн үндэсний байгууллага, Европын холбоо гэх мэт олон улсыг энгээндээ нэгтгэсэн байгууллагууд авлигатай тэмцэх асуудлаар эрчимтэй ажиллаж нийтээр дагаж мөрдөх конвенц, эрхийн баримт бичгүүдийг боловсруулан гишүүн орнуудаа үндэстний хууль тогтоомждоо нийцүүлэх үүрэг хүлээлгэсний дагуу дан гац эрүүгийн хууль бус. Хөдөлмөрийн хууль, Иргэний хууль, Захиргааны хуульд авлигатай холбоотой нарийн зохицуулалт оруулах шаардлага тавьж, хууль тогтоомжийг дээрх гэрээ коневицил нийцүүлэх талаар зөвлөмж өгсөөр байгаа болонч тодийнлен үр лиял хүрэхгүй байна. Тухайлбал, монгол угаах гэмт хэргийн бүрэлдхүүнийг 2002

¹ Аренд Лиийхартын “Ардчиллын хэв загвар, гучин зурган орны төр засгийн хэлбэр ба ирэл” зохиолын Монголчуудад зориуласан зохиогчийн уг 5 хуудас

оноос хойш удаа З дахь удаагаа² өөрчлөн найруулж мөрдүүлээд байгаа бөгөөд хэргийн бүрэлдэхүүн өөрчлөн батлагдах бүрт тухайн хэргийг эцслэн шийдвэрлэж гэм буруутай этгээдэд хариушлага хүлээлгэх боломжгүй болдог нь иууц биш.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, европ, төв Азийн авлигын эсрэг сүлжээ. Олон улсын СТАР байгууллагын шинжээчид авлигын хэргийн үндсэн хэлбэрүүдийг гэмт хэрэгт тооцсон хуулийн үндсэн зүйл заалтууд Монгол улсын Эрүүгийн хуульд байдаг хэдий ч энэ нь олон улсын стандарттаас хоцорсон, хээл хахуулийн гэмт хэргийн зарим зайлшгүй чухал элементүүд, хувийн хэвшилийн авлигын гэмт хэрэг болон нөвлөлтийн хууль бус үйлдлүүд, түүчинлэн гадаад улсын албан тушаалтан хээл хахууль авах үйлдлийг гэмт хэрэгт тооцож хуульчлаагүй, "хээл хахууль" хэмээх тодорхой болтолтод монгол бус, эдийн бус давуу байдал, албан үүрээ хэрэгжүүлженийн төлөв авсан хээл хахуулийн зүйлийг гэмт хэргийн бүрэлдхүүнд хамруулаагүй байна.

Аслигын гэмт хэрэгт ногдуулах эрүүгийн ял шийтгэлийг үр нөлөөтэй, үйлдсэн хэрэгт нь тохирсон, дахин үйлзэхийнг таслан зогсоодог байх шаардлагыг хангахын тулд хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага үүссээр байна.

Гэмт хэрэг ба яланы асуудлыг эрэгцүүлэн судлахгүйгээр зөвхөн эрүүгийн хуулийн зохицуулалт үр дунгээ өгөхгүй. Хөрөнгө хураах тухай хуулийн зүйл заалтуудыг түүний дотор хөрүүлсэн зөхүү нийтийн хөрөнгө, хөрөнгөөс олсон ашигийг хураахтай холбоотой зүйл заалтуудыг дахин авч үзэх шаардлагатай байна.

Аслигын эсрэг эрчимтэй тэмцэхийн тулд төрийн удирдлагад авлигатай тэмцэх улс төрчдийн сонирхлыг нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчинчдүүдийг сайтар бэлтгэх, хуулийн гол зорилт авлигын эсрэг эрх зүйн актууд нь хоорондоо зөрчилгүй байх, хоорондоо уялдаа холбоотой

² Монгол улсын эрүүгийн хууль 2002 он, Эрүүгийн хуулийн 2681, 1661 дэх заалтууд

үйлчлэх ямар нэгэн хувь хүний ашиг сонирхол агуулаагүй байх нь хамгаас чухал.

"Төрийн эрх мэдэлтнүүдийн ёс суртахууны төрийн эрх мэдэлгүй хүмүүсээс илүү чанга байх шаардлагатай байх, төрийн албан хаагчийн үүрэг, хариушлага нь илүү ондераас тэр" гэсэн ишлэл нь Засгийн эрхэнд гарсан хүмүүсийн үзүүлж болох нэн магадлалт үйлдлийн үр дагавар ямар байхыг 1887 онд лорд Актоны "Аливаа засаглал завхруулдаг, хэмжээгүй засаглал хэмжээгүйгээр завхруулдаг, ... хalamжлагч нь дарангуйлагч болж хувирах аюул ямагт заналхийлж байдаг, хангалийтэй эрх мэдэл хүч чадалтай болж авсан хүн буюу бүлэг таны үзэл болдлыг үл тоомсорлож таныг уландаа гишгэчин өөрдийн зарчмыг хэрэгжүүлэх нь ойлгомжтой" гэсэн гэсэн онолтой дүйж байна.

Энэ төрлийн гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх. таслан зогсоох, нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлж, гэм буруутай этгээдэд эрүүгийн хариушлага хүлээлгэхэдээрүүгийн хуулийн заалт онцгой үүрэг гүйцэтгэх ёстой боловч хуулийн зохицуулалт, хуулийг хэрэгжүүлэгч нарын дур зоргоор хийх тайлбар, улс төрчдийн авлига албан тушаалын гэмт үйлдэлтэй тэмцэх сонирхол, хүсэлгүй байдлаас үүдэн амжилтад хүрэлзгүй жишиг олон улсын туршлагаас бэлээхэн харж болно.

Монгол улсад албан тушаалтан төрийн албан хаагчийг ажлаас үндэслэлгүй халдаг, шүүхээр тухайн марган цянагдаж, төрийн албан тушаалтны буруу болохыг тогтоож ажилгүй байсан хугацааны тэтгэмж олгож байгаа явдал их байна. Захиргааны хэргийн шүүх тухай маргааныг хэлэлцэх үед төрийн байгууллага емгөөлөгч авах, шүүхийн шийдвэр гарсны дараа ажилгүй байсан хугацааны цалинг нөхөн олгох заргаар их хэмжээний мөнгөн хөрөнгийг үргүй зарцуулсаар байхад буруутай этгээдээс гарсан зардлыг нөхөн төлүүлэх

³ Оросын Холбооны Улсын авлигын эсрэг хуулийн сийкруулах нь иортай илтгэдэг ОХУ-ын төрийн захиргааны академийн профессор Владимир Соколов онцлон тэмдэглэсэн.

⁴ Адмичиллын тухай Роберт Даль Copyright 1998. Зориг сангаас ADMON ХХК-д хэвлүүлсэн номмын 66 дугаар худас

түүнд хариушлага хүлээлгэсэн нэг ч тохиолдол бүртгэгдээгүй байна.

Иймд авлигатай тэмцэхэд хамгийн чухал хүчин зүйл нь авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зоригийг бий болгох, төлөвшүүлэх үр нөлөөтэй авлигын эсрэг чиглэсэн бодлогын баримт бичгүүдийг батлан гаргах. Эрүүтийн хуулийн теселд тусгагдаад байгаа авлига албан тушаалын гэмт хэргийн бүрэлдэхүүнийг теселд тусгагдсан байдлаар нь батлан мөрдүүлэх, албан тушаалтан, албан хаагч наарт олгосон халдашгүй дархан байдлыг хязгаарлах, хуулийг нэг мөр ойлгох, хэрэглэх, төрийн худалдан авалтыг шударга ил тод болгох нь хамгаас чухал болно.

“Хуульд захирагдалгүй эрх мэдэлдээ эрдсэн этгээдүүдийн дур зорго ихдэх авас гэмтэй бол зэмтэй байх гэсэн өртөнцийн гурван байхын үзэл санаа алдагдаж хамгийн ардчилсан нийгэм маань адгийн дарангуйлалт нийгмээс долоон дор⁵ болж болзошгүй бид мартах ёсгүй” гэсэн А.Хаекийн үгээр энэхүү нийтлэлээ төгсгөж байна.

⁵ Фридрих А.Хаек Босчлогдох замд 2008 он Монсудар ХХК-иас хэвлэсэн 3 дахь хэвлэл худас 48 (лонхийн засаглал нь ардчиллыг хамгийн адгийн дарангуйллаас долоон дор тэсвэрлэшгүй болгок болно гэдгийн мартах хэрэгтүй)

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА: ХБНГУ, БНСУ

*Хууль зүйн судалгааны төвийн
судалгааны тохиж тайлан*

УДИРТГАЛ

Аливаа улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь тухайн улсын эрх зүйн тогтолцооны суурин зарчим болон өөрийн орны эрх зүйн сөйл, уламжлал, онцлогт сууринлан бүрэлдэн тогтсон байдаг. Онолын хувьд дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцоо нь эрх зүйн бүл буюу аймгуудад хуваагдан хөгжиг ирсэн түүхтэй боловч даяаршиж буй өнөөгийн нийгэмд эрх зүйн аймгийн холимог шинжийг агуулсан хууль тогтоомжууд ихээр төрөн гарах боллоо.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх 2002 оны хууль нь зүйл заалтыг тодорхой, дэлгэрэнгүй зааж өгсөнөөрөө хэрэг бүртгэгч, мэдрэн байцаагч, прокурор, шүүгчийн ажлын удирдамж болж, түүнчлэн эрх зүйт териин зарчимд сууринлан оролцогчдын эрхийг хангасан тедийгийг эрүүгийн процессийн ажиллагааг богино хугацаанд хэрэгжүүлж байхаар заасан зэрэг ач холбогдолтой болсон ба үндсэн бүтэц нь эх газрын эрх зүйн тогтолцоотой Герман улсын хуультай адил юм.¹ Англи-Америкийн эрх зүйн тогтолцоотой улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь мэтгэлцэх зарчим дээр суурилдаг ба өөрөөр хэлбэл, талуд шүүхийн хэлэлцүүлгийн агуулгыг өөрсдөө тодорхойлдог мөн өмгөөлөх ба яллах талууд шүүхэд мэдүүлэх нотлох баримтаа өөрсдөө мэдэж шийдвэг буюу гаргадаг байна.² Монгол Улсын ЭБШХ-ийн дагуу шүүгч шүүх хуралдааны аль ч үед асуулт тавих эрхээр хангагсан байгаа нь мэтгэлцэх зарчмыг үүгүйсгэж үүгээрээ манай хууль

эх газрын эрх зүйн системийн онцлогийг мөн хадгалж байгаа юм.

Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь байцаан шийтгэх ажиллагаа явуулдаг мэдрэн байцаах шат, шуун таслах ажиллагаа явуулдаг шүүх шат ба энэ 2 шатны зааг прокурорын яллах дүгнэлт байдаг. Эдгэр шинж болон шүүх хуралдааны үе шат мөн л эх газрын эрх зүйн зарчимд суурилсан байна.

Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Монгол Улсын Эрүүгийн хууль. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, бусад хуулиудын шинчлэх ажил хийддэх буй энэ үед эрүүгийн процессийн хуулийн боловсронгуй болгох үүднээс эх газрын эрх зүйн тогтолцоо болон нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орны туршлагыг судлах үүднээс ХБНГУ, БНСУ-ын эрүүгийн процессийн хуулиудыг харьцуулан судалж онцлог шинжийг илрүүлэхээр зорьлоо.

Өөрөөр хэлбэл, энэхүү судалгааны ажлын зорилго нь Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн боловсронгуй болгох үүднээс ХБНГУ, БНСУ-ын эрүүгийн процессийн хууль, тэдгээрийн зохицуулалт, үе шат, онцлогийг харьцуулан судалж, гадаад орны эрх зүйн зохицуулалтаас жишиг болохуйц туршлагыг илрүүлэн дүгнэлт гаргах явдал юм.

Судалгаагаар дараах асуудлыг нарийвчлан судлах зорилт дэвшүүлсэн. Үүнд:

1. ХБНГУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн онцлог, үе шат;
 2. БНСУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн онцлог, ажиллагааны үе шат;
 3. ХБНГУ, БНСУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн харьцуулалт.
- Судалгааг шинжлэх ухааны арга зүйг баримтлан гүйцэтгэсэн бөгөөд энд дэвшүүлсэн санал, дүгнэлт нь

¹ Бернд Шюнемани, "2002 оны Му-ын ЭБШХ-д хийх шинжлэх ухааны тайлбар, УБ, 2003 он.

² Мен тэнд.

тухайн судалгаагаар тогтоогдсон ур дунд тулгуурлан бодитойгоор гаргаж, саналаа онолын үндэслэлтэй боловсруулах зарчимд тулгуурласан ба баримт бичгийн судалгааны арга, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх арга, харьцуулалтын аргудыг тус тус хэрэглэв.

Захиалагчийн хүснэгтээр эх газрын эрх зүйн болон нийтийн эрх зүйн төлөөлөл болгон ХБНГУ, БНСУ-ын эрүүгийн байцаан шийгэх хуулиудыг судалж, тэдгээрийн ажиллагааны үе шат, онцлог зохицуулалтыг шинжилж харьцуулсан дүгнэв.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН АЖИЛЛАГААНЫ ҮЕ ШАТ

1954 онд Бүгд Найрамдах Солонгос Улс (цаашид БНСУ гэх)-ын Үндэсний Ассамблей тус улсын анхны орчин үеийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (цаашид ЭХХШТХ гэх)-ийг баталсан бөгөөд одоогийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байна. Ингэхдээ хуульд 1961, 1963, 1973, 1980, 1987, 1994, 1995, 1997, 2002, 2004, 2005, 2006, 2007, 2009, 2011, 2012, 2013, 2014 онуудад нэмэлт, өөрчлөлт орсон байна.

ЭХХШТХ-ийн зохицуулалтын хүрээнд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гэмт хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллага, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн үндсэн 2 хэсэгт хуваан үзэж болохоор байна.

1.1. ГЭМТ ХЭРГИЙГ ЕРДИЙН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Гэмт хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг харилцан хамаарал бүхий шат дараалсан дараах 3 үе шатанд хуваан тайлбарлай.

Мөрден байцаах/шалгах үе шат.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний үе шат нь мөрден байцаах (*investigation*) үе шат юм.

Энэ үе шат нь гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдийг олж тогтоох, шаардлагатай албадлагын болон бусад арга хэмжээг авах, холбогдох нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, тодорхой төрлийн гэмт хэрэгт буруутгаж эрүүгийн процессын ажиллагааг цаашид үргэлжлүүлэх боломжтой эсэхийг тодорхойлох зэрэг мөрден байцаах байгууллагын хийвэл зохиж бүхий л ўйл ажиллагааг хамарна. Мөрден байцаах байгууллага гэдэгт эрүүгийн хэргийг мөрден шалгах үүрэг бүхий байгууллагыг ойлох бөгөөд мөрден байцаах эрх бүхий этгээд нь прокурор, шүүхийн цагдаагийн ажилтан байна. Мөрден байцаах үе шатыг Эрүүгийн хэргэ хянан шийдвэрлэх тухай хууль³(цаашид ЭХХШТХ гэх)-ийн 195-245 дугаар зүйлд зохицуулсан байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн гэх сэжиг бүхий тохиолдолд прокурор өөрөө болон түүний заавраар шүүхийн цагдаагийн ажилтан (үүнд шүүхийн ердийн болон тусгай цагдаагийн ажилтан хамаарна) гэмтэтгээд, гэмт хэргийн улмэр, баримт, нотлох баримтыг мөрден шалгаж эхэнэ.⁴ Гэмт хэрэг үйлдэгдсэн гэх сэжиг бүхий тохиолдолд гэдэгт прокурор, шүүхийн цагдаагийн ажилтан өөрөө олж илрүүлснээс гадна тэдгээрт ирүүлсэн голдом, мэдээллийг ойлгоно. Шүүхийн цагдаагийн ажилтны мөрден байцаах ажиллагаанд прокурор хяналт тавина. Энэ талаар хуульд зааснаар дүүргийн прокурорын газрын дарга эзвэл дүүргийн прокурорын газрын салбар нэгжийн дарга мөрден байцаалтын ажиллагаанд хууль бусаар баривчлах, цагдан хорих асуудал гарч байгаа эсэхийг шалгах зорилгоор өөрийн харьяалах прокуророор дамжуулан тухайн мөрден байцаах байгууллагаас сэжигтэн баривчилсан, цагдан хорьсон газрыг сард нэг болон түүнээс дээш удаа шалгуулна. Шалгалт хийж байгаа прокурор нь баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдтэй уулзаж асуулт асуух, холбогдох бичиг баримтыг

³ Энэхүү судалгааг хийжээд БНСУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулийн албан бус Монгол орчуултыг ашиглалын зорилгоо олонгомжийг бруулагдсан хэсгийн Англи эхтэй тулган ойлгох карагдлын болно.

⁴ ЭХХШТХ-ийн 196 дугаар зүйл

хянах хэлбэрээр шалгалтыг явуулна.⁵ Шалгалтын явцад тухайн этгээдийг хууль бусаар хорьсон, баривчилсан гэж үзүүс сэжиг бүхий бодит шалтгаан байгаа тохиолдолд уг этгээдийг нэн даруй суллах эсхүл хэргийг прокурорт шилжүүлэхийг үүрэг болгоно.⁶ Мөрдөн байцаалт явуулах эрх бүхий бусад этгээд нь сэжигтэн болон зуугийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх ашиг нь хөндөгдж байгаа аливаа этгээдийн хүн ёсны эрхийг хундэтгэж, мөрдөн байцаалтын явцад олж мэдсэн хувийн нууцыг хадгалж, мөрдөн байцаалтын ажиллагаанд ямар нэгэн байдлаар саад учруулахгүй.⁷

1.2. ГЭМТ ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

БНСУ-ын эрүүгийн процессын эрх зүйгээр гэмт хэргийн хөнгөн, хүндээс хамааран ялгаатай эрх зүйн процессыг дамжих боломжийг олгожээ. Тодруулбал 200, 000 воноос бага торгууль оногдуулах гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд эрүүгийн процессын бүхий л ўе шатыг дамжих шаардлагагүй бөгөөд шүүх хуралдаан хийхгүйгээр гэм буруутай этгээдэд ял оногдуулдаг байна. БНСУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоонд ийм процессын 2 төрөл байдаг. Эдгээр нь хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай шүүхийн шийдвэр ба хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай шүүхийн захирамж юм.

1. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай шүүхийн шийдвэр. Энэ асуудлыг Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн шийдвэр гаргах хуралдааны тухай хууль (Act on the

Proceedings for Summary Judgments)⁸-аар тусгайлан зохицуулдаг байна. Харьяалах цагдаагийн хэсгийн дарга 200, 000 воноос бага хэмжээний мөнгөн дүнгээр тorgох эсхүл ял хойшлуулах боломжтой гэмт хэргийг ийнхүү шийдвэрлэх талаар хүсэлт гаргана.⁹ Энэ тохиолдолд эрх бүхий шүүг шүүх хуралдаан хийхгүйгээр хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх тухай шийдвэр гаргаж, зохих шийтгэлийг оногдуулна. Хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх тухай хуралдааны танхимд назлтэй явагдах бөгөөд шүүх хуралдааны танхим хүсэлт гаргасан цагдаагийн хэсэг байрладагаас өөр газар байрлах ёстай.¹⁰

2. Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн захирамж. Энэ талаар ЭХХШТХ-ийн 448-458 дугаар зүйл заасан. Хавтаст хэргийг шүүхэд хүлээлгэн өгсөн прокурор энэ талаар дүүргийн шүүхэд хүсэлт гаргана. Шүүх прокурорын хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд хэргийг ердийн журмаар шийдвэрлэхгүйгээр(шүүх хуралдаан хийхгүйгээр) тorgох эсхүл эд хөрөнгө хураах арга хэмжээ авах талаар хялбаршуулсан журмаар хэлэлцэж болно.¹¹ Шүүх хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь зүйтэй гэж узвэл энэ талаар прокурор болон яллагдагчид бичгээр мэдэгдэх¹² ба энэ тухай захирамжийг хүлээн авсаас хойш 7 хоногийн дотор хэргийг ердийн журмаар шийдвэрлүүлэх тухай хүсэлтээ бичгээр гаргаж болох талаар

⁵ Тус хуулийн энэ 1957 онд баталсан бөгөөд хамгийн сүүлд 2009 оны 12 дугаар сарын 29-ний өдөр 9831 тоот хуулиар нэмэлт,өөрчлөлт оруулжээ. Тус хуулийн антиг орчуулгыг БНСУ-ын Засгийн газрын харьяа Солонгосын Хууль тогтолцоожин хурээлэн (Korea Legislation Research Institute, abbreviated as KLRI)-ийн албан ёсны цахим хягь руу 2015 оны 03 дугаар сарын 27-ний өдөр нэвтрэх үзэв. Англи орчуулгыг http://elaw.kln.re.kr/eng_mobile/viewer.do?seq=18120&type=part&key=9 холбоосоор нэвтрэх үзэв.

⁶ Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн шийдвэр гаргах хуралдааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дахь хэсэг

⁷ Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн шийдвэр гаргах хуралдааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дахь хэсэг

⁸ ЭХХШТХ-ийн 448 дугаар зүйл

⁹ ЭХХШТХ-ийн 452 дугаар зүйл

¹⁰ ЭХХШТХ-ийн 198-2 дугаар зүйлийн 1 дахь хэсэг

¹¹ ЭХХШТХ-ийн 198-2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

¹² ЭХХШТХ-ийн 198 дугаар зүйлийн 2 дахь хэсэг

захирамжид заасан байна.¹³

1.3. ЯЛЛАХ ҮЕ ШАТ

Мөрдөн байцаах ажиллагааны үр дүнд үндэслэн прокурор нь хэргийг хэрэгсэхгүй болгох эсхүл ялын төлөвлөгөө үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлэх эрхтэй. Үүнийг прокурор ёөрийн дотоод итгэл үнэмшилээр шийднэ. Энэ байдлыг зарим судлаач "прокурорын ялын төлөвлөгөө үйлдэх монополь байдлын зарчим" хэмээн үзсэн байна.¹⁴

Прокурор нь сэжигтэн этгээд гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл байгаа гэж үзвэл ялын төлөвлөгөө үйлдэнэ. Ялын төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгана. Үнд:

- а) Яллагдагчийн нэр болон түүний таних бусад мэдээлэл;
- б) Эрүүгийн хэргийн нэр;
- с) Тухайн гэмт хэрэгт буруутгаж байгаа үндэслэл, үйл баримт (хэрэг үйлдэгдсэн огноо, цаг хугацаа, орон байр болон үйлдсэн арга зэргийг дэлгэрэнгүй тодорхой тусгана); Хуулийн хэрэглэгдэх зүйл, заалт.¹⁵

2 буюу түүнээс дээш үндсэн ялаас нэг ял оногдуулах эсхүл 2 буюу түүнээс дээш ялыг хамтад нь оногдуулах гэмт хэргийн хувьд хөнгөн ялыг хамгийн хүнд ялд баатаах замаар эдлэх ялыг тогтооноо.¹⁶

Хөнөн хэлэлцэх хугацааны тухайд цаазаар авах ял шийтгэх гэмт хэрэгт 25 жил; бүх насаар нь хорих эсхүл насаар нь хөдөлмөр эрхлүүлэхгүй хорих ял шийтгэх гэмт хэрэгт 15 жил; хорих эсхүл дээд тал нь 10-аас доошгүй жил хөдөлмөр эрхлүүлэхгүйзэр хорих ял оногдуулах гэмт хэрэгт 7 жил; хорих эсхүл 5-аас доошгүй жил хөдөлмөр эрхлүүлэхгүйзэр хорих ял оногдуулах эсхүл 10-аас доошгүй жил мэргэшлээрээз ажиллах эрхийг түдгэлзүүлэх, торгох гэмт хэрэгт 5 жил; 5-аас доошгүй жил мэргэшлээсээз ажиллах эрхийг түдгэлзүүлэх ял оноох гэмт хэрэгт 3 жил; 5 жил мэргэшлээрээз

ажиллах эрхийг түдгэлзүүлэх эсхүл сахилгын байранд хорих, бага хэмжээгээр торгох, эд хөрөнгө хураан авах гэмт хэрэгт 1 жил байна.¹⁷

Прокурор бичгээр үйлдсэн яллах төлөвлөгөөг шүүхэд хүргүүлснээр тухайн хэрэг шүүхэд шилжин.

1.4. ШҮҮХИЙН ШАТ

Шүүхэд хэргийг хэлэлцэх асуудал, иргэдийн төлөөлөгч шүүхийн шийдвэр гаргах үйл явцад оролцох нь

БНСУ-ын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг онцлог нь шүүх хуралдаанаас эмне урьдчилсан сонсгол хуралдаан (preparatory hearing) хийдэг явдал юм. Өөрөөр хэлбэл шүүхээс хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь

- Бэлтгэл /урьдчилсан/ хуралдаан,
- Шийдвэрлэх хуралдаан (шүүх хуралдаан) гэсэн 2 үе шатыг дамжина гэж ойлгох болох юм.

Мөн тангарагтны шүүхийн тогтолцоотой төстэй иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд, бүр шүүхийн шийдвэр гаргах процесст оролцох асуудал эрүүгийн процессын хууль тогтоомжид тусгалаа олсон байна. Эдгээр нь эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улсын эрүүгийн процесст нийтлэг /Англи-Америкийн/ эрх зүйн тогтолцооны элементийн шилжүүлэн авсан нэг сонирхолтой тохиолдот байж болох юм.

1.5. ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ: ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОХ НЬ

2008 онд батлагдсан Эрүүгийн шүүх хуралдаан дахь Иргэний оролцооны тухай хууль (국민참여재판장법 제2조 / Act on Citizen Participation in Criminal Trials)-д "Иргэний оролцоо бүхий шүүх хуралдаан" хэмээх нэр томъёо хэрэглэсэн бөгөөд үнд "Иргэн хүн шүүн таслах эрхтэйгээр (шүүгчийн хувиар) эрүүгийн шүүх хуралдаанд оролцож байгаа байдлыг ойлгоно" хэмээн заасан байна. Тангарагтны шүүх хуралданы мөн чанар нь ийнхүү

¹³ ЭХХШТХ-ийн 451 дүгээрэйн

¹⁴ Kim Young-Chul, *The Effective System of Criminal Investigation and Prosecution in Korea*, 120th International Senior Seminar Visiting Experts' Papers, p.85

¹⁵ ЭХХШТХ-ийн 254 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг

¹⁶ ЭХХШТХ-ийн 250 дугаар зүйл

¹⁷ ЭХХШТХ-ийн 249 дүгээр зүйлийн 1 дахь хэсэг

¹⁸ 국민참여재판장법 제2조

хуульч мэргжилтэй биш боловч хараат бүс, хөндлөнгийн иргэн хүн шүүн таслах эрхтэйгээр оролцох явдал байдаг учраас БНСУ-ын энэ хуулийн зохицуулалтыг Америкийн *jury trial system* буюу тангардтын шүүн таслах тогтолцоотой харьцуулах боломжтой юм.

Гэхдээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тангардтын шүүхийн тогтолцоог тодорхой тооны гэмт хэрэгт боломжтой байхаар хязгаарлагдмал түвшинд нэвтрүүлсэн байна.

Эрүүгийн шүүх хуралдаан дахь Иргэний оролцооны тухай хуулиар хүн алах, хүндүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хүн алах, болгоомжгүйгээр хүн алах, ноцтойгоор хүний биед гэмтэл учруулах, зодох болон хүчиндэх зэрэг хүчирхийллийн гэмт хэрэгт тангардтын шүүхийн тогтолцоог хуульчилжээ.¹⁹

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

ХБНГУ-ЫН ЭРҮҮГИЙН

ПРОЦЕССИЙН ОНЦЛОГ, ҮЕ ШАТ

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт нь аливаа гэмт хэргийг шудрагаар хянан шийдвэрлэж, эрх зүйт төрийн уйл ажиллагааг хангаж, хууль эрх зүйн хүрээнд эрх зүйн таатай орчинь бурддүүлж улмаар эрх зүйн баталгааг олгоход чиглэдэг. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад (цаашид Герман улс гэх) хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх журам²⁰ (ЭБШЖ) нь 8 бүлэг, 495 эрх зүйн зохицуулалтаас бүрддэг.

Энэ журмын анхны хувилбар 1877 оны хоёрдугаар сарын нэгэнд гарсан. Эрүүгийн байцаан шийтгэх журмын 1-р бүлэгт Эрүүгийн процессиийн арга хэмжээний талаар жишээ нь жолооны үнэмлэх хураах, жолоо барих эрх хасах, нэгжлэг хийх, баривчлах уйл ажиллагаа явуулах, эд зүйлс хураан авах талаар

мен Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны сэжигтэн болоод гэрчийн эрх үүргийн талаар, 2-р бүлэгт Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үйл явц, хэргийг хэрэгсэхгүй болгох талаар, 3-р бүлэгт хэрэг давж заалдах болон хянан шийдвэрлэх ажиллагааг, 4-р бүлэгт Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хэргийг ахин сэргээх тухай, 5-р бүлэгт Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хохирогийн эрх, эрх мэдлийн талаар, 6-р бүлэгт Эрүүгийн ял оногдуулах ажиллагааны талаар, 7-р бүлэгт Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардлын талаар, 8-р бүлэгт талууд хэргийн материалтай танилцах энэ талаар мэдээлэл авах асуудлын тухай тус тус зохицуулсан байна. Герман улсад гэмт хэргийг онцгой ба энгийн журмаар хянан шийдвэрлэдэг тухай авч судалсан ба энэ судалгааны хүрээнд хамгийн өргөн хэргэлзгэдэг онцгой журмаар хэрэг шүүн таслах талаар судлан харуулсан. Хэрэг байцаан шийтгэх ажиллагааны нэгчухал зүйл бол шүүхийн харьяаллыг зөв тодорхойлох багтдаг. Тиймээс тухайн хэргийг нутаг дэвсгэрийн болон хэрэг шалгах шүүхийн харьяаллаар яаж тогтоодог тухай харуулсан. Мен эрүүгийн хэрэг энгийн журмаар ямар дэс дарааллаар хянан шийдвэрлэгдэж дуусдаг тухай нарийвчлан судалсан.

2.1. ЭРҮҮГИЙН ГЭМТ ХЭРГИЙГ ОНЦГОЙ ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

2.2. Эрүүгийн гэмт хэргийг онцгой баэнгийн журмаар хянан шийдвэрлэдэг. Эрүүгийн гэмт хэргийг онцгой журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх²¹, гэмт хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлэх²², хувь хүн бие дааж шүүхэд яллах бичиг өргөх²³, хохирочг эрүүгийн гэмт хэргийн шүүн таслах ажиллагаанд яллагчаар оролцох²⁴ гэсэн онцгой хэлбэрүүд багтдаг.

2.2.1. Гэмт хялбаршуулсан журмаар хэргийг хянан

²¹ ЭБШЖ-ын 407-ын дагалдах заалтууд.

²² ЭБШЖ-ын 417-ын дагалдах заалтууд.

²³ ЭБШЖ-ын 474-ын дагалдах заалтууд.

²⁴ ЭБШЖ-ын 495-ын дагалдах заалтууд.

¹⁸ 국민참여재판법 제5조

²⁰ Герман улсад Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг эрүүгийн байцаан шийтгэх журмаар зохицуулсан байдал. Энэхүү судалгааг хийждэг Герман улсын ЭБШЖ-ыг Герман хэл дээр доорх линкээр уншиж Монгол хэл дээр хөөрүүлэн орчуулсан болно. <http://www.gesetze-im-internet.de/stpo/> сүүлд нэвтрэсэн 2015.04.08.

шийвэрлэх ажиллагаа

Герман улсад эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэдэг үйл ажиллагаа байдаг. Үгээр хөнгөн гэмт хэргийг шүүх ажиллагааны явцыг хөнгөвчлөх зорилготой ба үүний эрүүгийн шийтгэл оногдуулах тухай захирамж гаргаснаар шийдвэрлэдэг. Энэажиллагааны онцгой хэлбэр нь хүчин төглөдөр үйлчлэх ял, шийтгэлийг шүүх хуралдаан хийхгүйгээр гэм буруутай этгээдэд ял оногдуулдаг оршино. Прокурор тухайн хаваст хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэгдэх хүсэлтийг харьяллын шүүхэд гаргадаг. Энэ хүсэлтийн дагуу шүүг зохих захирамжийг гаргах үүгийг шийдвэрлэнэ.

Хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь шүүхийн хэрэг хянан шалгах ажиллагаа болон Прокурорын хэрэг байцаан шалгах ажиллагааг хөнгөвчилхээс гадна энэ ажиллагааны давуу талууд сэжигтний ашиг сонирхолд нийцэг. Учир нь сэжигтэн энэ ажиллагаагаар шүүхийн процессийн хөлс хэмнэж, тухайн хэрэг энгийн шүүх ажиллагаанаас илүү хурдан хугацаанд шийдвэрлэх, өөр ямар нэгэн хүндэрэл бэрхшээлгүй явагддаг.

2.2.2. Гэмт хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлэх

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг тодорхой нөхцөл дор хурдасгах болно. Энэ хурдавчлах ажиллагаа явуулах хүсэлтийг Прокурорын газар тухайн хэргийг хянан шийдвэрлэх харьяллын шүүхэд гаргадаг. Гэмт хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлэхэд тухайн хэрэг маш энгийн, нотлох баримт тогтоогдсон шууд шүүх ажиллагааг эхлүүлэхэд бэлэн мөн хэрэг шийдвэрлэх шүүх нь дүүргийн анхан шатны шүүх байх гэсэн нехцилийг хангаж ёстай. Дээрх нехцилийг хангаж байвал Прокурор хаваст хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлэх хүсэлтийг шалгах үзээж хүлээж авах шийдвэр гаргаснаар үйл ажиллагааг эхлүүлнэ.²⁵ Гэмт хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлэх нь энгийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхээс

дараах байдаа ялгардаг.

Гэмт хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлэхэд тухайн гэмт хэрэг саяхан болж өнгөрсөн байх ёстай.

Хурдавчилсан ажиллагаанд хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг нээх тухай бэлтгэл ажилыг хийхгүй. Прокурорын газраас яллах дүгнэлтийг бичгээр гаргахын оронд амаар шүүх хуралдаан дээр илтгэх болно.

Шүүх хурал Прокурорын газраас хаваст хэргийг хурдавчилсан журмаар шийдвэрлэх хүсэлтийг гаргасны зургаан долоон хоногийн дотор болдог²⁶.

Хурдавчилсан ажиллагаагаар шүүх, ял шийтгэл оноохдоо нэг жилээс илүү хорих ял оноож болохгүй²⁷. Хэрэв шүүгдэгээд хагас жилээс доoshgүй хорих ял оногдуулах бол шүүх тус хэргийг заавал шүүгдэгчийн хуулийн дагуу өмгөөлөгчтэй²⁸ шүүх ёстай.

Мөн хурдавчилсан ажиллагаанд нотлох баримт авах ажиллагаа хялбарчлагдсан байдаг.

Хэрэв шүүх шүүгдэгчийг тухайн хэрэгт гэм буруутай болох эсэхэд эзгэлзээтэй гэх үзвэл эсвэл уг хаваст хэрэг хянан шийдвэрлэхэд хурдасгах ажиллагаа зохимжгүй гэх үзвэл тус хэргийг энгийн хэрэг хянан шийдвэрлэх замаар шийдвэрлэнэ²⁹.

2.2.3. Хувь хүн бие дааж шүүхэд яллах бичиг өргөх

Зарчмын хувьд прокурор хэрэг мөрдөн байцаах ажиллагааг явуулж, яллах тухай бичгийг шүүхэд хүргүүлдэг. Гэвч энэ зарчмын онцгой хэлбэрт хувь хүн бие дааж шүүхэд яллах бичиг өргөх ажиллагааг ордог. Прокурор хэргийг мөрдөн байцааж, уг хэрэгт яллах дүгнэлтийг шүүхэд гаргаж байгаа ажиллагаа нь олон нийтийн ашиг сонирхолыг хангах үүднээс хийгддэг. Харин хувь хүн бие дааж яллах бичгийг шүүхэд хүргүүлэх ажиллагаанд зөвхөн тухайн бичиг гаргагчийн буюу хувь хүний

²⁵ ЭБШЖ-ын 418-р зүйл.

²⁶ ЭБШЖ-ын 419-р зүйл.

²⁷ Pflichtverteidiger гэдгийг хуулиин дагуу өмгөөлэгчээгээ оруулсан Хуулиин дагуу өмгөөлөгчийн шүүхийн зохицлагар, Прокурорын газэр эсээн сэжигтний хүсэлтийг ЭБШЖ-ын 140-р зүйлийн нөхцлийг хангаж байгаа тохиолдолд авдаг.

²⁸ ЭБШЖ-ын 201, 203-р зүйл

ашиг сонирхол илүү хамгаалагдсан байдаг. Хэрэв прокурор ямарваа нэгэн хэргийг нягталж үзсэний эцэст тухайн хэрэг олон нийтийн ашиг сонирхолын бус харин хувь хүний ашиг сонирхолын хүрээнд шийдвэгдэх хэрэгтэй гэж узвэл уг хэргийг мөрдөн байцааж, яллах дүгнэлт хийх үүргээс чөлөөлгөддөг. Ингэснээр хувь хүн прокурорын оронд яллах бичгийг шүүхэд хүргэх боломжтой болдог.

2.2.4. Хохирогч эрүүгийн гэмт хэргийн шүүн таслах ажиллагаанд яллагаар оролцох

Хохирогч эрүүгийн гэмт хэргийн шүүн таслах ажиллагаанд оролцох гэдгийг тус этгээд прокурорын яллах ажиллагаанд тодорхой хэмжээнд яллагаар оролцохыг хэлдэг. ЭБШЖ-ын 395-р зүйлд хохирогч эрүүгийн ямар гэмт хэргийн шүүн таслах ажиллагаанд Прокурортой хамтран яллагаар оролцож болдгийг зохицуулсан. Үүнд ихэвчлэн эрүүгийн хүнд, ноцтой хэрэг ордог жишиээ нь насандаа хүрээгүй хүүхдийг садар самуунд уруу татах, хүчингийн гэмт хэрэг, онц ноцтойгоор амь насандаа хүрхийг завдах, хүний биец санаатайгаар онц ноцтой гэмтэл учруулах, хүн барьцаалах гэх зэрэг хэрэг багтдаг. Хэрэв хохирогч өөрөө тухайн гэмт хэргийн улмаас амь наасаа алдсан бол түүний оронд ар гэрийнхэн нь Прокурортой хамт яллагаар хэрэг шүүн таслах ажиллагаанд орж болно. Тиймээс энэ ажиллагааны зорилт нь хохирогчийн эрхийг сайжруулахад оршдог. Хохирогч Прокурортой адил өөрийн гэсэн шүүх ажиллагааны дагуу эрх эдэлдэг бөгөөд энэ нь ЭБШЖ-ын 397- 401-т тусгагдсан. Хохирогч шүүх ажиллагаанд яллагаар оролцож байгаагийн давуу эрхэнд хавтаст хэрэгтэй танилцах, шүүн таслах ажиллагаанд оролцох, нотлох баримт авах хүсэлт гаргах, гэрч болон шүүгдэгчээс асуулт асуух зэрэг багтдаг. Түүнчлэн шүүх ажиллагааны тэгсөлд өөрийн зүгээс саналаа илэрхийлж үүгээрээ ял, шийтгэлийн хэмжээнд нелөө үзүүлэх эрхтэй. Өөрийгөө хамгаалуулах зорилгоор хохирогч өөрөө шүүхийн өмнө мэдүүлэгт өгөхдөө нийтээс болон шүүгдэгчээс дайдгээц болно.

боловсно. Мөн эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад тухайн хэргээс үүссэн хохирлыг иргэний байцаан шийтгэх ажиллагаагаар шийдвүүлэх бус энэ болж буй ажиллагааны дагуу хохирлоо нөхөн төлүүлэх нэхэмжлэл гаргаж болно. Үүнийг харилцан үйлчлэх ажиллагаагаар гэж нэрлэдэг^{*}.

2.3. ЭРҮҮГИИН ХЭРГИЙГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Эрүүгийн хэрг хянан шийдвэрлэх ажиллагааг дөрвөн үе шат дамжин хянан шийдвэрлэдэг. Үүнд мөрдөн байцаах үе шат, шүүх хуралдаанд бэлдэх үе шат, шүүх хуралдааны үе шат, шүүхийн шийдвэрийг давж заалдах үе шат багтдаг.

2.3.1. Мөрдөн байцаах үе шат

Зарчим ёсоор зөвхөн Прокурорын байгууллага яллах ба ялын саналыг тухайн хэргэг хянан шийдвэрлэх харьяаллын шүүхэд тавих эрхтэй. Тиймээс юуны өмнө шүүхийн үйл ажиллагаагаар эхлүүлэхийн өмнө тухайн хэргийг байцаан шийтгэх шүүхийн харьяалалыг тогтоох нь чухал. Учир нь бүх хэргэг эхлээд анхан шатны шүүхээр дамждагтуй ба хэрэг шууд 2-р шатны шүүх буюу Давж заалдах шатны шүүхээр анх шийдвэгдэх боломжтой гэсэн үг. Мөн хэрг шууд 3-р шатны шүүхээр анх шийдвэгдэх тохиолдол ч мөн бас бий.

Нутаг дэвсгэрийн харьяалал

Хэргийг аль нутаг дэвсгэрт шүүх тухайн шийдвэрдээс уг хэрг гарсан газар, сэжигтний амьдарч байгаа газар эсвэл сэжигтний баригдсан газар эсвэл усан онгоцанд тухайн хэрг гарсан бол тэр усан онгоцын боомт байрлаж байгаа газрыг тус тус харгалзан үзэж тухайн хэрг хянан шийдвэрлэх шүүхийн нутаг дэвсгэрийн харьяалалыг тогтоодог.

Хэрэг шалгах шүүхийн харьяалал

Хэргэг аль шатны шүүхэд анх шийдвэгдэх тухай Прокурор шийдвэрлэдэг. Прокурор уг хавтаст хэргэг хэнгэн, хунд, хүндэзвтэр, онц ноцтой хэргийн аль аngilalд хамаархыг нягталсаны дараа тухайн хэргэг харьяалагдах шатны шүүхэд шилжүүлнэ. Тус шийдвэгдэх хэргэг анхан шатны дүүргийн шүүхэд, дараагийн

* Adhdsionsverfahren.

шатны хотын шүүхэд эсвэл дээд шатны хотын шүүхэд шийдвэрлэх эсэх нь тухайн хэргийн хөнгөн, хүнд, хүндэвтэр, онц ноцтой эсэхээс шалтгаалдаг. Аanhан шатны дүүргийн шүүхийн шүүгч 2 жил хүртэлх ялын хэмжээтэй хэргийг шийдвэрлэх эрхтэй, хэрэв бүрэлдхүүнээрээ шийдвэрлэх 4 хүртэлх жилийн ялыг оногдуулдаг.

4 жилээс илүү ялын хэмжээтэй хэргийг анх шийдвэрлэх шүүх нь хотын шүүх байдаг. Тус хотын шүүх нь хэрэв аanhан шатны дүүргийн шүүх анх түүнд оногдсон хэргийн талаар шийдвэрлэсэн бол түүний дараагийн шатны шүүх буюу давж заалдах шатны шүүх болдог.

Харин онцгой хүнд хэргийг шийдвэрлэх анhan шатны шүүх нь дээд шатны хотын шүүх байдаг. Тиймээс хэрэг анх ямар шатанд хэрэг хянан шийдвэрлэгдэхээс хамаараад давж заалдах шатны шүүх бас ондоо байдаг.

Мэrden байцаалт эхлэх

Энэ үе шатанд мэrden байцаах ажиллагааны гол цөм буюу гол үүргийг Прокурорын газар гүйцэтгэж³¹ хувь хүний эсвэл албан байгууллагын гомдолоор эсвэл өөр арга замаар гэмт хэрэг гарсан талаар мэдээлэл авсан даруйдаа тухайн гэмт хэргийг нээн илрүүлэх ажиллагааг гардан авч явуулна³². Хэрэг гарсан гэх мэдэгдлийн мен хэвлэл мэдээллийн туслаамжтайгаар мэдэж болно.

Мэrden байцаах ажиллагааг зөвхөн Прокурорын газрын хийх ажил гэлтгүй бусад хэрэг мөрдэх эрх бүхий байгууллага буюу цагдаагийн байгууллага үүнд оролцод. Мэrden байцаах ажиллагааг явуулж байгаа байгууллага тухайн хэрэгтэй болон сэжигтэнтэй холбоотой зерэг, серег бүх бодит үзүүлж байдлыг нээн илрүүлж ажиллах эрх, үүрэгтэй. Хувь хүн эрүүгийн хэргийг гомдолоор буюу өргөдөөр үүсгэж болно³³. Хэн нэгэн ямарваа нэгэн хэргийг гарсан даруйд нь тухайн холбогдох байгууллагт гомдол мэдүүлэх үүрэг хүлээдэгүй

ч Эрүүгийн хуулийн 138.1-д тусгасан гэмт хэргийн аль нэг үйлдэгдэснийг мэдвэл холбогдох байгууллагад заавал мэдээлэх үүрэгтэй.

Эрүүгийн хэрг үүсгэх өргөдөл нь хоёр чиг үүрэгтэй. Нэг талаараа өргөдөл гарснаар Прокурорын газар тухайн хэргийг мэrden байцааж, нээн илрүүлэх ажиллагааг хийх ёстой бодлог бол негее талаараа тус өргөдөл гаргаж байгаа этгээдийн өргөдөл гаргасны дагуу мэrdөгддөг эрүүгийн хэргийн нехцилийг хангах байгаа юм. Герман улсад зөвхөн хохирогч өргөдөл гаргасны дагуу уг хэргийг мэrden байцааж улмаар үүсгэдэг хэд хэдэн гэмт хэрг байдаг. Эдгээр гэмт хэргүүд Эрүүгийн хуулинд тодорхой тусгагдсан байдаг бөгөөд тухайн эрүүгийн заалтад энэ хэргийг хохирогч өргөдөл гаргасанаар үүсгэнэ гэж нарийвчлан тусгасан байдаг. Хүнд жишээлблэг Эрүүгийн хуулийн дагуу гэрт зөвшөөрөлгүй нэвтрэн орох³⁴ гэсэн заалт өрдог. Иймээс өргөдлийн дагуу үүсдэг эрүүгийн хэргийг тус хэргийн хохирогч тухайн хэргийг үүсгэх үгүйгээ зөвхөн өвөр шийддэг.

Мэrden байцаалт явуулах

Мэrden байцаалт явуулах ажиллагааг нь юуны өмнө эд мэрийн баримтыг олж тогтооход чиглэсэн байдаг. Эд мэрийн баримтыг олж тогтооход хамгийн түрүүнд гэрч болон хохирогчийг байцаах, хэргийн газар дээрх эд мэрийн баримтыг баталгаажуулах мөн бусад нотлох баримтыг тогтоох шаардлагатай. Мэrden байцаалтын үед тухайн мэrden байцаах ажиллагааг гардан явуулж байгаа Прокурор өөрөө гүйцэтгэх³⁵ эсвэл бусад мэrden байцаалтын ажиллагааг гүйцэтгэдэг ажилтанд энэ талаар үүрэг даалгавар болгох болох ба энэ нь нэн ялангуяа цагдаагийн ажилтан юм³⁶.

Мөн мэrden байцаалтыг авах арга хэмжээнд Прокурорын газар тухайн хэрэгт холбоотой этгээдүүдийг

³¹ ЭХ-ийн 123 2-р зүйл.

³² ЭБШЖ-ийн 161-р зүйл.

³³ Шүүчин үйл ажиллагааны тухай хууль 152-р зүйл Дараа ШУАХ таң ишилэн. Энэхүү судалгааг хийжд Герман улсын ШУАХ-ийн Герман хал дээр доорх никисэр уншиг Монгол хал дээр хөврүүлэн оруулсан болно. <http://www.gesetze-im-internet.de/gvng/>

³⁴ Прокурорын гүйцэтгэдэг ажлыг ЭБШЖ-ийн 152.1. 2. 160 1.2. 163 гэсэн заалтуудаар илүү нарийвчлан зөхицуулсан.

³⁵ ЭБШЖ-ийн 160 1.-р зүйл.

³⁶ ЭБШЖ-ийн 158 1. 2-р зүйл.

байцааж мөн шаардлагатай бол албадлагын болон бусад арга хэмжээг авч болдог. Албадлагын болон бусад арга хэмжээнд³⁷ нэгжлэх хийх, нууц ажиллагааг явуулах жишээ нь харилцаа холбооны талаарх бух тоног төхөөрөмжийг хянах³⁸ зсвэл сэжигтийн цус авах³⁹ гэх зэрэг арга хэмжээнүүд багтдаг. Хэрэг илрүүлэхийн тулд зсвэл байцаан шийтгэх ажиллагааг хэвийн явуулахын тулд сэжигтийн байцаан шийтгэх албадлагын арга хэмжээ авдаг. Заримдаа тус шалгагдаж буй хэрэгтэй хамаагүй хүмүүс албадлагын арга хэмжээнд хамрагдах тохиолдол гардаг. Хэрэг илрүүлэхийн тулд авдаг арга хэмжээнд сэжигтийн⁴⁰ мөн гуравдаг этгээдэд⁴¹ нэгжлэг хийх, эд зүйлс хураан авах⁴², утас чагнах болон бусад холбоо барих хэрэгслүүрийг хянах⁴³, тагнуулын ажиллагаа явуулах⁴⁴, оршин суугаа байр, орон сууцыг хянах⁴⁵, биед нарийн нэгжлэг хийх⁴⁶, мөн ДНХ-ийн шинжилгээ⁴⁷ хийх гэсэн арга хэмжээнүүд багтдаг.

Мөрдөн байцаалтын чухал хэсгийн нэг бол сэжигтэнг мөрдөн байцаах ажиллагаа юм. Сэжигтэн байцаагдахаасаас өмнө өмгөөлөгч авах эрхтэй. Ингэснээр тэрээр мөрдөн байцаах ажиллагаа дуусахаас өмнө өөрийн буруутгагдаж байгаа хэргийн дагуу өөрийн зүгээс санаалаа илрүүхийлж мөн өөрийг нь гэм буруугүй нотлох эд мөрйин баримтыг ашиглах эрхийн талаар хүснэгт гаргаж болно. Гэрч, шинжээч мөн сэжигтэн хуулийн дагуу цагдаагийн өмнө очиж мэдүүлэг өгөх үүргэд хүлээдэггүй ч хэрэв прокурор тус этгээдүүдийг мэдүүлэг өгөхөөр хүрэлцэн ир гэж дуудвал тэд энэ үүргийг заавал биелүүлэх шаардлагатай.

³⁷ ЭБШЖ-ын 102-ын дагалдах заалтууд.

³⁸ ЭБШЖ-ын 100а-р зүйл.

³⁹ ЭБШЖ-ын 81а-р зүйл.

⁴⁰ ЭБШЖ-ын 102-р зүйл.

⁴¹ ЭБШЖ-ын 103-р зүйл.

⁴² ЭБШЖ-ын 94-р зүйл.

⁴³ ЭБШЖ-ын 100а, 1006-р зүйл.

⁴⁴ ЭБШЖ-ын 110а-р зүйл.

⁴⁵ ЭБШЖ-ын 100с, 1006-р зүйл.

⁴⁶ ЭБШЖ-ын 81а-р зүйл.

⁴⁷ ЭБШЖ-ын 81е-р зүйл.

2.3.2. Шүүх хуралдаанд бэлдэх үе шат⁴⁸

Эрүүгийн хэрэг үссэний дараа зарчмын хувьд ЭБШЖ-ын 199 дүгээр зүйлийн дагуу шүүх хуралдаанд бэлдэх үе шат эхэлдэг. Шүүх хуралдаанд бэлдэх үе шат гэдэг нь хэрэг Прокурорын газраас шүүхэд шилжин ирсэн байдаг боловч шүүх хуралдаан хараахан эхлээгүй бөгөөд тахайн хаваст хэргийг шүүх өөрийн зүгээс шүүх хуралдаанд зориулж нягтлах шалгах явц юм⁴⁹. Энэ үйл ажиллагааны зорилт нь нэг талаараа шүүх негее талаараа сэжигтэнг хэрэггүй шүүхийн ажиллагаанаас хамгаалахад оршино. Энэ үед сэжигтэнд яллах тухай бичигийг хүргүүлдэг ба тус бичигт Эрүүгийн хуулийн ямар заалтыг сэжигтэн биелүүлсэн байж болзошгүй тухай мөн үүнээс үүссэн хуулийн үр дагаварын талаар тодорхой тайлбарлан бичсэн байдаг. Түүчинлэн энэ яллах тухай бичигт эд мөрийн баримт, тус хэргийг хянан шийдвэрлэх харьяаллын шүүх, сэжигтний өмгөөлөгчийн тухай мөн мөрдөн байцаалтын явцад илэрсэн үр дүнг танилцуулна. Энэ үе шатанд шүүхийн зүгээс тухайн хэрэг хүлээн авсан шүүх тус хэргийг хянан шийдвэрлэх харьяаллын шүүх мөн эсэхийг тогтоож, хэргийг шүүн таслах хурлыг нээх⁵⁰ зсвэл татгалзах⁵¹ талаар урьдчилан шалгадаг.

Прокурорын газар шүүхэд шүүх ажиллагааг нээхийг татгалсан албан бичиг хүргүүлсэн байсан ч энэ бичгээс зөрүүтэйгээр бэлтгэл үеийн ажиллагааны шалгалтын явцад шүүх хурлыг нээх тухай шийдвэр гарч болно. Энэ бэлдэх үе шатанд гаргасан шийдвэр Прокурорын газраас ирүүлсэн ялын бичигтэй заавал нийцэх албагүй гэсэн уг юм. Бэлдэх үе шатанд гаргасан шүүх ажиллагааг нээх тухай шийдвэрийг өөрчилж болдоггүй⁵² бөгөөд Прокурорын газар энэхүү шийвэрэйн эсрэг үйл ажиллагаа явуулахыг хүсвэл энэ талаар гомдол

⁴⁸ ЭБШЖ-ын 199-р зүйл.

⁴⁹ ЭБШЖ-ын 199-р зүйл.

⁵⁰ ЭБШЖ-ын 203-р зүйл.

⁵¹ ЭБШЖ-ын 204-р зүйл.

⁵² ЭБШЖ-ын 210.1.-р зүйл.

мэдүүлж болдог⁵³. Хэрэв бодит байдал дээр хэрэг үйлдсэн нь ил тод бөгөөд тус хэргийг шүүх ажиллагаагүйгээр шийдэх боломжтой гэж үзвэл тухайн этгээдийг, шийтгэх тушаалтыг шүүх хуралгүйгээр шууд гаргана⁵⁴. Энэ нь харин хорих ялын шийтгэлтэй. Эмт хэрэг байж болохгүй бөгөөд үүнд ихэвчлэн мөнгөн тэмдэгтийн шийтгэл эсвэл жолооны үнэмлэх хураах гэх зэрэг шийтгэл багтдаг. Дээрх тохиолдолдоос гадна хэрэг хурдавчилсан журмаар шүүх ажиллагаа шаардлагатай үед⁵⁵ шүүх хуралдаанд бэлдэх үе шатыг явуулах хэрэгтүй байдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БНСУ, ХБНГУ-ЫН ЭРҮҮГИЙН ПРОЦЕССИЙН ОНЦЛОГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилго нь гэмт хэргээс урьдчилсан саргийлэх, олон нийтийг хамгаалах, гэмт хэргийн хохирогч, түүний гэр бүл, гэрчийг дэмжих, үйлдсэн гэмт хэргийных нь төлөө гэмт этгээдэд хариуцлага онгогдуулах, гэмт хэрэгтнийг нийгэмд нь буцаах, хууль дагагч нийгмийн гишүүн болоход нь туслах явдал байдаг. Нийтийн эрх зүйн тогтолцоотой улс орнуудын ЭБША-ны үндсэн зарчмууд:

❖ Гэм буруугийн зарчим буюу бүхий л зруүгийн гэмт хэргийг сэжигтнийг гэм буруугүй гэж таамаглах таамаглалаас эхэлдэг;

❖ Эрх зүйн зайлшгүй процесс (Due process), гэм буруугүйн дээрх зарчмытай холбоотойгоор яригддаг. Гэмт хэргийн үйл явдлыг шинжлэхдээ тухайн сэжиглэгдэж байгаа этгээдийн хууль ёсны эрхийг хамгаалах явдлыг чухалчилдаг;

❖ Бие даасан шүүх буюу хэрэгтэн бие даасан эрх бүхий шүүхээр шүүлгэх асуудал;

❖ Шүүх нээлттэй, хүртээмжтэй байх;

❖ Хуулийн өмнө бүх хүн эрх тэгш байх эдгээр болно.

Тэгвэл эх газрын эрх зүйн тогтолцоотой улсын ЭБША нь мөн л гэм

буруутай тогтоогдоогүй байхад шийтгэл оногууллахыг хориглох, олон нийтэд нээлттэй байх, хууль ёсны зарчим зэрэгт суурилан явах ба байцаалт явуулах зарчим буюу улсын прокурор, шүүх нь хэргийг байцаан явуулах үүрэгтэй гэж зааснаараа мэтгэлзэх зарчмаар явагддаг нийтийн эрх зүйн булийн зарчмаас онцлог ялгатай.

Герман улс болон БНСУ-ын зруүгийн байцаан шийтгэх ажиллагааны онцлогийг дараах 5 шинжээр харьцуулан шинжлэв.

1.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тус 2 улсад хоёр төрөлтэй байгаа ба БНСУ-д ердийн, хялбаршуулсан гэсэн хянан шийдвэрлэх ажиллагаа байгаа бол Герман улсад энгийн, онцгой гэсэн төрөлтэй байна.

БНСУ-ын ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний шат нь мөрдөн байцаалтаас эхлэх ба мөрдөн байцаах эрх бүхий этгээд нь прокурор, шүүхийн цагдаагийн ажилтан байдаг боловч практикт шүүхийн цагдаагийн ажилтан мөрдөн шалгах ажиллагааг хариуцан явуулдаг байна. Хэрэг бүртгэлт, мөрдөх байцаалтын шатанд оролцож төрийн байгууллагууд болон тэдний хоорондын эрх хэмжээний хуваарилалтын асуудлыг улс орнууд өөр өөрөөр шийддэг ба тухайлбал, Англид мөрдөн байцаалтын зөвхөн цагдаагийн байгууллага гүйцэтгэдэг⁵⁶ бол Германанд прокурор мөрдөн шалгах үйл ажиллагааг хариуцан явуулахаа ба цагдаагийн ажилтан түүний заавраар үйл ажиллагаа явуулж оролцно гэж хуульчилсан байдаг. Германанд онцгой журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хялбаршуулсан журмаар, хурдавчилсан журмаар, хувь хүн бие дааж яллах бичиг өргөх болон хохироч шүүн таслах ажиллагаанд яллагчаар оролцож хэрэг хянан шийдвэрлүүлэх гэсэн 4 онцгой төрөлтэй байна. Мөрдөн байцаалт явуулахдаа БНСУ-д сайн дурьн байдалд үндэслэсэн мөрдөн байцаах ажиллагаа, албадлагын арга хэмжээнд суурилсан мөрдөн байцаах ажиллагаа гэсэн 2 төрөл байх ба энэ нь албадлагын арга хэмжээ авах буюу

53 ЭБШЖ-ын 210.2-р зүйл.

54 ЭБШЖ-ын 407 ба дагалдах заалтууд.

55 ЭБШЖ-ын 417-420-р зүйл.

цагдан хорихгүйгээр сэжигтэнг шалгаж байгаагаар ялгагддаг онцлогтой. БНСУ-ын мөрдөн байцаах шатанд хэрэгжүүлж байгаа хүний эрхийн хамгаалалттай холбоотойгоор сайн зохицуулалт нь сэжигтэнг цагдан хорьсоос хойш шүүхийн цагдаагийн ажилтан 10 хоногийн дотор прокурорт шилжүүлэх ба прокурор яллах хангалттай үндэслэл байхгүй бол нэн даруй суллана гэсэн заалт юм.

ДҮГНЭЛТ

Тус судалгааны нэгдүгээр бүлгийг дүгнэн үзэхэд БНСУ улс шүүхийн өмнөх шатанд прокурорын оролцоо давамгайлсан эрүүгийн процессын тогтолцоотой байна. Энд прокурор нь өөрийн хяналтын чиг үүргээс гадна эрүүгийн процессын ажиллагаагаа төрийн зүгээс голлон хөтөлвн явуулагч этгээд юм. Мөн негеө талаас БНСУ нь эрүүгийн процессын тогтолцоогоо хөгжүүлэх, шинэтгэхийг эрмэлзэж байгаа нь Англи-Америкийн буюу нийтлэг эрх зүйн тогтолцооны зарим элементийг нутагшуулах гэсэн оролдлогоо харгадж байна.

Эрүүгийн процесст тангаргатны хувиар оролцож болох иргэдийн төлөөлөгч-шүүгчийн оролцоо бухий эрүүгийн шүүх хуралдааны хэлбэрийг бий болгосон байна. Тангаргатны гүйцэтгэхүүргэ Америкийн тогтолцоотой адил биш боловч шүүх хуралдааны ил тод, ардчилсан байдлыг сайжруулахад тодорхой хэмжээний түлхэц үзүүлж байна. Үүнээс гадна хэргийг эцэслэн шийдвэрлэхийн өмне урьдчилсан хуралдаан/сонсгол (reparatory hearing) хийхээр зохицуулсан нь яллах, өмгөөвхөн талуудыг шүүхийн шатанд идэвхитэй тоглогчид болгох, хэргийн нехцел байдлыг бүх талаас нь бүрэн бодитойгоор тогтоо бодит боломжийг улам бүр нэмэгдүүлж байгаа юм. Ийнхүү аливаа улсын эрх зүйн тогтолцоо ямар эрх зүйн бүл, уламжлалд хамаарна, тэрхүү бүл, уламжлалд хамаарах улсын эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалтыг нутагшуулан авах ёстой гэсэн уламжлалт хандлагын эсрэг жишээг эх газрын эрх зүйн бүлд хамаарах хэрээн жишгийн эрх зүйн бүлээс рецепци хийж

байгаа БНСУ-ын эрүүгийн процессийн эрх зүйн зохицуулалтаас харж болохор байна.

Хоёрдугаар бүлэгт авч үзсэн Герман улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд шүүхийн харьяаллыг тодорхойлох нь маш чухал үүрэгтэй. Учир Герман улсын шүүхийн тогтолцооны нэгэн онцгой чанарт хэрэг хөнгөн, хүндээссээ хамаараад аль ч шатны шүүхээр анх хянан шийдвэрлэгдэж болдог. Тэгхээр бүх хэрэг анхан шатаар дамжихгүйгээр шууд давах болон дээд шатны шүүхээр шийдвэрлэгдэж болдог онцлогтой.

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэргийг энгийн ба онцгой журмаар хянан шийдвэрлэдэг ба онцгой журмаар хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд тухайн хэргийн хохирогч Прокурорын яллах ажиллагааны хажуугаар бас хэрэгт яллагчаар орж болдог онцгой хэлбэрийг харуулсан. Мөн хувь хүн яллах бичиг буюу яллах дүгнэлтийг шүүхэд хүргүүлж болдог нь шүүхийн болон прокурорын ажиллагааг явуулахгүй хохирогчид өөрийгөө шүүхийн өмне хамгаалах боломжийг нээн өгч байгаа онцлог эрх зүйн зохицуулалт болиж байна.

Герман улсад иргэдийн төлөөлөгч буюу иргэдийн шүүгч гэж байдаг. Хэдийгээр тангаргатны шүүх гэх нэршилтэй шүүх байгаа боловч уг шүүх нь энгийн хэлбэрээр шүүх ажиллагаагаа явуулдаг. Эцэст нь тэмдэглэхэд Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх систем нь эх газрын болон нийтийн эрх зүйн тогтолцоотой улсуудын аль "сайн" туршлагыг судалж нутагшуулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, аливаа улсын эрх зүйн тогтолцоо ямар эрх зүйн бүл, уламжлалд хамаарна, тэрхүү бүл, уламжлалд хамаарах улсын эрх зүйн хэм хэмжээ, зохицуулалтыг нутагшуулан авах ёстой гэсэн уламжлалт хандлагын эсрэг жишээг эх газрын эрх зүйн бүлээс рецепци хийж байгаа БНСУ-ын эрүүгийн процессийн эрх зүйн зохицуулалтаас харгадж байна.

ШҮҮХИЙН ХАМГААЛАЛТЫН МЕХАНИЗМЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ НЬ: АСУУДЛЫГ УЛС ХООРОНДЫН ҮҮДНЭЭС АВЧ ҮЗЭХ НЬ



Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн дарга, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Оросын Холбооны Улсын Гавьяат хуулыч
Валерий Дмитриевич Зорыкин.

Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Конвенцийн хяналтын механизмын хөгжлийн шинэ үе шат:
Оросын Холбооны Улсын оролцоо

Өнөөдөр Европын Хүний Эрхийн Шүүх (цаашид ЕХЭШ гэх) үйл ажиллагааныхаа шинчлэлт гэж бараг хэлж болох вэрийн түүхийн нэгэн шинэ үе шатыг туулж байна. Конвенцоор олгогдсон эрхийг хамгаалах тогтолцоонд хувь хүний гомдол бурийн ач холбогдол, үүрэг, эрх зүйг хэрэглэдэг бие даасан байгууллага болох шүүхийн үүргийг хадгалахын зэрэгцээ үндэсний эрх зүйн тогтолцоон дахь бүтцийн хүндрэлтэй асуудлыг олж илрүүлэхэд илүү их ач холбогдол өгч эхэлжээ. ЕХЭШ-ийн үйл ажиллагаанд үндэсний эрх зүйн тогтолцоон дахь бүтцийн хүндрэлтэй асуудлыг олж илрүүлэх, тэдгээр асуудлыг даван туулахад нь туслах гах мээт шинэ зорилтуудурган гарч ирж байна. Шүүхийн үйл ажиллагааны арга барил мөн өөрчлөгджэй байна.

Шүүх дахин давтагдаж буй хүндрэлтэй асуудлын үр дагаврыг дангаар нь арилгахад бус тэдгээрийн шийдлийг олох механизм боловсруулахад илүү анхаарал хандуулж байна.

Конвенцийн хяналтын механизмын үр нөлөөг дээшлүүлэх хүчин зүйлсийн тоонд шүүгчдийн тоо болон тэднийг сонгон шалгаруулах ажиллагаанд оруулах өөрчлөлтийн асуудал ч орно. Брайтоны Бага хурлын үеэр, хүлээж авч болох гомдол эсэхийг ялгаж салгах ажлыг хийж гүйцэтгэх (шүүлтийн үе шат) шүүгчдийн тоог нэмэгдүүлэх санал гарч байсан юм. Тэгсэн хэдий ч ЕХЭШ-ийн үр нөлөөг нэмэгдүүлэх гол арга хэрэгсэл түүний үйл ажиллагааны хүрээний гадна байгаа юм. ЕХЭШ-ийн гаргаж ирсэн бүтцийн бэрхшээлтэй асуудлыг даван туулахад үндэсний эрх зүйн тогтолцоо хүчин чармайлт тавих ёстай.

Үүнтэй уялдуулан үндэсний шүүхийн тогтолцооны өмнө (түүний дотор ОХУ) Конвенцийн хяналтын механизмын харилцан үйлчилгээний үр нөлөөг дээшлүүлэх, (юуны өмнө бүтцийн хүндрэлтэй асуудлыг даван туулах хүчин чармайлтаяа уялдуулан зохицуулсанар Шүүхийн ачаалалаас болж үүсэх ноцтой нөхцөл байдлыг бууруулж) ЕХЭШ-ийн тогтоогыг (ерөнхий шинжтэй арга хэмжээний тусламжтайгаар) үндэсний төвшинд үр дүнтэй хэрэгжүүлэх болон эрх зүйг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаанд Конвенцийн стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой шинэ зорилтууд ч тавигдаж байна. Иймээс ОХУ-ын эрх зүйн тогтолцооны тэргүүн зэргийн зорилт нь бүтцийн бэрхшээлтэй асуудлын "жагсаалт гаргах", тэдгээрийн учир шалтгааныг тодорхойлох, шийдвэрлэх арга замыг хайх явдал болоод байна. Энэхүү ажлын зорилго

"Энэ өгүүлэл нь" Право в условиях глобальных перемен В.Д.Зорыкин Издательство "Норма 2013" №01Д хэвлэгдсэн

нь эрх зүйн хамгаалалтын дотоодын төвшинг сайжруулах явдал юм. ОХУ-ын олон улсын өмнө хүлээсэн үргээс үл хамааран энэ нь өөрөө маш үнэ цэнэтэй зорилго бөгөөд ЕХЭШ-ийн практик, түүний гарган ирж буй хүндэрлэлтэй асуудал нь ердөө уг зорилгод хүргэх хурдасгүүр юм.

Юуны тулд үүний хийх вэ? Энэ нь олон улсын өмнө хүлээсэн үргээ биелүүлэх тулгамдсан зорилгоос гадна ОХУ-ын Үндсэн хуулийн суурь болсон үнэт зүйлс, юуны өмнө хувь хүний Үндсэн хуулийн үндсэн эрхэд тулгууласан хүний эрхэмсэг оршихуйг сэргээн бэхжүүлэх явдал юм. Эдгээр үнэт зүйлс нь эрх, эрх чөлөөг хамгаалах Конвенцийн тогтолцооны үндэс суурь болж, түүнчлэн оролцогч улсуудын Үндсэн хуулийн уламжлалыг хамгаална.

ОХУ-ын эрх зүйн тогтолцоо болон ЕХЭШ-ийн хооронд байгаа бүтцийн хүндэрлэлтийг ихэнх асуудлаар зөвшилцэлд хүрсэн байдал. (Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх, хорих байрны нөхцөл байдал, хэт удаан хугацаагаар цагдан хорих, байцаан шийтгэх ажиллагааны баталгаа, түүний дотор ялын гажуудал).

Бүрэн зөвшилцэлд хүрч чадаагүй байгаа цөөн тохиолдолд ОХУ-ын Үндсэн хуулийн үнэт зүйлсийг ЕХЭШ-ийн практикийг үндэслэн түүний үнэт зүйлстэй нь цаашид харьцуулан үзэж судлах шаардлагатай. Мэдээжээр, энд хамгийн хүчтэй тоглогчид болох Англи, Франц, Герман "санал нийлэхгүй" байгаа бөгөөд Конвенцийн тогтолцооны хувьд санал нэгдэх асуудал нь нэлээд хугацаа шаардаж болох энгийн зүйл юм.

Конвенцийн хэрэгжилтийг үндэсний төвшинд боловсронгуй болгох:

ЕХЭШ-ийн шийдвэрийг биелүүлэх

Одоогийн байдлаар онол, арга зүй, зохион байгуулалтын хэд хэдэн асуудал тулгарч байна. Шийдвэрийн биелэлтийн үр дүнг дээшлүүлэхийн тулд онолын болоод практик арга хэрэгслийг боловсруулах шаардлагатай:

-Тусгай шинжтэй арга хэмжээ: шүүхийн шийдвэрийг эргэн хянах шаардлагатай/боловжтой тохиолдлыг тодорхойлох, шаардлагатай тохиолдолд Конвенцийн зөрчигдсэн эрхийг сэргээх өөр арга замыг ашиглах;

-Ерөнхий шинжтэй арга хэмжээ:

Ерөнхий шинжтэй арга хэмжээ авахаар заасан Шүүхийн тогтоолоос үүдэн гарах улсуудын үүргийг тодорхойлох. Үндсэн хуулийн шүүх нь тэдгээрийг тодорхойлох, батлах үйл ажиллагааг санаачлагчийн үүргийг гүйцэтгэхэд илүү тохиорох юм./

Ерөнхий стандарт боловсруулахад ОХУ-ын нөлөөг нэмэгдүүлэх ба Конвенцийг үндэсний төвшинд хэрэгжүүлэхэд Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх үүрэг

Конвенцийн үр нөлөөг дотооддоо нэмэгдүүлэхийн тулд үндэсний хэмжээнд түүний хэрэгжилтээр мэдэгдэхүйц үр дүнд хүрсэн байх хэрэгтэй юм. Ийм үр дүнгийн тодорхой нэг жишээ нь "Бурдов ОХУ-ын эсрэг" (№2) хэргийн асуудлаархи ЕХЭШ-ийн тогтоолыг гүйцэтгэхтэй холбогдуулан "Хэрэг зохих хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх болон шүүхийн шийдвэрлүүлэх талаар эрх нь зөрчигдсэн тохиолдолд олгох нөхөн олговрын тухай" Холбооны хууль баталсан явдал бөгөөд энэ нь эрх зүйн салбарынхны хамтынажиллагааны үр дүнд боловжтой болсон юм. Ийм хамтын ажиллагааны жишгээр дээр дурдсан асуудлуудыг (Конвенцийн стандартыг нэвтрүүлэх, бүтцийн хүндэрлэлтийг асуудлыг даван туулах арга зам, ЕХЭШ-ийн шийдвэрийн биелэлт, Үндсэн хууль ба Конвенцийн "дээд" хэм хэмжээний хооронд гарч болзошгүй зөрчилдөөнийг шийдвэрлэх, олон янзын өрсөлдөгч эрхийг хэрэгжүүлэх тэнцвэрийг эрж хайх) илүү өргөн цар хүрээтгээгээр хэлэлцэхэд чиглэсэн төсөл эхлүүлэх нь зүйтэй бөгөөд Үндсэн хуулийн шүүх нь ийм төслийн

зохицуулагч, ажлын талбар нь байж болох юм. Төсөлд Европын Конвенцийн Хяналтын механизмын байгууллагууд (ЕХЭШ, Хяналтын механизм) болон тэдний ОХУ дахь түншүүд (Хууль зүйн яам, Гадаад хэргийн яам), мөн эрх зүйн шинжлэх ухаан, шүүгч нарын болон өмгөөлөгчдийн нийгэмлэгийн төлөөллийг хамруулан оруулж болох юм. Хэрэгжүүлэх хэлбэр нь: Зөвлөгөөн, нээлттэй хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээний нийтлэл байх юм.

Энэхүү ажиллагааны үр дүн нь хуулийн төсөл боловсруулах (ЕХЭШ-ийн шийдвэрийг биелүүлэх өрөнхий шинжтэй арга хэмжээг боловсруулах гэх мэт) санаал байж болох юм. Уг төсөлд Конвенцийг үндэсний төвшинд хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Европын улсуудын өмнө нийтлэг тулгарч байгаа асуудал болон уг асуудлын талаархи тэдний нийтлэг байр суурийг хэлэлцэхэд зориулсан олон улсын элементийг оруулж болно. Интерлакен, Измир, Брайтоны Бага Хурлаас гаргасан тунхаглалт тусгагдсан Конвенцийн шинчлэх арга замын ихэнх нь 2006 онд Ярославль хотод болсон "Оролцогч улсуудын үндэсний эрх зүйн тогтолцоонд Европын Конвенцийн үзүүлж буй нелөө" сэдэвт бага хурлын үеэр анх яригдсан гэгдийг санах хэрэгтэй. Энэ утгаараа Ярославль нь Интерлакены өмнө бичигдэнэ.

Европын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өөрийн байр суурийг бэхжүүлэхийн тулд ОХУ ЕХЭШ-тай харилцах журмынхаяа дарааллыг өөрчилж, Страсбургт болж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдийн хувиар илүү идэвхтэй оролцох хэрэгтэй юм. (Оросын эрх зүйн тогтолцоонд стратегийн ач холбогдолтой, мөн ЕХЭШ-ээс гаргасан шийдвэртэй ОХУ санал нийлэхгүй байх болзошгүй асуудлаар) Түүнчлэн, "зөвшилцэл"-ийн мөн чанартай төдийлэн нийцээд байдаггүй "Конвенцийн стандарт"-ын боловсруулалтад нелөөлехийн тулд бусад түнш улсуудтай хамтран ажиллах

шаардлагатай. Гэвч уг ажил хийгдэж эхлээгүй байна.

Одоогийн байдлаар Конвенцийн стандартыг ОХУ-ын эрх зүйн практикт нэвтрүүлэх ажилд мэдэгдэхүйц ахиц гарч байна. Гэхдээ шүүх эрх мэдлийн үйл ажиллагааны дээд төвшинд болон өрөнхий онолын төвшинд Конвенцийг хэрэгжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн ч "доод" төвшинд энэхүү үйл явц сүл байна. Конвенцийг үндэсний төвшинд хэрэгжүүлэх гол үргийг дотоодын шүүгч нар гүйцэтгэн гэдгийг тодотгох нь чухалюм. Шүүгч нар эрх зүйн стандартыг уялдуулан зохицууллахад өндөр төвшний мэргэжлийн эрх чөлөө шаардлагатай. Энэ нь эргээд үндэсний хэмжээнд шүүгч нарын үүрэг, ролийг өөрчлөх, тэднийг мэргэжлийн бие даасан байдлаар хангах, мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэх шаардлагыг бий болгох байна.

ЕХЭШ-ийн шийдвэрийн хэрэгжилтийн талаар ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг хуулиар бэхжүүлж өгөхөд энэ үед онцгой анхаарал хандуулах хэрэгтэй байна.

Миний бодлоор, энэ чиглэлд хийгдэх ажил нь дараах үндсэн байр суурийг багтаасан үзэл баримтлалд тутгуурласан байх шаардлагатай.

1. Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны өнөөгийн олон улсын ба эрх зүйн бүрэлдэхүүн хэсгийг хууль зүйн үүднээс нь тодорхойлж өгөх шаардлагатай байна. Энэ нь, нэн ялангуяа, Европын Шүүхийн харилцах харилцаа ба харилцан үйлчлэлийн зөрэг (зөрчилдөөнгүй) болон серег (зөрчилдөөнтэй) тохиолдолд Европын Шүүхийн практикийг Оросын эрх зүйд харгалзан үзэх явдалд хамаатай юм. Ингэхдээ зөрэг (зөрчилдөөнгүй) тохиолдолд шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд бүрэн эрхээ бэхжүүлэх тал дээр улам бүр анхаарах хэрэгтэй юм. Зөрчилдөөнтэй нөхцөл байдалд шийдвэрийн эрх зүйн үр дагаврыг тодорхойлоходоо ЕХЭШ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг хягаарласан

хэмээн ойлгогдохуйц тусгай хэм хэмжээг хуульд тусгахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Үндсэн хуулийн шүүхээс ЕХЭШ-ийн шийдвэрийн хэрэгжилтийг хязгаарлах боломж олгосон заалтыг хуульд тусгах аливаа оролдлого нь дотоодод төдийгүй хилийн чанадад ч таагүй сэтгэгдэл төрүүлж байсныг туршлага харуулж байна. Тэгээд ч ОХУ-ын зүгээс серег хариу үйлдэл үзүүлэх (үндсэн хуулийн болон эрх зүйн үүднээс) ЕХЭШ-ийн "зэрчилдэентэй" шийдвэр тийм ч олон тоогоор гарахгүй биз дээ. Иймд тэдгээрийн цаашдын хувь заяг тодорхойлохын тулд хуульд заавал тусгай шинжтэй хэм хэмжээ оруулах шаардлагагүй юм. Харин ЕХЭШ-ийн гаргасан шийдвэрээс үүсч болзошгүй үр дагаврыг тухайн тохиолдлын бүх нөхцөл байдлыг харгалзсан үзсний үндсэн дээр тодорхойлох, төвийг сахисан шинж чанартай заалтыг бататган өгөх зайлшгүй шаардлагатай.

2. Энэхүү асуудлыг шийдвэрлэх гол арга нь ерөнхий шинжтэй арга хэмжээг тодорхойлох бүрэн эрхийг Үндсэн хуулийн шүүхэд өгөх явдал бөгөөд ОХУ-ын эсрэг гаргасан гомдлыг шийдвэрлэсэн ЕХЭШ-ийн тогтооплоос ийм арга хэмжээ авах хэрэгтэй гэдэг нь харгадах байна. Ингэснээр өнөөдөр үүсээд байгаа яг аль субъект, ямар журмын дагуу энэхүү ерөнхий шинжтэй арга хэмжээг авах процессыг эхлүүлэх вэ гэсэн тодорхой бус байдлыг даван тууплахад ихээхэн тус нэмэр болох юм. Бодит байдал дээр Үндсэн хуулийн шүүхээс энэ механизмыг практикт хэрэглэн хууль Үндсэн хууль зерчсэн болохыг тогтоодог бөгөөд здэээр хууль нь Европын Конвенцид нийцэж буй эсэхэд Европын шуухийн зүгээс зргэлзээтэй ханддаг. Үндсэн хуулийн шүүх өөрт олгогдсон эрх хэмжээний хүрээнд буюу өөрөөр хэлбэл өмнө нь ЕХЭШ-ээс Конвенцид үл нийцэж буйн улмаас шүүмжлэлд өртсөн хэм хэмжээг Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг шалтуулах тухай өргөдлийг хэлэлцэх замаар ажиллаж ирсэн. Гэсэн хэдий

ч хэлбэрийн төдий энэ хяналт шалгалаа нь ЕХЭШ-ийн тогтоолтой холбоогүй юм. Үндсэн хуулийн шуухийн тухай Холбооны Үндсэн хуульд ЕХЭШ-ийн тогтоол гарсантай холбогдуулан ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхэд хандан ерөнхий шинжтэй арга хэмжээ авах тухай хүсэлт гаргах боломж олгосон заалт оруулах санал гараад байна.

3. ЕХЭШ-ээс Конвенцийг зөрчсөн болохыг тогтоон, тусгай эсхүл ерөнхий шинжтэй арга хэмжээ авахаар шийдвэрлэж болно. Тусгай шинжтэй арга хэмжээг ЕХЭШ-ийн тогтоолд (шударга нөхөн олговор олгох, хохиролыг барагдуулах) тодорхойлж өгөх ба эсвэл дотоодын эрх мэдэл бүхий байгууллага тодорхойлоо шийднэ. (Шаардлагатай үед шүүхийн шийдвэрийг зргэн харна). Энэ нь ихэнхдээ (ердийн шүүх, эсхүл арбитр) шүүхийн өмнө гаргасан шийдвэрийг дахин хянуулахаар гомдол гаргач эрх мэдэл бүхий шүүхэд хандсан тохиолдолд хэрэгжиэнэ. Шийдвэрийг зргэн харах үндэслэл байгаа эсэхийг үндэсний шүүх хэрэгт холбогдох бүх нөхцөл байдлыг авч үзсний үндсэн дээр тодорхойлно.

Үүний зэрэгцээ, ерөнхий шинжтэй арга хэмжээ авах тухай асуудлыг санаачлах эрх ямар нэгэн байгууллагын бүрэн эрхэд хамаардагтүй. Энэ асуудал хууль санаачлах өрдийн журмаар хэрэгжих ёстойч үүнийг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага байхгүй байгаа нь энэхүү үйл явцыг үр дүн муутай болгож байна. Энэ агуулгаараа Үндсэн хуулийн шүүх нь эрх зүйн талбарт засвар хийх бодит эрх мэдлэтий байгууллагын хувьд ЕХЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлаар ЕХЭШ-ийн Орос дахь гол харилцаачийн үүргийг гүйцэтгэнэ. Энэ нь дотоодод болон олон улсын харилцаанд Үндсэн хуулийн шуухийн эрх мэдлийг бэхжүүлж, хамгийн чухал нь ЕХЭШ-ийн шийдвэрийн гүйцэтгэлийн явцыг хянан, үндэсний ашиг сонирхол болон олон улсын өмнө хүлээсэн үүргийн тэнцвэрийг хадгалах боломжийг

олгодог бөгөөд ЕХЭШ-ийн тогтоол нь өөрөө Үндсэн хуулийн шүүхээс өрөнхий шинжтэй арга хэмжээ авах шаардлага байгаа тухай дүгнэлт гаргах эсэхийг урьдчилан шийдвэрлэдгүй. ЕХЭШ-ээс тодорхой хэрэг, маргааны явцад гаргасан үндэслэлийг Үндсэн хуулийн шүүх авч үзээд хэм хэмжээний зохицуулалт хийх үндэслэлт бий эсэх, (маргаан бүхий заалт Үндсэн хуульд нийцсэн эсэх болон ОХУ-ын олон улсын өмнө хүлээсэн үүргийг нягтлан судалсны үндсэн дээр) эсхүл эрх зүйн зохицуулалтыг бүхэлд нь өөрчлөх үндэслэл байхгүй гэсэн дүгнэлт гаргадаг.

Үндсэн хуулийн шүүхэд ийм эрх мэдэл олговол ЕХЭШ-ийн тогтоолыг үндэслэн өрөнхий шинжтэй арга хэмжээг хэрэгжүүлэх механизмыг нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхдээ хэрэглэдэг механизмтэй адил байж болох юм.

4. ЕХЭШ-ийн тогтоолоос үдсэн өрөнхий шинжтэй арга хэмжээг тодорхойлохтой холбоотой асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх бүхий субъектээр хэм хэмжээний хийсвэр хянант хийх ажиллагааны ердийн субъект, Конвенцийн эрх нь зөрчигден гэж үзж ЕХЭШ-ээр хэрэг нь хянагахад оролцсон өргөдөл гаргагчид, түүнчлэн ЕХЭШ-ийн тогтоол гарсны үндсэн дээр шинэ нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан хэргийг дахин хянуулах тухай өргөдлийг хэлэлцэж байгаа шүүх байж болно.

Сүүлийн тохиолдолд, өргөдөл гаргагчийн хэрэгт шаардлагатай тусгай шинжтэй арга хэмжээ авах асуудлыг Үндсэн хуулийн шүүх бараг шийдвэрлэж чадна. Шүүхийн хүснэгтийг авч хэлэлцэхдээ Үндсэн хуулийн шүүх өрөнхий шинжтэй арга хэмжээ авах шаардлагатай, эсхүл шаардлагагүй гэсэн дүгнэлт гаргана. Энэ тохиолдолд Үндсэн хуулийн шүүх асуудлыг шийдвэрлэхдээ хэргийг зргэн хянах кувь заяаг нь урьдчилан шийдэж байгаа гэсэн уг юм. ЕХЭШ-

ээс өргөдөл гаргагчийн эрх зөрчигдсэн гэж тогтоосон байхад дүгнэлт сөрөг гарвал тухайн хэрэгт хэрэглэх хуулийг буруу тайлбарласнаас бус харин эрх зүйн зохицуулалтын улмаас өргөдөл гаргагчийн эрх зөрчигдсэн гэсэн уг юм. Энэ тохиолдолд хэм хэмжээний агуулгыг бүхэлд нь өөрчлөгүйгээр тухайн хэрэг дээр ЕХЭШ-ийн шийдвэрийг хэргийн нөхцөл байдал болон хэм хэмжээг өөрчлөх боломжгүй гэдгийг бүрэн тогтоосны эцэст гаргана. Хэрэв тухайн хэрэг дээр хэм хэмжээг *ad hoc* тайлбарлах боломжгүй бол Үндсэн хуулийн шүүх өргөдөл гаргагчийн зөрчигдсэн эрхийг (тухайн хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан) сэргээх өөр ямар нэг аргыг үндэс болгож болно. Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны практикаас үзэхэд энэ хандлага нь ЕХЭШ-ийн тогтоолын шийдвэрийг тухайн улс бүрэн биелүүлж байна гэсэн уг юм.

5 ОХУ-ын эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлага байгаа / ялангуяа, шаардлага байхгүй/ тухай үндэслэлийг ЕХЭШ-ийн үндэслэлийг нягтлан үзэж, тэр нь ОХУ-ын Үндсэн хуулийн суурь зарчим, терийн бодлогын үндэстэй хэрээн нийцэж байгаа болон ЕХЭШ-ийн шийдвэрт тусгагдсан асуудлын мөн чанарыг харгалзан үзсэнд үндсэн дээр ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх гаргаж, өөрийн шийдвэртээ тайлбарлахгүйгэх нь маш их ач холбогдолтой. ЕХЭШ-ийн тогтсон практикаас үндэслэн гаргаж ирсэн тогтолцооны шинжтэй асуудал тулгарах, /өөрөөр хэлбэл, эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулахад ганц шийдвэр хангалтгүйюм./ түүнчлэн, ЕХЭШ-ийн үндэслэлд эрх зүйн бүрэлдэхүүн хэсэг нь давамгайлал тохиолдолд л ийм арга хэмжээ авахыг шаардаж болох юм.

Энэхүү арга хэмжээ нь Үндсэн хуулийн шүүх болон ЕХЭШ-ийн хооронд хэлэлцэж буй асуудлаар зөрчилдөөн үссэн тохиолдолд тэдний хооронд

яриа хэлцэл хийх үр дүнтэй хэрэгсэл болно. Үндсэн хуулийн шүүхээс өмнө нь хэм хэмжээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгасан нь ЕХЭШ-ийн зүгээс шумжлэл дагуулж байсан бол энэхүү санал болгох буй загварын дагуу Үндсэн хуулийн шүүх асуудлыг дахин авч хэлэлцэх нь Үндсэн хууль болон Конвенц зөрчилдэж байгаа тохиолдолд үндэсний эрх зүйн болон түүний "дээрх" тогтолцоо хоорондоо харилцан үйлчлэх хамгийн үр дүнтэй арга болох нь харагдаж байна. Энэ тохиолдолд ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх нэг бол, ЕХЭШ-ийн үндэслэлтэй санал нийлж, хууль ба (эсвэл) эрх зүйг хэрэглэх практикаа засч запруулна. Эсхүл Страсбургийн үндэслэлтэй санал нийлэхгүй байгаагаа, үргэлжлүүлэн илэрхийлж, өмнөх байр сууриа хамгаална. Хэлбэрийн хувьд энэ нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг эргэн хянаж буй явдал биш юм. Энэ шийдвэр нь эцсийн шийдвэр бөгөөд ямар ч тохиолдолд түүнийг дахиж хянахгүй, түүний эрх зүйн байдалд эргэлзээ үүсч учиргүй. Үндсэн хуулийн шүүх нехцел байдал өөрчлөгдсөн, эсхүл үндэслэл болгосон эрх зүйн хэм хэмжээ нь алдаатай байсан гэх тохиолдолд л нэг асуудлаар гаргасан шийдвэрээ дахин хянана. Үнтэй холбогдуулан, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн практикт ижил хэм хэмжээгээр асуудлыг дахин хэлэлцсэн тохиолдол гарч байнсныг тэмдэглэх нь зүйтэй.

6. Санал болгож буй үзэл баримтлалыг хэрэгкүүлэх явдал нь дараах асуудлтай холбоотой өөрчлөлтийг хуульд оруулахыг шаардаж байна:

-Хэм хэмжээний хийсвэр хяналтын журмаар Үндсэн хуульд нийцэж буй эсэх асуудлыг шалгуулах тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтны хүсэлт; ЕХЭШ-ийн шийдвэр гарсантай холбогдуулан шинээр илэрсэн нехцел байдлын улмаас шүүхийн шийдвэрийг дахин хянуулахаар гаргасан өргөдлийг хянаж буй шүүхийн хүсэлт; ЕХЭШ-д

өргөдөл гаргасан иргэд, эсхүл тэдгээрийн нэгдлийн зүгээс ерөнхий арга хэмжээ /тухайлбал Конвенцийн дагуу эрх зүйн зохицуулалт хийх хэсэгт/ авахыг даалгасан шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай гаргасан өргөдлийн дагуу ЕХЭШ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбоотой ерөнхий шинжтэй арга хэмжээ авахыг тодорхойлох талаар Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг Үндсэн хуулийн шүүхийн тухай Холбооны Үндсэн хуулийн хуульд бататгаж өгөх;

- Процессийн хуулиудад /шинээр илэрсэн нехцел байдалтай холбоотойгоор шүүхийн шийдвэрийг эргэн хянах тухай холбогдох бүлгүүдэд/ ЕХЭШ-ийн гаргасан тогтоолтой холбоотойгоор шүүхийн шийдвэрийг дахин хянуулах тухай өргөдлийг хянаж буй шүүхээс ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхэд ерөнхий шинж чанартай арга хэмжээ авах талаар хүсэлт гаргах эрхийн тухай заалтыг нэмэлт болгон оруулах.

Европт төдийгүй дэлхий дахини олон улсын тогтолцоонд олон улсын эрх зүй бүрэлдэх явц нь "шүүгчийн ноёрхол"-д сууринласан сурвалжит язгуртны хэлбэрээс эрх зүйг бүтээх парламентын ардчиллын үйл ажиллагаа руу шилжсэн түүхийн логикийг ямар нэгэн байдлаар давтаж байгааг төгсгэлд нь дахин тэмдэглэхийг хүсч байна. Өнөөдөр олон улсын болон Европын эрх зүй бүрэлдэх үйл явц ерөнхийдөө "шүүгчийн эрх"-ийн үе шатандaa явж байна. (Шүүгчийн идэвхжилт/активизм/-ийн тухай номлол үүнээс үүдэлтгэйгээр олон нийтэд илүү тархсан юм.) Яагаад гэвэл одоогоор дэлхийн хэмжээнд өөр механизм байхгүй. Харин Европт энэ механизм Европын Зөвлөлийн байгууллагуудын дотор дөнгөж бий болж эхлэж байна. ЕХЭШ-ийн хүчин чармайлтын үр дүнд Европын ерөнхий эрх зүйн үр хөврөл тавигдаж байна. Үнийг эрхэмлэн үнэлэх хэрэгтэй. Энэ үйл явцыг явч тасалдуулж болохгүй.

Нэгдсэн бүрэн эрхт байдлын үзэл баримтлал дээр тулгуурлан олон улсын эрх зүй бүтээх арчилсан механизм бүрэлдэхэд тулгарах гол бэрхшээлийн нэг нь улс орнуудын нийгэм-эдийн засаг, улс төрийн (эрх зүйн) хөгжлийн тэгш бус байдал юм.

Энэ нехцэл байдалд Барууныхан олон улсын эрх зүйн хэм хэмжээ тогтоох үйл явцад ижил тэгшээр хамтран оролцож буй "арчиллыг шинээр тогтоосон" гэх тодотголтой улсуудын үүрэг оролцоог байнга эргэлзээтэй байдалд оруулдаг. (Гэхдээ Барууныхан өөрсдийн "улс төрийн чамбай байдал"-ын улмаас энэхүү бодлогоо зарлаад байдаггүй).

Барууны өндөр хөгжилтэй орнуудын зүгээс олон улсын эрх зүй бүтээх хүрээнд гаргаж буй "давхар стандарт" нь байж болшгүй зүйл хэмээн зарим улс шударгаар шүүмжилж, дургүйцлээ илэрхийлж байна. Гэхдээ тэгш эрхийн төлөө тэмцэхдээ эдээр улс өөрийн эрх зүйн тогтолцоог олон улсын суурь баримт бичигт тусгагдсан, хулээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээнд ойртуулахад илүү хучин чармайлт гаргах хэрэгтэй юм.

Ерөнхийдөө, миний бодлоор, бид Европын Зөвлөлийн хүрээнд цаашилбал дэлхийн улс тэр, эрх зүйн орон зайд эрх зүй бүтээх арчилсан механизмыг бий болгох шаардлагын тухай хууль дээдлэх зарчмыг үндэс болгон ярих хэрэгтэй байна. Энд ямар ч байсан алдаа гарахгүй юм.

Орос хэлнээс орчуулсан
Ё.Өнөборгил
Н.Соронзонболд
Д.Мандхай

---000---

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛ (ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН БОЛОН ДОТООДЫН ЭРХ ЗҮЙН ЖИШЭЭН ДЭЭР)



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
бодлогын судлаач З.Туулайхүү

Удиртгал

Олон улсын эрх зүйн субъект (subject of international law)-ын тухай ойлголт нь олон улсын эрх зүйн үндсэн ойлголтуудын нэг юм. Уламжлалт байдлаар үүнд зөвхөн улсыг хамааруулан ойлгох түйлийн бүрэн эрхт байдлын үзэл санаа олон улсын эрх зүйд зонхиж байв. Үүний улмаас олон улсын эрх зүйн субъектэд тавигдах шалгуур нь гол төлөв улсын онцлогт тулгуурлаж байсан бөгөөд энэ үзэл санаа 19 дүгээр зууны сүүл үе хүртэл үргэлжилсэн байна. Олон улсын эрх зүйн хөгжилд олон улсын амьдралын хэрэгцээ шаардлага нөлөөлж ирсэн бөгөөд энэ зүй тогтолтын дагуу улсуудын хоорондын хамтын ажиллагааны хөгжил нь олон улсын байгууллага гэх "улс биш" этгээд олон улсын харилцаанд институтын хувьд гарч ирэхэд хүргэсэн байна.

Олон улсын байгууллага нь олон улсын эрх зүйн дагуу үүссэн (үүсмэл)

нэгдэл юм. Үндэсний эрх зүйгээр эрх зүйн үүсмэл этгээдүүд болох компани, сан, нийгэмлэг, нөхөрлөл зэргийн эрх зүйн байдлыг тодорхойлдог бөгөөд этгээрийн заримд хуулийн этгээдийн статус олгосноор гишүүдээсээ тусдаа эрх эдэлж, үүргэх хулээх, байгууллага болон гишүүдийн хүлээх хариуцлагыг зааглах боломжтой болдог. Олон улсын эрх зүйн хувьд үндэсний эрх зүйн тогтолцоотой адил ийм эрх зүйн процесс байдаггүй нь олон улсын эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх зүйн харилцаанд хэрхэн оролцох асуудлыг авч үзэх шаардлагатай гэсэн уг биш юм. Олон улсын байгууллагын эрх зүйн байдал, хариуцлагын асуудал энэ хүрээнд хөндөгдхөн асуудал бөгөөд олон улсын эрх зүйн енөөгийн практикаас харахад гишүүн болон гишүүн бус улстай үүссэн эрх зүйн харилцаанд олон улсын байгууллага ямар статустай байх нь харилцан адилгүй асуудал байна. Мөн гишүүн улс олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцан хамаарлын ямар хандлага баримтладаг нь үүнд нөлөөлж байна.

Судалгааны хүрээнд олон улсын байгууллагын эрх зүйн байдал, хариуцлагын асуудлыг олон улсын эрх зүйн субъект (олон улсын эрх зүйн дагуу өөрийн нэрээр эрх эдэлж, үүргэх хулээн, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байх чадвартай этгээд) болох үүднээс судлан тайлбарласан болно. Ингэхдээ эхлээд олон улсын байгууллагын ойлголтыг, дараагаар нь олон улсын байгууллага олон улсын эрх зүйн болон дотоодын эрх зүйн субъект болох асуудлыг, гуравдугаарт нь хариуцлагын асуудлыг мөн олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүйд хэрхэн авч үзэж буй талаар авч үзсэн.

¹ Энэ өгүүлэл нь судлаачийн энэ сэдвээр бичсэн 2 дахь өгүүлэл бөгөөд эхийн нь Хууль дээдлэх ёс сэгүүлийн 2014 оны №04/50 дахь дугаарт International Legal Personality of International Organizations: International Law Perspectives сэдвээр нийтийгээн. Энэ асуудалт холбоотойгоор Монгол Улсын эрх зүйн хошуулалт, шүүхийн практик, олон улсын байгууллагын эрх ямба, дархан эрхийн асуудлыг тусгайлан судалж байгав болно.

Түлхүүр үгс: Олон улсын байгууллага, олон улсын эрх зүйн субъект буюу олон улсын эрх зүйн бие даасан этгээд, олон улсын эрх зүйн бие даасан этгээдийн чадвар бүхий байдаг.

I. ОЛОН УЛСЫН

II. БАЙГУУЛЛАГЫН ОЙЛГОТ

Франц улс, Ариун Ромын эзэнт гүрний хооронд 1804 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн гэрээгээр байгуулгасан *Administration general de l'octroi de navigation du Rhi* нь анхны олон улсын байгууллага нь байж болох талаар зарим эх сурвалжид дурдсан байх бөгөөд тус байгууллага нь хаалттай байгууллага байжээ.² Гэхдээ судлаачид олон улсын байгууллага гэх нэр томьёог 19 дүгээр зууны (суул) үеэс анх хэрэглэгдэж эхэлсэн гэдэгтэй санал нэг байдаг ба энэ үеэс эхлэн олон улсын байгууллага олон улсын эрх зүйд институцийн хувьд гарч ирсан байна.³

Дэлхийн 2 дугаар дайнаас хойш "засгийн газар хоорондын байгууллага (*intergovernmental organization*)", "олон улсын (*international organization*)" гэх нэр томьёо энэ чиглэлийн судалгаанд түгээмэл хэрэглэгдэх болсон байна.⁴ Тухайлбал Олон улсын шүүхийн дүрэмд "олон улсын нийтийн байгууллага" гэх нэр томьёог хэрэглэсэн байдаг⁵ бол 1969 оны Олон улсын гэрээний эрх зүйн тухай, 1975 оны Түгээмэл чанартай олон улсын байгууллагад

² C.F.Amerasinghe, *Principles of the institutional law of international organizations* (Second Revised Edition), Cambridge University Press 2005, p.66

³ Энэ талаар P.B. Potter, *An Introduction to the Study of International Organizations*, Nabu Press 2011, pp. 3-19; C.F.Amerasinghe, *Principles of the institutional law of international organizations* (Second Revised Edition), Cambridge University Press 2005, p.1; Dapo Akande, *International Law* (Third Edition), Oxford University Press 2010, p.270; Ian Brownlie, *Principles of Public International Law* (Fourth Edition), Oxford University Press, 1990, p.679; Henry G.Schermers, Niels M. Blokker, *International Institutional Law, Unity within Diversity* (Fifth Revised Edition), Martinus Nijhoff Publishers 2011, p.30 эзэрт дурдсан бандаг.

⁴ Henry G Schermers, Niels M. Blokker, *International Institutional Law, Unity within Diversity* (Fifth Revised Edition), Martinus Nijhoff Publishers 2011, p.30

⁵ Конвенцион 34 дүгээр зүүлийн 1, 2 даалж касаг

улсаа төлөөлөх тухай, 1986 оны Улс ба олон улсын байгууллага хоорондын болон Олон улсын байгууллагууд хоорондын Гэрээний эрх зүйн тухай гэсэн хэд хэдэн Венийн конвенцийн нэр томьёоны тайлбар хэсэгт "олон улсын байгууллага гэдэгт засгийн газар хоорондын байгууллагыг ойлгоно" хэмээн заасан байдаг.⁶ Энэ нь тухайн цаг үед эхлээд Үндэстнүүдийн Лиг (the League of Nations), дараагаар нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (the United Nations Organization) зэрэг засгийн тазар хоорондын олон улсын байгууллага олон улсын тавцанд идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлснэр энэ ойлголтыг улс орнуудын засгийн газруудын хамтын ажиллагааны үр дунд байгуулгасан байгууллагуудаар төлөөлүүлэн ойлгож байсантай холбоотой. Гэхдээ ийнхүү тодорхойлсныг бүх тохиолдолд хэрэглэгдэх нийтлэг тодорхойлолт бус зөвхөн тухайн конвенцийн зорилгын хүрээнд олон улсын байгууллагыг тодорхойлсон тодорхойлолт хэмээн үзэх нь зүйтэй. Ийнхүү олон улсын байгууллага гэх ойлголтыг зөвхөн засгийн газар хоорондын олон улсын байгууллагад хамаатуулах нь явцуу хүрээнд тодорхойлж байгаа хэрэг юм. Учир нь олон улсын байгууллага гэдэгт зөвхөн засгийн газар хоорондын олон улсын байгууллагыг ойлгох нь энэ ойлголтын улам бүр олон талтай болж байгаа агуулгыг бүрэн илэрхийлэхгүй (засгийн газраас бусад төрийн байгууллагуудын хооронд байгуулгасан, мөн олон улсын гэрээнээс бусад олон улсын эрх зүйн хэмжээгээр байгуулгасан байгууллага олон улсын эрх зүйн харицаанд идэвхтэй оролцох нь цөөнгүй) бөгөөд улам бүр хөгжжих байгаа олон улсын харилцааны дэвшигийг харгалзан узэж энэ асуудлын өргөн хүрээнд авч

⁶ Олон улсын гарээний эрх зүйн тухай конвенц (1969)-ийн 2.1 (ii) зүйл, Түгээмэл чанартай олон улсын байгууллагад улсаа төлөөлөх тухай конвенц (1975)-ийн 1(1) зүйл, Улс ба олон улсын байгууллага хоорондын болон Олон улсын байгууллагууд хоорондын Гэрээний эрх зүйн тухай конвенц (1986)-ийн 1(ii) зүйл

үзвэл засгийн газар хоорондын олон улсын байгууллагаас гадна өөр бусад этгээдийг хамааруулах эсэх талаар авч үзэх шаардлагатай байдаг. Гэхдээ олон улсын байгууллагын тухай нэгдсэн (нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн) тодорхойлолт байдаггүй нь эдгэр этгээдийг хамааруулах эсэх асуудлыг төвөөтгэй болгодог. Эдгэр нь үүсгэн байгуулагсан эрх зүй, эрх зүйн чадвар, зорилго, эрх, үүргээрээ өөр хоорондоо адилгүй. А. Олон улсын төрийн бус байгууллага (international non-governmental organization). Ийм байгууллага нь засгийн газар хоорондын төрийн бус байгууллагаас ялгаатай нь хувь этгээдүүдийн⁷ нэгдэл (association of individuals) байдаг бөгөөд олон улсын эрх зүйгээр буюу олон улсын гэрээгээр бус аль нэг улсын дотоодын эрх зүйн дагуу байгуулагсан байдаг. Гэхдээ үндэстэн дамнан үйл ажиллагаа явуулдаг бөгөөд гишүүнчлэлд нь хамаарах хувь этгээдүүд нь өөр өөр улс орноос гаралтай байдаг. Олон улсын төрийн бус байгууллагын олон улсын амьдралд үзүүлэх нелж нь улам бүр нэмэгдэж байгаа юм. Жишээлбэл, дэлхийн хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зааварчилгааг уялдуулахад чиглэсэн стандартуудыг баталдаг Олон улсын стандартжуулалтын байгууллага (International Standardization Organization), агаар болон далайгаар бараа тээвэрлэхэд хэрэглэгдэх эрх зүйн зохицуулалтыг ижилтгэх зорилготой Олон улсын иргэний агаарын тээврийн холбоо (International Aviation Transport Association). Гааг дахь Олон улсын Арбитрын шүүхийн үйл ажиллагааг зохицуулж арбитрын дурмийг тогтоодог Олон улсын Худалдааны танхим (the International Chamber of Commerce) байна.

Иргэний нийгмийн оролцоо олон улсын шийдвэр гаргах процессын легитим байх асуудалтай ихээхэн хэмжээгээр холбогддог. Үүний үр дүнд олон улсын төрийн бус байгууллагын

оролцоогянзбурийн түвшинд бий болгох асуудал засгийн газар хоорондын байгууллага болон олон улсын бага хурлын үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг болдог онцлогтой. Энэ нь засгийн газар хоорондын байгууллагын үүсгэн байгуулахаар баримт бичиг зэрэгт зөвлөх болох төлөөлөх эрхийн байдлаар тусгалаа олсон байдаг.⁸ Түүнчлэн олон улсын төрийн бус байгууллагудаас боловсруулсан стандарт, зөвлөмжийг засгийн газар хоорондын байгууллага заавал биелэгдэх хэм хэмжээ байдлаар баталж болно.

Мөн засгийн газар хоорондын байгууллага болон төрийн бус байгууллагын дундын холимог буюу гиприд шинжтэй байгууллагууд байдаг байна. Тухайлбал, Олон улсын Улаан Загалмайн хороо нь Швейцарийн хуулийн дагуу байгуулагсан боловч тус байгууллагад олон улсын эрх зүйгээр, тодруулбал зэвсэгт мөргөлдөөний үед хэрэглэгдэх олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн Женевийн 4 конвенц болон холбогдох нэмэлт протоколуудын дагуу тодорхой чиг үүрэг албан ёсоор олгосон байна. Ийнхүү Хороо нь олон улсын (нийтийн/төрийн) байгууллага болохгүй ч олон улсын эрх зүйн этгээдийн чадвартай тооцогдог байна.⁹ Үүнээс гадна дотоодын эрх зүйд эрх ямба, дархан эрх эдлэх тохиолдол бий. Олон улсын Хөдөлмөрийн байгууллага нь засгийн газар, ажил олгогч, ажилтан гэсэн "гурван түвшний талууд"-аас бүрдсэн засгийн газар хоорондын байгууллага бөгөөд олон улсын хөдөлмөрийн эрх зүйн салбарт олон улсын гэрээний хэлбэрээр олон улсын эрх зүйн хэм хэмжээ бий болгох эрх олгогдсон.¹⁰

Түүнчлэн өөрчлөн байгууллагадаа хэлбэрээр ийм төрийн байгууллагууд нь олон улсын нийтийн/төрийн байгууллага болж байгаа жишээнүүд

⁷ Finn Seyersted, *Common Law of International Organizations*. Martinus Nijhoff Publishers 2008, p.7

⁸ Bindschedler-Robert, Red Cross, EPIL 5 (1983), 248-54

⁹ Finn Seyersted, *Common Law of International Organizations*, Martinus Nijhoff Publishers 2008, p.8

¹⁰ Энд хувь этгээд гэдэгт хувь хүн, хуулийн этгээдийг ойлгож байгаа болно.

бий.¹¹ Гэхдээ энэ нь шууд угтаараа олон улсын төрийн бус байгууллага олон улсын нийтийн эрх зүйн субъект болно гэсэн үг биш юм.

Б. Олон улсын трибунал (international tribunal). Бодит байдал дээр олон тооны олон улсын трибуналд олон улсын гэрээ эсхүл дотоодын хууль тогтоомжир шууд болон шууд бусаар эрх зүйн чадвар, давуу эрх олгосон байдаг. Мөн энэ талаар зохицуулаагүй тохиолдол ч түгээмэл. Ийм тохиолдлын нэг жишээ нь *AS v. Iran-United States Claims Tribunal* хэрэг бөгөөд тус хэрэгт Нидерланд улсын шүүх Иран, АНУ-ын хооронд байгуулагдсан Иран-Америкийн Маргаан шийдвэрлэх трибунал (Iran-United States Claims Tribunal)-ын эрх зүйн байдлыг тодорхойлох шаардлагатай тулгарсан бөгөөд улмаар шүүх шийдвэртээ Трибуналы Нидерланд улсын эрх зүйд эрх зүйн бие даасан чадвар (шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч болж чадах) тай хэмээн үзсэн байна. Ингэхдээ Нидерланд улсын Гадаад хэргийн яамны шүүхэд гаргасан тайлбарыг удирдлага болгосон бөгөөд уг тайлбарт "Трибунал нь олон улсын эрх зүйн дагуух эрх зүйн баримт бичгээр байгуулагдсан холбогдох хоёр улсын хамтарсан байгууллага бөгөөд олон улсын эрх зүйгээс үндэлтэй эрх зүйн чадвартай этгээд болно" хэмээн заасан байна.¹²

Зарим олон улсын шүүх, трибунал нь томоохон олон улсын байгууллагын бүрэлдэхүүнд хамаардаг бөгөөд тухайн олон улсын байгууллагын

баримт бичгээр эрх зүйн статус нь тодорхойлögддог.¹³ Дээр дурдсанас хараад олон улсын трибуналын олон улсын эрх зүйн субъект болох асуудал нь засгийн газар хоорондын олон улсын байгууллагатай харьцуулахад тодорхой биш.

В. Олон улсын төрийн корпораци (international public corporation). Олон улсын төрийн корпораци буюу засгийн газар хоорондын компани, консорциум нь засгийн газар хоорондын байгууллага болон олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хувийн корпораци хоорондын дундын шинжтэй этгээд юм.¹⁴ Засгийн тэзэр хоорондын байгууллагын нэгэн адил улс болон улсын эрх бүхий байгууллагудаас байгуулдаг бөгөөд өөрийн дотоод бүтцийн нэгж, байгууллагатай. Ялгаа нь зайлшгүй ашигийн төлөө биш боловч ерөнхийдөө арилжааны зорилготой байдаг. Мөн энэ төрлийн байгууллагын байгуулах талаар олон улсын гэрээнд заасан байдаг ч аль нэг улсын компанийн эрх зүйн дагуу байгуулагддаг. Тухайлбал, EUROFIMA (European Company for the Financing of Railway Rolling Stock)-ыг байгуулах талаар Европын улсуудын хоорондох 1955 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн гарээнд заасан бөгөөд улмаар Швейцарын эрх зүйн дагуу компанийн хэлбэрээр байгуулсан байна.¹⁵ Олон улсын төрийн корпорацийг дотоодын эрх зүйгээр байгуулдаг, хуулийн этгээдийн чадвар, чадамжтай эсэх нь мөн дотоодын эрх зүйгээр тодорхойлögддог нь олон улсын эрх зүйн дагуу олон улсын эрх зүйн баримт бичгээр байгуулагддаг засгийн газар хоорондын байгууллагаас ялгах Үндсэн шинж юм.

Г. Үндэстэн дамнасан корпораци (*transnational or multinational corporation*). Зарим тохиолдолд олон

¹¹ Дэлхийн Метеорологийн байгууллага (World Meteorological Organization), Дэлхийн Аялал жуулчлалын байгууллага (World Tourism Organization), Олон улсын Иргэний хамгаалалын байгууллага (International Civil Defense Organization), Олон улсын Хөгжлийн эрх зүйн хурzzын (International Development Law Institute). Олон улсын худалдааны мэдээлэл хамтын ажиллагчны агентлаг (Agency for International Trade Information and Cooperation) заргыг байгууллага ийм замаар өөрчлөн байгуулдсан байна. Энэ талаар Henry G Schermer, Niels M Blokker, *International Institutional Law: Unity within Diversity* (Fifth Revised Edition), Martinus Nijhoff Publishers 2011 р 39-аас үзүүлүү.

¹² *Netherlands Yearbook of International Law* (1984), No. 15, p.356.

¹³ Уүний нэг жишээ нь Олон улсын шүүх (International Court of Justice) юм.

¹⁴ August Rehnisch, *International Organizations before Domestic Courts*, Cambridge University Press 2004, p.10.

¹⁵ Ibid

үндэстний корпораци гэж нэрлэдэг. Энэ нь тодорхой улсын дотоодын эрх зүйгээр байгуулагдсан боловч нэгзэс дээш улсын нутаг дэвсгэрт охин, хараат компани, хамаарал бүхий этгээдээрээ дамжуулан үйл ажиллагаа явуулдаг бизнесийн нэгдэл юм. Зарим үндэстэн дамнасан корпорацид дотоодын шүүхийн харьялалд үл хамаарах дархан эрх олгож байсан тохиолдол байдаг¹⁶ ч энэ нь нийтлэг биш. Иймээс үндэстэн дамнасан корпораци нь олон улсын байгууллагын чиглэлийн судалгаанд үндсэндээ хамааралгүй юм.

Харин анх 2002 оноос НҮБ-ын Олон улсын эрх зүйн комиссоос боловсруулж, 2011 онд 63 дахь хуралдаанаараа баталсан (Ерөнхий Ассамблейгаас хараахан эцэслэн батлагдаагүй байна) "Олон улсын байгууллагын хариуцлагын тухай баримт бичиг (Draft Articles on Responsibility of International Organizations)"-т өмнөхөөс өөр хандлага (дээр дурдсан Венин конвенциудын тодорхойллын эргэж харсан)-ыг баримталсан. Тодруулбал энэ үес олон улсын байгууллагын тодорхойллыг нарийвчлан авч үзэх бодит шаардлага байгааг олон улсын эрх зүйн баримт бичиг боловсруулагчид анхааралдаа авсан байна. Тус баримт бичгийн 2 дугаар зүйлийн 2(a) хэсэгт зааснаар "олон улсын байгууллага гэж олон улсын гэрээ эсхүл олон улсын эрх зүйн бусад баримт бичгийн дагуу байгуулагсан олон улсын эрх зүйн этгээдийн чадвар (international legal personality) бүхий этгээдийг хэлэх ба гишүүнчлэлд нь улсаас гадна өөр бусад этгээд байж болно".¹⁷ Энэ тодорхойллын дагуу аливаа байгууллагыг олон улсын байгууллага

гэж үзэхэд дараах урьдаач нөхцөл тавигдж байна. Үүнд:

а) Олон улсын гэрээ болон олон улсын эрх зүйн бусад баримт бичгийн дагуу байгуулагдсан байх;

б) Олон улсын эрх зүйн дагуу эрх эзэлж, үүрэг хүлээх чадвартай байх (олон улсын эрх зүйн бие даасан этгээдийн чадвар бүхий).

Энэ тодорхойллыг Олон улсын эрх зүйн комисс олон улсын байгууллагын хариуцлагын хил хязгаарыг тогтоох ажлын хүрээнд өгсөн нь олон улсын байгууллага эрх зүйн бие даасан этгээдийн чадвартай хэмээн хүлээн зөвшөөрөгдхөх нь байгууллагын болон гишүүний хариуцлагыг зааглах явдал¹⁸ гэсэн санааг давхар агуулдаг.

Олон улсын байгууллагын олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүй дэх эрх зүйн статусын асуудал зөвхөн олон улсын эрх зүй судлалын хүрээний онолын маргааны зүйл бус практикт шийдвэрлэх шаардлагатай асуудал болох нь ийм нөхцөл байдал шүүд болон шууд бусаар үндэсний болон олон улсын шүүхэд тулгарч байгаагаар нотлогддог. Тухайлбал, энд Ойрхи Дорнодод 1949 онд НҮБ-аас томилогдсон эвлэрүүлэн зуучлагч үргээ гүйцэтгэж явахдаа алагдсаны улмаас НҮБ тухайн улсын зэрэг нэхэмжлэл гаргаж болох эсэх (энэ асуудлаар гаргасан НҮБ-ын Олон улсын шүүхийн зөвлөх дүгнэлтийн талаар хойно өгүүлэх болно). 1989 онд International Tin Council төлбөрийн чадвартай байдалд орж дампуурахад (*Macalpine Watson Co.Ltd v. International Tin Council*) Английн шүүх түүний гишүүн улсын хүлээх хариуцлагыг ямар хэмжээнд тогтоох асуудалтай тулгарсан.¹⁹

Олон улсын байгууллагын эрх зүйн байдал нь олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүйд нэг түвшний ойлголт

¹⁶ First report on responsibility of international organizations by Mr. Giorgio Gaja, Special Rapporteur, 26 March 2003, UN DOCUMENT A/CN.4/532. Available at http://legal.un.org/c/documentaion/english/a_cn4_532.pdf.

¹⁷ Fleur Johns, *International Legal Personality*, Ashgate Publishing 2010, p.3

биш бөгөөд энэ 2 асуудлыг тусад нь авч үзэх шаардлагатай.

III. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

1. Олон улсын эрх зүйн жишээн дээр тайлбарлах нь

19 дүгээр зууны сүүл, 20 дугаар зууны эхэн хүртэл олон улсын эрх зүйн цорын ганц хүлээн зөвшөөрөгжсөн субъектыг улс гэж үзэх туйлын бүрэн эрхт байдлын үзэл санаа олон улсын эрх зүйд зонхиулж байжээ. Тэгвэл олон улсын байгууллага олон улсын харилцаанд гарч ирснээс энэ үзэл санаа вөрчлөгдхөж болсон байна.

Олон улсын эрх зүйд *subject of international law* гэх ойлголтын зарэгцээ *international legal person*²⁰, *international legal personality* гэх нэр томъёог хэрэглэгддаг. *International legal person*, *subject of international law* гасэн хоёр нэр томъёо зэлжлэн хэрэглэгддэг²¹, ижил агуулга бүхий ойлголт юм. Ингэхдээ эхнийх нь удаахыгаа бодвол төдийлэн их хэрэглэгддэггүй. Харин *international legal personality* гэх ойлголт нь олон улсын эрх зүйн субъектүүдийг тодорхойлоход хэрэглэгддэг боловч эдүгээ олон улсын эрх зүйн дагуу үүссэн (үүсмэл) нэгдэл болох олон улсын байгууллагын олон улсын эрх зүйн харилцаанд ямар байдалтайгаар оролцох (гишуудээсээ тусдаа эрх зүйн бие даасан этгээд болох эсэх) тухайд ихэвчлэн хэрэглэж байгаа нь ажиглалтадаг. *International legal personality* нь олон улсын эрх зүйн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээн чадварыг хэлдэг²² бөгөөд энэ нь олон улсын эрх

зүйн субъектэд тавигдах урьдчилсан нэхцэл юм. Энэ ойлголтыг монгол хэлнээс "олон улсын хуулийн этгээдийн чадвар бүхий байдал" гэхээсээ олон улсын эрх зүйн онцлогийг харгалzan "олон улсын эрх зүйн бие даасан этгээдийн чадвар бүхий байдал" хэмээн буулгах нь илүү ойлгомжтой болов уу.

Олон улсын байгууллага олон улсын эрх зүйн субъект буюу олон улсын эрх зүйн бие даасан этгээд болох асуудал бүрэн эрхт улстай олон улсын эрх зүйн харилцаанд ижил байр суурь эзэлнэ гэсэн үг биши юм. Олон улсын байгууллага нь тодорхой чиг үүрэг гүйцэтгэх зорилгоор байгууллагдаг учраас нийтэг эрх хэмжээг хэрэгжүүлдэг улсаас ялгаатай юм. Улс нь нутаг дэвсгэр, хүн ам, бүрэн эрхт засгийн газар (тер)-тай байх шаардлагыг хангаж байж олон улсын эрх зүйн субъект болдогтой адил шалгуурыг олон улсын байгууллагад тавих боломжгүй. Энэ шалтгаанаар эхний зэлжинд олон улсын байгууллага олон улсын эрх зүйн дагуу олон улсын эрх зүйн бие даасан этгээд болох эсэх асуудал чухалд тавигдана. Энэ утгаараа олон улсын харилцаан дахь олон улсын байгууллагын ач холбогдол нь түүний олон улсын эрх зүйн этгээд болох асуудалд тусгалаа олдог. Өөрөөр хэлбэл олон улсын байгууллагын олон улсын тавцанд үйл ажиллагаа явуулах чадвар нь түүний гишүүн улсуудаас тусдаа яригдах асуудал юм. Эндээс дараах асуудал урган гарна. Үүнд:

1. Олон улсын байгууллага гишуудээсээ тусдаа эрх зүйн субъектын чадвартай юу;

2. Хэрвээ тийм бол үүнийг хэзээ, хэрхэн олж авах вэ;

3. Гишуудээсээ тусдаа эрх зүйн субъектын чадвар нь ямар үр дагавар үүсгэх вэ.

Олон улсын байгууллагыг олон улсын эрх зүйн субъект гэж үзэхэд түүнд ийнхүү эрх зүйн статус олгосон дүрэм (үсгээн байгуулах баримт бичиг)-ийн заалтыг гол эх сурвалж гэж үздэг. Ийм заалт нь гишүүн улсад

²⁰ International legal person (лат *persona iure gentium*) гэх нэр томъёог анх Германы эрдэмтэн Готтфред Вильгельм Лейбниц *Codex Iuri Gentium diplomaticus* (1693) бүтээгдээ хэрэгжээ. Энэ талаар Verzijl, Jan Hendrik Willem. *International law in historical perspective* (1888). Volume II International persons, p 2-ас үзэх үү.

²¹ Henry G Schermers, Niels M. Blokker, *International Institutional Law: Unity within Diversity* (Fifth Revised Edition), p 985

²² C.F.Amerasinghe, *Principles of the institutional law of international organizations* (Second Revised Edition), Cambridge University Press 2005, p.1; Henry G.Schermers, Niels M. Blokker, *International Institutional Law: Unity within Diversity* (Fifth Revised Edition), p 985

тухайн олон улсын байгууллагыг эрх зүйн бие даасан этгээд хэмээн хүлээн зөвшөөрөхийг үүрэг болгодог. Энэ нь гишүүн бус улсын хувьд тухайн олон улсын байгууллагын статусыг тогтооход хэрэглэгдэх боломжтой бөгөөд тухайн байгууллагын олон улсын шинжтэй үүрэг гүйцэтгэх чадвартай эсэхийг тодорхойлоход дүрмийн ойлгомжтой тодорхой заалт ач холбогдолтой байж болно. Гэхдээ 1990-ээд оноос өмнө ийнхүү илт тодорхой байдлаар ихэнх олон улсын байгууллагад олон улсын эрх зүйн бие даасан этгээдийн статус олгосон заалт үүсгэн байгуулах баримт бичигт үүгэлзэгдэг байсан бол 1990 оноос хойш энэ байдал өмнөх үетэйгээ харьцуулахад арай нийтлэг шинж чанартай болоод байна.²³ Нөгөө талаас олон улсын байгууллагын дүрэмд зэрэгээрээ заах тохиолдолд ч бас байна. Жишигэлбэл 2010 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Герман, Бельги, Франц, Люксембург, Нидерланд, Швейцарь улсуудын хооронд байгуулагсан "Europe Central" агаарын орон зайн чиглэлээр хамтран ажиллах байгууллага байгуулах тухай гэрээний 2.2 дугаар зүйлд: "энэ гэрээ нь олон улсын эрх зүйн харицаанд бие даан оролцох чадвар бүхий (international legal personality) олон улсын байгууллага байгуулах зорилго агуулаагүй болно" хэмээн заасан байна.²⁴

Ихэнх олон улсын байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт олон улсын эрх зүйн дагуух тухайн байгууллагын эрх зүйн статусын талаарх заалт байдаггүй. НҮБ нь үүний нэг жишиг юм. Тодруулбал НҮБ-ын дүрэмд энэ талаар илт тодорхой заагаагүй байдаг.

Дээрх нөхцөл байдал нь олон улсын байгууллагын олон улсын эрх

²³ Дэлхийн Худалдааны Байгууллагыг байгуулах тухай Марракешийн хэлэлцэр (1994)-ийн VIII зүйл: Олон улсын худалдааны танхим (International Chamber of Commerce)-ын дүрэм (1998)-ийн 4.1 дүгээр зүйл; Дэлхийн Усны Түншлэлийн сүлжээ болон Дэлхийн Усны Түншлэлийн Байгууллагын дүрэм (2001)-ийн 1.3 дугаар зүйл зргийн энд дурдаж болох юм.

²⁴ www.fabectreaty.tv/downloads/FABEC_Treaty_English_version.pdf. Last visited on 27 April 2015.

зүйн бие даасан этгээдийн чадвартай эсэх талаарх маргааныг эрчимжүүлдэг. Одоогоор олон улсын эрх зүйд энэ талаар номлодог гурван үндсэн хандлага байна.

Эхнийх нь ийм чадвар зөвхөн байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт заасан тохиолдолд л боломжтой гэж үздэг. Гол төлөөлгэгчид байдаг бөгөөд өнөөдөр энэ хандлагыг дэмжих нь бағассан байна. Энэ хандлагын үүднээс авч үзвэл тухайн байгууллагын үүсгэн байгуулах баримт бичиг буюу дүрэмд заагаагүй бол тухайн байгууллага эрх зүйн бие даасан этгээд болохгүй бөгөөд гишүүн бус улсад ч ингэж тооцогддогтуйгээрээ дор өгүүлэх хандлагуудаас сүл талтай. Нөгөө талаас дүрэмд шууд заагаагүй ч дүрэмд заасан байгууллагын эрх мэдэл, эрх, үүргээс тухайн байгууллагыг олон улсын эрх зүйн бие даасан этгээдийн чадвартай хэмээн тодорхойлж болно гэж үздэг.²⁵ Энэ нь байгууллагаад ямар эрх олгож, үүрэг хүлээлгэснийг тодорхойлсны үндсэн дээр тогтоогдох юм. Уг хандлага нь бүхэлдээ гишүүдийн хүсэл зоригоos хамаарах шинжтэй.

Хоёрдахь хандлага нь олон улсын байгууллагын эрх зүйн объектив бие даасан байдал (objective legal personality)-ын үзэл санааг хөгжүүлсэн. Гол төлөөлгэгчид F. Seyersted юм. Олон улсын байгууллага нь үүсгэн байгуулсан гишүүдээсээ тусдаа доод тал нь нэг дотоод бүтцийн нэгж (organ)-тэй бол тухайн байгууллага нь олон улсын эрх зүйн бие даасан этгээд болно гэж үздэг.²⁶ Энэ утгаараа эрх зүйн бие даасан этгээд зорилт нь гишүүдийн (субъектив) хүсэл зоригоos үл хамааран "объектив" байдлаар оршино гэсэн уг юм. Энэ

²⁵ G.I. Tunkin, *Legal Nature of the United Nations* (1966), pp 20-25

²⁶ Manual Rama-Montalbo, *International Legal Personality and Implied Powers of International Organizations*, 44 Brt. Y.B. Int'l L. 111 (1970)

²⁷ F. Seyersted-ын *Objective International Personality of Intergovernmental Organizations*(1964); *The Legal Nature of International Organizations* (1982); *Common Law of International Organizations* (2008) бүтээлүүдэд энэ асуудлыг явч үзсэн.

хандлагын дагуу эрх зүйн статусыг талуудын хүсэл зориг бус олон улсын эрх зүйгээр олгодог бөгөөд эрх зүйгээр тогтоосон тодорхой объектив шаардлагуудыг хангасан тохиолдолд тухайн байгууллага нь олон улсын эрх зүйн субъектийн чадвартайд тооцогдоно гэж үздэг. Энэ хүрээнд судлаачид олон улсын байгууллагад тодорхой шалгууруудыг дэвшүүлэн тависан байдаг. Дурдвал, профессор Ian Brownlie нь 1. зохион байгуулалтын нэгжүүд бүхий хууль ёсны зорилготой улсуудын тогтвортой нэгдэл байх; 2. байгууллага нь гишүүн улсуудаасаа эрх зүйн хувьд эрх, үүрэг, зорилго тусдаа байх; 3. нэг буюу түүнээс дээш улсын үндэсний эрх зүйн тогтолцоонд бус олон улсын хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой хууль ёсны эрх мэдэлтэй байх байх²⁸ гэсэн 3 үндсэн шалгуурыг боловсруулсан бол Dapo Akande олон улсын байгууллага нь 1. улс болон олон улсын байгууллагын нэгдэл байх; 2. өөрийн гэсэн чиг үүрэг, эрх мэдэл олгогдсон байх; 3. байгууллагын хүсэл зоригийг гишүүдээс бие даан илэрхийлэх хамгийн багадаа нэг дотоод бүтцийн нэгж (organ)-тай байх²⁹ гэсэн 3 нехцэлийг хангасан байвал зохино хэмээн тэмдэглэсэн байна. Мэн Henry G. Schermers, Niels M. Blokker нар олон улсын байгууллагад олон улсын гэрээгээр байгуулагдсан байх; доод тал нь байгууллагын хүсэл зоригийг илэрхийлэх нэг дотоод бүтцийн байгууллага (organ)-тай байх; олон улсын эрх зүйн дагуу байгуулагдсан байх³⁰; Rudolf Bindschedler олон улсын гэрээгээр байгуулагдсан байх, дотоод бүтцийн байгууллагатай, нийтлэг (ихэнх тохиолдолд нийтийн) ашиг сонирхлыг хэрэгжүүлэх эрх олгогдсон

байх³¹; August Reinisch олон улсын гэрээгээр байгуулагдсан байх (олон улсын байгууллагыг үүсгэн байгуулах гэрээ нь конвенц харт, дүрэм зэрэг янз бурийн нэртэй байдгаас гадна гишүүн улсуудын эрх бүхий байгууллагын шийдвэр, улсуудын хооронд зохион байгуулагдсан бага хурлын тогтоол зэрэг баримт бичгээр байгуулагдсан тохиолдол байгааг судлаач бүтээлдээ дурдсан байна³²), тухайн байгууллагасаас тусгайлан эрх олгосон байх, нийтийн зорилготой байх³³; Pastor Ridruejo улс хоорондын, сайн дурын, тогтвортой бүтцийн байгууллагатай байх, бие даасан хүсэл зоригтой байх, өөрийн гэсэн эрх хэмжээтэй байх, нийтлэг ашиг сонирхлыг хангах зорилго бүхий гишүүдийн хоорондын хамтын ажиллагаатай байх³⁴ гэсэн үндсэн элементүүд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн байна.

Гуравдах хандлага нь олон улсын байгууллага гишүүдээсээ тусдаа доод тал нь нэг дотоод бүтцийн байгууллагатай байх болон дүрэмдээ олон улсын эрх зүйн бие даасан этгээд болох талаар зааснаас үл хамааран олон улсын эрх зүйн бие даасан этгээд байна. Хэрвээ байгууллага нь олон улсын гэрээ байгуулах, төлөөлгөч

²⁸ Rudolf Bindschedler, *International Organizations. General Aspects*, in Rudolf Bernhardi (ed.), *Encyclopedia of Public International Law* (Second edition, 1995), Vol.II, p.1289

²⁹ Nordic Council буюу Скандинавын орнуудын зөвлөл нь гишүүн улс тус бүрийн парламентын шийдвэрээр байгуулагдсан бөгөөд энэ олон улсын гэрээ байгуулак эрх бүхий төрийн таргун, засгийн газар орцлогуулж байна. Энэ байгууллагыг засгийн газар хоорондын байгууллага гаж үзэгдгүй болох олон улсын хэмжээнд тодорхой үйл ажиллагаа явуулах боломжтой байж болох талаар зарим судлаач улсын банкаа Өөрөөр хэлбэл олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж чадах эсэх олон улсын гэрээгээр байгуулагдсанасаас заншгүй хамаарах шинжгүй гэсэн уг юм. Мэн Сотвел (Здийн засгийн хариуцан туслаалцаа зөвлөл /Council for Mutual Economic Assistance/ наарээр 1949 онд байгуулагдсан 1991 онос Олон улсын здийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /Organization for International Economic Cooperation/ гэж наригдсан болсон) нь Зөвлөлт Холбоот Улс, Чехословак, Унгар, Польш, Румин улсуудын здийн зохион байгуулагдсан бага хурлын тогтооюлоор байгуулагдсан.

³⁰ August Reinisch, *International Organizations before Domestic Courts*, Cambridge University Press 2004, p.10

³¹ Finn Seyersted, *Common Law of International Organizations*, Martinus Nijhoff Publishers 2008, p.8-авс дам иштэв

²⁸ Ian Brownlie, *Principles of Public International Law* (Fourth Edition), Oxford University Press 1990, p.679

²⁹ Dapo Akande, *International Organizations* at Malcolm D Evans (ed.), *International Law* (Third Edition), Oxford University Press 2010, pp. 681-682

³⁰ Henry G Schermers, Niels M. Blokker, *International Institutional Law. Unity within Diversity* (Fifth Revised Edition), p.20

солилцох, олон улсын цэргийн хүчин хөдөлгөх эрх олгогдсон юм бол олон улсын эрх зүйн бие даасан этгээдийн статусгүйгээр байгууллага ийм эрх мэдэл хэрэгжүүлж боломжгүй гэж үздэг.

Дотоодын эрх зүйн жишээн дээр тайлбарлах нь

Олон улсын бус харилцаан дахь эрх зүйн байдал, чадвар нь өөрөө асуудал бөгөөд дотоодын эрх зүйн тогтолцоо нь олон улсын байгууллага тухайн эрх зүйн тогтолцоонд эрх зүйн чадвартай эсэхийг тодорхойлох текник, арга зүйтэй байдаг.³⁵ Хэрэглэх техник, арга зүй нь олон улсын эрх зүй ба тухайн улсын дотоодын эрх зүйн харилцан хамаарлаас³⁶ хамаарах шинжтэйгээс гадна тухайн олон улсын байгууллагын гишүүн болон гишүүн бус улсын хооронд ялгаатай.

Олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцан хамаарлын талаарх монист чиг хандлагыг илүүтэй баримтлагад гишүүн улсад тухайн олон улсын байгууллагын дотоодын эрх зүйд эрх зүйн чадвартай эсэх нь энэ тухай заасан олон улсын гэрээний заалтаар тодорхойлогдоно. Жишээ нь 1966 оны *Manderlier v Organisation des Nations Unies & Etat Belge* хэрэгт АНУ, Белги улс НҮБ-ыг, 1949 оны *UNRRA v Daan* (1949) хэрэгт Нидерланд улс НҮБ-ыг, 1954 оны *Branno v Ministry of War* хэрэгт Итали улс НАТО-г ийнхүү үзсэн байна.³⁷

Харин ийм үүрэг бүхий олон улсын гэрээ нь эрх зүйн тогтолцооных нь бүрэлдэхүүн хэсэг болохгүй, өөрөөр хэлбэл олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцан хамаарлын дуалист

³⁵ C.F.Amerasinghe, *Principles of the institutional law of international organizations* (Second Revised Edition), Cambridge University Press 2005, p.69

³⁶ Олон улсын эрх зүйд олон улсын эрх зүй ба дотоодын эрх зүйн харилцаан хамаарлыг тодорхойлох монист, дуалист гэсэн 2 үндсэн арга зүй (хандлага) байдаг. Эдгээр хандлага нь тус бүртээ холимог монист, холимог дуалист гэх балдаар салбарлан хөгжлийг байна. Монист, дуалист хандлага нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг дотоодын эрх зүйд эрх зүйн эх сурвалжийн хувьд хэрхэн үзүүлж асуудлыг тодорхойлох суурин арга зүй учраас энд авч үзүүлж байгаа болно

³⁷ Dapo Akande, *International Organizations*, in Malcolm D.Evans (ed.), *International Law* (Third Edition), Oxford University Press 2010, p.277

хандлагатай гишүүн улсын хувьд энэ асуудлыг дотоодын эрх зүйд дотоодын эрх зүйн холбогдох баримт бичгээр трансформаци хийх шаардлагатай юм. Ийм жишээ нь Их Британи эзргийн тогтолцоо бүхий улсуудад хэрэглэгдэгдэг байна. Их Британийн Олон улсын байгууллагын тухай хууль (1968)-д тус улс гишүүн нь болох олон улсын байгууллагад Нууц Зөвлөлт (Privy Council, мөн Queen-in-Council гэж нэрлэдэг)-ийн шийдвэрээр дотоодын эрх зүйн чадвар олгоно гэж заасан байдаг.³⁸ Тухайлбал, JH Rayner (Mincing Lane) Ltd v Department of Trade and Industry -ийн хэрэгт Английн шүүх International Tin Council-ийг эрх зүйн этгээд болохыг тус байгууллагыг үүсгэн байгуулсан олон улсын гэрээгээр бус дотоодын хууль тогтоомжоор тодорхойлсон. Тус хэрэгт Lord Oliver: "Зөвлөлийн шийдвэрүүгийн International Tin Council нь Нэгдсэн Вант Улсад эрх зүйн хувьд орших боломжгүй."³⁹ гэж хэлсэн байдаг.

Гишүүн бус улсын зүгээс олон улсын байгууллагыг дотоодын эрх зүйд эрх зүйн чадвартайд тооцох, хүлээн зөвшөөрөх ньдээр дурдсанас тогтвортой арга замаар явагддаг. Олон улсын хувийн эрх зүйд гадаадын эрх зүйгээр бий болсон (байгуулгадсан) байгууллагын эрх зүйн байдал, чадварыг ийнхүү бий болсон эрх зүйгээр нь буюу "хувийн хууль (personal law)"-аар нь тодорхойлдог зөрчилдөөний эрх зүйн аргыг хэрэглэдэг. Олон улсын байгууллага нь олон улсын эрх зүйгээр байгууллагдаг тул энэ дүрмийн дагуу түүний эрх зүйн байдал, чадварыг "хувийн хууль" болох олон улсын эрх зүйгээр тодорхойлох боломжтой. Жишээ нь International Tin Council v. Amalgament Inc-ийн хэрэгт Нью-

³⁸ Хуулийг <http://www.legislation.gov.uk/ukpga/1968-48/caihim> холбоосоор нэвтрүүлж узна уу. Мен тус хуульд измэлт болон нэхэвдээ заалт бүхий хуулийг 2005 онд баталсан байна (http://www.legislation.gov.uk/ukpga/2005/20/pdfs/ukpga_20050020_en.pdf). Сүүлд 2015 онд 04 дүгээр сарын 30-ны өдөр зөнчилсон.

³⁹ JH Rayner (Mincing Lane) Ltd v. Department of Trade and Industry (1989), in E. Lauterpach (ed.), *International Law Report* (1989)

Йоркийн хотын шүүх:

АНУ нь International Tin Council-ыг үүсгэн байгуулсан олон улсын гэрээний тал биш боловч уг гэрээгээр тус байгууллагад эрх зүйн чадвар олгосон нь дотоодын эрх зүйд мөн адил хүлээн зөвшвөрөгдөх учраас тус байгууллага нь Нью-Йорк хотын шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч болно.⁴⁰ Гэж үзсэн байна.

IV. ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ХАРИУЦЛАГЫН АСУУДАЛ

1. Олон улсын эрх зүйн жишээн дээр авч үзэх нь

Олон улсын байгууллагын олон улсын эрх зүйн субъект болох асуудал нь олон улсын байгууллага ямар хэмжээнд олон улсын эрх зүйн дагуу хүлээсэн үүргийнхээ зерчилд хариуцлага хүлээх вэ гэсэн олон улсын хариуцлагын асуудлыг нөхцөлдүүлдэг. Өөрөөр хэлбэл эрх зүйн байдал, хариуцлагын асуудал нь хоорондоо няйт холбоотой юм.

Олон улсын эрх зүйд олон улсын байгууллагын олон улсын эрх зүйн субъектийн чадвар болон хариуцлагын харилцан хамаарлыг 1949 онд Олон улсын шүүх зөвлөх дүгнэлт өгсөн *Reparation for the Injuries suffered in the service of the United Nations*-ын хэрэгт баталсан байна. Тус хэрэгт гол асуудал нь НҮБ олон улсын байгууллага болохынкоо хувьд олон улсын хэмжээнд нэхэмжлэл гаргах чадвартай эсэхийг тодорхойлох асуудал байсан тул шүүх энэ асуудлыг тодорхойлохыг тулд эхлээд гишүүн улсууд нь тухайн байгууллагад ийм эрх зүйн чадварыг олгосон эсэхийг тодруулахаас эхэлсэн бөгөөд НҮБ-ын дүрэмд нэхэмжлэл гаргах эрхийн талаар заагаагүй байна. Зөвлөх дүгнэлтдээ шүүх "олон улсын хамтын нийгмэлэгийн олонхи гишүүдийг төлөөлж байгаа (тухайн үед НҮБ нь 50 гишүүн улстай байсан)-ийн хувьд олон улсын эрх зүйн дагуу объектив олон улсын эрх зүйн чадвартай тооцогдох бөгөөд дан

ганц ийм чадвартай тооцогдоод зогсохгүй олон улсын хэмжээнд нэхэмжлэл гаргах чадвартай" гэж үзжээ.⁴¹ Энэ нь нөгөө талаас хэрвээ нэхэмжлэл гаргах чадвартай юм бол өөрийн үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг гуравдагч этгээдний эмнэ хариуцаах, шүүхэд хариуцагчар татагдах боломжтой гэсэн уг юм.⁴² Мен шүүх тус хэрэгт дараах дүгнэлтийг хийсэн нь олон улсын байгууллагыг олон улсын эрх зүйн субъект гэж үзэх асуудлыг шинэ шатанд гаргасан юм. Үүнд:

Аливаа эрх зүйн тогтолцооны эрх зүйн субъектүүд нь шинж, эрхийн хэмжээгээрээ адил байх шаардлагагүй бөгөөд эрх зүйн субъектийн шинж нь тухайн нийгмийн хэрэгцээ шаардлагаас үүдэн гардаг. Түүхийн туршид олон улсын амьдралын хэрэгцээ шаардлага нь олон улсын эрх зүйн хөгжилд нөлөөлж ирсэн бөгөөд улсуудын хамтын үйл ажиллагааны дэвшил нь улс биш этгээдүүд олон улсын тавцанд гарч ирэхэд хүргэсэн юм. Энэ хөгжил нь Нэгдсэн Үндэстний дүрэмд заасан тодорхой зорилго, зарчим бүхий олон улсын байгууллага 1945 оны 6 дугаар сард байгуулгадсанаар биеллээ олсон. Зорилгоо биелүүлэхийн тулд олон улсын эрх зүйн субъектийн чадвартай байх нь зайлшгүй. Гэхдээ ийм статус олгож байгаа нь НҮБ-ийг улстай адилхан зүйл гэж үзэх байгаа юм уу улстай ижил эрх эдэлж, үүрэг хүлээн, ижил эрх зүйн статустай байна гэсэн уг биш. Харин энэ нь олон улсын эрх зүйн субъект болж, олон улсын эрх зүйн дагуу тодорхой эрх эдэлж, үүрэг хүлээн чадвартай гэдгийг илэрхийлж байгаа хэрэг юм.⁴³

⁴⁰ ICJ Advisory opinion on Reparation for Injuries Suffered in the Service of the United Nations(1949), p.185. Available at <http://www.icj-cij.org/docet/index.php?r1=3&r2=4&page=4&p3=4>

⁴¹ Энэ талаар Sir Michael Wood, Maria Vicien-Milburn, Legal Responsibility of International Organizations in International Law (Summary of the International Law Discussion Group meeting held at Chatham House on Thursday, 10 Feb 2011), p 2 –аас үзүү.

⁴² ICJ Advisory opinion on Reparation for Injuries Suffered in the Service of the United Nations, 11 April 1949, p.179. Available at <http://www.icj-cij.org/docet/index.php?r1=3&r2=4&page=4&p3=4>

⁴⁰ International Tin Council v Amalgamated Inc., 524 NYS 2d (1988), p. 971

Гэхдээ 1980-аад оны дунд үеэс олон улсын байгууллагын хариуцлагатай холбоотой асуудлын тоо нэмэгдэж дараах 3 асуудалт анхааралт хандуулах шаардлагатай болсон байна. Нэгдүгээрт, олон улсын байгууллага хариуцлага хүлээх нөхцөл түүний гишүүн улсууд мөн адил хариуцлага хүлээх ўу? Гэхдээ зарчмын хувьд байгууллагын хариуцвал зохих ўйл ажиллагаа нь гишүүн улсын бус байгууллагын асуудал байна. Хоёрдугаарт, байгууллага хариуцлага хүлээж байгаа бол зардлаа гишүүн улсуудаараа төлүүлж болох ўу? Үнтэй хамааралтай асуудал нь байгууллага өрөө төлөхөд хангалттай санхүүгийн эх үүсвэргүй бол гишүүн улсуудынхаа тусламжид найдж болох эсэх асуудал юм. Гишүүд нь зээлдүүлэгчид өрийг шуд төлөх үүрэг хүлэхгүй ч өрөө төлөхөд шаардлагатай санхүүжилтээр байгууллагын хангаж болно. Энэ нь байгууллагын хариуцлагын асуудалт түүний гишүүн улсын гүйцэтгэх үүрэг чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ байгууллагын бие даасан эрх зүйн байдлын үүднээс нэгэн зэрэг байгууллагын хариуцлагатай зэрэгцэн улсын хариуцлага байх боломжгүй. Гуравдугаарт, зээлдүүлэгч өрөө байгууллагаар төлөөлүүлж чадахгүй тохиолдолд (санхүүжилт зогссон, гишүүд нь байгууллага хариуцлагагаа бүрэн хүлээхэд хангалттай санхүүжилт олгоогүй) тэрээр гишүүн улсуудаар төлүүлэхээр нэхэмжлэл гаргаж болох ўу? Энэ асуултад тийм гэж хариулбал гишүүн улсад хохиролтой бөгөөд байгууллагын бие даасан эрх зүйн байдалт асуудал үүсэх юм. Харин угийг гэх хариулбал гуравдагч этгээд болох зээлдүүлэгч хохироход хүрэх ба гишүүн улс нь байгууллагын халхавчны цаана хамгаалагдана.⁴⁴

Эдгээр асуудал олон улсын шүүхийн практикт тохиолдсныг товчхон авч үзье.

⁴⁴ Henry G.Schermer, Niels M. Blokker, *International Institutional Law: Unity within Diversity* (Fifth Revised Edition), pp. 1010-1011

Тухайлбал, 1999 онд НАТО (North Atlantic Treaty Organization)-ын явуулсан цэргийн ўйл ажиллагааны нь хариуд Бүгд Найрамдах Югослав улс тус цэргийн ажиллагааг хууль бус гэж үзэж НАТО-ын 10 гишүүн улсын эсрэг нэхэмжлэлийг Олон улсын шүүхэд гаргажээ. Тэрээр НАТО-ын цэргийн ажиллагааг түүний гишүүн улсууд хамтран эсхүл тус тусдаа хариуцах ёстой гэж үзсэн байна. Угтаа тус цэргийн ажиллагааг явуулах шийдвэрийг НАТО-ын шийдвэр гаргах гол байгууллага болох Хойд Атлантын Зөвлөл гаргасан. Эндээс НАТО нь цэргийн ажиллагаа явуулах эрх мэдэлтэй, чадвартай хөрнээ түүнээс үүсэн гарах үр дагаврыг хариуцах чадваргүй юу гэсэн асуулт гарсан. Гэхдээ энэ хэргийг Олон улсын шүүх өөрийн харьяалын маргаан биш гэж үзсэн байна.⁴⁵

Арабын Нэгдсэн Эмират, Саудын Араб, Катар, Египет зэрэг улсууд зэвсгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор Arab Organization for Industrialization гэх байгууллагыг байгуулжээ. Тусбайгууллагын Westland Helicopters Ltd компанитай Arab British Helicopters Company гэх хамтарсан компани байгуулахаар хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулжээ. Энэ гэрээнд талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд Олон улсын худалдааны танхимын дэргэдэх арбитаар маргаанаа шийдвэрлүүлэх тухай арбитрын заалт оруулсан байна. 1979 онд Израйл, Египет улсуудын хоорондох энхийн гэрээ дусгавар болсондой холбогдуулан Arab Organization for Industrialization ўйл ажиллагаагаа зогсоосон байна. Үүнийг Westland Helicopters Ltd компани эсэргүүцэж гишүүн улсууд, Arab Organization for Industrialization, Arab British Helicopters Company-аас 126 000 000 фунт стерлинг нэхэмжилж

⁴⁵ ICI Preliminary Objection on the Case Concerning Legality of Use of Force (Serbia and Montenegro v. Canada), 15 December 2004. Available at <http://www.icj-cij.org/docs/ci/files/106/8454.pdf>.

арбитрт маргаан үүсгэжээ.⁴⁶ Арбитрын бүрэлдэхүүн Arab Organization for Industrialization-ийг эрх зүйн хувьд бие даасан статустай гэж үзсэн ч байгууллагын үүсгэн байгуулах баримт бичигт гишүүн улсыг байгууллагын өмнөөс хариуцлага хүлээлгэхгүй байх талаар заасан заалт байхгүй байгаа нь эрх зүйн ерөнхий зарчмын дагуу гишүүн улсууд хариуцлага хүлээх үндэслэл болно хэмээн дүгнэсэн байна. Энэ талаар шийдвэртээ:

Arab Organization for Industrialization-ын өөрийн нэрээр байгуулсан арбитрын заалтыг 4 улс заавал дагаж мөрдөх ёстой эсэх нь эдэээр 4 улстус байгууллагын хүлээсэн үргийн ерөнхийдөө биелүүлэх ёстой юугэсэн материалыг асуулттай утга дүйх юм. Хэрэвээ хувьцаа эзэмшигчдийн гэрээгээр хүлээсэн материалыг эрх зүйн дагуух үүрэг нь байгууллагын төдийгүй 4 гишүүн улсын үүрэг юм бол, гэрээгээр хүлээсэн үүрэгтэй холбоотойгоор батлан хамгаалах ўл ажиллагаа явуулах чадвар нь мөн адил хөёуланд нь салшгүй шинжтэй гэвэл 4 улс арбитрын заалтыг дагаж мөрдэх нь зашыгч. Арбитрын заалтын заавал биелэгдэх хучин чадлыг гэрээгээр хүлээсэн материалыг эрх зүйн үүрэг амлалтаас салган ойлгох боломжгүй.⁴⁷

гэж дурдсан байна.

International Tin Council нь Их Британид төвтэй байгууллага байсан бөгөөд Их Британи тэргүүтэй 23 улс, Европын Эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хооронд байгуулдагсан 6 дахь удаагийн Олон улсын Тугалганы гэрээ (The Sixth International Tin Agreement ("I.T.A.6")-ээр тус байгууллагын эрх зүйн байдлыг тодорхойлсон. Гэрээний 16 дугаар зүйлд "Зөвлөл нь эрх зүйн бие даасан байдал (legal personality)-тай, тэр тусмаа гэрээ байгуулах, хедлэх, үл

* Bernard Hanotau, *The Issue of Non-Signatory States*, in the American Review of International Arbitration 2012/Vol. 23 Nos. 3-4, pp. 384-385

** ICC interim award of March 5, 1984 in case No. 3879, XI YB. COM ARB 127 (1986)

хедлех эд хөрөнгө олж авах, эрх зүйн процессын ажиллагаа үүсгэх(шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч болох) чадвартай" гэж заажээ.⁴⁸ Уг гэрээ нь тугалганы олон улсын зах зээлийн үнийг хэт хөөрөлтөөс урьдчилан сэргийлэх зорилготой байсан бөгөөд ийнхүү үнэ зохицуулах үндсэн механизмын нь гишүүн улсуудаас оруулж байгаа хөрөнгө оруулалт, банкнаас олгож байгаа зээлээр санхүүждэг "буфер хувьцаа"-г тогтвортжуулах явдал байжээ.⁴⁹ 1980-аад оны турш тугалганы үнэ олон улсын зах зээлд унасантай холбоотойгоор 1985 оны 10 дугаар сарын 24-ний өдөр International Tin Council-д шаардлагатай санхүүгийн эх үүсвэр хомтостоос Лондонгийн Металын биржид тогтвортжуулах үйл ажиллагаагаа явуулахаа түр хойшлуулсан. Төлбөрийн нэхэмжлэл хийгдэх үед олон тооны банк, брокерт буфер хувьцааны есэн зуун сая фунт стерлингийн хохирол учирсан. Тэдэнд мөнгөө хэрхэн олж авах асуудал тулгарсан. Зээлдүүлэгчдийн талд арбитрын шийдвэр гарсан боловч гэрээний үйл ажиллагааг удирдан зохицуулж байсан тус Зөвлөл төлбөрийн чадваргүй байдалд орсны улмаас мөнгөө авах боломжгүй болсон.⁵⁰ Олон тооны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Их Британийн шүүх, бусад улсын шүүх болон Европын шүүхэд үүсгэсэн. Гэсэн хэдий ч Их Британиас бусад улсын шүүх, Европын шүүхэд хэргийг хэлэлцэгүй.⁵¹

Олон улсын байгууллагын хариуцлагын талаарх баримт бичиг

48 This agreement is available at https://treating-un.org/doc/Publication/IANTS/volume%2012/2/volume_12%20-%201139-English.pdf. Last visited on 2 May 2015.

** Andrew Stumer, *Liability of Member States for Acts of International Organizations: Reconsidering the Policy Objections*, Harvard International Law Review (2007) / Vol.48/ No.2, p. 559

50 Ibid.

** R. Higgins, *The legal consequences for member states of the non-fulfilment by international organizations of their obligations toward third parties (report)*, 66 Annuaire de l'Institut de Droit International (Session of Lisbonne, Vol. I, 1995), p. 393

2001 онд НҮБ-ын Олон улсын эрх зүйн комисс Улсын хариуцлагын тухай баримт бичиг (Responsibility of States for Internationally Wrongful Acts)-ыг боловсруулан гаргасан. Тус баримт бичгийн 57 дугаар зүйл "олон улсын байгууллагын үйл ажиллагаанд олон улсын байгууллага, улсын хүлэх олон улсын хариуцлагын аливаа асуудлыг хөндөхгүй"⁵² гэж заасан нь 2002 онд Олон улсын байгууллагын хариуцлагын талаарх баримт бичгийг боловсруулах ажлыг эхлүүлэх нэг шалтгаан болсон байж болох юм. Негеэ талаас олон улсын байгууллагын олон улсын эрх зүйн субъект болох асуудал улсынхтай адилгүй, улстай адил эрх, үүрэгтэй биш, ижил шалгуур тавих боломжгүй учраас улсын хариуцлагын хэм хэмжээг төстэй хэрэглэх нь хүндрэлтэй гэх нөхцөл байдлаас үүдсэн байж талтай. Ингэснээрээ тодорхой чиг үүрэг гүйцэтгэх зорилгоор байгууллагдаг олон улсын байгууллагыг нийтлэг эрх хэмжээ хэрэгжүүлдэг улаас ялгах зорилго бүхий тусгай байдлын зарчим (principle of speciality)-ыг чухалчилсан байна. Олон улсын байгууллагын хариуцлагын талаарх баримт бичгийн төсөлд тусгагдсан хариуцлагын талаарх гол зохицуулалтуудыг авч үзье.

Олон улсын байгууллагын олон улсын хариуцлага үүсэх нөхцөл. Олон улсын байгууллагын олон улсын хэмжээнд явуулсан хууль бус үйл ажиллагаа нь олон улсын хариуцлагыг бий болгоно.⁵³ Үүнд олон улсын эрх зүйн дагуу олон улсын байгууллагад хамаарч байгаа болон байгууллагын олон улсын үүргийн зөрчлийг үүсгэж байгаа үйлдэл, эс үйлдвүүгийг ойлгоно.⁵⁴ Энэ баримт бичигт олон улсын байгууллагын олон хэмжээний хууль бус үйл ажиллагаанаас үүдэн гарсан үр

дагаврыг ямар этгээд (ямар тохиолдолд олон улсын байгууллага өөрөө, ямар тохиолдолд улс) хариуцан арилгах талаар зохицуулснаас дотоодын эрх зүйн хүрээнд, олон улсын байгууллага болон түүний гишүүдийн хооронд, олон улсын байгууллага болон түүний албан тушаалтан, ажилтны хооронд үүссэн хариуцлагын харилцааг зохицуулаагүй.

Олон улсын байгууллагын бүтцэд хамаарах байгууллага, төлөөлөгчийн чиг үүргийнээз хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааг тухайн байгууллагын олон улсын эрх зүйн дагуух үйл ажиллагаа гэж үзнэ.⁵⁵ Энэ тухайд Олон улсын шүүх "НҮБ-ын төлөөлөгчийн үйл ажиллагаанаас учирсан хохирлыг НҮБ хариуцна"⁵⁶ гэж үзсэн зөвлөх дүгнэлт байdag. Олон улсын байгууллага нь улс, бусад олон улсын байгууллагыг тодорхой үйл ажиллагаа явуулахыг албадсан бол дараах тохиолдолд түүнээс үүдэн гарах үр дагаврыг хариуцна. Үүнд:

а) Улс, бусад олон улсын байгууллагыг албадсаны улмаастухайн олон улсын байгууллага олон улсын хэмжээнд хууль бус үйл ажиллагаа явуулсан;

б) Ийнхүү албадаж байгаагийнхаа үр дагаврыг (хууль бус болохыг) олон улсын байгууллага мэдэж байсан.

Олон улсын байгууллагын үйл ажиллагаатай холбоотойоор улсын хүлэх хариуцлага. Улс нь олон улсын байгууллагыг олон улсын хэмжээнд хууль бус үйл ажиллагаа явуулахад туслалцаа үзүүлсэн тодорхой тохиолдуудад хариуцлага хүлээхээр заасан байна. Тэдгээр нь 1) тухайн туслалцаа үзүүлж байгаа үйл ажиллагааг хууль бус болох талаар мэдсэн, 2) тухайн үйл ажиллагааг хууль бус болгох байдлаар туслалцаа үзүүлсэн гэсэн 2 урьдчилсан нөхцөл

⁵² Responsibility of States for Internationally Wrongful Acts (2001). Available at http://legal.un.org/ilc/texts/instruments/english/draft%20articles/3_6_2001.pdf. Last visited on 30 April 2015.

⁵³ Art.3, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁵⁴ Art.4, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁵⁵ Art.6, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁵⁶ ICJ Advisory opinion, Difference Relating to Immunity from Legal Process of a Special Rapporteur of the Commission on Human Rights(1999), pp.88-89

юм.⁵⁷ Улс нь олон улсын байгууллагыг албадсны улмаас тухайн олон улсын байгууллага олон улсын хэмжээнд хууль бус үйл ажиллагаа явуулсан, ийнхүү албадаж байгаагийнхаяа үр дагаврыг (хууль бус болохыг) улс мэдэж байсан бол ийм үйл ажиллагаанаас үүдэн гарах үр дагаврыг хариуцна.⁵⁸ Дээрх хариуцлага хулээх нөхцөлүүд нь гишүүн болон гишүүн бус улсын аль алинд нь хамаарна.

Гишүүн улсын хувьд дараах тохиолдолд хариуцлага хулээн. Үүнд:

а) Хохирсон этгээдийн өмнө олон улсын байгууллагын олон улсын хэмжээнд явуулсан хууль бус үйл ажиллагааны хариуцлагыг хүлээхийг хулээн зөвшөөрсөн;

б) Хохирсон этгээд гишүүн улсын хариуцлагад найдаад хүрсэн.⁵⁹

Энд заасан гишүүн улсын хариуцлага хулээх хоёр дахь тохиолдол нь олон улсын байгууллага төлбөрийн чадваргүй байдалд орсны улмаас зээлдүүлэгч өр, төлбөрөө гаргуулах боломжгүй болсон үед зээлдүүлэгчийн өр, төлбөрийг тодорхой тохиолдолд гишүүдээс гаргуулж болох тухайд илүү тохиоржтой.

Хохирлыг арилгах арга. Олон улсын байгууллага олон улсын хэмжээнд явуулсан хууль бус үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг хохирол учраас өмнөх байдалд нь буцаан оруулах/сэргээх/(restitution), нөхөн төлөх(compensation), буруугаа хулээх/сatisfaction/ гэсэн 3 аргыг тусад нь эсхүл хослуулах замаар арилгана.⁶⁰ Хохирол учрааас өмнөх байдалд буцаан сэргээх боломжгүй тохиолдолд нөхөн төлбөр олгох хувилбар луу шилжин. Нөхөн төлбөр нь санхүүгийн хувьд үнэлж

боловхуйц хохиролд хамаарна.⁶¹ Эхний 2 арга замаар хохирлыг арилгах боломжгүй, тохиоржгүй тохиолдолд гаргасан зөрчлөө хулээн зөвшөөрөх (an acknowledgement of the breach), харамсаж буйгаа илрэхийлэх (an expression of regret), албан ёссоор учжал гүйх (a formal apology) зэрээр буруугаа хулээх зохицуулалттай.⁶²

Ийнхүү Олон улсын байгууллагын хариуцлагын баримт бичгийн төсөлд байгууллагын хулээх хариуцлага, гишүүн болон гишүүн бус улсын хулээх хариуцлага (байгууллагын халхавчийг нэвтлэх), хохирлыг арилгах арга замыг зохицуулсан байна.

2. Дотоодын эрх зүйн жишээн дээр авч үзэх нь

Олон улсын байгууллага нь үндэсний шүүхийн харьяаллаас ангид байх дархан эрх эдлэх нь түүний хариуцлагын асуудалд нөлөөлөхгүй юм. Олон улсын байгууллага нь тодорхой тохиолдолд дархан эрхээсээ татгалзах зорилгогүй байгаа эсхүл маргаан шийдвэрлэх өөрийн гэсэн тогтолцоогүй бол маргааныг эвийн журмаар эсхүл арбитраар шийдвэрлүүлнэ.

Өмнөх хэсэгт авч үзсэн International Tin Council-ын төлбөрийн чадваргүй байдалд орсноос үүдсэн хэрэгт Их Британид зарим шүүх олон улсын эрх зүйд олон улсын байгууллага эрх зүйн хувьд гишүүдээсээ бие даасан эрх зүйн чадвартай байх нь байгууллагын үүргээ зөрчсөний хариуцлагаас гишүүдийг зайлшгүй чөлөөлне гэх баталгаа болохгүй⁶³ гэж үзсэн байхад Зөвлөл эрх зүйн хувьд гишүүдээсээ бие даасан учраас энэ хэрэгт байгууллагын хариуцлагыг гишүүн улсуудад нь халдаан хэрэглэх нь зохижгүй гэж шийдвэрлэсэн тохиолдол ч мөн

⁵⁷ Art 58, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁵⁸ Art 60, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁵⁹ Art 62.1, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁶⁰ Art 34, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁶¹ Art 36, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁶² Art 37, Draft Articles on the Responsibility of International Organizations (2011)

⁶³ Henry G. Schermers, Niels M Blokker, *International Institutional Law. Unity within Diversity* (Fifth Revised Edition), p 1013

байна.⁶⁴ Тухайлбал, хяналтын шатны шүүхэд шүүгч Kerr: "энэ асуудлыг шийдвэрлэх эрх зүй байхгүй. Английн шүүг олон улсын эрх зүйн дагуу хулээх хариуцлагын хэм хэмжээ бий болгох боломжгүй"; шүүгч Ralph Gibson: "International Tin Council-ын эрх зүйн бие даасан байдал нь гишүүн улсуудыг хариуцлагаас чөлөөлнэ"; шүүгч Nourse "олон улсын эрх зүйн зарчмын дагуу гишүүн улсууд нь хамтран эсхүл тус тусдаа хариуцлага хулээн"⁶⁵; Lord Oliver: "олон улсын эрх зүй судлаачдын зохиол бутзэлд хөөрдög буюу давхар хариуцлагын талаар нийтээр хулээн зөвшөөрсөн дүрмийг тогтоогогоогүй"⁶⁶ гэх байдлаар өөр өөр байр сууртай байсан бол Lordдуудын танхим "гышүүн улсууд нь эрх зүйн бие даасан этгээдийн чадвартай байгууллагын үйл ажиллагааны төлөө хариуцлага хулээхгүй"⁶⁷ гэж үзжээ.

Мөн олон улсын байгууллага хариуцлагын асуудлыг шийдвэрлэх өөрийн гэсэн эрх бүхий шүүхийн тогтолцоотой бай тохиолдол бий. Ийм олон улсын байгууллагын жишээ нь Европын Холбоо юм. Тус байгууллагыг үүсгэн байгуулах гэрээнд гэрээний бус хариуцлагын үед Европын Холбоо нь учирсан хохирлыг арилгах⁶⁸ ба Европын шүүх (Court of Justice) ийм хохирлыг нөхөн төлөхтэй хөлбоотой Маргааныг хянан шийдвэрлэх онцгой харьяалалтай байна⁶⁹; харин гэрээний хариуцлагын үед тухайн асуудалд хэрэглэгдэвэл зохих эрх зүйн дагуу

⁶⁴ Andrew Stumer, *Liability of Member States for Acts of International Organizations: Reconsidering the Policy Objections*, Harvard International Law Review (2007) Vol.48/ No.2, pp.559-560

⁶⁵ MacLaine Watson & Co.Ltd. v. Department of Trade and Industry (1988), in E.Lauterpacht (ed.), *International Law Report* (1989)

⁶⁶ JH Rayner (Mincing Lane) Ltd v. Department of Trade and Industry (1989), in E.Lauterpacht (ed.), *International Law Report* (1989)

⁶⁷ Ibid.

⁶⁸ Art.288 of the Treaty establishing the European Community (2002). Available at <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/PDF/?uri=CELEX:12002E/TXT&from=EN>. Last visited on 30 April 2015.

⁶⁹ Art.235 of the Treaty establishing the European Community (2002).

асуудлыг зохицуулна⁷⁰ гэж заажээ. Ингэсэнээр Европын Холбоо нь гишүүн улсын дотоодын шүүхэд хариуцагч байх боломжтой гэсэн үг юм.

Дүгнэлт

Олон улсын байгууллагын олон улсын эрх зүй болон дотоодын эрх зүй дэх статусын асуудал яагаад чухал байдаг вэ? Олон улсын байгууллагын ямар хүрээнд олон улсын эрх зүйн субъект болох эсэх асуудлыг юуны учир судлах шаардлагатай вэ? гэх асуултуудыг тодруулах зорилгоор энэ судалгааг хийсэн болно. Эдгээрт товчон хариуцлагын олон улсын байгууллага ийм эрх зүйн статусгүйгээр гэрээ байгуулах, хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө олжавах, цаашлаад олон улсын болон дотоодын эрх зүйн харилцаанд идэвхтэй оролцох боломжгүй. Иймээс олон улсын байгууллага нь олон улсын эрх зүйн бие даасан этгээдийн чадвартай (international legal personality) байх нь дараах үндсэн үр дагавартай. Үүнд:

а) Гишигдээс бүрдсэн хамтарсан этгээдээс ялгах боломжтой болно. Ялангуяа олон улсын байгууллагын эзлэх эрх, хулээх үүрэг, хариуцлага нь гишүүдийнхээс тусгаарлагдана;

б) Олон улсын эрх зүйн дагуу өөрийн эрх, ашиг сонирхлыг хамгаалан өөрийн нэрээр нэхэмжлэл гаргах эрх олгогдоно. Энэ эрхээ олон улсын эрх зүйд оршин буй маргаан шийдвэрлэх тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлнэ;

с) Мен үүргээ биелүүлээгүйнхээ хариуцлагыг олон улсын байгууллага өөрийн хулээх нэхцэл байдал бий болно.

НҮБ-ын Олон улсын эрх зүйн комиссийн боловсруулсан Олон улсын байгууллагын хариуцлагын баримт бичгийн тесэл нь олон улсын байгууллагын эрх зүйд томоохон дэвшил авчирч байгаа юм. Үүнд олон улсын байгууллагыг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тодорхойлж байснаас өөр хандлагаар авч үзсэн,

⁷⁰ Art.288 of the Treaty establishing the European Community (2002).

тухайлбал зөвхөн тодорхой төрлийн байгууллага (засгийн газар хоорондын байгууллага)-ыг хамааруулах ойлголтын явцуу байдлаас зайлсхийсэн нь олон улсын байгууллагын цаашдын хөгжилд зөргээр нөлөөлне. Мен олон улсын байгууллагын хариуцлагыг шийдвэрлэхэд улсын хариуцлагын хэм хэмжээг тестэй хэрэглэх нь олон улсын байгууллагын онцлогт бүрэн нийцэх боломжгүй учраас ийм тусгайлсан зохицуулалтыг бий болгосон. Хэрвээ уг баримт бичиг Ерөнхий Ассамблейгаар батлагдсан тохиолдолд олон улсын байгууллагын олон улсын хэмжээнд явуулсан хууль бус үйл ажиллагааны хариуцлагыг хүлээх эрх зүйн үндэс бий болно. Ингэхдээ олон улсын байгууллагын өөрийн нэрээр эрх эдэлж, үүрэг хүлээж чадварыг түүний хариуцлагын асуудалтай холбох хүрээнд байгууллагын болон гишүүний хүлээх хариуцлагыг зааглах оролдлого хийсэн.

Гэхдээ ихэнх олон улсын байгууллага улсаас хамааралтай байдаг нь бодит байдал гэдгийг харгалзан үзэж тодорхой тохиолдлуудад байгууллагын хариуцлагыг нэвтлэх асуудлыг зохицуулсан байна. Нөгөө талаас зарим олон улсын байгууллага (гол төлөв засгийн газар хоорондын байгууллага) өргөн хүрээний эрх ямба, дархан эрх эдэлдэг нь тэдгээрийг дотоодын шуухэд хариуцагчаар татах асуудлыг боломжгүй болгодог гэх шалтгаанаар энэжүү баримт бичиг практикт төдийгүй нөлөөтэй үйлчилж чадахгүй гэх шүүмжлэл байдаг. Гол нь энд эрх ямба, дархан эрх нь шүүхийн харьяллаас хамгаалах баталгааг бий болгох байгаа учраас хариуцлагын асуудлаас тусдаа байна гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Иймээс олон улсын байгууллага эрх ямба, дархан эрх эдлэх нь олон улсын байгууллага хариуцлага хүлээх эсэх гэсэн анхдагч асуултад нөлөөлөхгүй. Үүний оронд эрх ямба, дархан эрх нь хариуцлагын асуудлыг зохицуулсан эрх зүйн дагуу хагна нэхэмжлэл гаргах асуудлыг хязгаарлаж болзошгүй юм.

---оо---